



ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2023 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

Улаанбаатар хот
2022 он



ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2023 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

Улаанбаатар хот
2022 он

МОНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ, АРГА ХЭРЭГСЭЛ

Төв банкны тухай хуульд Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах гэж тодорхойлсон байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд зорилтол тувшний орчимд тогтвожуулах бодлогыг “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д тусган хэрэгжүүлж байна. Инфляцыг нам түвшинд тогтвожуулснаар иргэдийн бодит орлого, хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал хангагдах нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжинэ. Монголбанк инфляцыг 2022-2024 онд жилийн 6 хувь орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтвожуулахыг зорьж байна. Монголбанкаас мөнгөний бодлогын хүрээнд бодлогын хүүг өөрчилсөөр санхүүгийн зах зээлийн хүү, мөнгө, зээлийн эрэлт, нийлүүлэлтэд, улмаар үйлдвэрлэлийн хэмжээ, хөрөнгийн үнэ, хүлээлт, валютын ханш, дотоод эрэлтэд нөлөөлөх замаар инфляцын түвшин, түүний хүлээлтийг тогтвожуулахыг зорьдог. Түүнчлэн, 2018 оноос эхлэн макро зохицой бодлогын хүрээнд системийн хэмжээнд мөрдүүлэхүйц банкны зохицой харьцааны хэрэгслүүдээр дамжуулан банкны зээлийн хэт өсөлт, үүний аль нэг салбар, бүтээгдэхүүн эсвэл гадаад валютад хэт төвлөрсөн байдлыг оновчтой удирдах зэрэгт чиглэсэн арга хэмжээг мөнгөний бодлогын арга хэрэгслүүдтэй хослуулан хэрэглэх стратегийг баримталж байна. Монголбанк мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулахын тулд олон нийттэй харилцах харилцааны нээлттэй байдалд ач холбогдол өгч байна. Иймд Монголбанк макро үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, инфляц, эдийн засгийн ойрын төлөв байдал, түүнд нөлөөлж буй гадаад эдийн засаг, санхүүгийн салбар, нийт эрэлт, нийлүүлэлт, ажил эрхлэлт, үнэ, өргтийн хүчин зүйлс зэргийг инфляцын тайланда танилцуулж, улирал тутам олон нийтэд мэдээлж байна. Төв банкны зорилттой нийттэй, инфляцын төсөөлөлд үндэслэн авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ, үр дунг олон нийтэд нээлттэй танилцуулснаар бодлогын ил тод байдлыг хангах, Монголбанканд итгэх итгэлийг дээшлүүлэх замаар зах зээлд оролцогчдод ирээдүйн талаар мэдээлэл өгөх, хүлээлтийг удирдах ач холбогдолтой.

Монголбанкны мөнгөний бодлогын үйл ажиллагааны зорилт нь банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанкаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүгийн нэгдсэн бодлого, репо санхүүжилт болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг ашиглаж байна. Мөнгөний бодлогын шилжих механизм ёсоор банк хоорондын захын хүүгийн өөрчлөлт нь хадгаламж, зээлийн хүү болон бусад хөрөнгийн үнэд нөлөөлсөөр инфляц болон тэдгээрийн ирээдүйн төлөвийн талаарх хүлээлтэд нөлөөлдөг. Ингэхдээ бодлогын хэрэгсэл нь эцсийн зорилт болох эдийн засгийн идэвхжил, инфляцад тодорхой хугацааны хоцролтой нөлөөлдөг.

Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь банк хоорондын захын богино хугацаатай хүү, банкуудын эх үүсвэрийн хэлбэлзлийг удирдах замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл болж байна. Түүнчлэн бодлогын хүүгийн коридор системтэй уялдуулан мөнгөний бодлогын бусад хэрэгслүүдийн хүү тодорхойлогдож байна.



ГАРЧИГ

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл.....	5
Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийн ерөнхий танилцуулга.....	7
Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийг батлах УИХ-ын тогтоолын төслийн 2 дугаар заалтын танилцуулга.....	10
Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийн танилцуулга.....	39
Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын 91 дүгээр тогтоолын хэрэгжилт.....	66
Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн хэрэгжилт.....	79
Төслийн тооцоо, судалгаа.....	87
I. Инфляц.....	87
II. Бодит сектор	90
2.1.Нийт нийлүүлэлт	90
2.2.Нийт эрэлт	93
III. Улсын төсөв	93
IV. Макро эдийн засгийн төлөв	97
4.1.Эдийн засгийн өсөлтийн төлөв	97
4.2.Төсвийн бодлогын төлөв.....	98
4.3.Мөнгө, зээлийн үзүүлэлтийн төлөв	100
4.4.Төлбөрийн тэнцэл, гадаад секторын төлөв	105
4.5.Инфляцын гол эрсдэлүүдэд суурилсан хувилбар төсөөлөл.....	106
V. Мөнгөний үзүүлэлтүүд.....	112
5.1.Мөнгөний нийлүүлэлт, зээл.....	112

5.2. Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр	114
5.3. Мөнгөний зах, хүүгийн түвшин	119
5.4. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш.....	121
VII. Төлбөрийн тэнцэл, гадаад зээл	123
6.1. Төлбөрийн тэнцэл.....	123
6.2. Хөрөнгө оруулалтын позиц	129
6.3 Монгол Улсын гадаад өр	132
VIII. Санхүүгийн тогтвортой байдал.....	133
7.1. Санхүүгийн салбар	133
7.2. Банк бус санхүүгийн салбар	138
7.3. Банкны салбарын өнөөгийн байдал, цаашдын төлөв.....	142
7.4. Банкны салбарын эрсдэл даах чадвар.....	147
VIII. КОВИД-19 цар тахлын үеийн мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээнүүд	150
8.1. КОВИД-19 цар тахлын эдийн засагт нөлөөлсөн сувгууд	150
8.2. КОВИД-19 цар тахлын эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдалд үүсэж буй эрсдэлүүд.....	153
8.3. Цар тахлын үед авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүд, үр дүн	156
8.4. Монголбанкны урт хугацаат репо санхүүжилт.....	160
Статистикийн хавсралтууд.....	164

ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Шигтгээ 1. Төв банкууд инфляцын зорилтоо нэмэгдүүлэх шаардлагатай юу?.....	88
Шигтгээ 2. Тээвэр, логистикийн өнөөгийн байдал.....	92
Шигтгээ 3. Үнэ-цалин харилцан нэгнээ өсгөх үзэгдэл.....	94
Шигтгээ 4. Хүүхдийн мөнгөний талаарх эх сурвалж, статистик	99
Шигтгээ 5. Жендерийн мэдрэмжтэй санхүүгийн салбарын хэрэгцээ, шаардлага.....	102
Шигтгээ 6. Эдийн засгийн сектор хоорондын хөрөнгийн урсгал	115
Шигтгээ 7. Гадаад төлбөр тооцоонд үүсэж буй хүндрэл, эрсдэлийг бууруулахад монголбанкнаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	125
Шигтгээ 8. Суудлын автомашины импорт.....	128
Шигтгээ 9. Монгол Улсын корреспондент банкны харилцаа	130
Шигтгээ 10. Хувьцаат компани хэлбэртэй банкны зохистой засаглалын зарчмуудын тухай..	135
Шигтгээ 11. Банкны харилцагчдын сэтгэл ханамжийн судалгаа	144
Шигтгээ 12. Банкны зээлийн шимтгэлийн талаарх судалгаа.....	148

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

2022 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2023 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

1/ Гадаад төлбөрийн чадварыг сайжруулж, эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангахад чиглэсэн төсөв, мөнгө, санхүүгийн бодлогыг уялдуулан хэрэгжүүлэх;

2/ Гадаад худалдаа, тээвэр, логистикт үүсэж буй хүндрэлийг шийдвэрлэж, түүхий эд, бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

3/ Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлэх, банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах, валютын эх үүсвэр бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4/ Уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүний боловсруулалтыг шат ахиулж, экспортыг дэмжихэд чиглэсэн гадаад худалдааны санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх;

5/ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг үндэсний хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэх;

6/ Тогтвортой, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх чиглэлд батлагдсан бодлого, хөтөлбөрийг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;

7/ Санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор иргэд, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны төслийг боловсруулж, хэрэгжүүлэх;

8/ Орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтолцоог олон улсын сайн туршлагын дагуу бэхжүүлж, хөтөлбөрийг Монголбанкаас Засгийн газарт 2023 онд багтаан шилжүүлэх;

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпүнцаг/-нд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г. ЗАНДАНШАТАР

*Монгол Улсын Их Хурлын
2022 оны ... сарын ... –ны өдрийн
... дугаар тогтооолын хавсралт*

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2023 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

Цар тахал, геополитикийн асуудлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийг хохирол багатай даван туулж, тогтвортой байдлыг хамгаалахад мөнгө, санхүүгийн болон макро зохистой бодлогын арга хэмжээг чиглүүлнэ.

1. Мөнгөний болон макро зохистой бодлогын хүрээнд:

1.1. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2023 онд нэг оронтой тоонд, дунд хугацаанд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтвормуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ.

1.2. Санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийн шинжилгээ, мониторингийг сайжруулан, эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

1.3. Төв банк олон нийттэй харилцах харилцаандаа ил тод байдлын зарчим баримталж, олон улсын сайн туршлагыг өөрийн орны онцлогт нийцүүлэн хөгжүүлж, ашиглана.

2. Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд:

2.1. Банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгсэл, үнэлгээний аргачлалыг олон улсын жишиг, зарчимд нийцүүлэх бодлого, арга хэмжээг үргэлжлүүлнэ.

2.2. Эрсдэлд суурисан хяналт шалгалтыг нэвтрүүлэх хүрээнд банкны салбарын макро стресс тестийн аргачлалыг боловсронгуй болгож, системийн болон тухайлсан банкны эрсдэлийн үнэлгээг нэвтрүүлнэ.

2.3. Банкны салбарын зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхийн шийдвэрийн үр дүнтэй байдлыг сайжруулах, харилцагчийн хууль ёсны эрхийг хамгаалах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг үргэлжлүүлнэ.

3. Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:

3.1. Дотоод, гадаад төлбөр тооцоог хэвийн үргэлжлэх нөхцлийг бүрдүүлнэ. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, төлбөрийн хэрэгслийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж, олон улсын зарчмын дагуу төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлнэ.

3.2. Иргэд болон бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүү, эдийн засгийн суурь мэдлэг олгох ажлыг үргэлжлүүлнэ.

3.3. Монголбанкны бодлого, үйл ажиллагаанд их өгөгдлийг ашиглах бэлтгэл ажлын хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн үе шаттайгаар хөгжүүлнэ.

3.4. Монгол Улсын гүйлгээнд хүчин төгөлдөр ашиглаж буй мөнгөн тэмдэгтийн эдийн засгийн үр ашиг бүхий зохистой бүтцийг судалж, танилцуулна.

Монгол Улс өнгөрсөн хоёр жил хагасын хугацаанд дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хосолсон хүндрэлийг даван туулж байна. Дэлхий нийтийг хамарсан хүндрэл нь глобал эдийн засагт тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, эрсдэлийг бий болгосоор байна. Энэхүү нөхцөл байдал нь дэлхийн эдийн засгийн төлөвийг муутгаж, бүрэн сэргээгүй нийлүүлэлтийн сүлжээг доголдуулснаар хүнс, эрчим хүчний үнэ хурдтай өсөж олон улсад инфляц өгцом нэмэгдлээ. Цаашид инфляцын өсөлт алгуур буурч, дэлхийн эдийн засаг тогтвортыхи хүлээлттэй хэдий ч үүнд хамгийн багадаа 1-2 жилийн хугацаа шаардагдахаар байна.

Цар тахал, геополитикийн нөхцөл байдал нь Монгол Улсад шууд болон шууд бусаар нөлөөлж өнгөрсөн 2 жил гаруй хугацаанд манай эдийн засгийн идэвхжил сүл байлаа. Энэ оны эхний хагас жилд хөл хорионы дэглэм супарч, төсөв, мөнгө, санхүүгийн бодлогын арга хэмжээ үр дүнгээ өгч, дотоод эрэлт эрчимжсэнээр эдийн засаг 2022 оны эхний хагас жилд өнгөрсөн оны мөн үеэс 1.9 хувиар тэлээд байна. Тухайлбал, тээвэр, уул уурхай, барилгын салбараас бусад бүх салбар өсөж, өрхийн хэрэглээ, хөрөнгө оруулалт үргэлжлэн сэргэв. Ийнхүү эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, уул уурхайн бус салбарууд нийт дүнгээр 2019 оны мөн үеэс 5.2 хувиар өндөр байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүн цар тахлын өмнөх үеийн түвшнээс давсныг илтгэж байна. Түүнчлэн өрхийн хэрэглээ сүүлийн 3 улирал дараалан өсөж, дотоод эрэлтийг нэмэгдүүлж байна. Гэхдээ цаашид хэрхэн өөрчлөгдөх нь бодит орлогын өөрчлөлтөөс голлон хамаарахаар байна. Гадаад орчинд таагүй, тодорхой бус нөхцөл байдал давамгайлж уул уурхайн салбарын өсөлт төдийлөн сэргэхээргүй байгаа ч уул уурхайн бус салбарын идэвхжил үргэлжлэн нэмэгдэж эдийн засгийн өсөлтийг 2022 онд голлон тэтгэхээр байна. Харин 2023 онд зэсийн баяжмалын агууламж нэмэгдэнэ, нүүрсний экспорт хэвийн түвшинд хүрнэ, газрын тосны олборлолт сайжирна гэж үзвэл уул уурхайн салбарын өсөлт нэмэгдэх бол гадаад эрэлт саарах, худалдааны нөхцлийн төлөв муудах, гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оноос төдийлөн нэмэгдэхээргүй байгаа нь уул уурхайн бус салбарын өсөлтийг сааруулахаар байна.

Дэлхийн эдийн засаг ОХУ-Украины хурцадмал байдал үүсэх хүртэл хурдтай өсөж, түүхий эдийн үнэ сэргэхэд нөлөөлж байсан хэдий ч манай улсын экспортын бодит орлого төдийлөн сэргэж чадаагүй байна. Сүүлийн саруудад голлох бүтээгдэхүүний экспорт, тэр дундаа нүүрсний экспорт нэмэгдэж эхэлсэн ч энэ нь үнийн бууралт, уул уурхайн компаниудын экспортлосон бүтээгдэхүүнээс орж ирэх бодит орлого нэмэгдэхгүй байгаагаас экспортын биет хэмжээний эзрэг нөлөөг сааруулж байна. Негөө талаас төсвийн зардлын өсөлт, дотоод эдийн засгийн идэвхжил, худалдааны түнш орнуудын өндөр инфляц, газрын тосны өндөр үнэ зэргээс шалтгаалж импорт тэлж, урсгал дансны алдагдал энэ онд ДНБ-ий 20 хувийг давахаар байна. Гадаад эдийн засгийн төлөв байдал муудаж, тодорхой бус байдал серөг чиглэлд давамгайлж буй өнөө үед манай экспортын орлого болон хөрөнгийн орох урсгал хүлээлтээс саарч, улмаар төлбөрийн тэнцлийн алдагдал одоогийн суурь төсөөллөөс улам томрох эрсдэл бий. Иймээс гадаад эдийн засгийн орчинд эрсдэл нэмэгдсэн, худалдааны гол түнш орнуудын нөхцөл байдал тодорхойгүй байгаа энэ үед төлбөрийн тэнцэл, валютын орох урсгалыг сайжруулах шаардлагыг нэмэгдүүлж байна.

Банкны салбарын төгрөгийн эх үүсвэрийн өсөлт буурч, гадаад валютын эх үүсвэрийн өсөлт нэмэгдэх хандлага өнгөрсөн оноос үргэлжилж байгаа нь эх үүсвэрийн долларжилтийг нэмэгдүүлж, төгрөгийн зээлийн эх үүсвэрийг хумих нөлөөг үзүүлж байна. Үүний нөлөөгөөр өнгөрсөн оноос эрчимжиж эхэлсэн банкны системийн зээлийн өсөлт сүүлийн саруудад саарч эхэллээ. Цар тахлын нөхцөл байдал, геополитикийн эрсдэл, системийн ач холбогдол бүхий банкуудын IPO-тэй холбоотойгоор арилжааны банкуудын зээлийн нийлүүлэлт, нөхцөл, шалгуур хэрхэн өөрчлөгдөх болон төлбөрийн тэнцлийн алдагдал хэр хэмжээгээр тэлэхээс банкны системийн эх үүсвэрийн

өсөлт, зээлийн өсөлт болон мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн цаашдын төлөв шууд хамаарч байна.

Үнийн тогтвортой байдал буюу инфляцыг зорилтот түвшинд хадгалах нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад урьдач, суурь нөхцөл болдог. Иймээс Монголбанк инфляцыг 2023 онд нэг оронтой тоонд, дунд хугацаанд 6 ± 2 нэгж хувийн интервалд тогтвorumулах зорилтыг хангахад чиглэсэн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Энэ нь Монгол Улсын эдийн засаг дунд хугацаанд тогтвортой өсөх, хувийн секторын хэрэглээ, хөрөнгө оруулалтыг дэмжих үндсэн хөшүүрэг болно. Цар тахалтай холбоотойгоор өнгөрсөн оноос дэлхий даяар тээвэр, логистикийн саатал үүсэж, дэлхийн зах зээл дээрх газрын тос, хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөх хандлага 2022 онд геополитикийн хямралаас үүдэн эрчимжиж инфляц зорилтот түвшнээс давахад голлон нөлөөллөө. Эдгээр хүчин зүйлсийн нөлөө ирэх улирлуудад алгуур саарч, инфляц буурах хүлээлттэй байна. Гэхдээ гадаад орчны нөхцөл байдал, худалдааны түнш орнуудын өндөр инфляц, олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд үүссэн саатал хэзээ хэвийн түвшиндээ очих нь тодорхойгүй байгаа тул инфляцын төлөв нэмэгдэх эрсдэлийг бий болгосон хэвээр байна. Түүнчлэн, гадаад хүү хурдтай үргэлжлэн өсөж, дотоод эрэлт цар тахлын өмнөх үеийг давж, “үнэ-цалин ээлжлэн өсөх” үзэгдэл үүсэж болзошгүйн дээр нийлүүлэлтийн шалтгаантай дээрх хүчин зүйлсийн “дараа үеийн нөлөө” үргэлжлэх эрсдэл байсаар байна. Иймээс Монголбанк инфляцын хүлээлтийг бууруулах, төгрөгийн өгөөжийг хадгалах зорилгоор мөнгөний бодлогын төлөвийг хатууруулах шийдвэрийг 2022 онд 4 удаа гаргаад байна. Цаашид Монголбанкны Мөнгөний бодлогын хороо инфляц зорилтот түвшинд тогтвормжих хүртэл шаардлагатай мөнгөний болон маクロ зохистой бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлнэ.

Монголбанкнаас банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишиг, зарчимд нийцүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын арга барилд шилжих арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд ирэх онд банкны өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын дотоод үнэлгээ, удирдлагыг оновчтой хийх чадвхыг бэхжүүлэх зорилгоор Baselyn стандартад тусгагдсан аргачлалуудыг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан нэвтрүүлж, хяналт шалгалтын аргачлалыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх хүрээнд зохицуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Банкны салбарын эрсдэл даах чадварыг бэхжүүлэх зорилгоор банкны хяналт шалгалтын хүрээнд тогтоосон олон улсын стандарт, банкны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллана. Түүнчлэн банкны салбарын зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхийн шийдвэрийн үр дүнтэй байдлыг сайжруулах, харилцагчийн хууль ёсны эрхийг хамгаалах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг үргэлжлүүлнэ.

Эдийн засгийн гадаад орчны савлагаа, тодорхой бус байдал нэмэгдсэн, дотоод эдийн засгийн сэргэлт удаан, инфляц зорилтоос давж өссөн энэ цаг үед төв банкны үйл ажиллагааны ил тод байдал, олон нийттэй харилцах харилцааны ач холбогдол улам бүр нэмэгдэж байна. Иймээс төв банк олон нийттэй харилцах харилцаагаа олон улсын сайн туршлагад тулгуурлан өөрийн орны онцлогийг тусгасан хэлбэрээр боловсронгуй болгож, иргэдийн мэдээллийн тэгш бус байдлыг бууруулж, хүлээлтийг тогтвorumуулж, улмаар бодлогын зорилтод үр дүнтэй хүрэх боломжийг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулан ажиллана. Үүний зэрэгцээ төлбөрийн системийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, олон улсын шилдэг технологийг нутагшуулах, санхүүгийн үйлчилгээний инновацыг дэмжих, цахим хөгжлийн багц хуультай уялдуулан мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, иргэдэд эдийн засаг, санхүүгийн суурь мэдлэг олгох чиглэлээр тодорхой ажлуудыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөж байна.

Геополитикийн эрсдэл өндөр хэвээр хадгалагдаж, БНХАУ-д “Тэг-КОВИД” бодлого цаашид ч үргэлжлэхээр байгаа нь Монгол Улсын гадаад худалдааны эргэлт хумигдах, төлбөрийн тэнцлийн алдагдал тэлэх, гадаад валютын нөөцийн хүрэлцээт түвшин буурах, эдийн засгийн өсөлт саарах, инфляц одоогийн түвшний орчимд хадгалагдах зэрэг нөхцөл, байдал ирэх онд үргэлжлэх эрсдэлийг дагуулж байна. Эдгээр эрсдэл бодитоор илрэх тохиолдолд ирэх онд төлбөрийн тэнцлээ сайжруулахад ихээхэн хүндрэлтэй болохын зэрэгцээ дотоод эрэлтийн тохиргоог цаг алдалгүй хийх ёстой болно. Иймд энэ чиглэлд төсөв, мөнгө, санхүүгийн бодлогыг уялдуулан хэрэгжүүлж, эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх нь бодлогын гол сорилт болохоор байна. Иймээс энэ сорилтыг даван туулахад чиглэсэн холбогдох зорилтуудыг томьёолж, Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран хэрэгжүүлэхээр УИХ-ын тогтоолын төсөлд тусгалаа. Энэ хүрээнд тээвэр, логистикийн хүндрэлийг шийдвэрлэж, хилийн гацааг арилгахгүйгээр экспортын орлогыг нэмэгдүүлэх, худалдааны эргэлтийг сайжруулах боломж хомс юм. Иймээс эдийн засгийн гадаад тэнцвэр алдагдаж байгаа энэ үед дотоод эрэлтийг дэмжсэн төсөв, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх нь импортыг урамшуулж, гадаад тэнцвэргүй байдлыг улам даамжуулах эрсдэлтэй. Харин гадаад орчны сөрөг нөлөөг зөөлрүүлж, эдийн засгийг дэмжих зайлшгүй хийх арга хэмжээ нь гадаад төлбөрийн чадварыг сайжруулж, гадаад санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх явдал болж байна. Хэрэв төлбөрийн тэнцлийг сайжруулж чадахгүй тохиолдолд дотоод эрэлтийг бууруулах чиглэлд төсөв, мөнгөний бодлогыг чангараулахаас өөр сонголтгүй болно. Мөн тээвэр, логистикийн чадавхыг сайжруулж, үүсээд буй тээврийн хүндрэлийг шийдвэрлэх, уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэхэд гадаад худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр хөгжүүлж, нэвтрүүлэх, тогтвортой, ногоон санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх, “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зэрэг олон чиглэлээр төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай үргэлжлүүлэн хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг нэгтгэн харахад ААН, хэрэглэгчид цар тахлын нөхцөл байдалд дасан зохицон бизнесийн үйл ажиллагаа тогтвортыхи хандлагатай болж, эдийн засгийн ихэнх салбарт өсөлт ажиглагдаж эхлээд байна. Ийнхүү цар тахлын сөрөг нөлөө буурч байгаа хэдий ч гадаад орчны эрсдэл, тодорхой бус байдал үргэлжилж, урд хөршийн цар тахлын эсрэг хэрэгжүүлж буй бодлого нь төлбөрийн тэнцлийн алдагдлыг тэлж, зардлын шалтгаантай инфляцыг эрчимжүүлж, ДНБ-д эзлэх төсвийн зардал нэмэгдэж, гадаад, дотоод тэнцвэр алдагдах нөхцөл болж байна. Иймээс цаашид нийгэм, эдийн засгийн бодлогыг эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах, валютын дотогшлох урсгалыг нэмэгдүүлэх, зорилтот бүлэгт чиглэсэн халамжийн бодлого хэрэгжүүлэхээс гадна дунд, урт хугацааны тогтвортой хөгжлийн зорилтой нийцүүлэх шаардлагатай байна.

Цаашид үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэрийг хангахад макро эдийн засгийн бодлогуудыг чиглүүлэх нь чухал болж байна. Монголбанкны 2023 оны бодлого, үйл ажиллагаа инфляцыг зорилтот түвшинд эргүүлэн тогтвортуюулах замаар эдийн засагт эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах, тогтвортой өсөлтийн суурь нөхцлийг бий болгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2023 ОНД
БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН
2 ДУГААР ЗААЛТЫН ТАНИЛЦУУЛГА**

1/ Гадаад төлбөрийн чадварыг сайжруулж, эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангахад чиглэсэн төсөв, мөнгө, санхүүгийн бодлогыг уялдуулан хэрэгжүүлэх

Үндэслэл

Байгалийн арвин баялагтай, дэлхийн зах зээл дэх үнийн хэлбэлзлээс өндөр хамааралтай Монгол Улсын хувьд гадаад сөрөг шоктой үед валютын ханшийн тохиргоог суурь хүчин зүйлстэй уялдуулан хийх, ургал дансны алдагдлыг бууруулах, төсөв, мөнгөний бодлогыг нөхцөл байдалтай уялдуулан хэрэгжүүлэх, түүнчлэн төсвийн өндөр сахилга батыг хангах, төсвийн дурмийг хэрэгжүүлэх, инфляцыг онилох мөнгөний бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, санхүүгийн тогтвортой байдалд анхаарах нь эдийн засгийн хэлбэлзэл, мөчлөгийн далайцыг бууруулах гол арга зам байдаг¹. Иймд эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангах, ургал дансны алдагдлыг бууруулах, инфляцыг зорилтот түвшинд тогтвортжуулах, эдийн засаг, санхүүгийн мөчлөгийн далайцыг бууруулахад чиглэсэн төсөв, мөнгө, санхүүгийн бодлогыг уялдуулан хэрэгжүүлж, тогтвортой өсөлтийг хангах шаардлагатай байна.

КОВИД-19 цар тахал, олон улсын харилцаанд үүссэн геополитикийн хурцадмал байдал гэсэн дараалсан хүндрэлүүдийн үед эдийн засагт зарим бараа, үйлчилгээний нийлүүлэлтийн тасалдал бий болж, экспортын хилийн боомтоор нэвтрэх дээр гацаа үүссэн нь эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэр алдагдахад нөлөөллөө. Энэ нь инфляц нэмэгдэж, бизнесийн орчин муудах, ургал дансны алдагдал өсөх байдлаар илэрч байна.

КОВИД-19 цар тахлын үед эдийн засгийн өсөлт саарахад уул уурхай, тээвэр, худалдаа, үйлчилгээний салбаруудын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа 2020 онд муудсан нь голлон нөлөөлсөн. Цар тахлын хязгаарлалтууд 2021 оны сүүлийн хагасаас сularч эхэлсэн ч 2022 оны 2 дугаар сараас олон улсад геополитикийн хурцадмал байдал үүссэн нь гадаад орчны сөрөг шок болов.

Эдгээр дараалсан сөрөг шокын нөлөөгөөр дотоод эрэлт агшиж, өсөлт саарч байгаа ч инфляц өсөж, зорилтот түвшин рүү тогтвортых хугацаа хойшлоод байна. Тодруулбал, 2021 оноос хилийн хязгаарлалт үргэлжилж, импортын бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн, малын гоц халдварт өвчин гарснаар махны үнэ улирлын хандлагаасаа зөрж өссөн, тээвэр, шатахууны үнийн өсөлт үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлсэн зэрэг нь инфляц нэмэгдэхэд голлон нөлөөлж байна. Энэ онд дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ хурдтай өсөж, шатахууны инфляц нэмэгдсэн, хилийн хязгаарлалт, тээвэр, үйлдвэрлэлийн зардлын өсөлт, төгрөгийн ханшийн суралтаар дамжин дотоод үнэ өссөн, гадаад инфляц нэмэгдсэн зөргээс дотоодын инфляц өндөр түвшинд хүрсэн.

Олон улсад үүсэж буй геополитикийн асуудалтай зэрэгцээд БНХАУ-д “Тэг-КОВИД” бодлого үргэлжилж байгаагаас манай улсын худалдааны эргэлт багасаж, төлбөрийн тэнцлийн алдагдал тэлж, гадаад валютын нөөцийн хүрэлцээ буурав. КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй огцом уналтын дараа дэлхийн эдийн засаг хурдтай сэргэж, манай экспортын үнэ огцом өссөн хэдий ч хилийн болон тээврийн хязгаарлалтаас шалтгаалан энэхүү давуу талыг ашиглаж чадсангүй. Энэ оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар ГВУН-ийн хүрэлцээ импортын 4.2 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрч буураад байна. Цаашид гадаад орчны таагүй нөхцөл байдал үргэлжилж, дордох эрсдэлтэй байна (Хүснэгт 1).

¹ Дэлхийн банк тайлан 2021.

Хүснэгт 1. Гадаад валютын нөөцийн эмзэг байдлын индикаторууд

	Хэвийн үе	Цар тахлын үе		Цар тахал + Геополитикийн эрсдэлийн үе						
		2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022H1	Эмзэг байдал бага
Гадаад валютын нөөцийн хүрэлцээ	ГВУН/Импорт	5.0	4.9	8.0	7.5	9.1	10.7	8.0	4.2	3 сар <
	ГВУН/Мөнгөний нийлүүлэлт	28	24	49	45	55	52	45	33	5% - 20%
	ГВУН/Богино хугацаат өр	180	150	227	260	371	355	308		100%
	ГВУН/ ГВУН(ARA EM)	33	30	61	68	79	78	71		100%-150%


■ эмзэг байдал бага
■ эмзэг байдал дунд зэрэг
■ эмзэг байдал ондер
■ эмзэг байдал маш ондер

- (1) Гадаад валютын нөөцийн импортын хэрэгцээг хангах хүрэлцээ, сараар
- (2) Гадаад валютын албан нөөц нийт эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтэд эзлэх хувь буюу хөрөнгийн урсгал чөлөөтэй эдийн засгаас гэнэт их хэмжээний хөрөнгө гадагшлаад түүнийг хангах ГВАН-ийн хүрэлцээ
- (3) Гадаад валютын нөөцөөр богино хугацаат өр төлбөрийг төлж барагдуулах чадвар
- (4) Эдийн засгийн тухайн нөхцөл байдалд тохирох гадаад валютын нөөцийн зохицтой түвшинийг тус тус илрэхийлнэ.


Эх сурвалж: Монголбанк

Сүүлийн 2 жилд гадаад шокын нөлөөгөөр эдийн засгийн өсөлт саарч, инфляц нэмэгдсэн нь дотоод тэнцвэргүй байдлыг үүсгэж байна. Экспортын орлого буурч, үйлчилгээ, орлогын дансны алдагдуулуд тэлснээр урсгал дансны алдагдал 2022 оны эхний 6 сард 2.0 тэрбум ам.долларт хүрсэн нь гадаад тэнцвэр алдагдсаныг илтгэнэ. Гадаад, дотоод тэнцвэр ийнхүү удаан хугацаанд алдагдах нь үнийн тогтвортой байдлыг алдагдуулах, ажилгүйдлийг нэмэгдүүлэх, эдийн засгийн хүндрэлийг бий болгож, хямралд хүргэх эрсдэлтэй тул холбогдох төсөв, мөнгө, валютын ханшийн тохиргоог хийх шаардлагыг улам бүр нэмэгдүүлж байна.

Зураг 1. ДНБ-ий өсөлт, инфляц



Зураг 2. Урсгал данс, ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: YCX

Эх сурвалж: Монголбанк, YCX

Эдийн засгийн өсөлт саарсан, инфляц нэмэгдсэн, төгрөгийн ханш сулрах дарамт өндөр байгаа одоогийн нөхцөлд мөнгөний бодлогоор тохиргоо хийж, эдийн засгийн сэргэлтийг дэмжих бодлогын орон зай хязгарагдаж байна. Иймд мөнгөний бодлогыг хатууруулах төлөвт шилжээд байна. Нөгөө талаас, БНХАУ-ын цар тахлын тархалтыг хязгаарлах бодлого, КОВИД-19-ын дотоод халдварт зэрэгтэй холбоотойгоор уул уурхайн бүтээгдэхүүний экспорт хангалттай сайн өсөхгүй байгаагаас урсгал тэнцлийн алдагдал нэмэгдэж байгаа нь гадаад валютын нөөцөд дарамт болж байна. Ийм орчинд төсвийн зардлыг бууруулах шаардлагатай байна. Үүний зэрэгцээ, цар тахал эхэлснээс хойших 2 жил гаруйн хугацаанд Төв банкнаас авч хэрэгжүүлсэн санхүүгийн зохицуулалт, хөнгөлөлт, чөлөөлөлтийн арга хэмжээнүүд 2022 оны 2 дугаар улиралд дуусгавар

болсон тул зээл авагч талд санхүүгийн нөхцөл чангартч байна. Геополитикийн эрсдэл өндөр хэвээр хадгалагдаж, гадаад орчны төлөв төдийлөн сайжрахгүй байгаа нь одоогоор үүсээд буй эдийн засгийн хүндрэлийг зардал багатайгаар даван туулахад төсөв, мөнгө, санхүүгийн бодлогуудыг уялдуулан эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогын тохиргоог хийх нь чухал боллоо. Энэ нь ирэх оны макро бодлогын өмнө тулгарч буй гол сорилт болж байна.

Макро бодлогуудын урт хугацааны зорилт нь эдийн засгийн тогтвортой өсөлтөд чиглэдэг бол тогтвортой өсөлтийн суурь нөхцөл нь дотоод, гадаад тэнцвэрийг хангах явдал билээ. Гадаад орчин тодорхой бус байдал өндөр, гадаад шоконд өртөх эмзэг байдал өндөртэй орчинд эдийн засаг, санхүүгийн мөчлөгийн далайцыг бууруулах чиглэлд бодлого, үйл ажиллагааг чиглүүлэх шаардлагатай байна.

Дотоод тэнцвэр зөвхөн бизнесийн мөчлөгөөр бус санхүүгийн мөчлөгөөс хамааралтай бөгөөд улс орнуудын туршлагаас харахад дийлэнх тохиолдолд бодит эдийн засаг, санхүүгийн мөчлөгийн уналтууд давхцаж, мөчлөгийн далайцыг нэмэгдүүлэн, банк, санхүү, эдийн засгийн хямрал даамжрах нөхцөл байдлыг үүсгэдэг. Иймээс эдийн засгийн мөчлөгийг удирдах замаар санхүүгийн мөчлөгийн далайцыг бууруулж, хүндрэлийг зөөлрүүлэх; нөгөө талд, санхүүгийн секторт хуримтлагдаж буй эрсдэл, болзошгүй хүндрэлийг харгалzan бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж, эдийн засгийн мөчлөгийн далайцыг тэлэхгүй байхад анхаарах нь чухал болж байна. Эдийн засгийн мөчлөгийг удирдах гол хэрэгсэл нь төсөв, мөнгөний бодлого бөгөөд мөнгөний бодлого нь цаг хугацааны хоцрогдолтойгоор инфляц, эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх бол төсвийн зардал, татварын бодлого нь нийт эдийн засаг болон тодорхой салбаруудад шууд нөлөөтэй. Гэвч гадаад тэнцвэр алдагдаж байгаа үед дотоод эрэлтийг дэмжсэн төсөв, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх нь импортыг урамшуулж, гадаад тэнцвэргүй байдлыг улам даамжуулах эрсдэлтэй. Харин гадаад орчны сөрөг нөлөөг зөөлрүүлж, эдийн засгийг дэмжих зайлшгүй арга зам нь гадаад төлбөрийн чадварыг сайжруулж, гадаад санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх явдал болж байна. Хэрэв гадаад төлбөрийн чадварыг сайжруулж чадахгүй тохиолдолд дотоод эрэлтийг бууруулах чиглэлд төсөв, мөнгөний бодлогыг чангартуулахаас өөр сонголтгүй юм.

Тээвэр, логистикийн хүндрэлийг шийдвэрлэж, хилийн гацааг арилгахгүйгээр экспортын орлогыг нэмэгдүүлэх, худалдааны эргэлтийг сайжруулах боломжгүй гэдэг нь тодорхой харагдаж байна. Нэгэнт эдгээр асуудлыг Монгол Улс дангаараа шийдвэрлэх боломжгүй тул гадаад тэнцвэр алдагдах буюу төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэхээс хамааруулан төгрөгийн ханш болон төсвийн төлөвийг зохистой түвшинд хадгалах бодлогын тохируулгыг богино хугацаанд авч хэрэгжүүлэх ёстой болно. Төсвийн зардал, түүний оновчтой дүрмийг тогтоох нь бусад бодлогын орон зайн нэмэгдүүлэхдээ дэмжлэг үзүүлнэ. Цаашлаад дунд, урт хугацаанд гадаад, дотоод тэнцвэрийг хангахад бодлогын тохиргоог туштай хэрэгжүүлэн, гадаад шоконд өртөмтгий байдлыг бууруулах зорилгоор бодлогын орон зайн, нөөц сангаль аль бодлогуудын хувьд бүрдүүлэх нь урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах суурь гэж үзэж байна.

Стратеги

- Эдийн засгийн гадаад төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх хүрээнд гадаад валютын урсгал, экспортыг нэмэгдүүлэх, импортын саад тогторыг арилгах арга хэмжээг зохион байгуулах.
- Гадаад төлбөрийн чадварын нөхцөл байдалтай уялдуулан төсөв, мөнгөний бодлогын төлөвийг тодорхойлох. Гадаад төлбөрийн чадвар сайжрахгүй тохиолдолд дотоод эрэлтийн тохиргоог цаг алдалгүй хийхэд чиглэсэн төсөв, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх.
- Инфляцыг дунд хугацааны зорилтот түвшинд хүргэж бууруулахад чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх.
- Төсвийн бодлогыг хэрэгжүүлэхдээ ялангуяа төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг тодорхойлоходоо инфляц, импортын дарамтыг бууруулах зарчмыг хатуу баримтлах.

- Валютын дотогшлох урсгалыг нэмэгдүүлэхийн тулд уул уурхайн болон уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх, саад тогторыг арилгах.
- Эдийн засгийн төрөлжилтийг дэмжихийн тулд уул уурхайн бус экспортлогчдын бизнесийн орчныг сайжруулах.
- Засгийн газрын зүгээс экспортыг төрөлжүүлэх, импортыг орлоход чиглэсэн төслүүдийг шийдвэрлэж, гадаадын хөрөнгө оруулалтыг татах ажлыг эрчимжүүлэх.
- Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан зохицуулагч байгууллагууд хамтран уялдааг ханган ажиллах.
- Хэрэглээний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг (тээвэр, логистик, агуулах гэх мэт) сайжруулж хөгжүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Экспортын орлогыг нэмэгдүүлэх хүрээнд тээвэр, логистикийн саад тогторыг худалдааны түвшн орнуудтай хамтран шийдвэрлэх гарцыг олж, шийдвэрлэх.
- Гадаад орчны тодорхой бус байдалтай холбоотойгоор гадаад төлбөрийн чадварыг сайжруулах, гадаад санхүүжилтийн орох урсгалыг нэмэгдүүлэх.
- Гадаад орчны нөхцөл байдал, болзошгүй эрсдэлээс хамааруулан төсөв, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, эдийн засгийн мөчлөгийн далайцыг бууруулах чиглэлд төсвийн бодлогын оновчтой дүрмийг тогтоон дагаж мөрдөх.
- Эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангах чиглэлд бодлогын тохиргоог тууштай хэрэгжүүлэн, гадаад шоконд өртөмтгий байдлыг бууруулах зорилгоор бодлогын орон зайд, нөөц санг аль аль бодлогуудын хувьд бүрдүүлэх.
- Төсөв, мөнгө, санхүүгийн бодлогын уялдааг хангах оновчтой механизм, институцийг хөгжүүлэх.

2/ Гадаад худалдаа, тээвэр, логистикт үүсэж буй хүндрэлийг шийдвэрлэж, түүхий эд, бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

Үндэслэл

Инфляцын одоогийн бүтцээс харахад импортын шатахуун, хүнсний бүтээгдэхүүн дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлтөөс гадна гадаад худалдаа, тээвэр, логистикийн хүндрэл, зардлын өсөлт, түүхий эд, бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт дагасан үнийн өсөлт хүчтэй нөлөөлж байна. Иймд энэ шалтгаантай үнийн өсөлтийг тогтворжуулах нь инфляцын зорилтыг дунд хугацаанд тогтвортой хангахад туйлын чухал байна.


КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр дэлхийн худалдааны эргэлтэд бий болсон догоолдол, гацаа арилаагүй байхад геополитикийн нөхцөл байдал хурцадсан нь олон улсын тээвэр логистикийн хүндрэлийг даамжруулж байна. Энэ нь тээврийн зардлыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл удааширч, зардал нэмэгдэн, өрсөлдөх чадварыг бууруулах, бизнесийн орчинд тодорхой бус байдал бий болгох, иргэдийн бодит орлогыг бууруулах, эдийн засаг хумигдах зэрэг олон сөрөг үр дагаврыг үүсгэж байгаа нь манай улсад ч илрэч байна. Иймд тээвэр, логистикийн хүндрэлийг шийдвэрлэж, түүхий эд, бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт хангамжийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага тулгараад байна. Тухайлбал, Олон улсын контейнер тээврийн Freightos Baltic Index (FBX) үнийн индекс 2022 оны 6 сарын эцсийн байдлаар КОВИД-19 цар тахлын өмнөх үе буюу 2019 оны дунджаас 5.2 дахин өссөн бол Монголын томоохон тээвэр зуучийн компаниудын мэдээгээр манай улсын импортын бараа, бүтээгдэхүүний тээврийн зардал хэвийн үеийнхээс 2-5 дахин нэмэгдэж, дундаж хугацаа нь 2-4 дахин буюу 30-90 хоногоор уртасжээ. Үүнээс үзэхэд импортын барааны үнийн өсөлтийн томоохон шалтгаан нь тээвэр логистиктой холбоотой зардал болж байна. Түүнчлэн хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцын түвшин 2022 оны 6-р сард

улсын хэмжээнд 16.1 хувьд хүрсэн бөгөөд үүний тал орчим хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шууд шалтгаалсан байна.


Түүнчлэн, геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалж барууны орнуудаас ОХУ-д тавьж буй эдийн засгийн болон санхүүгийн хоригууд нь дэлхийн нийлүүлэлтийн сүлжээний доголдлыг дордуулав. ОХУ-д тавьж буй хоригууд нь зөвхөн тухайн улсад хамааралтай хориг боловч манай улсын тээвэрт шууд болон дам байдлаар нөлөөлж байна. Тодруулбал, ОХУ, Беларусаар дамждаг эсвэл тус улсын тээвэрлэгчдийн оролцоотойгоор хийгддэг авто, төмөр замын тээврүүдэд хоригоос үүдэлтэй төлбөр тооцооны болон тээвэрлэлтийн саад учирч байна. Хэрэв хориг илүү чанграх, тухайн бүс нутгаар огт тээвэрлэж чадахааргүй нөхцөл байдал үүсвэл илүү урт зам туулах тээврийн чиглэлийг сонгох, цөөн хэдэн чиглэлд тээврийн ачаалал ихсэх, улмаар тээврийн үнэ, хугацаа улам нэмэгдэх эрсдэлтэй байна.

Үүнээс гадна тээвэр, логистикийн дэд бүтэц, хууль тогтоомж, чанар стандартыг сайжруулах нь нэн чухал болохыг манай улсын дэд бүтэц, логистикийн хөгжил сүл байгаагаас харж болохоор байна (Зураг 3). Монгол Улс худалдааны хамаарал өндөр буюу гадаад худалдааны ДНБ-д эзлэх хувь хэмжэ² дэлхийн дунджаас 30 орчим нэгж хувиар өндөр хэдий ч Дэлхийн банк (2018)-наас гаргадаг Логистикийн гүйцэтгэлийн индекс (LPI)-ийн мэдээгээр 160 орноос 130 дугаар байрт жагсаж, 2016 оноос даруй 22 байр ухарчээ. Судалгаанд хамрагдсан 160 улсын хувьд логистикийн хөгжил нь ДНБ-ий хэмжээтэй өндөр хамааралтай бөгөөд логистик хөгжих тусам дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ сайжирдаг зүй тогтол тод ажиглагдаж байна (Зураг 4).

Зураг 3. Логистикийн хөгжил, гадаад худалдааны хамаарал



Зураг 4. Логистикийн хөгжил, ДНБ-ий хамаарал



Эх сурвалж: Дэлхийн банк

Хүнсний бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлт, нийлүүлэлт сүлжээний хөгжил сүл байгаа нь хилийн боомт дээр доголдол, саатал үүсэх бүрт бараа, бүтээгдэхүүний үнэ огцом хөөрөгдөх нөхцөлийг бурдүүлж байна. Тухайлбал, 2021 оны 10 дугаар сард Эрээн-Замын-Үүд боомт хаагдахад хэрэглээний сагсанд багтдаг импортын хүнсний ногооны үнэ сарын 21 хувиар өссөн бол, дараа сард нь дотоодын хүнсний ногооны үнэ сарын 17 хувиар өссөн бөгөөд нийлүүлэлт эргэн

² Гадаад худалдааны эргэлтийн хэмжээг ДНБ-д харьцуулж тооцсон дун.

сайжирсан ч үнэ буураагүй. Өөрөөр хэлбэл, хүнсний бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлтэд саатал үүсэх нь тухайн импортын барааны нийлүүлэлтийг бууруулж, үнийг өсгөхөөс гадна түүнийг орлох дотоодын бараа, бүтээгдэхүүний үнийг хөөрөгдүүлдэг төдийгүй үүссэн үнийн шок нь богино хугацаанд арилдаггүйгээс өрхүүдэд өндөр үнийн дарамт учирч байна. Иймд хүнсний тээвэрлэлт, нийлүүлэлтийн сүлжээг сайжруулах нь үнийн тогтвортой байдал, иргэдийн бодит орлогыг хадгалахад чухал үүрэгтэй байна.

Монгол Улсад гуравдагч орноос ирдэг нийт ачааны 90 орчим хувь нь зөвхөн БНХАУ-ын Тяньжин боомтоор дамждаг буюу манай улс цөөн тооны боомтоос хамааралтай байгаа нь гадаад орчны өөрчлөлтөд улам эмзэг болгож байна. Түүнчлэн, БНХАУ-тай хиллэдэг боомтуудыг авч үзвэл Эрээн - Замын-Үүдийн боомтоор Монгол Улсын нийт барааны импортын 70 хувийг, чингэлэг тээврийн 94 хувийг нэвтрүүлдэг талаар Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбооны мэдээнд дурджээ. Энэ нь Монгол Улс гадна талаас Тяньжиний боомт, дотоодод Замын-Үүдийн боомтоос маш их хамааралтай болохыг харуулж байна. Иймээс дээрх боомтуудад гацаа үүсэхэд нийлүүлэлт доголдож, дотоодод үнэ өсөх томоохон шалтгаан болж байна. Тухайлбал, 2021 оны 4-р улирал, 2022 оны 1-р улиралд Эрээн- Замын-Үүдийн боомтын ачаа тээвэр удаашрахад импортын бараа, бүтээгдэхүүний үнэ харгалзан өмнөх улирлаас 3.8, 5.7 хувиар өссөн нь 2018-2020 онуудын улирлын дундаж өсөлттэй харьцуулбал даруй 3-4 дахин өндөр өсөлт юм.

Монгол Улсын Засгийн газраас тээвэр, логистикийн асуудалд онцгойлон анхаарч “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх 6 багц асуудалд багтаагаад байна. Харин одоо үүсээд байгаа нөхцөл байдал нь тус асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх шаардлагыг нэмэгдүүлж байна.

Стратеги

- Тээвэр, логистикийн чадавхыг нэмэгдүүлж, үүсээд буй тээврийн хүндрэлийг шийдвэрлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн үүрэг оролцоог тодорхойлж, хамтын ажиллагааны механизм бүрдүүлэх.
- Судалгаа шинжилгээнд үндэслэсэн үүсээд буй асуудлыг үр дүнтэй, шуурхай шийдвэрлэх стратеги, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Монгол Улс олон улсын худалдааны бодлоготой уялдсан тээвэр, логистикийн бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх.
- Олон улсын стандарт шаардлагад нийцүүлэх чиглэлд боомтуудын хүчин чадал, дэд бүтцийг сайжруулах.
- Ачаа тээврийн улсын хилээр орох, гарах урсгалыг нэмэгдүүлэх, аль нэг талд контейнерын бөөгнөрөл үүсгэхгүй байх үр дүнтэй зохицуулалт хийх
- Гадаад худалдааны тээвэрлэлтийн маршрутын тоог нэмэгдүүлэх боломжийг судалж, шаардлагатай тохиолдолд ашиглах.
- Ачаа тээврийн эргэлтэд гэнэтийн саатал үүсэх эрсдэлүүдийг судалж, шаардлагатай нөөц төлөвлөгөөг боловсруулах.

3/ Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлэх, банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах, валютын эх үүсвэр бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

Үндэслэл

Олон улсын геополитикийн нөхцөл байдал, хилийн боомт дээрх тасалдалтай зэрэгцэн БНХАУ-ын “Тэг-КОВИД” бодлогын нөлөөгөөр төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал 2022 оны

эхний 7 сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 52.6 хувиар өсөж, 2.2 тэрбум ам.долларт хүрлээ. Цар тахлын дараах эдийн засгийн идэвхжилтэй уялдан дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ нэмэгдэж, харьцангуй таатай нөхцөл бүрдсэн хэдий ч хилийн хязгаарлалт болон тээвэрлэлтийн доголдоос шалтгаалан экспортын биет хэмжээ хангалттай түвшинд нэмэгдсэнгүй.

Нөгөөтэйгүүр дэлхийн тэргүүлэгч улс орнуудын инфляц сүүлийн 40 жилийн дээд түвшинд хүрч, Төв банкууд инфляцыг хязгаарлах зорилгоор бодлогын хүүгээ хурдацтайгаар нэмж эхэлсэн. Тухайлбал, АНУ-ын Холбооны нөөцийн банк 2022 он гарснаас хойш бодлогын хүүгээ 4 удаа өсгөж, дээд хязгаарыг 0.25 хувиас 2.5 хувь болгон нэмэгдүүллээ. Ингэснээр ам.долларын ханш бусад валютуудын эсрэг огцом чангач байна.

Ургал дансны алдагдал нэмэгдэж гадаад санхүүжилтийн өртөг өсөж ам.доллар дэлхий нийтэд чангач буй нөхцөлд гадаад валютын нөөц дэх дарамт нэмэгдэж, улмаар нөөцийн хэмжээ 2022 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар 2,878.6 сая ам.долларт хүрч оны эхнээс 34.1 хувиар буурлаа. ГВУН-ийн хүрэлцээ нь валютын төлбөртэй барааны импортын 3.6 сарын хэрэгцээг хангах түвшинд байна. Энэ нь олон улсад өргөн ашиглагддаг хүрэлцээт байдлын суурь хэмжүүрийг (3 сар) хангаж байгаа хэдий ч Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан 12 сарын хэрэгцээг хангах түвшнээс үнэмлэхүйц доогуур түвшинд байна.

2021 онд Монгол Улсын Засгийн газар өрийн удирдлагын хүрээнд Центури төслийг амжилттай хэрэгжүүлсэн нь 2022-2023 онд төлөгдөх хуваарь бүхий Чингис, Гэрэгэ бондуудыг дахин санхүүжүүлж, богино хугацааны өрийн дарамтыг бууруулахад чухал нөлөөтэй байв. Гэсэн хэдий ч 2022 оны 12 дугаар сард Чингис бондын үлдэгдэл болох 136.8 сая ам.долларын төлбөр, 2023 оны 4 дүгээр улиралд Монгол Улсын Хөгжлийн Банкны 500.0 сая ам.доллар болон 30.0 тэрбум иентэй тэнцэх бондуудын эргэн төлөлт хүлээгдэж байна.

Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх нь олон нийтийн төгрөгт итгэлийг бэхжүүлэх, Монгол Улсын зээлжих зэрэглэлд зөргээр нөлөөлөх, гадаад сөрөг шоконд дархлаатай байхад өндөр ач холбогдолтой. Олон улсын geopolitik, эдийн засгийн нөхцөлд тодорхой бус байдал өндөр, Монгол Улсын Засгийн газрын богино хугацааны өрийн дарамт өндөр хэвээр байгаа зөргээс үзэхэд цаашид гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх замаар ирээдүйд төлөх гадаад өрийн эргэн төлөлтөд бэлтгэж, гадаад валютаарх төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Стратеги

- Гадаад орчны тодорхой бус байдал нэмэгдсэнтэй холбогдуулан гадаад валютын улсын нөөцийн аюулгүй байдлыг үргэлжлүүлэн хадгалж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад онцгой анхаарах.
- Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд банк, санхүүгийн байгууллага, дотоодын ААН-үүдтэй хамтран ажиллах.
- Гадаадын валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, богино хугацааны өрийн дарамтыг бууруулах чиглэлд Засгийн газартай хамтран ажиллах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Гадаад төлбөр тооцооны тасалдалгүй байдлыг хангах чиглэлд гадны харилцагч банкуудын хүрээг тэлж, харилцаа холбоог сайжруулах.
- Гадаад валютын нөөцийн удирдлагын бүтцийг сайжруулах, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах чиглэлд Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах.
- Дотоодын зах зээлээс алт худалдан авах ажиллагааг сайжруулж, алт тушаалтыг нэмэгдүүлэх, дотоодын алт олборлогч ААН-үүдэд санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэх.
- Засгийн газрын зүгээс гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах, дэд бүтцийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ гаднаас валютын эх үүсвэр татах замаар гадаад валютын нөөцөд дарамт багатайгаар шийдвэрлэх.
- Засгийн газрын өрийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж, гадаад валютын бондуудыг таатай нөхцөлөөр дахин санхүүжүүлэх.

4/ Уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүний боловсруулалтыг шат ахиулж, экспортыг дэмжихэд чиглэсэн гадаад худалдааны санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх

Үндэслэл


Монгол Улсын төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал 2008 оноос хойш алдагдалтай гарч ирлээ. Энэхүү алдагдал нь төлбөрийн тэнцлийн алдагдлыг бий болгож, улмаар гадаад валютын нөөцийг бууруулах үндсэн хучин зүйл байсаар байна. Төв банкны төлбөрийн тэнцлийн суурь төсөөллөөр энэхүү нөхцөл байдал үргэлжлэх төлөвтэй энэ үед урсгал дансны алдагдлыг бууруулахад чиглэсэн бодлогын тохиргоог авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бий болоод байна. Урсгал дансны алдагдлыг бууруулахын тулд уул уурхайн экспортын боломжийг бүрэн ашиглахаас гадна валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэхэд анхаарах ёстой болж байна. Энэ бодлого нь эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх ач холбогдолтой юм.

Сүүлийн жилүүдэд уул уурхайн бус экспортын нийт экспортод эзлэх хувь буурч, экспортын зах зээлийн төвлөрөл³ нэмэгдэн, бүтээгдэхүүний төрөлжилт⁴ буурч, улмаар экспортын өрсөлдөх чадвар муудах хандлагатай байна. Тухайлбал, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт 2003 онд нийт экспортын 43 хувийг бүрдүүлж байсан бол 2021 оны байдлаар 7 хувь болжээ (Зураг 5). Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-с гаргасан судалгаанаас харахад манай улсын экспортын төвлөрлийн индекс 2003-2019 оны хооронд 2.5 дахин өсөж, экспортын хувьд цөөн улсаас хамааралтай байдал нэмэгдэж байгааг онцолсон байна (Зураг 6). Мөн Дэлхийн банкны “Doing Business-2020” судалгаанаас харахад Монгол Улс гадаад худалдаа эрхлэх, хил дамнасан худалдааны үзүүлэлтээр 60.8 оноогоор дэлхийн 190 орноос 143-т эрэмбэлэгдэж байна. Энэ нь 2016 оны үзүүлэлттэй харьцуулахад 21 хувиар буурч, 69 байраар ухарсан үзүүлэлт болж байна.


³ НҮБ-аас тооцдог энэхүү индекс нь экспортын түнш орнуудын худалдааны төвлөрлийг илэрхийлдэг бөгөөд маш цөөхөн зах зээлд төвлөрсөн худалдаа бүхий улс 1-тэй ойролцоо, харин олон зах зээлд төвлөрсөн худалдааны бүтэцтэй улсын индекс 0-тэй ойролцоо байна.

⁴ Манай Улс 2019 оны байдлаар 0.85 индексийн утгатай буюу худалдааны бүтэц дэлхийн дунджаас ихээхэн ялгаатай байна. Өөрөөр хэлбэл, дэлхийн бусад орны худалдааны бүтэцтэй харьцуулахад бүтээгдэхүүний төрөлжилт багатайг харуулж байна.

Зураг 5. Монгол Улсын нийт экспортын бүтэц



Зураг 6. Монгол Улсын экспортын зах зээлийн төвлөрлийн индекс



Эх сурвалж: ГЕГ, Монголбанк Эх сурвалж: Herfindahl-Hirschman market concentration index, UNCTAD

Манай улсын экспортын орлого 2003 онд голлох 15 нэр төрлийн бүтээгдэхүүнээс бүрдэж байсан бол 2021 онд 25 нэр төрлийн бүтээгдэхүүнээс бүрдэх болжээ. Энэ хугацаанд бүтээгдэхүүний нэр төрлийн хувьд нэмэгдсэн хэдий ч нэг бүтээгдэхүүний орлогоос хамаарах хамаарал нь уул уурхайн салбарын бүтээгдэхүүний хувьд улам нэмэгдэж байна⁵. Бүтээгдэхүүний төрөлжилтийг нэмэгдүүлэх ажлуудын хувьд хөдөө аж ахуйн салбарын тэр дундаа мал, мал аж ахуйн түүхий эд, түүгээр хийсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх боломжтой гэсэн дүгнэлтүүд гарч байна. Тухайлбал, арьс шир, түүгээр хийсэн бүтээгдэхүүн, ноос, ноолуур, сүлжмэл зэрэг уул уурхайн бус салбарын бүтээгдэхүүн нь бусад бүтээгдэхүүнтэй харьцуулахад экспортыг нэмэгдүүлэх боломжтой, харьцангуй давуу талтай бүтээгдэхүүнүүд болж байна (Хүснэгт 2).

⁵ Б.Ананд, Э.Хулан, 2022. Уул уурхайн бус салбарын экспортыг нэмэгдүүлэх боломжийн талаарх санал, зөвлөмж.

Хүснэгт 2. Экспортыг нэмэгдүүлэх боломжтой бүтээгдэхүүн, судалгааны үр дүнгүүдийн огтлоолцол

Бүтээгдэхүүний төрөл \ Аргачлал	RCA индекс	НН индекс	ЕСI индекс	Эдийн засгийн төрөлжилтийн индекс	Гарцын загвар	Огтлоолцол
1. Адууны мах					2	
2. Альбуминойдын бодис					1	
3. Амьтны үс					2	
4. Арьс шир, түүгээр хийсэн зүйлс					4	
5. Боловсруулсан арьс шир					1	
6. Газрын тос;					2	
7. Газрын тосны олборлолт					1	
8. Даавуу					1	
9. Карт					1	
10. Max					2	
11. Max түүгээр хийсэн бүтээгдэхүүн					1	
12. Металлын хүдэр					1	
13. Модны цеплполоз					1	
14. Ноос					4	
15. Ноос ноолуур, сүлжмэл					3	
16. Нүүрс					1	
17. Нэхмээлийн утас					1	
18. Савхи					1	
19. Түлш					1	
20. Үйлдвэрийн машин, эд ангиуд					1	
21. Үнс хөө					1	
22. Үнэртэн гоо сайхны бэлдмэл					1	
23. Үхрийн мах					2	
24. Химийн гаралтай бүтээгдэхүүн					1	
25. Хүдэр					1	
26. Цаас цаасан бүтээгдэхүүн					1	
27. Цавуу					1	
28. Эмийн бүтээгдэхүүн					1	
	Б.Түвшинтөгс нар (2015)	Б.Цэнгүүнжав, Б.Мөнхзул (2015)	Л.Даваажаргал, Б.Хүслэн (2017)	Ц.Бямбацогт (2019)	Ц.Бямбацогт, Д.Цэнддорж (2017)	

Иймд уул уурхайн бус экспортыг дэмжих бодлогыг нэгтгэх, санхүүжилтийн хүртээмжтэй тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээг тодорхойлох, аж ахуйн нэгжүүдийн саналыг авах зорилгоор “Уул уурхайн бус экспортлогчдын түүвэр судалгаа”⁶-г Монголбанк Монголын Үндэсний Худалдаа Аж үйлдвэрийн танхимтай хамтран гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнгээс үзэхэд *уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэхэд саад болж буй гол хүндрэлээр* экспортыг дэмжих санхүүжилт, түүхий эдийн өртөг, валютын ханшийн хэлбэлзэл зэргийг нэрлэж байна. Түүнчлэн, бодлого боловсруулагчдын зүгээс нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний хувьд 1) хилийн тээврийн зохицуулалтыг сайжруулах, 2) экспортын зах зээлийг хөгжүүлэх буюу сурталчлан таниулах, 3) чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг хийх, 4) санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг санал болгожээ (Зураг 8).

⁶ Тус түүвэр судалгаанд нийт 157 аж ахуйн нэгж хамрагдсан бөгөөд 2021 онд уул уурхайн бус бүтээгдэхүүн экспортолсон 540 аж ахуйн нэгжийн 29% болж байна.

Зураг 7. Экспортыг нэмэгдүүлэхэд саад болж буй хүндрэлүүд



Зураг 8. Уул уурхайн бус экспорттыг нэмэгдүүлэхийн тулд авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний санал



Эх сурвалж: Монголбанк, Уул уурхайн бус экспортлогчдын түүвэр судалгаа-2022

Бусад орны туршлагаас харахад худалдаа эрхлэгчид зээлийн уламжлалт санхүүжилтээс гадна худалдааны эрсдэл бууруулах, шуурхай худалдааны санхүүжилтийг түлхүү ашиглаж байна. Дэлхийн худалдааны байгууллагын тооцооллоор дэлхийн нийт гадаад худалдааны 80 орчим хувь нь худалдааны санхүүжилтийн хэрэгслүүдийг ашигладаг. Ялангуяа, худалдааны санхүүжилт нь бага болон дунд орлоготой орнуудын худалдааны эргэлтийг тэлэх гол хөшүүрэг болдог. Худалдааны санхүүжилтийн хүртээмжтэй байдал нь тухайн улсын гадаад худалдааг дэмжих замаар эдийн засагт эргээр нөлөөлж, эдийн засгийн өсөлт нь эргээд худалдааны санхүүжилтээ дэмждэг байна.

Олон улсад гадаад худалдааны санхүүжилтийн төрөлжсөн үйлчилгээг банкууд, хөгжлийн банк эсвэл экспорт-импортын банк, экспорттын зээлийн батлан даалтын сан зэрэг байгууллагууд хэрэгжүүлж байна. Тухайн худалдааны санхүүжилт хариуцсан агентлагууд нь гадаад худалдаа эрхлэгчдэд аккредитив үйлчилгээ, борлуулалтаас үүссэн богино хугацаат өглөг, авлагад баталгаа гаргах, урьдчилгаа төлбөрийн санхүүжилт олгох, ачилтын баримтад үндэслэн төлбөр нэхэмжлэх зэрэг үйлчилгээг үзүүлж гадаад худалдаанд үүсэж болзошгүй тодорхой бус байдал, эрсдэлийг бууруулахын зэрэгцээ гадаад худалдааны эргэлтийг шуурхай, тасралтгүй болгоход дэмжлэг үзүүлдэг. Худалдааны санхүүжилтийн дээрх хэрэгслүүдийн ашиглалт улс орнуудын хувьд ялгаатай хэдий ч, дунджаар 52 хувь нь аккредитив болон гадаад баталгааны төрлийн үйлчилгээ байдаг бол үлдсэн 48 хувийг импорт, экспорттын зээлийн санхүүжилт бүрдүүлдэг байна.

Бусад улс орнуудад нийтлэг хэрэглэгдэг худалдааны санхүүжилтийн хэрэгслүүдэд аккредитив⁷,

⁷ Аккредитив нь экспортлогчийн хувьд импортлогчийн төлбөрийн чадвараас үл хамааран бараагаа үйлдвэрлэх, худалдан авагч тал руу ачуулах, харин импортлогчийн хувьд экспортлогч орноос бараа ачигдсаны дараа эсвэл бараагаа хүлээн авсны дараа төлбөр шилжүүлэх боломж олгодог хэрэгсэл юм.

инкасс⁸, баталгаа⁹, форфайтинг¹⁰, факторинг¹¹, гадаад худалдааны зээл, худалдааны зээлийн даатгал зэрэг багтаж байна. Манай банкуудын хувьд худалдааны санхүүжилтийн төрлүүдээс баримтын аккредитив, банкны баталгаа, баримтын инкасс, гадаад худалдааны зээл гэсэн худалдааны санхүүжилтийн хэрэгслүүдийг ашиглаж байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Банкуудын худалдааны санхүүжилтийн ашиглалт

Худалдааны санхүүжилтийн төрөл	Баримтын аккредитив	Банкны баталгаа	Баримтын инкасс	Гадаад худалдааны зээл	Импортын факторингийн үйлчилгээ	Экспортыг дэмжих төслийн зээл
Хаан банк	✓	✓	✓	✓		✓
ХХБ	✓	✓	✓			
Голомт	✓	✓	✓	✓	✓	
Хас банк	✓	✓				
Төрийн банк	✓	✓	✓	✓		

Манай орны хувьд гадаад худалдааны санхүүжилт нь худалдааны эргэлтийг дэмжих гол хэрэгслүүдийн нэг байх боломжтой. Салбаруудын санхүүжилтийн байдлыг харахад уул уурхайн салбар нь гадаад эх үүсвэрээр голлон санхүүжиж байгаа бол уул уурхайн бус салбарын хувьд дотоодын эх үүсвэрээр, тэр дундаа банкны зээлээр голлон санхүүжиж байна (Зураг 9).

Зураг 9. Салбаруудын санхүүжилтийн суваг



Эх сурвалж: Монголбанк (2021)

Гэхдээ уул уурхайн бус салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийн хуриатлал дутмаг, барьцаа хөрөнгө хангалтгүй зэргээс шалтгаалан худалдааны санхүүжилтийн хүртээмж сүл хэвээр байна. Тухайлбал, экспортын санхүүжилт нь банкуудын зээлийн нийт багцын 0.5%-ийг эзэлж байна¹². Мөн 2022 оны эхний хагас жилийн байдлаар Монголбанкны репо санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд 113.4 тэрбум төгрөг олгосны 9.4 хувь нь уул уурхайн бус экспорт болон боловсруулах үйлдвэрлэлийн салбарт олгогдоод байна.

⁸ Инкасс нь банк эсвэл худалдааны санхүүгийн мэргэшсэн байгууллага худалдагчийн өмнөөс худалдан авагчид баримт хүргүүлж төлбөр нэхэмжлэн авах ажиллагаа.

⁹ Банкны/Зээлийн баталгаа (letter of credit) нь банк эсвэл худалдааны санхүүгийн мэргэшсэн байгууллагаас баталгаага хүлээн авагчийн өмнө хүлээж буй баталгаа гаргуулагчийн төлбөрийн болон ажил үйлчилгээний үүргийн биелэлтийг баталгаажуулж, тодорхой мөнгөн дунгээр төлбөрийн үүрэг хүлээсэн баримт юм.

¹⁰ Форфайтинг (forfaiting) нь экспортлогчдод дунд болон урт хугацааны гадаад авлагаяа форфайтерт хөнгөлөлттэй үнээр зарж бэлэн мөнгө авах боломжийг олгодог.

¹¹ Факторинг (factoring) Форфайтингтай төстэй бөгөөд нэмэлт төлбөрөөр худалдааны аюулгүй байдлыг нэмэгдүүлж, эрсдэлээ бууруулах боломжийг олгодог.

¹² MYXAYT, 2020. Монголын ЖДҮ-ийн экспортын санхүүжилт.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниуд, банкууд, аж ахуйн нэгжүүд хамтран олон улсын жишгийн дагуу худалдааны даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх боломжийг эрэлхийлэх, ач холбогдлыг таниулах арга хэмжээг авч эхлээд байна. Иймд уг санаачилгыг төрийн эрх бүхий байгууллагууд өөрийн чиг үүргийн хүрээнд судалж, зах зээлд амжилттай нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах шаардлагатай байна. Үүнтэй адилаар олон улсад нийтлэг хэрэглэгддэг боловч Монгол Улсад нэвтрээгүй эсвэл төдийлөн ашиглагдахгүй байгаа худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж, хөгжүүлэх хэрэгцээ зүй ёсоор тавигдаж байна. Ийнхүү шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлснээр аж ахуйн нэгжүүд эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг шуурхай авч, үйл ажиллагаагаа санхүүгийн хувьд илүү үр ашигтай явуулах, цаашид тэлэх боломж нэмэгдэж, санхүүгийн хүртээмж дээшлэх суурь нөхцөл бүрдэнэ.

Хүснэгт 4. Үйл уурхайн бус экспортлогчдоо тулгарч буй гол саад бэрхшээл, шийдвэрлэх арга замууд

№	Үйл уурхайн бус экспортлогчдоо тулгарч буй голлох саад бэрхшээл	Шийдвэрлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага
1	Санхүүжилтийн асуудал	<ul style="list-style-type: none"> - Санхүүжилтийн хүртээмжтэй тогтолцоог бий болгох - Салбарын онцлогт тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэрэгслүүдийг нэвтрүүлэх - Гадаад шилжүүлгийг найдвартай, шуурхай гүйцэтгэх 	Монголбанк, Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо, Хувийн хэвшил
2	Тээврийн зардал, логистикийн асуудал	<ul style="list-style-type: none"> - Хилийн тээвэрлэлтийн үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах - Хилийн ачаа нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх - Олон талт тээврийн үйл ажиллагааг бий болгож, хөгжүүлэх 	Засгийн газар, Хувийн хэвшил
3	Ханшийн хэлбэлзлээс үүдэлтэй түүхий эдийн өртөг, түүхий эдийн олдцын асуудал	<ul style="list-style-type: none"> - Гадаад валютын орох урсгал бага үед төсвийн тэлэлтийг багасгаж, гадаад валютын ханшийн хэлбэлзлийг бууруулах - Экспорт, алтны худалдан авалтыг нэмэгдүүлэх замаар гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх - Уул уурхайн салбарын экспортын гадаад валютын орлогыг уул уурхайн бус салбарыг хөгжүүлэхэд зориулах - Найдвартай түнш олоход зуучлах 	Монголбанк, Засгийн газар, Хувийн хэвшил
4	Өрсөлдөх чадвар, тарифын болон тарифын бус саад бэрхшээл	<ul style="list-style-type: none"> - Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чанар, стандартыг сайжруулах - Олон улсын стандарт бүхий лабораторийг байгуулах - Чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг хийж, худалдааны таатай нөхцөлийг бүрдүүлэх, квотын дэмжлэг үзүүлэх - Гадаад худалдааны таатай татварын тогтолцоог бүрдүүлж, татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх 	Засгийн газар, MYXAYT, Хувийн хэвшил

5	Гадаад зах зээлийн эрэлт, маркетингийн асуудал	<ul style="list-style-type: none"> - Гадаад зах зээлийн судалгааг хийхэд дэмжлэг үзүүлэх - Олон улсын стандартыг хангасан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх - Гадаад зах зээлийн маркетингийг эрчимжүүлэх, үндэсний онцлогийг илтгэсэн брэндийг бий болгох шаардлагатай арга хэмжээг авах - Гадаад зах зээл дээрх борлуулалтын олон төрлийн сувгийг бий болгох 	Засгийн газар, MYXAYT, Хувийн хэвшил
6	Зөвшөөрөл, лиценз, лавлагаа, гэрчилгээ олгохтой холбоотой асуудлууд	<ul style="list-style-type: none"> - Зөвшөөрөл олголтын үйл ажиллагааг хялбаршуулах 	Засгийн газар
7	Ажилчдын ур чадвар, туршлагатай холбоотой асуудал	<ul style="list-style-type: none"> - Ажилчдыг сургах, олон улсын туршлага судлах, мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх - Бүтээгдэхүүний судалгаа, хөгжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх 	Засгийн газар, MYXAYT

Эх сурвалж: Монголбанк, Уул уурхайн бус экспортлогчдын түүвэр судалгаа-2022

Стратеги

Уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хүртээмжтэй санхүүгийн тогтолцоог бүрдүүлж, гадаад худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхэд банкууд, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Уул уурхайн бус экспортлогчдыг дэмжих зорилгоор санхүүгийн хүртээмжтэй тогтолцоог бий болгох талаар банк, санхүүгийн бусад байгууллагууд аж ахуйн нэгжүүд холбогдох төрийн байгууллагуудтай хамтрах, санхүүжилтийн тогтолцоог сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох;
- Уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болох санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэрэгслүүдийг нэвтрүүлэх, сайжруулах боломжийн талаар судлах;
- Экспортын болон худалдааны зээлийн даатгалын хэрэглээг нэмэгдүүлэх, улмаар аж ахуйн нэгжүүдийн зээлжих чадварыг сайжруулах чиглэлээр цуврал уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, уг хамтын ажиллагааны үр дүнд үндэслэн оролцогч талуудад харилцан ашигтай боломжтой санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, үе шаттайгаар нэвтрүүлэх;
- Экспортыг дэмжиж, гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлд худалдааны чөлөөт бүсийг хөгжүүлэх
- Төрийн худалдан авалтыг зохион байгуулахдаа үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих

5/ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг үндэсний хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэх

Үндэслэл

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд 2007, 2017 онуудад харилцан үнэлгээг хийсэн.

Монгол Улсын Харилцан үнэлгээний тайландаа манай улсыг үндэсний хэмжээний мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, стратегийн баримт бичигтэй болж, ФАТФ-ын Зөвлөмж 1-т заасан улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ үнэлэх, Зөвлөмж 2-т заасан эрсдэлийн үнэлгээний үр дүнд сууринласан үндэсний бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага тавьсан.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 143 дугаар тогтооолоор 2017-2019 онд хэрэгжүүлэх “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд төр, хувийн хэвшлийн байгууллагууд хамтран хөтөлбөрийг хэрэгжүүлж дууссан. Улмаар ФАТФ-ын Зөвлөмж 1-ийн шаардлагын дагуу Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу 2020-2021 онд хоёр дахь удаагаа хийсэн бөгөөд ФАТФ-ын Зөвлөмж 2-т заасны дагуу Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх шаардлага тулгарсан.

Иймд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх, дараагийн шатны харилцан үнэлгээнд амжилттай үр дүн үзүүлэх, олон улсын байгууллагын хориг жагсаалтад орохгүй байх зорилгоор Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 265 дугаар тогтооолоор баталсан.

Хөтөлбөрийн эрхэм зорилго нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх тогтолцоог олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэн боловсронгуй болгох явдал юм. Хөтөлбөрийг 8 зорилго болон 48 зорилтын дагуу 2022-2030 оны хооронд үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бөгөөд олон улсын стандартын шаардлагыг хангах, Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлж, сайжруулах арга хэмжээг багтаасан.

Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 265 дугаар тогтоолын дагуу Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Үндэсний зөвлөлөөс баталж, хэрэгжилтэд хяналт тавихыг үүрэг болгосон. Иймд Хөтөлбөрийг арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсний үр дүнд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо бэхжиж, эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа амжилттай хэрэгжиж, улс орны эдийн засгийн хөгжил, санхүүгийн салбарын тогтвортой байдалд зерэг нөлөө үзүүлнэ.

Түүнчлэн, энэхүү хөтөлбөрөөр дамжуулан Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтооолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтооолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтооолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ач холбогдолтой.

Стратеги

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран үндэсний хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэх,
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэг, хариуцлага, эрсдэлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх.
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх.
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлд сууринсан бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- Мэдээлэх үүрэгтэй этгээдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэрэгт холбогдооос урьдчилан сэргийлэх.
- Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлж болзошгүй үйлдлийг таних, мөнгө угаах үйлдлийг илрүүлэх ажиллагааг сайжруулах.
- Суурь гэмт хэрэг нь эрсдэлтэй гэж үнэлсэн мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах, шүүхээр шийдвэрлэх болон хөрөнгө хураахтай холбоотой ажиллагааны чанарыг сайжруулах.
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зохистой бүтэц, зохион байгуулалт, чадавхыг бэхжүүлэх.

6/ Тогтвортой, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх чиглэлд батлагдсан бодлого, хөтөлбөрийг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх

Монгол Улсын хувьд байгаль орчинд ээлтэй, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалсан, иргэдийн оролцоог хангасан цогц эдийн засгийг бүрдүүлэх зорилгын хүрээнд “Ногоон хөгжлийн бодлого”, “Алсын харах-2050”, НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилт (TX3)-2030”, Парисын хэлэлцээрийн “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр” (YTXH) зэрэг үндэсний болон олон улсын баримт бичиг, үүрэг амлалтуудыг соёрхон баталсан.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн тооцоолсноор Монгол Улс 2030 он гэхэд үндэсний хэмжээнд тодорхойлсон TX3-уудыг биелүүлэхийн тулд 126 их наяд төгрөг (44.2 тэрбум ам.доллар) буюу жил тутам 12.6 их наяд төгрөг (4.42 тэрбум ам.доллар)-ийн нэмэлт зардал гаргах шаардлагатай бөгөөд энэ нь дунджаар жилийн ДНБ-ий 18 хувьтай тэнцэж байна¹³. YTXH-ийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хүлэмжийн хийн ялгарал (ХХЯ)-ыг 2030 он гэхэд 22.7 хувиар бууруулах зорилт тавьсан бөгөөд тус зорилтыг хангахын тулд ойролцоогоор 30.3 их наяд төгрөг шаардлагатай¹⁴. Эдгээр санхүүжилтийг дан төсвийн хөрөнгө оруулалт болон гадаадын зээл тусламжаар санхүүжүүлэх боломжгүй тул хувийн секторын хөрөнгө оруулалтыг татан оролцуулах, нэмэгдүүлэх шаардлага ойрын жилүүдэд бий болж байна. Гэсэн хэдий ч тогтвортой, ногоон бизнес нь “хүрэн бизнес”-тэй харьцуулахад өртөг өндөр тул өрсөлдөх боломжгүй байдгаас өртөг, үнийн зөрүүг тэнцвэржүүлэх зорилгоор “карбон татвар”-ийг орнууд ашиглахад хүрдэг. Манай улсын хувьд ч энэ чиглэлээр татварын тогтолцоогоо өөрчлөх ажлыг эхлүүлэхгүй бол тогтвортой, ногоон санхүүжилтийг цаашид нэмэгдүүлэхд хүндрэл учрахаар байна. Манай орны хувьд уур амьсгалын сөрөг нөлөөг бууруулах, ХХЯ-ыг багасгах, шингээлтийг нэмэгдүүлэх зорилготой гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлсэн томоохон төслүүд нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэхд илүүтэй чиглэжээ. Гэсэн хэдий ч Сэргээгдэх эрчим хүчний хуульд зааснаар салхи болон нарны эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх эрчим хүчний үнэ харгалзан 0.085 болон 0.12

¹³ НҮБ-ын Хүүхдийн хөтөлбөр, 2021. Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлын тухай баримт бичгийн төсөл (шинчлэгдэж буй).

¹⁴ Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2020. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт.

ам.доллар/кВт.цаг байгаа нь нүүрсээр ажилладаг цахилгаан станцуудын дундаж зардалтай харьцуулахад өндөр дүн юм. Үүнтэй холбоотойгоор, сэргээгдэх эрчим хүчийг одоогийн суурилуулсан чадлаас бага хэмжээгээр ашиглаж байгаа бөгөөд цаашид ч байгаль орчинд ээлтэй ногоон бизнес эрхлэх, үйл ажиллагаа явуулах нь хүрэн бизнестэй харьцуулахад өрсөлдөх чадвар сул, өртөг өндөртэй байсаар байх тохиолдолд хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын сонирхлыг бууруулна.

Эдгээр хүндрэл бэрхшээл, шаардлагатай санхүүжилтийн хэрэгцээг дан ганц төсвийн санхүүжилт, гадаадын зээл, тусламжаар хангах боломжгүй тул эдийн засгийн бүхий л салбарт ногоон бизнесийг дэмжихэд чиглэсэн татварын орчныг бүрдүүлэх нь дунд, урт хугацаанд тогтвортой, ногоон хөгжлийн зорилтуудыг хангахад том түлхэц өгөх бодлогын арга хэмжээ болохыг бусад орны туршлага нотолсоор байна. Тухайлбал, байгаль орчин болон эдийн засгийн үр ашигт байдлыг харгалзаж үзвэл нүүрстөрөгчийн үнэ (carbon pricing)-ийг тогтоо замаар шатах ашигт малтмал (fossil fuel)-ын үнийг нэмэгдүүлэх нь сөрөг нөлөөллийг бууруулах стратегийн гол арга хэмжээ юм. Ингэснээр айл өрх, үйлдвэрүүдэд хүлэмжийн хийн бохирдлоо бууруулах сэдлийг төрүүлэхээс гадна байгаль орчинд ээлтэй бусад эрчим хүчний эх үүсвэрийг эрэлхийлэх хөшүүрэг болно. Түүнчлэн, нүүрстөрөгчийн үнийн бодлогыг хэрэгжүүлснээр олох орлогыг бусад эдийн засгийн үр ашигтай төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх боломж бүрдэнэ. Олон улсад 2008 онд Канад улсын Бритиш Колумбия мужийн баталсан нүүрстөрөгчийн татварын бодлого нь шилдэг туршлагаар нэрлэгддэг. Тухайн мужид өрх гэр болон үйлдвэрүүдийн шатах түлшний хэрэглээнд нь жигд татвар ноогдуулсан бөгөөд 1 тонн нүүрстөрөгчид оногдох татварын хэмжээ нь 2008 онд 10 ам.доллар байсан бол 2012 онд 30 ам.доллар болж аажмаар нэмэгджээ. Энэ бодлого нь эдийн засгийн өсөлт, хөгжилд нь сөрөг нөлөө багатайгаар тус мужийн ХХЯ-ийг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулж чадсан байна. Мэдээж үүнээс гадна УАӨ-тэй холбоотой хууль эрх зүйн орчныг сайжруулах, оролцогч талуудын уялдаа, хамтын ажиллагааг сайтар хангах, хүлэмжийн хийн татвар, хураамжийг нэмэгдүүлэх, үнийн тохируулга хийх замаар ногоон бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, утаяа бага ялгаруулдаг технологийн талаарх судалгаа, хөрөнгө оруулалтыг дэмжих, зах зээлд оролцогчид, олон нийтийг зөв мэдээллээр хангах зэрэг арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай.

Монголбанкны зүгээс тогтвортой, ногоон санхүүжилтийг дэмжих, санхүүгийн салбарт үзүүлэх уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг тодорхойлох, тооцох, удирдах тухай ойлголтыг тодорхой болгох үүднээс 2019, 2022 оны Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд тусгайлан заалт оруулан холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн. Энэ хүрээнд 2019 оны 12 сард Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-өөр ногоон үйл ажиллагааны ангилал зүй болох “Ногоон таксономи”-г баталж, 2020 оны 1 дүгээр улирлаас эхлэн ногоон зээлийн статистикийг арилжааны банкуудаас авч нэгтгэн, олон нийтэд мэдээлж байна. Мөн 2022 оны 3 сард СТБЗ-өөр “Үндэсний тогтвортой санхүүгийн замын зураг” баталж 2030 он гэхэд банкны болон банкнаас бусад санхүүгийн байгууллагын олгосон нийт зээлийн багцад ногоон зээлийн эзлэх хэмжээг харгалзан 10 болон 5 хувьд хүргэх зорилтыг дэвшижүүлээд байна.

Энэхүү замын зургаар Монголбанкны хяналт шалгалтын чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж эхлэх 5 жилийн төлөвлөгөөг доорх байдлаар баталсан.

Эхний гурван жилд буюу I-3 дахь жилийн төсөл:

- Банкуудаас ногоон/тогтвортой хөгжлийн таксономитой нийцүүлэн зээлийн статистик мэдээллийг авах;
- Банкуудын тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтэд хяналт тавих, мониторинг, үнэлгээний тогтолцоог бий болгох;
- Уур амьсгалын эрсдэлийн удирдлагын журам, шаардлагыг судлах, нэвтрүүлэх,
- Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал боловсруулах ажил хийгдэнэ.

Эхний 3 жилийн үр дүнд үндэслэн хөтөлбөрийн 3-5 дахь жилүүдэд ногоон, тогтвортой хөгжлийн зээл олголтыг дэмжих зорилгоор банкны үйл ажиллагаанд тавигдах шаардлагуудад өөрчлөлт оруулах талаар судлахаар төлөвлөж батлуулсан.

Одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 2.16-т зааснаар Монгол Улсын Засгийн газар, “А”-с доошгүй үнэлгээ бүхий зээлжих зэрэглэлтэй этгээд, олон улсын хөгжлийн банкууд болон санхүүгийн байгууллагуудаас баталгаа, батлан даалт гаргасан тохиолдолд эрсдэлээр жигнэх активын үлдэгдэлд баталгаа, батлан даалтын дүнгээр цэвэршүүлэлт хийх боломжтой.

Цаашид “Ногоон зээл”-ийг дэмжих боломж нь дараах урьдаач нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд эрсдэлээр жигнэх хувийг нь бусад (хүрэн) активаас ялгамжтай тогтоох явдал болж байна. Үүнд:

- “Ногоон зээл”-ийн эрсдэлээр жигнэх хувийг тухайн активын улмаас банкны хүлээх эрсдэлд үндэслэн тогтоох, энэ зорилгоор “ногоон зээл”-ийн эрсдэлийг үнэлэх;
- Эрсдэлийн дун шинжилгээ хийхэд хангалттай хугацаан цуваа бүхий тоон мэдээллийг цуглуулах;
- “Ногоон зээл”-ийн эрсдэлийн түвшинд зайнаас хяналт тавих, үнэлгээ хийх тогтолцоог бий болгох;
- Уур амьсгалын, “Ногоон зээл”-ийн эрсдэлийн удирдлагын аргачлал боловсруулах.

Түүнчлэн, “Хөгжлийн санхүүжилтийн олон улсын гуравдугаар чуулга уулзалт”-аас улс орнууд “Үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцоо” (YCHT)-г нэвтрүүлэх, улмаар санхүүжилтээ хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэйгээ уялдуулан үр дүнтэй ашиглах, санхүүгийн шинэ урсгал, тэр дундаа хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зөвлөмж гаргасан¹⁵. YCHT-г өөрийн улс орны онцлог нөхцөл байдал, тогтвортой хөгжлийн тэргүүлэх чиглэлд нийцүүлэн Европын холбоо болон НҮБ-ын ТХЗ хэрэгжилтийг дэмжих хамтын сан (UN Joint SDG Fund)-гийн санхүүжилтээр дэлхий даяар 80 гаруй орон хөгжүүлж буйн нэг нь манай улс юм. Энэ хүрээнд Сангийн яамны удирдлага дор НҮБ-ийн холбогдох түншүүдтэй хамтран Монгол Улсын YCHT-ийн төслийг боловсруулан, батлуулахаар ажиллаж байна. Мөн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон бусад хөгжлийн түншүүдийн дэмжлэгтэйгээр Ногоон таксономиг өргөжүүлэн, ТХЗ-уудтай уялдсан байгаль орчин, нийгэмд эерэг үр нөлөө үзүүлдэг эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, тусгайлсан шалгуур үзүүлэлт, баталгаажуулалтын аргачлал бүхий Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн таксономиг боловсруулж байна.

Стратеги

- Монгол Улсын Засгийн газар тогтвортой, ногоон бизнесийг дэмжих татварын зохистой орчныг бүрдүүлэхэд шаардлагатай суурь судалгаа хийж, бодлогын зөвлөмжийг тодорхойлох.
- Монгол Улсын дунд ба урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтуудтай уялдуулан “Үндэсний тогтвортой санхүүгийн замын зураг”-д тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх.
- Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн стратеги, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, санхүүгийн салбарт нэвтрүүлэх.
- Төрийн байгууллага, институцууд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийг бууруулах чиглэлээр нягт уялдаатай хамтран ажиллах.

¹⁵ Хөгжлийн санхүүжилтийн олон улсын гуравдугаар бага хурлын Аддис Абебагийн Үйл ажиллагааны хөтөлбөр, 2015.

- Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой санхүүжилтийн ойлголт, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, олон нийтийн анхаарлыг нэмэгдүүлэх.
- Тогтвортой санхүүжилтийн хүрээнд гадаад зах зээлээс эх үүсвэр босгох чиглэлээр ажиллах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Тогтвортой, ногоон бизнесийг дэмжих татварын зохистой орчныг бүрдүүлэхэд шаардлагатай суурь судалгааг Засгийн газрын түвшинд хийж, бодлогын зөвлөмжийг тодорхойлох.
- “Үндэсний тогтвортой санхүүгийн замын зураг”-д тусгагдсан арга хэмжээнүүдийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.
- Төрийн байгууллагууд уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг бууруулах чиглэлээр нягт уялдаатай хамтран ажиллах, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад харгалзан үздэг болох.
- Бодлого арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх, үүн дээр үндэслэн дараагийн шатны төлөвлөгөө боловсруулан, арга хэмжээг авах.
- Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан байгаль орчин, нийгэмд эерэг үр нөлөө үзүүлдэг эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, тусгайлсан шалгуур үзүүлэлт, баталгаажуулалтын аргачлал бүхий Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн таксономийг боловсруулан, батлуулах.
- Тогтвортой санхүүжилтийг санхүүгийн байгууллагад амжилттай сайн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Төв банк, Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс авч хэрэгжүүлэх боломжтой хөшүүргийн арга хэрэгслүүдийг судалж нэвтрүүлэх.
- Банк, банк бус санхүүгийн салбарын статистик тайлан мэдээллийг хүйсээр ангилан нийтэд мэдээлэх, жендерийн мэдрэмжтэй санхүүжилтийн тогтолцоо бүрдүүлэх чиглэлд салбарын холбоод, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах.
- Тогтвортой санхүүжилтийн талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх чиглэлээр судалгаа, шинжилгээ хурал уулзалтыг дэмжиж ажиллах.

7/ Санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор иргэд, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны төслийг боловсруулж, хэрэгжүүлэх

Үндэслэл

Сүүлийн жилүүдэд банк, санхүүгийн салбарын өсөлт эрчимжиж, хүн амын дунд санхүүгийн бүтээгдэхүүний хэрэглээ эрс нэмэгдэж байна. Хэдий тийм боловч иргэдийн дунд санхүүгийн мэдлэг, санхүүгийн бүтээгдэхүүний талаар ойлголт дутмаг байгаагаас өөрсдийн хэрэгцээнд тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг сонгож, урт хугацааны санхүүгийн шийдвэр гаргахад нь хүндрэл тулгарах асуудал байсаар байна. Энэхүү ажлын хүрээнд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, БСШУЯ-ны хамтарсан тушаалаар батлан 2016 оноос хойш хэрэгжүүлээ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад голлон хийсэн ажлыг дурдвал: Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад санхүүгийн мэдлэг олгох “Бизнес судлал” хичээлийг судлуулах Боловсролын сайдын 2016 оны 6-сарын 27-ны А/275 тоот тушаалаар батлагдсан “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” шийдвэр гарч, уг хичээлийн сурх бичиг, багшийн номыг мэргэжлийн баг бүрэлдэхүүнээр гүйцэтгүүлж, дараах сурх бичиг, гарын авлагуудыг боловсруулсан. Үүнд:

1. Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр «Бизнес судлал» (2016 он)
2. ЕБС-ийн Х ангийн “Бизнес судлал” хичээлийн сурах бичиг (2017 он)
3. ЕБС-ийн Х ангийн “Бизнес судлал” хичээлийн багшийн ном (2017 он)
5. ЕБС-ийн XI ангийн “Бизнес судлал” хичээлийн сурах бичиг (2017 он)
5. ЕБС-ийн XI-XII ангийн “Бизнес судлал” хичээлийн багшийн ном (2018 он)

Мөн ЕБС-ийн I-V, VI-IX ангийн сурагчдад санхүүгийн суурь мэдлэг олгох багшид зориулсан заах аргын зөвлөмж боловсруулав. 2018 онд хэвлэгдсэн “Бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй –III” сургалтын гарын авлагад “Бизнес судлал” хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн үндэсийг тусгасан.

Тус хөтөлбөрийн 2019 онд хийсэн явцын үнэлгээний тайланда уг хичээлээр дамжуулан ЕБС-ийн сурагчдад санхүүгийн мэдлэг олгох багшийн үйл ажиллагааг дэмжих, тэдний заах арга зүйг дээшлүүлэх, сурагчдад мэдлэг, чадвар, санхүүгийн шийдвэр гаргах зөв шийдвэр гаргах зөв хандлагыг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой болсонг онцолж, ЕБС-ийн сурагчдад санхүүгийн мэдлэг олгох хичээлийг аль болох багаас нь заах, ахлах ангид сонгон судлах “Бизнес судлал” хичээлийн агуулгаас ерөнхий эрдмийн шалгалтын асуултад оруулах зөвлөмж гаргасан.

Иймд зөвлөмжийн дагуу Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн сургалтын төлөвлөгөөнд санхүүгийн мэдлэг олгох анхан шатны агуулгыг оруулах шаардлагатай гэж үзэж байна.

Санхүүгийн сахилга батад төлөвшөөгүй насанд хүрэгчдийн хувьд чадавх, хандлагыг өөрчлөхөд хугацаа их зарцуулагддаг. Тиймээс санхүүгийн мэдлэгийн суурь ухагдахууныг бага насанд нь эзэмшүүлэх зорилгоор ерөнхий боловсролын хөтөлбөрт тусгах нь ирээдүйд нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдолтой юм.

Санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд иргэдийн санхүүгийн зах зээлд ухаалгаар оролцох оролцоог нэмэгдүүлэх, санхүүгийн бүтээгдэхүүний хүртээмжийг дээшлүүлэх дараагийн үе шат болох Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны төслийг Засгийн газар, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл хамтран хэрэгжүүлэх шаардлага үүсч байна.

Дээрх төслийг дараах 5 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ. **1) сургуулийн насынханд, 2) залуу үеийнхэнд, 3) хөдөө орон нутгийн иргэдэд, 4) цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох 5) Бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн мэдлэг олгох**

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх төслийг хэрэгжүүлснээр иргэдийн санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх, хуримтлал болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүү, банкны системд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, цаашлаад Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжлийг дэмжих юм.

Санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх сэдвийн агуулга нь 1) гэнэтийн эдийн засгийн цочролыг даван гарах үүднээс хадгаламжийн ач холбогдлыг ойлгуулах, 2) ирээдүйдээ зориулж хуримтлал бий болгох, 3) орлогодоо тохируулж амьдрах, 4) санхүүгийн шийдвэр гаргахдаа мэдээлэл, зөвлөмж хайх зэрэг чадварыг суулгах зорилготой. Иймд санхүүгээ зөв удирдаж сурах дадал хэвшлийг хүүхэд байхаасаа эзэмших нь хувь хүний амьдралын чанарт эергээр нөлөөлдөг болохыг Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын судалгаагаар харуулсан байна¹⁶. Тус судалгааны үр дүнгээс үзэхэд хүүхэд нааснаасаа эхлэн хадгаламж үүсгэсэн хүмүүсийг хуримтлуулж заншаагүй хүмүүстэй харьцуулахад санхүүгийн чадавх нь өндөр байна. Мөн үүнтэй ижил Дэлхийн банкнаас хийсэн судалгаанд бага насанд нь санхүүгээ зөв удирдах дадалд сургах нь үр өгөөжтэй болохыг

¹⁶ OECD, 2015. *OECD/INFE Core competencies framework on financial literacy for youth*.

дүгнэжээ¹⁷. Багадаа хуримтлуулж сурсан хүмүүс нь санаачлагатай байх, ирээдүйгээ төлөвлөх болон ирээдүйдээ зориулж хуримтлуулах дадал нь багадаа хуримтлал үүсгэж эхлээгүй хүмүүсээс илүү өндөр үзүүлэлттэй байгааг харуулжээ. Нөгөөтээгүүр, дэлхийн улс орнууд санхүүгийн мэдлэгийг аль болох бага наснаас нь олгоход ихээхэн анхаарч, ач холбогдол өгч ажиллаж байна. Тухайлбал, АНУ, Их Британи, Канад, Япон, Малайз, Индонез, Тайван зэрэг орнуудад санхүүгийн мэдлэг олгох сургалтын агуулгыг нийгмийн ухаан, тоо, түүх, газар зүй зэрэг хичээлүүдэд нь багтаасан байдаг. Зарим тохиолдолд тусад нь судлах хичээл болгосон туршлагууд ч бий. Иймд санхүүгийн мэдлэг олгох агуулгыг ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт багтаах нь урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой юм.

Стратеги

- Засгийн газар, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл хамтран Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх төслийг боловсруулж хэрэгжүүлэх.
- Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сургалтын төлөвлөгөөнд санхүүгийн мэдлэг олгох зорилттой сонгон судлах “Бизнес судлал” хичээлийг тусгасан бөгөөд цаашид дунд ангийн сургалтын төлөвлөгөөнд санхүүгийн мэдлэг олгох анхан шатны агуулгыг тусгах.
- Иргэдийн амьдралын болон амьжиргааны түвшнийг дээшлүүлэхийн тулд сургуулийн гадна үлдсэн, сургууль завсардсан болон зохих боловсролыг эзэмшиж чадаагүй залуус, насанд хүрэгчдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг системтэй зохион байгуулах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Засгийн газар, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл хамтран Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх төслийг боловсруулж хэрэгжүүлэх
- БСШУС-ын сайдын 2019 оны 08 дугаар сарын 01-ний А/491 дугаар “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалын Дунд ангийн сургалтын төлөвлөгөөнд батлагдсан “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлд санхүүгийн мэдлэг олгох агуулга оруулах ажлыг дэмжиж ажиллах.
- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан сонгон судлах “Бизнес судлал” хичээлийн агуулгаас Ерөнхий эрдмийн шалгалтын асуултад оруулах ажлыг дэмжих.
- Сурагчдад санхүүгийн мэдлэг түгээх арга хэмжээг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- Сурагчдад санхүүгийн мэдлэг олгох ажлыг БСШУЯ, Монголбанк, СЗХ бодлогын хэмжээнд дэмжиж ажиллана.
- Аймаг, дүүрэг, сумдын Насан туршийн боловсролын төвөөр дамжуулан:
 - Багш нарыг системтэй бэлдэх.
 - Насанд хүрэгчдийн боловсролын сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах.
 - Олон нийтэд зориулсан мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээг ашиглан мэдээлэл хүргэх.

8/ Орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтолцоог олон улсын сайн туршлагын дагуу бэхжүүлж, хөтөлбөрийг Монголбанкаас Засгийн газарт 2023 онд багтаан шилжүүлэх

Үндэслэл

Монголбанк, Засгийн газар “Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр”-ийг 2013 оны 6 дугаар сараас хойш хэрэгжүүлж байна.

¹⁷ The World Bank, 2022. Financial and private sector development.

2022 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар хөтөлбөрийн хүрээнд Монголбанк, Засгийн газар, банкуудын эх үүсвэрээр нийт 6.4 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийг 107.5 мянган зээлдэгчид олгоод байна. Үүнээс 18.2 мянган өрхөд нийт 1.4 их наяд төгрөгийн зээлийг жилийн 6 хувийн хүүтэй олгосон бөгөөд хөтөлбөрийн зээлийн хүүг жилийн 6 хувь болгон бууруулснаар зээлдэгчийн сарын төлбөрийн хэмжээ 20 орчим хувиар багасаж, үүнийг дагаад зээлийн шаардлага дахь өрхийн орлогын доод хэмжээ мөн ижил хувиар буурав. “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд Монголбанк болон банкуудын эх үүсвэрээр 2021-23 онд нийт 2 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээл олгохоор төсөвлөснөөс 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 17.1 мянган зээлдэгчид нийт 1.3 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийг олгоод байна.

Хэдийгээр тус хөтөлбөр нь дундаж орлоготой өрхүүдийн орон сууцны нөхцөлийг сайжруулах, агаар, орчны бохирдол болон орон нутгийн шилжилт хөдөлгөөнийг бууруулах зэрэг нийгмийн олон талын ач холбогдолтой боловч Төв банкнаас хөтөлбөрийг санхүүжүүлэх нь инфляцыг өсгөх, төгрөгийн ханшийн сулрах дарамтыг өсгөх сөрөг үр дагавартай. Мөн хүү нь зах зээлийн хүүгээс бага хөнгөлөлттэй нөхцөлтэй учир зах зээлийг гажуудуулах, Төв банкны мөнгөний бодлогын зорилттой нийцтэй бус байхад хүрдэг.

Тиймээс олон улсын туршлагад нийцүүлэн Монголбанк 2020 оноос эхлэн ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх бэлтгэлийг хангаад байсан боловч КОВИД-19 цар тахлын эдийн засагт үзүүлсэн нөлөөнөөс шалтгаалан ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх хугацааг “Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”, УИХ-ын 2020 оны 32 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээ”, Монгол Улсын Засгийн Газрын 183 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээ”-ний дагуу Монголбанк 2021-22 онд үргэлжлүүлэн санхүүжүүлэв.

Харин цар тахлын үед хорио цээрийн дэглэм тогтоох, улмаар бизнес эрхлэгчдийн орлого тасалдах зэргээр эдийн засагт учруулах сөрөг нөлөө харьцангуй саармагжиж, инфляц өсөх, ханш сулрах дарамт өндөр хэвээр байгаа тул цар тахлын өмнө Төв банк ипотекийн хөтөлбөрийг Засгийн газарт шат дараатай шилжүүлэхээр төлөвлөж байсны дагуу холбогдох бэлтгэлийг хангахаар, Дэлхийн банктай хамтран зөвлөх үйлчилгээ аван ажиллаж байна.

Харин тус хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх хүртэл хугацаанд санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд дараах нөхцөл байдал үүсээд байна. Үүнд:

- Ипотекийн зээлийн эрэлт нэмэгдэж байна. Ипотекийн хөтөлбөрийн зээлийн эрэлт өндөр байгаа бөгөөд 2022 оны эхнээс 6 дугаар сарын байдлаар банкуудад нийт 946.9 тэрбум төгрөг (14.4 мянган иргэн)-ийн ипотекийн зээлийн хүсэлт ирээд байгаагаас 227.7 тэрбум төгрөг (2.6 мянган иргэн)-ийн зээл олгогдож, 262.9 тэрбум төгрөг (14.4 мянган иргэн)-ийн зээлийн хүсэлтэд журам, гэрээний шаардлага хангаагүй болон өөрийн хүсэлтээр гэсэн шалтгаанаар татгалзсан байна. Улмаар нийт 456.4 тэрбум төгрөг (8.8 мянган иргэн)-ийн ипотекийн зээлийн хүсэлт банкууд дээр хуримтлагдаж, сар тутам ойролцоогоор 157.8 тэрбум төгрөг (2.4 мянган иргэн)-ийн хүсэлт нэмэгдэж байна. Иймд зах зээлийн нөхцөл байдлаас хамааран ипотекийн зээлийн эрэлт өндөр үед хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг тогтвортой түвшинд байлгах нөхцөл үүссэн.
- Монголбанкнаас олгох санхүүжилтийн эх үүсвэр буурах эрсдэл үүссэн. Коронавируст цар тахлын хүндрэлтэй холбоотойгоор банкууд орон сууцны ипотекийн зээлийн төлөлтийг хойшлуулах хүсэлтийг иргэдээс хүлээн авч шийдвэрлэж байгаа бөгөөд 1) 2020 оны 4 дүгээр

сараас 6 сарын хугацаанд нийт 2 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 38,152 өрх, 2) 2020 оны 11 дүгээр сараас 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл нийт 3.0 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 55,728 өрх, 3) 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 2021 оныг дуустал 3.1 их наяд төгрөгийн зээлийг үлдэгдэлтэй 58.2 мянган өрх, 4) 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл 3.4 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 61.7 мянган өрх, 5) 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2022 оныг дуустал 3.4 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 63.2 мянган өрхийн зээлийн төлбөрийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлуулсан. Эдгээр хойшлуулсан ипотекийн зээлийн үлдэгдэл нь нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 80 гаруй хувийг эзэлж байна. Энэхүү ипотекийн төлбөрийг хойшлуулснаар Ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)-ны үндсэн болон купоны төлбөр тасалдаж, улмаар орон сууцны ипотекийн зээлийг санхүүжүүлэх эх үүсвэр буурах эрсдэл үүссэн. Иймд ИЗББ-ны ирээдүйн мөнгөн урсгалаас санхүүжүүлэх замаар эх үүсвэрийг шийдвэрлэж, хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийн тасралтгүй байдлыг хангах шаардлага бий болсон. Уг шаардлагын дагуу Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 285/A-334 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоо бүрдүүлэх хөтөлбөрөөс гаргах төлөвлөгөө”-нд Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 163/A-136 дугаар хамтарсан тушаалаар холбогдох өөрчлөлтийг оруулсан.

Цаашид хөтөлбөрийг урт хугацаанд тогтвортой үргэлжлүүлэх зорилгоор олон улсын тэргүүн туршлага, зах зээлийн зарчимд суурилсан орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр судалж, санал боловсруулах ажлын хэсгийг Монголбанк, Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яамны төлөөллийг оролцуулан ажиллаж байгаа билээ. Энэ хүрээнд сан бүрдүүлэх байдлаар тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, ажил эрхэлж байгаа хүмүүсийг нийгмийн даатгалтай санхүүжилтийг уялдуулах зэрэг олон улсын сайн туршлагыг судлан нэвтрүүлэхээр судалж байна. Мөн дунд болон урт хугацаандaa иргэдийг орон сууцжуулахад чиглэсэн хөтөлбөрүүдийг зах зээлийн зарчмаар санхүүжих хэлбэрт шилжүүлэх нь үр ашигтай юм. Ингэхдээ макро эдийн засгийн оновчтой бодлого явуулах замаар зах зээлийн хүүг бууруулах, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлийг хөгжүүлснээр ипотекийн хөтөлбөр болон энэ төрлийн хөтөлбөрүүдийг төрөөс дэмжих, татаас, хүүгийн хөнгөлөлт үзүүлэх зэрэг арга хэмжээ шаардлага багасна. Иймд тогтвортой санхүүжилтийн тогтолцоог Монголбанкнаас холбогдох байгууллагууд хамtran бүрдүүлж, хөтөлбөрийг Засгийн газарт 2023 онд багтаан шат дараатай шилжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Стратеги

- Нийгэмд гарч буй эерэг ач холбогдол, цар тахлын эдийн засагт үзүүлсэн нөлөө зэргийг харгалzan хөтөлбөрийн санхүүжилтийг “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль ”-ийн хугацаанд Засгийн газарт, Монголбанк болон банкуудын эх үүсвэрээр шийдвэрлэнэ.
- Олон улсын санхүүгийн байгууллагуудын зөвлөмж, олон улсын сайн туршлагатай нийцүүлэн орон сууцны ипотекийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, дунд болон урт хугацаанд зах зээлийн зарчимд тулгуурласан ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоо бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг “Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн хугацаанд Монголбанк хэрэгжүүлэх.
- Ипотекийн зээлээр баталгаажсан бондын ирээдүйн мөнгөн урсгалыг өөрчлөх замаар хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийн тасралтгүй байдлыг хангах.
- Монголбанк, Сангийн яам, Барилга хот байгуулалтын яамны төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийн хүрээнд хөтөлбөрийг Засгийн газарт шат дараатай шилжүүлэх саналыг боловсруулах.
- Орон сууцны ипотекийн хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг олон улсын сайн туршлагад үндэслэн төрөлжүүлж, холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тусгах.

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2023 ОНД
БАРИТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ УИХ-ЫН ТОГТООЛЫН
2-Р ЗААЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ЗААЛТ	ЗААЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ
1	2.1/ Гадаад төлбөрийн чадварыг сайжруулж, эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангахад чиглэсэн төсөв, мөнгө, санхүүгийн бодлогыг уялдуулан хэрэгжүүлэх.	Экспортын орлогыг нэмэгдүүлэх хүрээнд тээвэр, хилийн хязгаарлалтыг шийдвэрлэх чиглэлд худалдааны түнш орнуудтай олон давтамжтайгаар хамтран ойлголцож, шийдвэрлэх гарцыг тодорхойлох
		Гадаад орчны тодорхой бус байдалтай холбоотойгоор гадаад төлбөрийн чадварыг сайжруулах, гадаад санхүүжилтийн орох урсгалыг нэмэгдүүлэхэд тууштай анхаарах
		Эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор 2023 онд дотоод эрэлтийг тэлэхгүй байхад чиглэсэн төсөв, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх
		Эдийн засгийн мөчлөгийн далайцыг бууруулах чиглэлд төсвийн оновчтой дүрмийг тогтоон дагаж мөрдөх
		Экспортыг төрөлжүүлэх, импортыг орлох, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэхдээ зөвхөн дотоод эх үүсвэрээр бус гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх, мөн гадаадын хөрөнгө оруулалтыг татах ажлыг эрчимжүүлэх
		Эдийн засгийн төрөлжилтийг дэмжихийн тулд уул уурхайн бус экспортлогчдын бизнесийн орчныг сайжруулах
2	2.2/ Гадаад худалдаа, тээвэр, логистикт үүсэж буй хүндрэлийг шийдвэрлэж, түүхий эд, бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;	Гадаад, дотоод гэнэтийн, болзошгүй эрсдэлээс сэргийлэхэд төсөв, мөнгө, санхүүгийн бодлогын хурдан хариу үйлдэл үзүүлэх тогтолцоог хөгжүүлэх
		Олон улсын стандарт шаардлагад нийцүүлэх чиглэлд боомтуудын хүчин чадал, дэд бүтцийг сайжруулах
		Ачаа тээврийн улсын хилээр орох, гарах урсгалыг нэмэгдүүлэх, аль нэг талд контейнерийн бөөгнөрөл үүсгэхгүй байх үр дүнтэй зохицуулалт хийх
		Тээврийн маршрутыг нэмэгдүүлэх боломжит сувгуудыг судалж, шаардлагатай тохиолдолд ашиглах
		Гэнэтийн нийлүүлэлтийн saat албан ёсны эрсдэлүүдийг судалж, шаардлагатай төлөвлөгөөг боловсруулах
		Монгол Улс олон улсын худалдааны бодлоготой уялдсан тээвэр, логистикийн бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх

		<p>Гадаад төлбөр тооцооны тасалдалгүй байдлыг хангах чиглэлд гадны харилцагч банкуудын хүрээг тэлж, харилцаа холбоог сайжруулах,</p> <p>Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын бүтцийг сайжруулах, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах чиглэлд Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах,</p> <p>Дотоодын зах зээлээс алт худалдан авах ажиллагааг сайжруулж, алт тушаалтыг нэмэгдүүлэх, дотоодын алт олборлогч ААН-үүдэд санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэх,</p> <p>Гадаад валютын улсын нөөцийн хүрэлцээт байдлыг нэмэгдүүлэх чиглэлд Засгийн газартай хамтран ажиллах;</p> <p>Засгийн газрын зүгээс гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах, дэд бүтцийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар гадаад валютын нөөцөд дарамт багатайгаар эх үүсвэр бүрдүүлэх тал дээр анхаарч ажиллах;</p> <p>Засгийн газрын өрийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж, гадаад валютын бондуудыг үр ашигтайгаар дахин санхүүжүүлэх чиглэлд хамтран ажиллах;</p> <p>Валютын гадагшлах урсгалыг бууруулах чиглэлд тансаг зэрэглэлийн болон бусад (архи, тамхи гэх мэт) бараа, бүтээгдхүүний импортын тарифын болон тарифын бус бодлогыг хэрэгжүүлэх;</p> <p>Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор хөрөнгө оруулалт, татвар болон бусад хууль тогтоомж дахь татварын хөнгөлөлт, зохицуулалтыг нийцтэй болгож хэрэгжүүлэх;</p> <p>Валютын зохицуулалтын тухай хуулийн 12.2-т заасан Монгол Улсад байнга оршин суугч нь валютын орлогоо 60 хоногийн дотор банкинд хадгалах, худалдах тухай заалтыг мөрдүүлэх;</p>
3	2.3/ Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлэх, банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах, валютын эх үүсвэр бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;	

		<p>Уул уурхайн бус экспортлогчдыг дэмжих зорилгоор санхүүгийн хүртээмжтэй тогтолцоог бий болгох талаар банк, санхүүгийн бусад байгууллагууд аж ахуйн нэгжүүд холбогдох төрийн байгууллагуудтай хамтрах, санхүүжилтийн тогтолцоог сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох;</p> <p>Уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болох санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэрэгслүүдийг нэвтрүүлэх, сайжруулах боломжийн талаар судлах;</p> <p>Экспортын болон худалдааны зээлийн даатгалын хэрэглээг нэмэгдүүлэх, улмаар аж ахуйн нэгжүүдийн зээлжих чадварыг сайжруулах чиглэлээр уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, уг хамтын ажиллагааны үр дүнд үндэслэн оролцогч талуудад харилцан ашигтай боломжтой санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, үе шаттайгаар нэвтрүүлэх;</p> <p>Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт, хөдлөх хөрөнгө(мах, махан бүтээгдэхүүн, ноос, ноолуур, сүү, сүүн бүтээгдэхүүн гэх мэт) барьцаалсан санхүүжилт, факторинг (экспортын гэрээ барьцаалсан)-ийн үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг боловсронгуй болгох</p> <p>Экспортыг дэмжиж, гадаад худалдаа, төлбөр тооцоог хөнгөвчлөх чиглэлд худалдааны чөлөөт бүсийг хөгжүүлэх</p> <p>Төрийн худалдан авалтыг зохион байгуулахдаа үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих</p>
4		<p>2.4/ Уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүний боловсруулалтыг шат ахиулж, экспортыг дэмжихэд чиглэсэн гадаад худалдааны санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх;</p>
5		<p>2.5/ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг үндэсний хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэх;</p>

		<p>Тогтвортой, ногоон бизнесийг дэмжих татварын зохистой орчныг бүрдүүлэхэд шаардлагатай суурь судалгааг Засгийн газрын түвшинд хийж, бодлогын зөвлөмжийг тодорхойлох.</p> <p>“Үндэсний тогтвортой санхүүгийн замын зураг”-д тусгагдсан арга хэмжээнүүдийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.</p> <p>Төрийн байгууллагууд уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг бууруулах чиглэлээр нягт уялдаатай хамтран ажиллах, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад харгалzan үздэг болох.</p> <p>Бодлого арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх, үүн дээр үндэслэн дараагийн шатны төлөвлөгөө боловсруулан, арга хэмжээг авах.</p> <p>Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан байгаль орчин, нийгэмд эерэг үр нөлөө үзүүлдэг эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, тусгайлсан шалгуур үзүүлэлт, баталгаажуулалтын аргачлал бүхий Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн таксономийг боловсруулан, батлуулах.</p> <p>Тогтвортой санхүүжилтийг санхүүгийн байгууллагад амжилттай сайн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Төв банк, Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс авч хэрэгжүүлэх боломжтой хөшүүргийн арга хэрэгслүүдийг судалж нэвтрүүлэх.</p> <p>Банк,банк бус санхүүгийн салбарын статистик тайлан мэдээллийг хүйсээр ангилан нийтэд мэдээлэх, жендерийн мэдрэмжтэй санхүүжилтийн тогтолцоо бүрдүүлэх чиглэлд салбарын холбоод, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах.</p> <p>Тогтвортой санхүүжилтийн талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх чиглэлээр судалгаа, шинжилгээ хурал уулзалтыг дэмжиж ажиллах.</p>
6	2.6/ Тогтвортой, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх чиглэлд батлагдсан бодлого, хөтөлбөрийг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;	<p>Засгийн газар, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл хамтран дунд хугацааны олон нийтэд санхүүгийн мэдлэг олгох төсөл боловсруулж, хэрэгжүүлнэ.</p> <p>Зорилтот бүлгийн санхүүгийн мэдлэгийн түвшинд нийцсэн хөтөлбөр, бие даан сурал гарын авлага, зөвлөмж боловсруулах, санхүүгийн боловсролын сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах, олон нийтэд зориулсан мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээг ашиглан сурталчилгаа хийнэ.</p> <p>БСШУС-ын сайдын 2019 оны 08 дугаар сарын 01-ний А/491 дугаар “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалын Дунд ангийн сургалтын төлөвлөгөөнд батлагдсан “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлд санхүүгийн мэдлэг олгох агуулга оруулах</p> <p>Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан сонгон судлах “Бизнес судлал” хичээлийн агуулгаас Ерөнхий эрдмийн шалгалтын асуултад оруулах</p> <p>Аймаг, дүүрэг, сумдын ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг системтэй бэлтгэх, сурагчдад санхүүгийн мэдлэг түгээх арга хэмжээг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх</p>
7	2.7/ Санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор иргэд, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны төслийг боловсруулж хэрэгжүүлэх;	<p>Засгийн газар, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл хамтран дунд хугацааны олон нийтэд санхүүгийн мэдлэг олгох төсөл боловсруулж, хэрэгжүүлнэ.</p> <p>Зорилтот бүлгийн санхүүгийн мэдлэгийн түвшинд нийцсэн хөтөлбөр, бие даан сурал гарын авлага, зөвлөмж боловсруулах, санхүүгийн боловсролын сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах, олон нийтэд зориулсан мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээг ашиглан сурталчилгаа хийнэ.</p> <p>БСШУС-ын сайдын 2019 оны 08 дугаар сарын 01-ний А/491 дугаар “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалын Дунд ангийн сургалтын төлөвлөгөөнд батлагдсан “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлд санхүүгийн мэдлэг олгох агуулга оруулах</p> <p>Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан сонгон судлах “Бизнес судлал” хичээлийн агуулгаас Ерөнхий эрдмийн шалгалтын асуултад оруулах</p> <p>Аймаг, дүүрэг, сумдын ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг системтэй бэлтгэх, сурагчдад санхүүгийн мэдлэг түгээх арга хэмжээг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх</p>

8	2.8/ Орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтолцоог олон улсын сайн туршлагын дагуу бэхжүүлж, хөтөлбөрийг Монголбанкнаас Засгийн газарт 2023 онд багтаан шилжүүлэх;	<p>Монголбанк “Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр”ийг Засгийн газарт шат дараатай бүрэн шилжүүлэх хүртэл уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх</p> <p>Монголбанк, Засгийн газар 2023 онд хамтран “Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр”-ийн тогтолцоог олон улсын сайн туршлагад суурилсан, тогтвортой удаан хугацаанд хэрэгжих байдлаар шинэчлэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх</p> <p>Шинэчилсэн тогтолцооны схемийн дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газарт шат дараатай бүрэн шилжүүлэх</p>
---	---	--

1. МӨНГӨНИЙ БОЛОН МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:


ЗОРИЛТ 1.1

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2023 онд нэг оронтой тоонд, дунд хугацаанд +/- 2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтвортжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ.

Үндэслэл

Үнийн тогтвортой байдал нь мөнгөний бодлогын гол зорилго бөгөөд инфляцыг нам түвшинд тогтвортжуулах явдал юм. Өөрөөр хэлбэл, инфляц нам түвшинд тогтвортой байх нь төгрөгийн худалдан авах чадварын тогтвортой байдлыг хангаж, хөрөнгө оруулалт, санхүүгийн шийдвэрийг хялбар болгож, дунд, урт хугацаанд хадгаламж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, улмаар эдийн засгийн тэнцвэртэй, тогтвортой өсөлтийг дэмжинэ. Түүнчлэн, иргэдийн бодит орлого, тэр дундаа бага орлоготой өрхийн амьжиргааг хамгаалах, амьдрах болон бизнес эрхлэхэд таатай орчныг бүрдүүлэхэд тогтвортой инфляц нь чухал хүчин зүйл болдог.

Зураг 10. Инфляц, түүний хэлбэлзэл




Эх сурвалж: Монголбанк

Цар тахлаас шалтгаалсан дэлхийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэргүй байдал бүрэн арилаагүй үед геополитикийн хурцадмал байдал үүссэн нь гадаад, дотоод эдийн засагт хүчтэй, дараалсан шокын нөлөөг бий болгож, олон улсад үнийн өсөлтийг даамжуулж байна. Эдгээр гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр эрчимжсэн инфляцыг дотоод мөнгөний бодлогын хэрэгслүүдээр тогтвортжуулах хүндхэн сорилттой тулгарч байна. Монгол Улсад инфляц 2020 оны туршид харьцангуй нам дор түвшинд байсан бол 2021 оноос хойш тасралтгүй нэмэгдэж 2022 оны II улирлын байдлаар зорилтоос даваад байна (Зураг 11). Үүнд гадаад орчны тодорхой бус байдал нэмэгдсэн, дэлхий даяар тээвэр, логистикийн saat албан ёссын, нийлүүлэлтийн сүлжээ доголдсон зэрэг нийлүүлэлтийн хязгаарлалттай, зардлын шинжтэй хүчин зүйлс голлон нөлөөлөв. Тухайлбал, 1) олон улсын тээврийн зардал 2019 оны дунджаас 5 дахин ёссөн, 2) газрын тосны үнэ 100 ам доллар давсан, 3) дэлхийн хүнсний үнэ түүхэн дээд түвшиндээ хүрсэн, 4) дэлхийн үйлдвэрлэлийн үнийн индекс 2020 оны дундаас эхлэн тасралтгүй нэмэгдсэн, 5) манай улсын гол боомтуудын нэг “Эрээн-Замын-үүд” боомтын үйл ажиллагаа хязгаарлагдсан нь импортоор дамжин инфляцыг өдөөгч гол хүчин зүйлс болж байна. Тодруулбал, нийт инфляцын талаас илүү хувийг импортын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийн шууд нөлөө тайлбарлаж байна. Үүний дээр импортын

орц болон шатахууны үнийн өсөлт нь дотоодын бараа, үйлчилгээний үйлдвэр, тээврийн зардлыг нэмэгдүүлэх шууд бус нөлөөг үзүүлж байна.

Дээрх хүчин зүйлсийн нөлөө ирэх улирлуудад үргэлжлэх хандлагатай байгаа бөгөөд өрхийн хэрэглээ сэргэж, уул уурхайн бус салбаруудын үйл ажиллагаа тогтворжиж эхэлсэнтэй уялан эрэлтийн шалтгаантай инфляц алгуур нэмэгдэх төлөвтэй байна.

Зураг 11. Инфляцын бүрэлдэхүүн хэсэг



Эх сурвалж: YCX

Мөнгөний бодлогын үндсэн хэрэгсэл болох бодлогын хүүгээр нийлүүлэлтийн хязгаарлалтыг бууруулж, зардлын өсөлтөөр өдөөгдсөн инфляцыг удирдах боломжгүй. Гэсэн хэдий ч одоогийн үүсээд буй нийлүүлэлтийн хязгаарлалт, зардлын шинжтэйгээр эрчимжсэн инфляц даамжрах эрсдэлээс сэргийлэхийн тулд ихэнх төв банк бодлогын хүүгээ өсгөж, бодлогын төлөвөө хатууруулах арга хэмжээг авч эхэллээ. Монголбанк ч мөн адил 2022 оны 1-р сараас эхлэн бодлогын хүүг шатаатайгаар нэмэгдүүлээд байна. Бодлогын хүүг нэмэгдүүлсэн нь 1) одоогийн өндөр инфляциад шууд нөлөөлж чадахгүй ч үүнээс үүсэх хоёр дахь үеийн нөлөөг бууруулах, 2) ирээдүйн инфляцын хүлээлтийг тогтворжуулах, 3) гадаад суурь хүү хурдтай нэмэгдэж буй энэ үед гадаад, дотоод хүүгийн зөрүү болох төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах юм.

Улс орнууд өөрийн онцлог, эдийн засгийн бүтэц, хөгжил зэргээс хамааран инфляцын зорилтот түвшнийг харилцан ялгаатай тогтоодог. Төв банкуудын туршлагаас харахад инфляцын зорилтот түвшнийг 1) цэгэн, 2) цэгэн голчтой интервал болон 3) интервалаар тогтоох гэсэн үндсэн 3 арга хэлбэр ашиглаж байна. Хөгжиж буй орнуудын инфляцын хэлбэлзэл хөгжингүй орнуудынхтай харьцуулахад өндөр байдгаас гадна гадаад, дотоод орчны өөрчлөлтөд илүү өртөмтгий, эмзэг байдаг. Түүнчлэн, хөгжиж буй орнуудын төсвийн сахилга бат сул, санхүүгийн зах зээлийн хөгжил дорой, олон нийтийн төв банканд итгэх итгэл бага байдаг нь инфляцын хэлбэлзлийг бууруулахад хүндрэл учруулдаг. Иймээс хөгжиж буй орнуудад инфляцын зорилт алдагдах эрсдэлийг бууруулах, эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх нь чухал юм. Өөрөөр хэлбэл, инфляцын зорилтыг цэгэн голчтой интервалтай утгаар тогтоох нь төв банкнаас үнийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ эдийн засгийг тогтворжуулах, богино хугацаанд эдийн засгийн идэвхжилийг дэмжих бодлогын орон зайг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Инфляцын хэлбэлзэл өндөр, төв банкны бодлогоор шууд нөлөөлөх боломжгүй нийлүүлэлтийн хүчин зүйлсийн инфляциад үзүүлэх нөлөө өндөр, гадаад орчны савлагаанд өртөмтгий манай улсын хувьд 2021 оноос инфляцын зорилтоо цэгэн голчтой интервал хэлбэрээр буюу 6%(+/-2) хувийн орчимд тогтворжуулах зорилтыг тавьж эхэлсэн. Энэ нь зах зээлд оролцогчдын хүлээлтийг удирдах, цаашлаад дунд, урт хугацаанд инфляцын өндөр хэлбэлзлийг үргэлжлүүлэн бууруулахад зөрөг нөлөөтэй.

Стратеги

Эрэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг зөв таних. Мөнгөний бодлогын үндсэн хэрэгсэл болох бодлогын хүү нь зээл олголт, хүү, ханш, хөрөнгийн үнэ, хүлээлт зэрэг гол сувгуудаар дамжин хэрэглээ, хөрөнгө оруулалт, экспорт, импортод нөлөөлөх замаар эдийн засгийн идэвхжилийг эрэлт талаас удирдаж, инфляцад нөлөөлнө. Нэг талдаа цар тахал болон геополитикийн таагуй нөхцөл байдлаас шалтгаалан түүхий эдийн үнэ өсөх, тээвэр логистикийн саатал даамжрах, зардал нэмэгдэх зэрэг нийлүүлэлтийн шок нөгөө талдаа дотоод эрэлт сэргэхтэй холбоотойгоор эрэлтийн шалтгаантай үнийн өсөлт эрчимжих эрсдэлтэй орчинд эрэлт, нийлүүлэлтийн шокын нөлөөг оновчтой тодорхойлох нь томоохон сорилт болж байна.

Инфляцыг дунд хугацаанд тогтвортжуулах чиглэлд мөнгөний бодлогын төлөвийг өөрчилнө. Суурь үеийн болон нийлүүлэлтийн шалтгаантай хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц зорилтот интервалаас давж болох хэдий ч инфляцын дарамтыг зөв тодорхойлох замаар түүнийг дунд хугацаанд тогтвортжуулах оновчтой мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ. Ингэхдээ эдийн засгийн сэргэлт, гадаад эдийн засгийн орчинд гарч буй өөрчлөлтийг харгалзан мөнгөний бодлогын төлөвийг өөрчлөх бөгөөд мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ зах зээлийн зарчимд суурилсан арга хэрэгслийг ашиглаж, хүүгийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлнэ.

Ирээдүйд үндсэн зорилтыг хангахад чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ. Эрэлтийн болон нийлүүлэлтийн гаралтай, бүтцийн эсвэл түр зуурын шинж чанартай шокын нөлөөгөөр инфляцад хэлбэлзэл үүсдэг. Тухайлбал, гадаад зах зээл дээрх түүхий эдийн үнийн хэлбэлзэл, хөрөнгийн урсгалын өөрчлөлт, олон улсын худалдааны гэрээ, тариифын өөрчлөлт, санхүүгийн зах зээл дээрх инновац, технологи болон дэд бүтэц сайжрах, ган, зуд гэх мэт байгалийн гэнэтийн үзэгдлүүд, төсвийн зардал, бүтээмж, цалин орлогын өсөлт зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц тодорхой хугацаанд зорилтот түвшинээс хазайх тохиолдол бий. Тухайн нөхцөлд шокын шалтгаан, шинж чанар, цар хүрээ, үргэлжлэх хугацаа, үнийн түвшинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэж дунд хугацаанд инфляцыг зорилтот түвшинд хадгалахад чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ.

Мөнгөний бодлогын хэрэгслээр удирдах боломжгүй инфляцын хэлбэлзлийг бууруулахад эдийн засгийн бусад оролцогчдын үүрэг чухал юм. Тиймээс дунд, урт хугацаанд инфляцыг нам түвшинд тогтвортой барихад дараах арга хэмжээ чухал үүрэг гүйцэтгэнэ. Тухайлбал:

- Эдийн засгийг олон тулгууртай болгон төрөлжүүлэх. Ингэснээр валютын ханшийн савлагааг тогтвортжуулах, инфляцад шилжих нөлөөллийг бууруулах зэрэг олон талын эерэг нөлөө үзүүлнэ.
- Хөдөлмөрийн бүтээмж, ажиллах хүчний ур чадварыг нэмэгдүүлэх. Энэ нь цалингийн өсөлтийн инфляцад үзүүлэх нөлөөг бууруулна.
- Төсвийн сахилга бат, өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, эдийн засгийн хэт халалт, уналтын мөчлөгөөс үүдэлтэй инфляцын дарамтыг бууруулж, хувийн секторыг мөнгөний бодлогоор дэмжих орон зай бүрдэнэ.
- Гадаад худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын бодлого, тэдгээрийн хууль эрх зүй, татварын орчны зохицуулалтуудыг сайжруулна.
- Нийлүүлэлтийн сүлжээ, дэд бүтцийг сайжруулах. Энэ нь барааны түр хугацааны хомсдол, улирлын үнийн өсөлтөөс сэргийлэхэд тусална.
- Иргэд, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэг, сахилга батыг сайжруулахад чиглэсэн боловсролын үйл ажиллагааг өргөжүүлэх. Ингэснээр иргэдийн хэрэглэх, хуримтлуулах зан төлөвт эергээр нөлөөлнө.

ЗОРИЛТ 1.2

Санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийн шинжилгээ, мониторингийг сайжруулан, эрдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

Үндэслэл

Дэлхийн санхүүгийн 2007-2009 оны хямралаас авсан хамгийн том сургамж бол санхүүгийн тогтвортой байдлыг хангахад үнийн тогтвортой байдал хангалтгүй болохыг тогтоосон явдал билээ. Үүний үр дүнд улс орнууд санхүүгийн системийн тогтвортой байдлыг бүхэлд нь хангах, түүний сегментүүдэд эрсдэлүүд хэт нэмэгдэж хуримтлагдахаас сэргийлэх, хямрал өرنөж эдийн засагт сөргөөр нөлөөлөх магадлалыг хамгийн бага байлгахад чиглэсэн макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх үндэс суурь бүрдсэн. Макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийн багц нь тухайн улсын санхүүгийн секторын хэмжээ, хөгжил, өгөгдлийн олдоц, дүн шинжилгээ хийх чадавх зэргээс хамаарч харилцан адилгүй байна. Улс орнууд макро зохистой бодлогын стратегийг тодорхойлох, системийн эрсдэлүүдийг илрүүлэн хянах системийг бий болгох, макро зохистой бодлогын хэрэгслүүдийг эрсдэлд суурилсан байдлаар тодорхойлж, тухай бүр тохиргоо хийн хөгжүүлэх, олон нийттэй харилцах, бодлогын арга хэмжээний үр нөлөөг үнэлэх нь санхүүгийн тогтвортой байдлыг хангахад үлэмж ач холбогдолтой болж байна.

Монгол Улсын “Макро зохистой бодлогын стратеги”-ийн хүрээнд макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх үндсэн зорилго нь 1) санхүүгийн тогтвортой байдлыг хангах, 2) санхүүгийн системийн дархлааг бэхжүүлэх, 3) системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино. Үүний тулд Монголбанкнаас зээлийн хэт өсөлт, актив пассивын зөрүү, төвлөрлийн гэсэн 3 төрлийн эрсдэлийг оновчтой удирдаж бууруулахад олон улсад өргөн хэрэглэгддэг макро зохистой бодлогын хэрэгслүүдийг ашиглан ажиллаж байна. Санхүүгийн сектор тогтвортой байснаар мөнгөний бодлогын шилжих механизм үр ашигтай хэрэгжинэ. Системийн эрсдэлүүдийг хязгаарлах нь санхүүгийн хямрал бий болох магадлалыг бууруулж, санхүүгийн заход оролцогчдын тодорхой байдлыг нэмэгдүүлнэ. Гадаад хүчин зүйлсийн болон бусад нөлөөгөөр санхүүгийн захууд дээр тааламжгүй нөхцөл байдал өрнөх тохиолдолд макро зохистой бодлогын шаардлагыг сулруулах замаар санхүүгийн секторын хэвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн хангаж, бодит секторт үзүүлэх сөрөг нөлөөг зөөлрүүлэх боломжтой болно.

Мөнгөний бодлого болон макро зохистой бодлогыг уялдуулан хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Макро зохистой бодлогын шийдвэрүүд нь эдийн засаг, санхүүгийн захын мөчлөгийн хэлбэлзэлтэй холбоотой. Иймд Монголбанк макро зохистой бодлогын шийдвэрүүдийг гаргахдаа мөнгөний бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг харгалzan үзэхээс аргагүй болдог. Макро зохистой бодлогын арга хэмжээнүүд нь эргээд мөнгөний бодлого хэрэгжих орчинд, тухайлбал нийт зээлийн динамикт нөлөөлнө. Иймд Монголбанк санхүүгийн системийн эрсдэлүүдийг хязгаарлах бодлогын шийдвэрийг гаргахдаа макро зохистой болон мөнгөний бодлогын харилцан үйлчлэлийг харгалzan үздэг.

Макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдалд хамаарах эрсдэлүүд нэгэн зэрэг бий болох тохиолдолд макро зохистой бодлогын шийдвэр, арга хэмжээ нь мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх ач холбогдолтой байdag.

КОВИД-19 цар тахлын үед эдийн засгийн уналт бий болж санхүүгийн зах зээлд тодорхой бус байдал нэмэгдэн, банкуудын зээл олголт хумигдаж эхэлснээр ААН-үүдийн санхүүгийн зуучлал хэвийн үргэлжлэх боломжгүй болж, эдийн засгийн уналтыг улам гүнзгийрүүлэх эрсдэл бий болсон. Иймд зохицуулагч байгууллагуудын зүгээс хүндрэлийг зөөлрүүлэхийн тулд зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, зээлийн ангиллыг тодорхой хугацаанд бууруулахгүй байх, аж ахуйн

нэгжүүдийн төлбөрийн чадварыг дэмжих зорилгоор 10 их наядын хөнгөлөлттэй зээлийн арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд эдийн засаг дахь төлбөрийн чадварын хүндэрэлээс сэргийлсэн. Түүнчлэн Мөнгөний бодлогын хорооноос 2021 оны эцэст эдийн засаг, санхүүгийн зах зээлийн төлөв, эрсдэлийг харгалзан банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор гадаад валютын татан төвлөрүүлсэн хөрөнгөнд тооцох заавал байлгах нөөцийн хувийг 3 нэгж хувиар нэмэгдүүлж 18 хувьд хүргэв.


Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээл 2021 он гарснаас хойш сэргэж, эрдэс бүтээгдэхүүний үнэ өсөж, гадаад орчинд зэрэг өөрчлөлтүүд гарч, хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүдийн олголт нэмэгдсэнээр манай улсын санхүүгийн мөчлөг тэнцвэрт түвшнээс илүү сэргэж эхлээд байна. Харин өмнөх онтой харьцуулахад шинээр зээл олголт 2022 оны эхнээс тогтвожиж, санхүүгийн мөчлөг тогтвожиж байна (Зураг 12). Банкуудын нийт зээлийн үлдэгдэл 2022 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар өссөн дүнтэй байна (Зураг 13). Сүүлийн 2 жилд зээл олголт нэмэгдсэн нь иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадварт дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд цаашид зээлийн өсөлтийг дотоод эдийн засгийн нөхцөл байдал, макро орчинтой уялдуулан тогтвортой хадгалах шаардлага бий.

Зураг 12. Санхүүгийн мөчлөг (улирлаар)



Эх сурвалж: Монголбанк

Зураг 13. Зээлийн жилийн өсөлт (улирлаар)



Эх сурвалж: Монголбанк

Орос-Украины нөхцөл байдалтай холбоотойгоор дэлхийн эдийн засгийн тодорхойгүй байдал улам нэмэгдэж, цаашид сунжиравал дэлхий даяараа санхүүгийн тогтвортой байдал алдагдах эрсдэлтэй болж байна. Орос-Украины хурцадмал байдал эрчим хүч, түүхийн эдийн үнийн цочмог өсөлтийг даамжуулж, цар тахлын дараа хүлээгдэж байсан эдийн засгийн өсөлт, инфляц болон санхүүгийн захын нөхцөл байдалд эрсдэл учруулав.

Евро бүсийн засгийн газрууд, компаниуд болон өрхүүд зах зээл дээрх хүүгийн өсөлт болон зардлын өсөлттэй нүүр тулж байна. Өрийн дарамт өндөр байгаа аж ахуйн нэгж, этгээдийн хувьд өрийн тогтвортой байдлаа хангах нь маш том сорилт болж болзошгүй байна.

Нөхцөл байдал ноцтой муудсан тохиолдолд зээлдэгчдэд дорвитой дэмжлэг дахин үзүүлэх шаардлага гарч болзошгүй ч ийм бодлогын орон зай нэлээн хумигдаад байна. Ийм нөхцөлд зохицуулагчдын хувьд дэмжлэгийг үргэлжлүүлэх болон бодлогыг хэвийн түвшинд шилжүүлэх гэсэн хоёр сонголтын хооронд тэнцвэр олох шаардлагатай тулгарч байна.

Иймд ирэх онд макро зохистой бодлого, санхүүгийн зохицуулалт нь дотоод эдийн засгийн нөхцөл байдал, гадаад орчны нөлөөтэй уялдуулж санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалах шаардлага үүсж байна. Цаашилаад санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийг тогтмол хянаж, сөрөг нөлөөг урьдчилан тооцож, банк, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн макро зохистой бодлогыг үргэлжлүүлж, мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлэх нь чухал болж байна.

Стратеги, арга хэмжээ

Монголбанк макро зохистой бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэхдээ дараах стратегийг баримтлан ажиллана. Үүнд:

- Санхүүгийн системд үүсэж буй эрсдэлүүдийн мониторинг хяналтыг сайжруулан, тэдгээрийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад чиглэгдсэн макро зохистой бодлогын арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.
- Макро зохистой бодлогын шийдвэрийг гаргахдаа мөнгөний болон макро зохистой бодлогын харилцан үйлчлэлийг харгалзан үзнэ.

Системийн эрсдэлийг урьдчилан таних чадавхыг бий болгохын тулд макро зохистой бодлогын шинжилгээний цогц арга зүйг хөгжүүлнэ. Энэ хүрээнд санхүүгийн системийн эрсдэлийн шинжилгээ, стресс тест, бодит болон санхүүгийн сектор хоорондын харилцан хамаарлыг нарийвчлан тодорхойлох судалгаа, шинжилгээний ажлуудыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. Олон улсын туршлагад үндэслэн макро зохистой бодлогын арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх аргачлал, үзүүлэлтүүдийг хөгжүүлж макро зохистой бодлогын үр нөлөөг нэмэгдүүлнэ.

ЗОРИЛТ 1.3

Төв банк олон нийттэй харилцах харилцаандaa ил тод байдлын зарчим баримталж, олон улсын сайн туршлагыг өөрийн орны онцлогт нийцүүлэн хөгжүүлж, ашиглана.

Үндэслэл


Төв банкны олон нийттэй харилцах харилцаа нь 1) төв банкны хуульд заасан зорилго, үйл ажиллагаа 2) тэдгээрт хүрэх бодлогын стратеги, арга хэлбэр, 3) эдийн засаг, санхүүгийн зах зээлийн талаарх мэдээлэл, үнэлэлт дүгнэлт, 4) төв банкны бодлого, шийдвэр болон тэдгээрийн үндэслэл зэргийг оролцогч талуудад тайлбарлах, таниулах үйл ажиллагааны цогц юм.

Эдийн засгийн гадаад орчны тодорхой бус байдал, савлагаа нэмэгдсэн, дотоод эдийн засгийн сэргэлт удаан, инфляц зорилтоос давж өссөн энэ цаг үед төв банкны үйл ажиллагааны ил тод байдал, олон нийттэй харилцах харилцааны ач холбогдол улам бүр нэмэгдсээр байна. Эдийн засаг, санхүүгийн зах зээлийг тогтвортжуулж, сэргэлтийг дэмжих бодлогын шийдвэрийн үр нөлөө нь хэрэглэгчид, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид болон санхүүгийн зах зээлд оролцогчдын хүлээлтээс ихээхэн хамааралтай. Иймээс Төв банк олон нийттэй харилцах харилцаагаа олон улсын сайн туршлагад тулгуурлан өөрийн орны онцлогийг тусгасан хэлбэрээр боловсронгуй болгосноор эдийн засагт оролцогчдын мэдээллийн тэгш бус байдлыг бууруулж, хүлээлтийг тогтвортжуулж, улмаар бодлогын зорилтод үр дүнтэй хүрэх боломжийг нэмэгдүүлнэ.

Стратеги, арга хэмжээ

Монголбанкны олон нийттэй харилцах харилцааг хөгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална.

- Бусад төв банкуудын олон нийттэй харилцах сайн туршлагыг судалж нэвтрүүлнэ
- Монголбанкны хуримтлуулсан туршлага, судалгааны үр дүн, мэргэжилтнүүдийн зөвлөмжид тулгуурлана
- Олон нийтэд түгээх мэдээллийг боловсруулах, түгээх сувгуудыг хөгжүүлэхдээ төв банкны оролцогч талуудын онцлог, хэрэгцээнд нийцүүлнэ
- Технологийн дэвшилтэт шийдлээр мэдээллийн шуурхай бөгөөд хүргээмжтэй байдлыг дээшлүүлнэ



Хэрэгжүүлэх арга хэмжээ

Мөнгөний болон макро зохистой бодлогын чиглэлээр:

- Мөнгөний бодлогын мэдэгдлийг ирээдүйн бодлогын шийдвэрийн дохиог өгдөг болгон сайжруулах
- Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийн үндэслэлийг тайлбарласан агуулгыг Инфляцын тайландаа нэмж тусгах
- Инфляцын тайлангийн загвар дизайн, тайлбар, дүрслэлийн энгийн, ойлгомжтой байдлыг сайжруулах
- Инфляцын хүлээлтийн судалгааны үр дүнг инфляцын тайландаа нэмж тусгах,
- Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийг олон нийтэд танилцуулах, тайлбарлах бүтээгдэхүүнүүдийн агуулга, найруулгын уялдааг хангах, ойлгомжтой болгох
- Мөнгөний бодлоготой холбоотой контентуудыг тогтсон давтамжтайгаар, урьдчилж зарласан хуваарийн дагуу олон нийтэд хүргэх үүднээс дотоод үйл ажиллагаа, мэдээлэл дамжих процессыг илүү үр ашигтай болгох

Санхүүгийн тогтвортой байдлын чиглэлээр:

- Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн агуулга ойлгомжтой байдлыг сайжруулах,
- Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлын мэдээг олон нийтэд түгээх
- Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ, олон нийтэд мэдээлэл түгээх арга хэлбэрийг сайжруулах

Дотоод зохион байгуулалтын чиглэлээр:

- Төв банкны дотоод мэдээллийн урсгалд үнэлэлт дүгнэлт өгч, шаардлагатай өөрчлөлтийг хийх
- Олон нийттэй харилцах бодлогын баримт бичгүүдийг шинэчлэх
- Төв банкны олон нийттэй харилцах харилцааны сувгуудад шаардлагатай өөрчлөлт сайжруулалтуудыг хийх
- Монголбанкны цахим хуудсыг шинэчилж, сайжруулах
- Мэдээллийг түгээхдээ технологийн дэвшүүдийг нэвтрүүлж, ашиглах
- Мэдээллийн хүртээмж бага орон нутагт мэдээлэл түгэх үр дүнтэй сувгуудыг хөгжүүлэх
- Залуу үеийн хэрэглээнд нийцсэн мэдээллийн сувгуудыг хөгжүүлэх, контент боловсруулж түгээх

2. БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД:

ЗОРИЛТ 2.1

Банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгсэл, үнэлгээний аргачлалыг олон улсын жишиг, зарчимд нийцүүлэх бодлого, арга хэмжээг үргэлжлүүлнэ.

Үндэслэл

Монголбанкнаас банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишиг, зарчимд нийцүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын арга барилд шилжих арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Өнгөрсөн жилийн хугацаанд Монголбанкнаас банкны эрсдэл даах чадвартай холбоотойгоор эрсдэл даах чадварыг хамгаалах зориулалт бүхий нөөц интервалыг бүрэн нэвтрүүлэх, банкны

хувь нийлүүлсэн хөрөнгийн доод шаардлагыг нэмэгдүүлэх зохицуулалтын хэрэгжилтийг хангуулж ажилласан. Түүнчлэн банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд банкны тогтвортжуулах санг бүрдүүлэх, банкнаас тогтвортжуулалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх харилцааг зохицуулсан журмуудыг тус тус батлуулан хэрэгжүүлж байна.

Манай улсын хувьд Baselyn цуврал стандартыг дотоодын банкны системийн онцлогт нийцүүлэн хэсэгчлэн нэвтрүүлж ирсэн бөгөөд цаашид Монголбанкнаас олон улсын сайн туршлагад үндэслэн Basel стандартын Бүлэг 2-т тусгагдсан Хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP)-ыг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан, шат дараатайгаар нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.

Хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP) нь банкуудад учирч болзошгүй материаллаг түвшний эрсдэлүүдээс сэргийлэх хангалттай хэмжээний өөрийн хөрөнгө, хөрвөх чадвартай байх шаардлагыг нэмэгдүүлж, зохистой засаглал болон эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулахыг зорьдог. Энэ хүрээнд банкуудын 1) бизнес загварын үнэлгээ, 2) засаглал ба эрсдэлийн удирдлагын үнэлгээ, 3) өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдэл, 4) хөрвөх чадвар болон санхүүжилтийн эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэдэг (Зураг 14).

Зураг 14. Хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP)-ын хүрээнд үнэлэх үндсэн хэсгүүд



Хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP)-ыг нэвтрүүлэхэд банкуудын зүгээс өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP) болон хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ILAAP) бүхий дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байх шаардлагатай. Тус аргачлалуудын дагуу банкны тооцоолсон өөрийн хөрөнгийн хүрэлцээ, хөрвөх чадварын үзүүлэлтийг хяналт шалгалтын хүрээнд эрх бүхий байгууллагаас зохих шалгууруудын дагуу үнэлэхийн зэрэгцээ стресс тестийг гүйцэтгэж, үнэлгээний үр дүнгээр аливаа дутагдал илэрсэн тохиолдолд эрсдэлийг бууруулах, өөрийн хөрөнгийн хүрэлцээг сайжруулах зэрэг арга хэмжээг тухай бүрд авах боломжийг нэмэгдүүлнэ.

Базел стандартын Бүлэг 1-д тусгагдаагүй бусад материаллаг эрсдэлүүдийг үнэлэх, банкуудын өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын дотоод үнэлгээ, удирдлагыг оновчтой хийх чадварыг бэхжүүлэх, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэхэд хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP) нь чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн чуулганаар банкны системд нөлөө бүхий банкийг нээлттэй хувьцаат компани хэлбэрээр, бусад банкийг хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, банкны хувьцаа эзэмшилийн хэт төвлөрлийг бууруулж, өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх, улмаар банкны зохистой засаглалыг бэхжүүлэх үзэл баримтлал бүхий хуулийг баталсан.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 3 дугаар 3 дугаар сарын 26-ны өдрийн А-90/85 дугаар хамтарсан тушаалаар “Банкийг хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт тавих түр журам”-ыг баталсан. Тус түр журмын дагуу банкууд 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулагдах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцийг өөрчлөх төлөвлөгөөг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн бөгөөд одоогоор тус төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

Түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн А-262/262 дугаар тушаалаар “Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ыг батлуулсан. Тус журмын хүрээнд банк хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулагдах, хувьцаат компани хэлбэртэй банкны хувьцааг арилжих, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох зөвшөөрлийг олгох харилцааг зохицуулах бөгөөд уг журмын дагуу Богд банк 2022 онд хувьцаагаа нийтэд санал болгон анх удаагаа гаргаж, нээлттэй хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулагдаад байна.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу банкууд 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан байх шаардлагатай. Үүний хүрээнд хувьцаат компани хэлбэртэй банкны хяналт, зохицуулалтыг санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагууд харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах замаар хяналт шалгалтын давхардал үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллах болно.

Стратеги

- Банкны өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын дотоод үнэлгээ, удирдлагыг оновчтой хийж, гүйцэтгэх чадварыг бэхжүүлэх зорилгоор Basel III цуврал стандартад тусгагдсан аргачлалуудыг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан нэвтрүүлэх.
- Хяналт шалгалтын аргачлалыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх хүрээнд зохицуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх.
- Банкны салбарын эрсдэл даах чадварыг бэхжүүлэх зорилгоор банкны хяналт шалгалтын хүрээнд тогтоосон олон улсын стандарт, банкны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Базел стандартын Бүлэг 2-т заасны дагуу банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP)-ыг холбогдох журам, зөвлөмжид тусгаж, банкны системд үзүүлэх нөлөө, эрх зүйн орчин зэрэгтэй уялдуулан шат дараатайгаар хэрэгжүүлэх хугацааг тогтоох.
- Базел стандартын Бүлэг 2-ын хяналт шалгалтын үнэлгээний аргачлалыг (SREP) нэвтрүүлэх зорилгоор холбогдох журам, зөвлөмжийг шинэчлэх.
- Банкуудын хөрвөх чадварыг дотооддоо үнэлэх аргачлал (ILAAP)-ыг Базел III стандартын хөрвөх чадварын зохицой харьцааг нэвтрүүлэх хугацаатай уялдуулан хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх.
- Хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP)-ын хүрээнд макро стресс тест, банкуудын бизнес загварын үнэлгээг гүйцэтгэх.
- Хувьцаат компанийн хэлбэртэй банкны хяналт, зохицуулалтыг санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах замаар хяналт шалгалтын давхардал үүсгэхгүй байх нөхцөлийг бурдүүлэх.

ЗОРИЛТ 2.2

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх хүрээнд банкны салбарын макро стресс тестиийн аргачлалыг боловсронгуй болгож, системийн болон тухайлсан банкны эрсдэлийн үнэлгээг нэвтрүүлнэ.

Үндэслэл

Гадаад орчны эрсдэл нэмэгдэж тодорхой бус байдал дунд хугацаанд үргэлжилвэл дотоод эдийн засагт сөргөөг нөлөөлж улмаар санхүүгийн салбарын эмзэг байдлыг нэмэгдүүлэн эрсдэл хуримтлагдах нөхцөл байдлыг бий болгож болзошгүй юм.

Иймд гадаад, дотоод эдийн засгийн сөрөг нөлөөгөөр банкны салбар болон банкуудад учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлох, санхүүгийн тогтвортой байдал муудахаас сэргийлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлэх үүднээс системийн эрсдэлийн шинжилгээний аргачлалуудыг хөгжүүлж хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Олон улсад үүссэн санхүүгийн хямралын үр дагавар, сургамжид суурилан дэлхийн улс орнуудаас ирээдүйд чиглэсэн шинжилгээний арга зүйг сайжруулах, банкны системийн тогтвортой, уян хатан байдлыг хангах чиглэлд макро стресс тестиийн аргачлалыг эрчимтэй ашиглаж ирлээ.

Түүнчлэн банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд Базел стандартын Бүлэг 2-ын хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP), банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP), төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дотооддоо үнэлэх аргачлал (ILAAP)-ийг шат дараатай мөрдүүлэхэд банкны салбарын Макро стресс тестиийн аргачлалыг уялдуулан нэвтрүүлэх шаардлагатай юм.

Монгол Улсын банкны системийн хувьд макро стресс тестиийн загварчлалыг боловсруулснаар банкуудын эрсдэл даах чадвар, төлбөрийн чадварын эрсдэлүүдийг үнэлэх арга зүй, техникийг сайжруулахаас гадна, дотоод болон гадны шинжтэй гэнэтийн шокууд тухайн нэг банк, банк хоорондын хамаарлаар дамжуулан хэрхэн сөргөөр нөлөөлж болох, улмаар нийт банкны системд үүсэж болзошгүй санхүүжилтийн дутагдлын эрсдэлийг шинжлэх боломж бүрдэнэ.

Монголбанкнаас банкны салбарын тогтвортой байдал, эрсдэлийн шинжилгээний хүрээнд макро стресс тестиийн аргачлалыг боловсруулахаар олон улсын байгууллагууд болон тус чиглэлээр мэргэшсэн зөвлөхүүдтэй хамтран ажиллаж байна. Цаашид банкуудад тулгарч болох эрсдэлүүдийг хянах, гадаад болон дотоодын боломжит сөрөг нөлөөллийг урьдчилан тогтоосон таамаглалын

хүрээнд тооцоход макро стресс тестийн аргачлалыг системийн болон банкуудын эрсдэлийн үнэлгээнд нэвтрүүлж, тогтмол давтамжтайгаар стресс тест/мониторинг хийх нь чухал юм.

Стратеги

Монголбанк макро стресс тестийн аргачлал боловсруулахдаа доорх стратегийг баримтлан ажиллана:

- Макро стресс тестийн аргачлалыг Монгол Улсын макро эдийн засаг, санхүүгийн системийн онцлогт нийцүүлэн боловсруулж, тогтмол сайжруулан хөгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- Макро стресс тестийн аргачлалыг банкны систем болон банк тус бүрээрх эрсдэлийн шинжилгээнд нэвтрүүлж банкуудын эрсдэл даах чадвар, төлбөрийн чадварын эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Зохицуулагч байгууллагаас болон тухайн банкнаас хийх макро стресс тестийн шинжилгээний аргачлалууд (Top-Down, Bottom-Up approach)-ын хувьд олон улсын стандарт болон бусад орнуудын сайн туршлагыг судалж, Монгол Улсын макро эдийн засаг, банк санхүүгийн салбарын онцлогт тохирсон аргачлалыг боловсруулан хөгжүүлэх;
- Зохицуулагч байгууллагаас хийх макро стресс тестийн шинжилгээний аргачлал (Top-Down approach)-д ашиглагдах макро загварууд, суурь болон сөрөг сценари төсөөллийг тодорхойлж, шаардлагатай тоон мэдээллийг бэлтгэх, шинэчлэх;
- Эрсдэл даах чадвар (өөрийн хөрөнгийн хүрэлцээ) болон төлбөрийн чадварын эрсдэлүүдэд суурилсан загварчлал боловсруулах, эдгээр эрсдэлүүд банкуудын тайлан тэнцэл, зохистой харьцааны үзүүлэлтэд хэрхэн нөлөөлөх боломжтой эсэхийг тогтоох, шинжлэх;
- Тухайн банкнаас хийх стресс тестийн шинжилгээний аргачлал (Bottom-Up approach) аргачлалын хүрээнд банкны салбарын макро стресс тестэд ашиглах таамаглал, сценари төсөөллийг банкуудад нэгдсэн байдлаар хүргүүлэх, банкуудын зүгээс тус мэдээллийг ашиглан стресс тестийн дотоод үнэлгээг тооцож, мэдээлэх;
- Банкуудын стресс тестийн дотоод аргачлалд тулгуурласан шинжилгээний үр дүнг нэгтгэх, Top-Down аргачлалын үр дүнтэй харьцуулан шинжлэх;
- Дээрх аргачлалуудыг ашиглан банкуудын эрсдэл даах чадварын үнэлгээ, шинжилгээний үр дүнг тогтмол боловсруулж, холбогдох тайлан, мэдээнд тусгах.

ЗОРИЛТ 2.3

Банкны салбарын зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхийн шийдвэрийн үр дүнтэй байдлыг сайжруулах, харилцагчийн хууль ёсны эрхийг хамгаалах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг үргэлжлүүлнэ.

Үндэслэл

Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” 21 дүгээр тогтоолоор зээлийн хүүг 2019 оны суурь түвшнээс дөрвөн нэгж хувиар бууруулж, 2023 оны эцэст сарын нэг хувьд хүргэх зорилтыг тавьсан. Зээлийн хүүг бууруулах стратегийн зорилт, үр дүнд тогтсон хугацаанд хүрэх, стратегийн арга хэмжээг бодитой хэрэгжүүлэхийн тулд иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг үр дүнтэй хамгаалдаг байх зохицуулалт шаардлагатай байна.

Дээрх стратегийг хэрэгжүүлэх, зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах ажлын хүрээнд бизнес эрхлэгч хооронд (B2B)-ын болон бизнес эрхлэгч болон иргэн, санхүүгийн хэрэглэгч хооронд (B2C)-ын хэрэг, маргаан шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн бус журмаар өр төлбөр барагдуулахтай холбогдсон эрх зүйн орчин, тэдгээрийн хоорондын үүргийн харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 5 дугаар хавсралтад туссан байдаг. Энэ чиглэлд Монголбанкнаас ХЗДХЯ-тай хамтран ажиллаж байгаа бөгөөд Хууль зүй дотоод хэргийн сайдын 2022 оны 4 дугээр сарын 13-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар байгуулсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг тус хуулийн төслийг Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх зорилт тавин бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Зээлийн хүү нь эдийн засгийн суурь хүү болон үйл ажиллагааны зардал, санхүүгийн эрсдэлийн зардал буюу санхүүгийн зуучлалын өртгөөс хамаардаг. Монгол Улсад санхүүгийн эрсдэлийн зардал өндөр байгаа суурь хүчин зүйлийн нэг нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зохицуулалт, механизмыг бүрдүүлдэг голлох хуулийн зохицуулалт санхүүгийн зах зээлийн өнөөгийн хөгжлөөс хоцрогдолтой байгаагаас шалтгаалж байна. Тухайлбал, чанаргүй зээлээс улбаатай зээлийн эрсдэлийн сангийн зардал, чанаргүй авлагыг барагдуулахтай холбоотой хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зардал нь Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Компанийн тухай хууль, Дампуурлын тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Санхүүгийн түрээсийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Хөдлөх хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль болон холбогдох бусад хуулийн оновчтой бус зохицуулалт, хийдлээс шалтгаалж байна.

Зээлийн хүүг бууруулах стратегид зээлийн хүүгийн зардал өндөр байх, чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэхэд нөлөөлж байгаа дээр дурдсан хууль тогтоомжийг сайжруулах талаар тусгасан. Мөн Монгол Улсын Их Хурлын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүргэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Санхүүгийн түрээсийн тухай, Дампуурлын тухай, Компанийн тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудыг боловсронгуй болгох асуудлыг Засгийн газар санаачлах буюу түүний эрхлэх асуудлын хүрээнд хамааруулсан байдаг.

КОВИД-19 цар тахлын үед эдийн засгийг дэмжих хүрээнд иргэдийн зээл төлөх хугацааг хойшлуулсантай холбоотойгоор чанаргүй зээлийн түвшин хэвийн үзүүлэлттэй байгаа боловч зээл төлөлтийг хэвийн горимд шилжүүлэхэд чанаргүй зээлийн удирдлага, шийдвэрлэлт чухал бөгөөд энэ нь чанаргүй зээлийн огцом өсөлтөөс сэргийлэх чухал хүчин зүйл болно.

Иймд зээлийн хүүгийн зардлыг бууруулах, чанаргүй зээлийг бууруулах хүрээнд дээр дурдсан хуульд дор дурдсан агуулгатай өөрчлөлтийг оруулах хуулийн төслийг боловсруулж, нэн тэргүүнд өргөн мэдүүлэх шаардлагатай байна:

- Зээл төлөх хөшүүргийг ашиглаж, чанаргүй зээлийг төлүүлэх, барьцаа хөрөнгөөр зээлийн төлбөрийн үүргийг хангуулах ажиллагааг эрчимжүүлэх,
- Зээл төлүүлэх ажиллагааг шүүхийн бус журмаар шийдвэрлэх,
- Үүргийн гүйцэтгэлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хангуулах явцад хөрөнгийн үнэлгээ, эх үүсвэрийн өртгийг хадгалах, хамгаалах.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”, 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”, 2017-2022 оны “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-ийн хүрээнд Монголбанкнаас “Банк, санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Тус хөтөлберийн хүрээнд банк, санхүүгийн салбарын голлох хуулиудад тус салбарыг хөгжүүлж, тогтвортой байдлыг хангах, харилцагч, хадгаламж эзэмшигч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр зарчмын шинжтэй өөрчлөлт, шинэчлэл хийж байгаа билээ. Уг шинэчлэлийг үргэлжлүүлэн доор дурдсан хууль тогтоомжийн төсөл, төслийн саналыг зохих журмын дагуу хууль санаачлагчид уламжлах арга хэмжээг авах шаардлагатай байна.

Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн 2 дугаар зүйл, Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-өөр Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгох зорилт дэвшигүүлсэн байдаг. Монгол Улсад санхүүгийн хэрэглэгчийн эрх, түүний өнөөгийн нөхцөл байдлын талаар Дэлхийн банкнаас 2012 онд гаргасан «Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн суурь боловсролын өнөөгийн байдлын оношилгоо дүгнэлт» болон Азийн хөгжлийн банкнаас 2017 онд хийсэн «Монгол Улсын санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн болон зохицуулалтын өнөөгийн тогтолцоо ба түүнийг шинэчлэх төсөл»- судалгаа тус тус хийгджээ. Эдгээр судалгаанд “санхүүгийн зах зээлийн оролцогчид санхүүгийн үйлчилгээ авахдаа шаардлагатай мэдлэг, мэдээллийг үнэ төлбөргүй авах, зорчигдсөн эрхээ мэргэшсэн байгууллагаар хурдан шуурхай, чирэгдэл багатайгаар шийдвэрлүүлэх хууль, эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох, санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тусгайлсан эрх зүйн орчныг бүрдүүлэх” шаардлагатай тухай дүгнэж, зөвлөжээ.

Санхүүгийн салбарын хэрэглэгчид аливаа санхүүгийн үйлчилгээг авахад шаардлагатай мэдлэг, мэдээлэл, боловсролоор үнэ төлбөргүй хангуулах, зөрчигдсөн эрхээ эрх бүхий мэргэшсэн байгууллагаар хурдан шуурхай, чирэгдэл багатайгаар шийдвэрлүүлэх, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, тэдгээрт зохицуулагч байгууллагын зүгээс тавих хяналт, шалгалтыг өндөржүүлэх хууль, эрх зүйн зохицуулалт шаардлагатай байгаа нь практикаар ноглогдож байна. Иймд дээр дурдсан дүгнэлт, зөвлөмж, шаардлагыг үндэслэн Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооноос Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг олон улсын сайн туршлага, жишигт нийцүүлэн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлж байгаа санхүүгийн бутэгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагыг тогтоож, зохицуулагч байгууллагаас зохистой хяналт шалгалтаас гадна санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх агуулгаар боловсруулж байна.

Стратеги

- Зээлийн хүүг бууруулах, чанаргүй зээлийг шийдвэрлэх хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон суурь хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газраас баримталж байгаа хувийн эрх зүйн шинэчлэлийн бодлогын зорилт, төлөвлөгөөтэй уялдуулах.
- Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үсэж буй тулгамдсан асуудлын талаар олон нийтэд зөв ойлголт бүрдүүлэх, холбогдох судалгааны үр дүнг нийтэд танилцуулах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Хуулийн төслийн санал, холбогдох судалгааг Хууль тогтоомжийн тухай хуульднийцүүлэн тус хуульд заасны дагуу эрх бүхий хууль санаачлагчтай хамтран боловсруулах.
- Хуулийн төслийн санал, судалгааг хууль санаачлагчид уламжилж, хууль санаачлагчтай хамтран олон нийт, холбогдох бусад байгууллагаас санал авч хуулийн төсөлд тусгах.
- Хуулийн төслийг хэлэлцүүлж, батлуулахад хууль санаачлагч, Улсын Их Хурлын холбогдох байнгын хороотой хамтран ажиллах.
- Хуулийн төсөл батлагдсаны дараа хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хуулийн төслийг олон нийтэд таниулах, холбогдох дүрэм, журмыг баталж, мөрдүүлэх арга хэмжээ авах.

3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

ЗОРИЛТ 3.1

Дотоод, гадаад төлбөр тооцоог хэвийн үргэлжлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, төлбөрийн хэрэгслийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж, олон улсын зарчмын дагуу төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлнэ.

Үндэслэл

Төлбөрийн системийн бие даасан эрх зүйн орчныг бий болгох ажлын хүрээнд хэрэгжүүлсэн чухал ажлын нэг нь Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталж, 2018 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн Монгол Улсын “Үндэсний төлбөрийн системийн тухай хууль” юм. Хуулийн хэрэгжилтийг хангуулахтай холбоотойгоор Монголбанкнаас шаардлагатай эрх зүйн хэм хэмжээний акт, дүрэм, журам, заавар боловсруулах, хуульд заасан зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хяналт тавих зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Эдгээр үйл ажиллагааг явуулахад хуулийн зарим зүйл, заалт ойлгомжгүй, тодорхойгүй, давхардсан зөвшөөрөл олгох, зарим шаардлагатай арга хэмжээ авахад хуулиар олгосон бүрэн эрх хэмжээ хүрэхгүй зэрэг хүндрэл бэрхшээл гарч байгааг харгалzan үзэж, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг судалж, боловсронгуй болгож сайжруулах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар хүлээсэн үүргийн дагуу төлбөрийн системийн оролцогч банк, банкнаас бусад хуулийн этгээд болон төлбөрийн системүүдийн үйл ажиллагаа, тэдгээрийн хоорондын хамаарлыг зохицуулсан журам, дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьдаг. Хяналтыг хэрэгжүүлэхдээ зайнаас болон газар дээрх хяналт шалгалтыг тогтмол хийх, олон улсын стандартын дагуу системийн үнэлгээг хийж, бүтэц үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх зарчмыг баримтлан ажиллаж байна.

Монголбанк нь төлбөрийн системийн оролцогчийн зүгээс нэвтрүүлж буй төлбөрийн шинэ үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжих, учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зарчмыг Монголбанк баримтлан ажиллаж байна.

Төлбөрийн үйлчилгээ нь хамгийн эрчимтэй хөгжиж байгаа финтекийн нэг бөгөөд иргэд, байгууллагууд олон төрлийн төлбөрийн суваг, хэрэгсэл ашиглан өөр хоорондоо мөнгөн хөрөнгө шилжүүлэх, төлбөр тооцоо хийх нь жилээс жилд нэмэгдэж байна. Энэ нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг бий болгох давуу талтай ч нөгөө талаар шинэ эрсдэлийг дагуулж болзошгүй тул Монголбанк инновацыг дэмжихийн зэрэгцээ эрсдэлийг бууруулах

зохицуулалтыг сайжруулах шаардлагатай. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч финтек байгууллагууд Монголбанкнаас зөвшөөрөл авдаг болсноор иргэдийн финтект итгэх итгэлийг нэмэгдүүлж, хэрэглэгчдэд тулгарах хүндрэл, эрсдэлийг багасгах чухал алхам болсон.

Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээд болон финтек байгууллагаас ирүүлсэн зөвшөөрөл авах хүсэлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хянан шалгаж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, системийг тасралтгүй найдвартай ажиллуулах зэрэг шалгуур, шаардлагыг хангуулах зарчмыг баримтлан зөвшөөрөл олгох нь ирээдүйд үүсэх эрсдэлийг багасгах чухал ач холбогдолтой юм.

Өнөөгийн дэвшилтэд технологийн хөгжилд суурилсан аливаа эд, баялгаар баталгаажаагүй виртуал хөрөнгө, криптовалют гэх ойлголт эрчимжиж сүүлийн жилүүдэд дэлхийн эдийн засаг, санхүүгийн салбар тодорхой бус байдлыг нэмэгдүүлэх болсон. Энэ ойлголттой холбоотойгоор улс орнууд бэлэн бус төлбөр тооцоо давамгайлах болж, цахим мөнгийг хувийн хэвшлийн гаргаж, криптовалютын эрэлт хурдаатай нэмэгдэж байна. Иймээс, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилт хийгээд мөнгөний бодлого хэрэгжүүлэхэд эрсдэл үүсч болзошгүй байгааг харгалzan төв банкуудын зүгээс авч буй хариу арга хэмжээний нэг нь төв банкнаас өөрийн цахим мөнгө (ТБЦМ) гүйлгээнд гаргах санаачилгыг дэвшигүүлж байна. Бидний зүгээс хууль эрх зүй, дэд бүтэц, хүний нөөцийг хөгжүүлэх бусад орнуудын адилаар олон улсын болон өөрийн орны түвшинд ТБЦМ-ний талаарх хийгдэж буй судалгаа, шинжилгээний үр дүнг харьцуулах, хөгжүүлэх улмаар өөрийн орны онцлогт тохирох загвар, технологийн шийдлийг тодорхойлох нь нэн тэргүүний зорилт болж байна.

Стратеги

Төлбөрийн системийн эрх зүйн орчныг бэхжүүлэх зорилгоор холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангахад гарч буй хүндрэл бэрхшээл, давхардал, хийдэл байгаа эсэхэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, холбогдох системийн оролцогчдоос санал авч тусгах замаар олон улсын шилдэг технологийг нутагшуулах, санхүүгийн үйлчилгээний инновацийг дэмжиж ажиллана.

Төв банкны цахим мөнгө гаргах талаар бусад улс орон, төв банкуудын хийсэн судалгаа, зөвлөмжүүдэд үндэслэн Монгол улсын нийгэм, эдийн засаг, санхүүгийн зах зээлийн онцлогт тохирсон ТБЦМ, түүний хамрах хүрээ, үйл ажиллагааны загвар, технологийн шийдлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, дараа дараагийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулж зорилтынхоо хүрээнд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг дагаж мөрдөхөд тулгарч байгаа хүндрэл, холбогдох бусад хуультай үүсч байгаа давхардал, хийдэл байгаа эсэхийг тодорхойлж тус хуулийг шинэчлэн найруулгын төслийг боловсруулах.
- Төлбөрийн хэрэгслийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж ажиллах зорилтынхоо хүрээнд Төлбөр тооцооны газар нь Азийн хөгжлийн банкны «Төлбөрийн системийн шинэчлэл төсөл»-ийн санхүүжилтээр 2022 онд Төв банкны Үндсэн бүртгэлийн систем, Их өгөгдөл (Big data), Token баталгаажуулах систем гэсэн дэд системийг шинээр нэвтрүүлэхээр ажиллаж байна. Эдгээр систем нь төлбөр тооцооны системд шинэ технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн тул эрх зүйн зохицуулалтыг хийх шаардлагатай бөгөөд «Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам» болон холбогдох системийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.
- Монголбанк төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах хүрээнд төлбөрийн системийн оролцогчдын шалгалт, операторын шалгалт, цахим мөнгөний шалгалт, ирүүлсэн санал, гомдлын дагуу хийх гэнэтийн шалгалтуудыг газар дээр хийх.
- Зайнаас тавих хяналтын хүрээнд тасралтгүй ажиллагааны тайлан, хөдөлгөөнт банкны тайлан, төлбөрийн системийн тайлан болон цахим мөнгөний тайланг тус боловсруулах.
- Төв банкны цахим мөнгө гаргах судалгааны ажлыг үргэлжлүүлж, үр дүнд суурилан технологийн шийдлийг гаргах.

ЗОРИЛТ 3.2

Иргэд болон бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүү, эдийн засгийн суурь мэдлэг олгох ажлыг үргэлжлүүлнэ.

Үндэслэл

Санхүүгийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаанд хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд иргэдийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх асуудал ач холбогдол өндөр хэвээр байна. Мөн КОВИД-19 цар тахлаас үүдэлтэйгээр дэвшилтэт технологи өргөнөөр нэвтэрч, банк, санхүүгийн салбар хөгжин, санхүүгийн зуучлал гүнзгийрэхийн хэрээр санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл олширсоор байна.

Санхүүгийн суурь мэдлэгийг иргэн өөрийн нөхцөл байдалд тохируулан санхүүгийн зохистой шийдвэр гаргах, арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, хандлагыг хэлнэ хэмээн тодорхойлон “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг 2016-2021 онуудад 1) Сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох; 2) Залуу үед санхүүгийн мэдлэг олгох; 3) Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох; 4) Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэсэн 4 тэргүүлэх чиглэлээр хэрэгжүүллээ. Дээрх хөтөлбөрийн үнэлгээг 2019 онд хийж хөтөлбөрийн нөхцөл байдал, хөтөлбөр хэрэгжсэнээр гарсан өөрчлөлт, хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах хүрээнд анхаарвал зохих асуудлыг тодорхойлон, санал зөвлөмж өгсөн бөгөөд хөтөлбөрийн хүртээмжийг сайжруулах болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг үргэлжлүүлэх шаардлага хэвээр байна.

Төв банкууд эдийн засгийн суурь мэдлэг, ойлголт, ухагдахуунууд болох инфляц, валютын ханш, ДНБ, төлбөрийн тэнцэл зэрэг үзүүлэлтүүдийн мэдлэгийг олон нийтэд энгийн байдлаар болон

боловсролын хөтөлбөртөө багтаан хүргэж байна. Иймд Төв банкнаас мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлд итгэлийг дээшлүүлэх зорилгоор Төв банкны мэдлэг буюу эдийн засгийн суурь мэдлэгийг иргэд олон нийтэд олгох ажлыг үргэлжлүүлэх шаардлага үүсэж байна.

Стратеги

- Монголбанкнаас санаачлан төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 2016-2021 онуудад “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөрийн үргэлжлэл болгон иргэдэд эдийн засгийн мэдлэг олгох ажлыг үйл ажиллагааны чиглэлдээ тусган ажиллах.
- Иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь санхүүгийн харилцагчийг дунд болон урт хугацаанд санхүүгийн хүндрэлд орох эрсдэлээс хамгаалах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

Хүүхэд залууст санхүүгийн суурь мэдлэг олгох ажлын хүрээнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгагдсан сонгон судлах “Бизнес суддал” хичээлийг сонгон суралцах хүртээмжийг нэмэгдүүлэх.
- Оюутан залууст зориулсан санхүүгийн мэдлэг олгох идэвхжүүлэлтийн арга хэмжээнүүдийг зохион байгуулах.

Иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн мэдлэг олгох ажлын хүрээнд:

- Санхүүгийн мэдлэг түгээх сургагч багш нарыг үргэлжлүүлэн бэлтгэх.
- Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах
- Иргэдэд цахим сургалт, контент хийж үр дүнтэй түгээхэд чиглэсэн технологийн дэвшлүүдийг ашиглана;

Эдийн засгийн мэдлэг олгох ажлын хүрээнд:

- Иргэдийн эдийн засгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгаа хийх.
- Эдийн засгийн мэдлэг олгох дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах.

ЗОРИЛТ 3.3

Монголбанкны бодлого, үйл ажиллагаанд их өгөгдлийг ашиглах бэлтгэл ажлын хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн үе шаттайгаар хөгжүүлнэ.

Үндэслэл


Монголбанк өнгөрсөн жилүүдэд макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн шинжилгээнд их өгөгдлийг ашиглах техникийн болон мэргэшлийн ур чадварыг үе шаттайгаар бүрдүүлэх зорилтыг 2022 онд баримтлах үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд банкны системийн цахим баримт бичгийг мэдээллийн сүлжээний тусгайлсан нэг шугамаар цуглувалж, хадгалах, боловсруулах, ашиглах зорилготой мэдээллийн системийг нэвтрүүлэх ажлыг амжилттай гүйцэтгэлээ. Энэхүү мэдээллийн систем нь Монголбанкны мэдээлэл цуглувалах, хадгалах үйл ажиллагааны дэс дараалал, үйл явцыг өөрчлөх учраас мэдээллийн урсгалын тогтолцоо болон мэдээллийн аюулгүй байдлын менежментийг шинэ системтэй уялдуулан зохион байгуулах нөхцөл шаардлагыг бий болгож байна.

Монгол Улс 2022 оны байдлаар дэлхийн 160 орноос Дижитал хөгжлийн түвшнээр 92-т эрэмбэлэгджээ (Зураг 15). Харин Кибер аюулгүй байдлын индексээр дэлхийд 125-д жагссан

бөгөөд дижитал хөгжлийн түвшин болон кибер аюулгүй байдлын индексийн зөрүү хамгийн өндөр 15 дахь улс болж байна. Олон улсын жишгээс харахад Монгол Улсын дижитал хөгжлийн түвшин (46.4)-д харгалзах кибер аюулгүй байдлын индекс 39.0 байхаас ердөө 18.2 буюу хоёр дахин сүл үзүүлэлттэй байна. Олон улсын харилцаа холбооны байгууллагаас гаргасан тооцооллоор манай улсын цахим аюулгүй байдлын хувьд боловсон хүчин болон бүтэц зохион байгуулалтын хүчин зүйлс хамгийн сүл үнэлэгджээ.

Монгол Улсын Их хурлаас 2021 оны 12 сарын 17-ны өдөр Кибер аюулгүй байдлын тухай хууль баталсан бөгөөд Монголбанк, Монголбанкны үндэсний цахим гүйлгээний төв нь онц чухал мэдээллийн дэд бүтээцтэй байгууллагын жагсаалтад багтсан. Энэ хуулийн 9.4 дэх заалтын дагуу тагнуулын байгууллагаар, эсвэл түүний зөвшөөрснөөр мэдээллийн аюулгүй байдлын аудитыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээдээр мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэх тухай заасан. Монголбанк “Цахим хөгжлийн багц хууль” болон олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн өөрийн мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог MNS ISO/IEC 27001:2021 стандартын дагуу шинэчлэн зохион байгуулж, шаардлагатай өөрчлөлтүүдийг үе шаттай нэвтрүүлэх, заасан хугацаанд хөндлөнгийн аудитаар үнэлгээ тогтмол хийлгэж, өөрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны чанарыг баталгаажуулдаг болох шаардлага зүй ёсоор тавигдаа боллоо.

Зураг 15. Цахим аюулгүй байдлын индекс



Эх сурвалж: National Cyber Security Index

Эх үүсвэр: ITU Global Cybersecurity Index v4, 2020

Өгөгдлийн аюулгүй байдлын менежментэд дараах бүрэлдэхүүнүүдийг хамруулан ойлгож байгаа тул эдгээр бүх чиглэлд анхаарал хандуулах ёстой болж байна. Үүнд:

- Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, зорилт
- Мэдээллийн эрсдэлийн үеийн авч хэрэгжүүлэх арга хэмжээ
- Эрсдэлийг бууруулах төлөвлөгөө
- Эрсдэлийн үнэлгээний тайлан
- Боловсон хүчиний сургалт, ажлын туршлага болон ур чадварын батламж
- Хяналт, үнэлгээний үр дүн
- Дотоод аудитын төлөвлөгөө
- Дотоод аудитын дүгнэлт
- Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн дүгнэлт
- Сайжруулах арга хэмжээний дүгнэлт

Стратеги

Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх замын зураглалыг боловсруулж, Цахим хөгжлийн багц хуультай уялдуулан олон улсын стандартыг төв банкны хэмжээнд шинээр нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй мэдээллийн аюулгүй байдлын менежмент болон олон улсын стандартын хооронд зөрүүг тодорхойлох үнэлгээ хийх
- Цахим аюулгүй байдлын чиглэлд боловсон хүчинийг бэлтгэх, дахин сургах чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, сайн туршлагуудыг судлах.

ЗОРИЛТ 3.4

Монгол Улсын гүйлгээнд хүчин төгөлдөр ашиглаж буй мөнгөн тэмдэгтийн эдийн засгийн үр ашиг бүхий зохиостой бүтцийг судалж, танилцуулна.

Үндэслэл

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжин орж, шинэ Үндсэн хууль батлагдсантай холбоотойгоор 1993-1995 онуудад мөнгөн тэмдэгтүүдээ шинэ загвартайгаар хэвлэж, гүйлгээнд гаргасан. Энэ хугацаанд 20,000-тын дэвсгэрийг 2006 онд хэвлэж гаргаснаас хойш шинэ дунтэй аливаа дэвсгэрт гаргаагүй. Одоогоор Монгол Улсын бэлэн мөнгөний гүйлгээнд 1-т, 5-т, 10-т, 20-т, 50-т, 100-т, 500-т, 1000-т, 5000-т, 10000-т, 20000-тын гэсэн нийт 11 төрлийн цаасан тэмдэгт хүчин төгөлдөр ашиглагдаж байна.

Мөнгөн дэвсгэртүүдийг анх гаргаснаас хойших 29 жилийн хугацаанд мөнгөн тэмдэгтийн бүтэц, худалдан авах чадварт дараах өөрчлөлтүүд гарчээ:

- Монгол Улсын эдийн засаг өсөн томорч, 1993 онд 227 тэрбум төгрөг байсан нэрлэсэн дотоодын нийт бүтээгдхүүн (ДНБ) 2021 онд 43.0 их наяд төгрөгт хүрч, 189 дахин өссөн байна. Инфляциаас шалтгаалан 1993 оноос хойш манай улсын мөнгөн тэмдэгтүүдийн дотоод худалдан авах чадвар буурсан. Тухайлбал, өнөөгийн байдлаар 1, 5, 10, 20 төгрөгийн хувьд дотоод дахь бодит худалдан авах чадваргүй байгаагийн зэрэгцээ тэдгээрийг үйлдвэрлэх зардал нэрлэсэн өртгөөсөө өндөр байна. 20,000-тын мөнгөн дэвсгэрийн бодит худалдан авах чадварыг инфляциаас хамааруулан өнөөгийн байдлаар тооцвол анх гүйлгээнд гаргаж байсан үеэс 70 хувиар буурсан буюу 5960 төгрегтэй (2006 оны үнээр) тэнцэж байна.
- Мөнгөн дэвсгэрийн худалдан авах чадвар муудсаар байгааг харуулах өөр нэг хүчин зүйл нь түүний гадаад валюттай харьцах ханш юм. Хамгийн том дэвсгэрт болох 20,000 төгрөгийн хувьд анх гүйлгээнд гаргаж байсан 2006 онд 17 ам.доллартай тэнцэж байсан бол 2022 оны эхний хагас жилийн байдлаар 6.4 ам.доллартай тэнцэж байгаагаас узэхэд гадаад худалдан авах чадвар 2.6 дахин буурсан байна. Гэтэл манай улстай орлогын түвшнээрээ ойролцоо улсуудын хамгийн том мөнгөн дэвсгэрт нь дунджаар 40 ам.доллартай тэнцэж байна.
- Сүүлийн жилүүдэд 20,000-тын мөнгөн дэвсгэрийн хэрэглээ эрс өсөж байна. Тухайлбал, дэвсгэрийн тоогоор нийт гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний 8.1 хувийг эзэлж байгаа бол мөнгөн дүнгээр 67 хувийг дангаараа эзэлж байна. Үүнийг мэргэжилтнүүд хамгийн том дунтэй дэвсгэртэд ирэх ачаалал хэт ихэссэн гэж үздэг.
- Үндэсний статистикийн хороо (YCX)-ны мэдээгээр 2019 онд улсын хэмжээнд нэрлэсэн дундаж сарын цалин 1,124,300.00 төгрөг (394.5 ам.доллар) байсан бөгөөд үүнийг бэлнээр авах, төлөх шаардлагатай гэж үзвэл 56 ширхэг 20,000-тын мөнгөн тэмдэгт эсвэл 112

ширхэг 10,000-тын мөнгөн тэмдэгт шаардлагатай болно. Хөгжиж буй бусад орнуудтай харьцуулж үзэхэд дундаж цалинг том дүнтэй дэвсгэртээр бэлнээр олгоход 5-6 ширхэг дэвсгэрт шаардагддаг байна. Өөрөөр хэлбэл, манай улсын төв банк зохистой хэмжээнээс 10 дахин их дэвсгэрт ашиглаж байна.

- Дэвсгэргийн тооны хувьд 11 төрлийн цаасан тэмдэгт байгаа хэдий ч 1-т, 5-т, 10-т, 20-тын дэвсгэртүүд цөөн тохиолдолд мөнгөний хариултад ашиглагдах төдийгөөр хязгаарлагдаж, тэдгээрийн худалдан авах чадвар нь тэг байгаагаас ялангуяа 1-т, 5-тын дэвсгэргийг ихэвчлэн зориулалтын бусаар ашиглах хандлага нэмэгдсэн. Үүнээс шалтгаалан эдгээр жижиг дүнтэй дэвсгэртүүд Монголбанканд болон банкуудад буцан орж ирэхгүй байна.
- Өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний дотоодын жижиглэнгийн зах зээл дээрх үнийг судалж үзэхэд өнөөдөр хамгийн хямд бараа 100-200 төгрөг (орос чүдэнз, ширхгийн бохь, найруулдаг цай) төгрөг байна. Улаанбаатар хотын гэр хорооллын ус түгээх худагт 10 литр усыг 10 төгрөгөөр худалдаж байна. Үнийн хувьд Номин хүнсний сүлжээ дэлгүүрийн барааг төлөөлөл болгон авч үзвэл ихэвчлэн үнийн хувьд 1249, 1319, 2679, 6559, 999 гэх мэт тогтоогдсон байна.

Эдгээр энгийн тооцоонаас харахад Монгол Улсын гүйлгээнд хүчин төгөлдөр байгаа мөнгөн тэмдэгт өнөө цагт:

- Инфляцаас шалтгаалан үнэгүйдэлд орсон,
- Үнэгүйдэлд орсноос шалтгаалан жижиг дэвсгэргийг хэвлэх өртөг нь нэрлэсэн үнээс өндөр байх болсон,
- Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн урт хугацааны үргэлжилсэн суралтаас шалтгаалан гадаад худалдан авах чадвар муудсаар байна.

Түүнчлэн хэт олон тооны буюу 11 төрлийн цаасан дэвсгэргийн төрөлтэй байгаа нь оновчгүй, үр ашиг муутай бүтэц болж хувирсан байгаа тул Монголбанк цаашид бүтцэд нь шинэчлэл хийх шаардлагатай юм. Монголбанк энэ чиглэлээр олон улсад ашигладаг түгээмэл аргачлалуудыг ашиглан судалгаа, тооцоог хийж байна.

Төгрөгийн худалдан авах чадварын уналтаас шалтгаалан манай орны мөнгөн тэмдэгтийн зохистой бүтэц алдагдаад байна. Тухайлбал, манай улстай ойролцоо түвшний хөгжиж буй бусад орнуудтай харьцуулж үзэхэд эдийн засагт байх зохистой хэмжээнээс 9 дахин их тооны дэвсгэрт гүйлгээнд ашиглаж байна. Үүний зэрэгцээ хэвлэх өргөөс хэд дахин бага нэрлэсэн дүнтэй, гүйлгээнд бараг ашиглагдахгүй дэвсгэртүүд (1-т, 5-т, 10-т) ч нэмэгдэж байна. Хамгийн том дүнтэй дэвсгэрт болох 20,000-тад ирэх ачаалал нэмэгдэж, бодит худалдан авах чадвар муудсаар байна.

Стратеги, арга хэмжээ

Монгол Улсын мөнгөн тэмдэгтийг эдийн засгийн ач холбогдол бүхий үр ашигтай зохистой бүтэцтэй болгох, үүний тулд шаардлагагүй зарим жижиг дэвсгэртүүдийг гүйлгээнээс хасах, 20,000-таас илүү том нэрлэсэн дүнтэй мөнгөн дэвсгэрт гаргах арга хэмжээг авах хэрэгцээ үүсэж байна. Ингэснээр Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн бүтэц дэх үр ашиггүй байдлыг бууруулж, бүтцийг сайжруулна. Том дүнтэй мөнгөн дэвсгэрт гүйлгээнд гаргасны дараа бусад олон тооны жижиг дэвсгэртүүдийн хэрэглээ буурч, эргэлт нь удааширснаар богино хугацаанд дахин дахин үйлдвэрлээд байх хэрэгцээ буурна. Учир нь 1) бага дүнтэй мөнгөн тэмдэгтийн насжилт нь том дүнтэй мөнгөн тэмдэгтээс богино байдаг, 2) бага дүнтэй дэвсгэрт олныг хэвлүүлэхийн оронд том дүнтэй цөөн дэвсгэрт хэвлүүлнэ. Мөн Төв банкны хувьд тоолох, ялгах, ангилах, тээвэрлэх, хадгалах, бүртгэх, хэвлүүлэх зардал буурах зэрэг үйл ажиллагаатай холбоотой бусад зардал, цаг хугацаа хэмнэх ач холбогдолтой юм.

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2023 ОНД БАРИМТЛАХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үндсэн чиглэлийн төслийн заалт	Заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээ
1. Мөнгөний болон макро зохистой бодлогын хүрээнд:		
1	1.1. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2023 онд нэг оронтой тоонд, дунд хугацаанд +/- 2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтвортжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ.	<p>Мөнгөний бодлогын шийдвэр гаргалтанд шаардлагатай макро эдийн засгийн ирээдүйн төсөөлөл, мөнгөний бодлогын шинжилгээг цогцоор нь хийх</p> <p>Инфляцын төсөөлөл, макро эдийн засгийн ирээдүйн төлөвийг тусгасан, инфляцын зорилтыг хангах бодлогын хувилбаруудыг агуулсан бодлогын саналыг боловсруулж, Мөнгөний бодлогын хороонд танилцуулах</p> <p>Инфляцын зорилтыг хангахад шаардлагатай бодлогын шийдвэрийг гаргах мөнгөний бодлогын хорооны хурлыг улирал тутам, шаардлагатай тохиолдолд тухай бүр зохион байгуулах</p> <p>Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл, түүний үндэслэл, танилцуулгыг нэгтгэн боловсруулах, тооцоо судалгааг хийх</p> <p>Мөнгөний бодлогын шийдвэрийн үндэслэлийг олон нийтэд тайлбарлах, таниулах</p>
2	1.2. Санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийн шинжилгээ, мониторингийг сайжруулан, эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.	<p>Банкны системийн эрсдэлийг шинжилгээ, макро зохистой бодлогын үр нөлөөг тооцох шинжилгээний аргачлал, индикаторууд, холбогдох загварыг олон улсын туршилагад нийцүүлэн хөгжүүлж, бодлогын шийдвэр гаргалтанд нэвтрүүлэх</p> <p>Зээлийн өсөлтийг тогтвортжуулахад чиглэсэн макро зохистой бодлогын оновчтой арга хэрэгслийг тодорхойлж, холбогдох бодлогын арга хэмжээг авч ажиллах</p> <p>Банкны системийн тогтвортой байдлын эрсдэлийг тогтмол хянаж, шаардлагатай тохиолдолд макро зохистой бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах</p> <p>Санхүүгийн мөчлөгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, мониторинг хийх</p>

		<p>Мөнгөний бодлогын мэдэгдлийг олон улсын зөвлөхүүдийн өгсөн зөвлөмжийн дагуу ирээдүйн бодлогын шийдвэрийн дохиог өгдөг болгон сайжруулах</p> <p>Инфляцын тайлангийн агуулгыг бодлогын шийдвэрийн үндэслэл, инфляцын хүлээлтийн судалгаагаар өргөжүүлэх, дизайныг улам сайжруулах;</p> <p>Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийг олон нийтэд танилцуулах, тайлбарлах бүтээгдэхүүнүүдийн үндсэн агуулга, найруулгын уялдааг хангах, ойлгомжтой болгох;</p> <p>Мөнгөний бодлогын шийдвэрийг танилцуулах хэвлэлийн хурлыг урьдчилж товлосон хуваарийн дагуу зохион байгуулах;</p> <p>Мөнгөний бодлоготой холбоотой контентуудыг тогтсон давтамжтайгаар, урьдчилж зарласан хуваарийн дагуу олон нийтэд хүргэх үүднээс дотоод үйл ажиллагаа, мэдээлэл дамжих процесийг илүү үр ашигтай болгох;</p> <p>Санхүүгийн тогвортой байдлын тайланг сайжруулах, олон улсын зөвлөхүүдийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх</p> <p>Санхүүгийн тогвортой байдлын шинжилгээ, олон нийтэд мэдээлэл түгээх арга хэлбэрийг тогтмол сайжруулах</p> <p>Төв банкны дотоод мэдээллийн урсгалд үнэлэлт дүгнэлт өгч, хүний нөөцөө оновчтой зохион байгуулах</p> <p>Олон нийттэй харилцах бодлогын баримт бичгүүдийг шинэчлэх</p> <p>Төв банкны олон нийттэй харилцах харилцааны сувгуудад шаардлагатай өөрчлөлт сайжруулалтуудыг хийх</p> <p>Монголбанкны вебсайтыг шинэчилж, сайжруулах</p> <p>Мэдээллийг түгээхдээ технологийн дэвшлүүдийг нэвтрүүлж, ашиглах</p> <p>Мэдээллийн хүртээмж бага орон нутагт мэдээлэл түгэх үр дүнтэй сувгуудыг хөгжүүлэх;</p> <p>Залуу үеийн хэрэглээнд нийцсэн мэдээллийн сувгуудыг хөгжүүлэх, контент боловсруулж түгээх;</p> <p>Төв банкны олон нийттэй харилцах харилцааны олон улсын сайн жишгийг судалж нэвтрүүлэх, олон улсын байгууллагатай хамтран ажиллах</p>
3	1.3.	Төв банк олон нийттэй харилцах харилцаандаа ил тод байдлын зарчим баримталж, олон улсын сайн туршлагыг өөрийн орны онцлогт нийцүүлэн хөгжүүлж, ашиглана.

2. Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд:	
4	“Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP), өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP), хөрвөх чадварыг дотооддоо үнэлэх аргачлал (ILAAP)-ыг банкны хяналт шалгалтын журам, зааварт нэвтрүүлэх, аргачлалыг боловсруулах.
	Олон улсын улсын сайн туршлагад үндэслэн ICAAP, ILAAP, SREP-г нэвтрүүлэхтэй холбоотой суурь судалгааг хийж гүйцэтгэх.
	Базел стандартын Бүлэг 2-ын өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP)-ыг холбогдох журам, зөвлөмжид тусгаж, банкны системд үзүүлэх нөлөө, эрх зүйн орчин зэрэгтэй уялдуулан шат дараатайгаар хэрэгжүүлэх хугацааг тогтоох.
	Базел стандартын Бүлэг 2-ын хяналт шалгалтын үнэлгээний аргачлалыг (SREP) нэвтрүүлэх зорилгоор холбогдох журам, зөвлөмжийг шинэчлэх.
	Базел стандартын Бүлэг 2-ын банкуудын хөрвөх чадварыг дотооддоо үнэлэх аргачлал (ILAAP)-ыг Базел III стандартын хөрвөх чадварын зохистой харьцааг нэвтрүүлэх хугацаатай уялдуулан хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх.
	Хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP)-ын хүрээнд макро стресс тест, банкуудын бизнес загварын үнэлгээг гүйцэтгэх.
	Хувьцаат компани хэлбэртэй банкны хяналт, зохицуулалтыг санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах замаар хяналт шалгалтын давхардал үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ

		Банкны салбарын стресс тестийн загварчлалыг Top-Down (зохицуулагч байгууллагаас хийх) аргачлалын хүрээнд боловсруулах, хөгжүүлэн шинэчлэх
5	2.2. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх хүрээнд банкны салбарын макро стресс тестийн аргачлалыг боловсронгуй болгож, системийн болон тухайлсан банкны эрсдэлийн үнэлгээг нэвтрүүлнэ.	Стресс тестэд ашиглагдах таамаглал, сценар төсөөллийг бэлтгэх, мөн макро төсөөллүүдийг банкуудад нэгдсэн байдлаар хүргүүлэх, банкуудын зүгээс тус мэдээллийг ашиглаж өөрсдийн дотоод аргачлалд тулгуурласан стресс тестийг гүйцэтгэх, үр дүнг мэдээлэх;
		Стресс тестийн шинжилгээнд ашиглагдах зээлийн эрсдэлийн параметрүүдийн тооцооллыг боловсронгуй болгох, шинэчлэх
		Банкны дотоод аргачлалд тулгуурласан стресс тестийн шинжилгээний үр дүнг нэгтгэх, зохицуулагч байгууллагаас хийсэн шинжилгээний үр дүнтэй харьцуулан шинжлэх;
		Зохицуулагч байгууллагаас (Top-Down) болон банкуудаас (Bottom-Up) хийх стресс тестийн аргачлалуудыг ашиглан банкуудын эрсдэл даах чадварын үнэлгээ, шинжилгээний үр дүнг тогтмол боловсруулж, холбогдох тайлан, мэдээнд тусгах.
6	2.3. Банкны салбарын зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхийн шийдвэрийн үр дүнтэй байдлыг сайжруулах, харилцагчийн хууль ёсны эрхийг хамгаалах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг үргэлжлүүлнэ.	Хуулийн төслийн санал, холбогдох судалгааг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулах
		Хуулийн төслийн санал, судалгааг хууль санаачлагчид уламжилж, хууль санаачлагчтай хамтран олон нийт, холбогдох бусад байгууллагаас санал авч хуулийн төсөлд тусгах
		Хуулийн төслийг хэлэлцүүлж, батлуулахад хууль санаачлагч, Улсын Их Хурлын холбогдох байнгын хороотой хамтран ажиллах
		Хуулийн төсөл батлагдсаны дараа хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хуулийн төслийг олон нийтэд таниулах, холбогдох дүрэм, журмыг баталж, мөрдүүлэх арга хэмжээ авах.

3. Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:	
	Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулж зорилтынхоо хүрээнд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг дагаж мөрдөхөд тулгарч байгаа хүндрэл, холбогдох бусад хуультай үүсч байгаа давхардал, хийдэл байгаа эсэхийг тодорхойлж тус хуулийг шинэчлэн найруулгын төслийг боловсруулах.
7	<p>3.1. Дотоод, гадаад төлбөр тооцоог хэвийн үргэлжлэх нөхцлийг бүрдүүлнэ. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, төлбөрийн хэрэгслийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж, олон улсын зарчмын дагуу төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлнэ.</p>
	Төлбөрийн хэрэгслийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж ажиллах зорилтынхоо хүрээнд Төлбөр тооцооны газар нь Азийн хөгжлийн банкны “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”-ийн санхүүжилтээр 2022 онд Төв банкны Үндсэн бүртгэлийн систем, Их өгөгдөл (Big data), Token баталгаажуулах систем гэсэн дэд системийг шинээр нэвтрүүлэхээр ажиллаж байна. Эдгээр систем нь төлбөр тооцооны системд шинэ технологид сууриссан шинэлэг бүтээгдэхүүн тул эрх зүйн зохицуулалтыг хийх шаардлагатай бөгөөд “Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам” болон холбогдох системийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.
	Монголбанк төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах хүрээнд төлбөрийн системийн оролцогчдын шалгалт, операторын шалгалт, цахим мөнгөний шалгалт, ирүүлсэн санал, гомдлын дагуу хийх гэнэтийн шалгалтуудыг газар дээр хийх.
	Зайнаас тавих хяналтын хүрээнд тасралтгүй ажиллагааны тайлан, хөдөлгөөнт банкны тайлан, төлбөрийн системийн тайлан болон цахим мөнгөний тайланг тус боловсруулах
	Төв банкны цахим мөнгө гаргах судалгааны ажлыг үргэлжлүүлж, үр дүнд суурilan технологийн шийдлийг гаргана.

		<p>Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгагдсан сонгон судлах “Бизнес судлал” хичээлийг сонгон суралцах хүртээмжийг нэмэгдүүлэх</p> <p>Санхүүгийн мэдлэг түгээх арга хэмжээг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх,</p> <p>Оюутан залууст зориулсан санхүүгийн мэдлэг олгох идэвхжүүлэлтийн арга хэмжээнүүдийг зохион байгуулна</p>
8	3.2. Иргэд болон бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүү, эдийн засгийн суурь мэдлэг олгох ажлыг ургэлжлүүлнэ.	<p>Иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчд санхүүгийн мэдлэг олгох ажлын хүрээнд санхүүгийн мэдлэг түгээх сургагч багш нарыг бэлтгэх, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр баталсан хөтөлбөр, төлөвлөгөөг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх</p> <p>Иргэдийн эдийн засгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгаа хийж эдийн засгийн мэдлэг олгох дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах</p> <p>Иргэдэд цахим сургалт, контент хийж үр дүнтэй түгээхэд чиглэсэн технологийн дэвшлүүдийг ашиглах</p>
9	3.3. Монголбанкны бодлого, үйл ажиллагаанд их өгөгдлийг ашиглах бэлтгэл ажлын хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн үе шаттайгаар хөгжүүлнэ.	<p>“Их өгөгдлийн систем нэвтрүүлэх” ажлыг амжилттай дуусгах</p> <p>“Их өгөгдлийн систем”-ийн тасралтгүй үйл ажиллагааг хангах</p> <p>Өгөгдлийн аюулгүй байдлын ISO270001 болон одоогийн системийг харьцуулсан шинжилгээ хийх</p> <p>Өгөгдлийн удирдлага болон мэдээллийн аюулгүй байдлын талаар хүний нөөцийг чадавхижуулах</p> <p>Мэдээллийн аюулгүй байдал болон өгөгдлийн удирлагын талаар техник туслалцаа авах</p>
10	3.4. Монгол Улсын гүйлгээнд хүчин төгөлдөр ашиглаж буй мөнгөн тэмдэгтийн эдийн засгийн үр ашиг бүхий зохистой бүтцийг судалж, танилцуулна.	<p>Дэлхийн улс орнуудын мөнгөн тэмдэгтийн бүтцийг, Монгол улсын мөнгөн тэмдэгтийн өнөөгийн бүтээцтэй харьцуулан судлах.</p> <p>Тооцоолол судалгаан дээр үндэслэн боломжит аргуудыг ашиглан Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн эдийн засгийн үр ашиг бүхий зохистой бүтцийг тодорхойлох.</p>

ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ
(2022 оны 2 дугаар улирлын байдлаар)

2.1. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, бизнесийн орчин болон эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах замаар экспортыг дэмжсэн, нэмүү өртөг шингэсэн аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж, уг төлөвлөгөөг эдийн засгийн сэргэлт болон өсөлтийн хүртээмжийг дэмжихэд чиглэсэн төсөв, мөнго, санхүүгийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх

2.1.1. Орлогын тэгш бус байдлыг бууруулахад ээлтэй татварын бодлогын талаар судалж, санал боловсруулж Засгийн газарт хүргүүлэх

“Орлогын тэгш бус байдлыг бууруулахад ээлтэй татварын бодлого” сэдэвт судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. Тус судалгааны ажлаар Монгол Улсын хувь хүний орлогын албан татвар нь орлогын тэгш бус байдлыг бууруулах нөлөө үзүүлдэг эсэхийг судалж, олон улсын туршлага болон татварын оновчтой түвшнийг тодорхойлох загваруудыг ашиглан прогрессив татварын тогтолцоонд шилжихтэй холбоотой гарах асуудал, татварын хувь хэмжээ, шатлалын түвшнийг тооцох ажлыг хийсэн. Голлох дүгнэлтээс дурдвал, 1) өнгөрсөн жилүүдэд хэрэгжүүлсэн татвар, халамжийн бодлого нь тэгш бус байдлыг бууруулахад эергээр нөлөөлсөн хэдий ч цаашид нийгмийн халамж, нийгмийн даатгалын зарим шилжүүлгийг зорилтот нөхцөл заасан хэлбэрт шилжүүлэх шаардлагатай, 2) хувь хүний орлогын албан татварын хувьд прогрессив тогтолцоонд шилжих тохиолдолд татварын шатлал нэмж тооцох орлогын босго утга ойролцоогоор 1.0-1.6 сая төгрөгийн хооронд, хамгийн өндөр орлоготой иргэдээс авах шаталсан татварын дээд хэмжээ 25-32 хувь орчимд байх нь оновчтой байна.

2.1.2. Төв банкны хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд төв банкны бодлого, үйл ажиллагаа, судалгаа шинжилгээг нэмүү өртөг шингэсэн аж үйлдвэржилтийг дэмжихэд чиглүүлэх

Орчин үеийн аж үйлдвэржилтийн бодлогын олон улсын туршлагыг судалж, Монгол Улсын хувьд авч хэрэгжүүлэх боломжтой бодлогыг тодорхойлж, богино болон дунд хугацааны бодлого боловсруулалтад тусгах нь ач холбогдолтой юм. Иймд “Орчин үеийн аж үйлдвэржилтийн бодлого болон ногоон эдийн засаг: Олон улсын туршлага” сэдэвтэй судалгааны ажлыг хийж байна. Тус судалгааны ажлын хүрээнд 2022 оны 2 дугаар улиралд аж үйлдвэржилтийн бодлогын ач холбогдлыг тодорхойлж, хөгжлийн чиг хандлага, түүний загваруудыг судалсан. Тухайлбал, олон улсад орчин үеийн аж үйлдвэржилтийн бодлогын build-up, catch-up, new industrial revolution (NIR) буюу шинэ аж үйлдвэржилтийн хувьсалд суурилсан гэсэн үндсэн гурван загварыг хөгжүүлж байна. Эдгээр нь бие биеэсээ салангид загварууд биш бөгөөд “build-up” загвар нь өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх хэвтээ арга хэрэгслүүдийг багтаадаг, “catch-up” загвар нь инновац, шинэ технологийг дэмждэг бол NIR-д суурилсан загвар нь шинэ үйлдвэржилтийг бий болгох механизмыг ашигладаг. Улс орнууд хөгжлийн ялгаатай байдал болон өөрсдийн онцлогоос хамаарч дээр дурдсан загваруудыг өөрийн улсад тохируулан тодорхойлдог байна. Сүүлийн үед батлагдсан аж үйлдвэржилтийн стратегийн 40 орчим хувь нь тодорхой үйлдвэрүүдийг бий болгох (build-up) босоо бодлоготой байгаа бол 1/3-ээс илүү нь хамгийн их бүтээмжид хүрэх (catch-up), өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх хэвтээ бодлогыг анхаарч авч үзэж байна. Харин 1/4 нь NIR-д суурилсан бодлогод тулгуурлаж байна. Дурдсан сэдвийн хүрээнд Монгол Улсын хөгжлийн онцлог болон дээрх гурван загварыг харгалзан манай орны хувьд тохиромжтой аж үйлдвэржилтийн бодлогын загварыг тодорхойлоо судалж байна. Мөн орчин үеийн аж үйлдвэржилтийн бодлого болон ногоон эдийн засаг, санхүүжилтийн холбоо, хамаарлыг гаргахаар ажиллаж байна.

Төв банкны барьцаа хөрөнгийн бодлогын хүрээнд хямралын үед шаардлагатай тохиолдолд Монголбанк барьцаанд авах боломжтой банкуудын тайлан тэнцэл дэх санхүүгийн хөрөнгийг тодорхойлох зорилгоор улирал бүр танилцуулга бэлтгэж удирдлагуудад танилцуулж байна. Түүнчлэн “Хэвийн зээлийн эрсдэлийн хямдруулалтыг эдийн засгийн салбар тус бүрд тооцох боломж” судалгааны ажил болон “Ердийн болон хямралын үеийн төв банкны барьцаа хөрөнгийн бодлого” судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэв.

2.1.3. MYXAYT болон бизнес эрхлэгчдийн саналд үндэслэн бизнесийн орчныг сайжруулах, бизнес эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний санал боловсруулж, УИХ, УИХ-ын байнгын хороод болон Засгийн газарт хүргүүлж, хамтран ажиллах

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа, бизнесийн орчны нөхцөл байдал, үйлдвэрлэлийн хүчин чадал, санхүүжилт болон бусад төрлийн хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор “Бизнесийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдлын талаарх түүвэр судалгаа”-г 1-2 жил тутамд улсын хэмжээнд зохион байгуулж байна. Хамгийн сүүлийн байдлаар 2021 онд тус түүвэр судалгааг гүйцэтгэсэн бөгөөд судалгааны үр дүн, тайланг олон нийтэд мэдээлж, холбогдох яамдад хүргүүлэн хамтран ажилласан. Энэ жилийн түүвэр судалгааг 2022 оны 9 дүгээр сард зохион байгуулна.

Түүнчлэн “Санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хуульд зээлдэгч, зээлдүүлэгчийн эрх ашгийг тэгш оруулах санал боловсруулах, иргэний хуульд тусгах чиглэлээр тодорхой саналууд гаргах” судалгааны ажлыг гүйцэтгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран ажиллаж байна.

2.1.4. Эдийн засгийн өсөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын хэрэгслүүдийг тогтвортой өсөлт, нийгмийн халамж, хамгаалал, сайн засаглалын хүрээнд нарийвчлан судалж, олон улсын сайн туршлага, олон улсын байгууллагуудын зөвлөмжид үндэслэн бодлогын санал боловсруулах

“Хүртээмжтэй өсөлт ба түүнд нөлөөлөх хүчин зүйлс” сэдэвт судалгааны ажлыг хийж гүйцэтгэв. Энэхүү судалгаагаар 1) хүртээмжтэй өсөлтийн тодорхойлолт, түүнийг хэмжих талаар нэгдсэн ойлголтод хүрэх, 2) хүртээмжтэй өсөлт түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг хэрхэн тооцсон бусад орнуудын туршлагыг судлах, 3) хүртээмжтэй өсөлтийг илэрхийлэх нэгдсэн үзүүлэлт тооцох, 4) түүнд нөлөөлөх макро болон бодлогын хүчин зүйлсийг тодорхойлохыг зорьсон. Улмаар хүртээмжтэй өсөлтийг нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт болон орлогын тэгш хуваарилалтын өсөлт аль аль нь хангагдах нөхцөл гэж тодорхойлсон бөгөөд эхний шатанд хүртээмжтэй өсөлтөд нөлөөлөгч хүчин зүйлсийн хувьд үнэлгээний голлох үр дүнгээс дурдвал хүртээмжтэй өсөлтөд инфляцын түвшин, орлогын дахин хуваарилалтын үзүүлэлтүүд сөргөөр, гадаадын шууд хөрөнгө оруулалт болон гадаад худалдааны нээлттэй байдал зэрэг нь эерэг нөлөөтэй гэсэн үр дүн гарлаа.

2.1.5. Монгол улсын хөгжлийн бодлогод тусгагдсан аж үйлдвэржилтийг хөгжүүлэх зорилтыг хангахад дэмжлэг үзүүлэх хүрээнд санхүүгийн эх үүсвэрийг урт хугацааны хөрөнгө оруулалтанд чиглүүлэх, санхүүгийн хүртээмж болон гүнзгийрэлтийг нэмэгдүүлэх арга хэрэгслийн зохицуулалтыг бий болгох талаар судлах

Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт (HCC) нь бараа бүтээгдэхүүн, ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээний шат дамжлага бүрд оролцож буй үйлдвэрлэгч, тээвэрлэгч, борлуулагч зэрэг оролцогчид хоорондын харилцаанаас үүсэх өглөг, авлагын хэлцэл, бараа, бүтээгдэхүүн, бусад хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг үүргийн гүйцэтгэлд барьцаалж, зээл олгох санхүүжилтийн тогтолцоо юм. Монголбанк нь Монгол Улсын санхүүгийн системд HCC-ийг дэмжих чиглэлээр Олон улсын санхүүгийн корпорацтай хамтран ажиллахаар хэлэлцэж байна. Энэ хүрээнд Капитрон банкны удирдлагад HCC-ийг хэрэгжүүлэх саналыг тавьж, ээлжит уулзалтуудыг зохион байгуулаад байна.

2.2. Уул уурхайн бус экспортыг дэмжих бодлогыг нэгтгэн тодорхойлж, санхүүгийн дэд бүтэц, санхүүжилтийн хүртээмжтэй тогтолцоог бүрдүүлэх, бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллах

“Уул уурхайн бус экспортыг дэмжих, хөгжүүлэх дунд хугацааны (2022-2024) төлөвлөгөө”-г боловсруулж байна. Тус ажлын хүрээнд “Уул уурхайн бус экспортын санхүүжилтийн тогтолцооны олон улсын туршлага, арга хэрэгслүүд” гэсэн сэдвээр судалгааны ажил хийж байгаа бөгөөд экспортыг дэмжих бодлого, экспортын санхүүжилт, зээлийн баталгаа, даатгалын тогтолцооны олон улсын туршлагыг судалж байна. Тухайлбал, БНСҮ, Дани, Энэтхэг, Канад, Герман, Испани, Малайз зэрэг улсуудын экспортыг дэмжих бодлого, санхүүжилтийн тогтолцоог судлаад байна. Түүнчлэн, Монгол Улсын уул уурхайн бус (ҮҮБ) экспортын өнөөгийн байдал, санхүүжилтийн тогтолцоо, холбогдох хууль, журам, бодлогуудтай танилцсан бөгөөд цаашид хэрхэн сайжруулах талаар судалж байна.

Мөн “Экспортлогч Үндэстэн-Уул уурхайн бус экспорт, түүний санхүүжилт” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулахаар ажиллаж байна. “Экспортлогч Үндэстэн-Уул уурхайн бус экспорт, түүний санхүүжилт” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулах ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газар, MYXAYT-тай хамтран ажиллаж байна. Тус хэлэлцүүлгийг 300 орчим ҮҮБ экспортлогч аж ахуй нэгжүүд, төрийн байгууллагууд, банкууд, даатгалын компаниуд, олон улсын байгууллагуудыг оролцуулан 2022 оны 3 улиралд зохион байгуулахаар төлөвлөж байна.

“Уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх боломж” сэдэвт судалгааны ажлыг хийж гүйцэтгэн, судалгааны үр дүнг удирдлагуудад танилцуулсан. Энэхүү судалгаагаар Монгол Улсын ҮҮБ салбарын экспортыг төрөлжүүлэх, өсөлтийг хангах, харьцангуй давуу талтай бүтээгдэхүүнийг тодорхойлох чиглэлээр хийгдсэн судалгааны ажлуудын үр дүнг нэгтгэн харьцуулж нэгдсэн зөвлөмж боловсруулсан. Мөн төрөлжилтийг нэмэгдүүлэх, өсөлтийг хангах оновчтой бодлогын санал дэвшүүлэх зорилгоор ҮҮБ салбарын манай улсын өнөөгийн нөхцөл байдлыг бодлогын орчин болон санхүүжилтийн хувьд судлав. Улс орнууд харьцангуй давуу талтай бүтээгдэхүүнээ дагнан хөгжүүлэх ёстой гэсэн уламжлалт онолын үзэл баримтлааас экспортын сагсыг өргөжүүлэх нь зүйтэй гэсэн хандлагад чиглэж байгаа энэ үед Монгол Улс 1) экспортын сагсыг өргөжүүлэх, 2) харьцангуй давуу талтай бүтээгдэхүүнүүд төвлөрч буй хөдөө аж ахуйн салбарт технологи болон хиймэл оюун ухааныг ашиглан өсөлтийг хурдаасгах зэрэг бодлогыг баримтлах нь зүйтэй.

ҮҮБ экспортлогч аж ахуйн нэгжүүдийн тулгамдаж буй асуудал, санхүүжилтийн байдлыг тодорхойлж, улмаар экспортыг дэмжих үйл ажиллагааны бодлогын санал боловсруулахад шаардлагатай анхдагч мэдээллийг цуглуулах зорилгоор MYXAYT-тай хамтран “Уул уурхайн бус экспортлогчдын түүвэр судалгаа”-г зохион байгуулж, хамтран ажиллаж байна.

Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд экспортын хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн санхүүжилтийн нөхцөлийг шинэчлэх талаар судлах хүрээнд Монголбанкны урт хугацаат репо санхүүжилтэд хамрагдсан ҮҮБ экспортын салбарын зээлдэгчдийн судалгааг сар бүрээр гарган нэгтгэж, тус санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тооцоо болон холбогдох саналын танилцуулгыг боловсруулав.

2.3. Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ-ын 2023 оны харилцан үнэлгээнд бэлтгэх ажлын хүрээнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын Үндэсний хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, ФАТФ-ын зөвлөмжийн үнэлгээг дээшлүүлэх, зөвлөмжид нийцүүлэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээнд үндэслэн эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгох, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх

2.3.1. Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дотоодын эрх бүхий байгууллагуудтай хамтран боловсруулж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Зөвлөмж 1-д улс орнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ үнэлэх, Зөвлөмж 2-т эрсдэлийн үнэлгээний үр дүнд суурилан үндэсний бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг шаарддаг. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Харилцан үнэлгээний тайландаа манай улсыг үндэсний хэмжээний мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, стратегийн баримт бичгийг баталж хэрэгжүүлэхийг зөвлөсөн. Түүнчлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд суурилсан үндэсний бодлого, хөтөлбөрийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авахыг заасан байдаг.

Үүний хүрээнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудтай хамтран Монгол Улсын хоёр дахь Үндэсний эрсдэлийн үнэлгээг 2020-2021 онд хийж гүйцэтгэн, Монгол Улсын МУТСТ тогтолцоог бэхжүүлэх, дараагийн шатны харилцан үнэлгээний үр дүн амжилттай байх, олон улсын байгууллагын хориг жагсаалтад орохгүй байх зорилгоор Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд суурилан холбогдох байгууллагуудтай хамтран **Монгол Улсын МУТСТ Үндэсний хөтөлбөрийг 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, батлуулав.**

Үндэсний хөтөлбөрөөр дамжуулан УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын харах-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ач холбогдолтой юм.

2.3.2. Монгол Улсын 2022 оны Явцын тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлж, ФАТФ-ын Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах

Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудтай хамтран Монгол Улсын 2022 оны Явцын тайланг боловсруулж, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АНДМУТБ)-т 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдөр хүргүүлсэн. Тус тайландаа Үндэсний зөвлөлөөс баталсан төлөвлөгөөний дагуу МУТСТ тогтолцоог бэхжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон “Хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй байгаа Зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулах хүрээнд хийсэн ажлуудыг тайлагнасан.

АНДМУТБ-ийн үнэлгээний багаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монголбанкнаас холбогдох байгууллагын төлөөллүүдтэй хамтран нэмэлт мэдээлэл, тайлбарыг бэлтгэж хүргүүлэхээс гадна үнэлгээний багтай цахим уулзалтыг зохион байгуулав. Улмаар АНДМУТБ-ийн Харилцан үнэлгээний хорооны 2022 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн хурлаар Монгол Улсын Зөвлөмж 15-ын “Хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээг “Дийлэнхийг биелүүлсэн” болгон нэг шатаар ахиулж, Монгол Улсын 2022 оны Явцын тайланг батлахаар тогтов.

Монгол Улсын ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээ дараах үр дүнтэй байна.
Үүнд:

Үнэлгээ	Зөвлөмжийн тоо
Биелүүлсэн (C)	8
Дийлэнхийг биелүүлсэн (LC)	31
Хэсэгчлэн биелүүлсэн (PC)	1
Биелүүлээгүй (NC)	0

Монгол Улсын зүгээс 2023 онд ФАТФ, АНДМУТБ болон олон улсын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ФАТФ-ын олон улсын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээг ахиулах зорилгоор үргэлжлүүлэн ажлын явцыг тайлагнаж ажиллах болно.

2.3.3. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх

ФАТФ-ын Зөвлөмж 15-ын шаардлагын дагуу Монгол Улсын виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж тайлагнах үүрэг бүхий ажлын хэсгийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2022 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 4/A-5/12/A-02 дугаар хамтарсан тушаалаар байгуулж, тус ажлын хэсэгт Монголбанк орж ажиллаж байгаа бөгөөд Дэлхийн банкны аргачлалын дагуу шаардлагатай мэдээллийг асуулга хэлбэрээр цуглуулж, олон улсын зөвлөхүүдтэй хамтран сургалт зохион байгуулсан. Түүнчлэн үүнтэй холбоотойгоор СЗХ-ноос зохион байгуулсан ажлын хэсгийн хуралд салбарын эрсдэлийн үнэлгээний МУТСТ эмзэг байдал болон эрсдэлийг бууруулах арга хэмжээний хэсгийн тайлангийн төслийг боловсруулаад хамтарч ажилласан.

Мөн 2022 оны 6 дугаар сарын 3, 10-ны өдрүүдэд Монголбанк болон СЗХ хамтран төрийн байгууллага болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд хэлэлцүүлэг зохион байгуулав. Тус хэлэлцүүлгийн хүрээнд Монголбанк, СЗХ болон хууль сахиулах байгууллагын төлөөллүүд виртуал хөрөнгийн салбарын эрсдэлийн үнэлгээний үр дүнг танилцуулж, санал авсан бөгөөд эрсдэлийн үнэлгээний тайланг эцэслэсэн. Улмаар 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан хурлаар СЗХ, Тагнуулын ерөнхий газар, Монголбанкны төлөөллүүд тайлангийн эцсийн хувилбар, эрсдэлийн үнэлгээний үр дүнг ажлын хэсгийн гишүүдэд танилцуулсан бөгөөд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит хурлаар СЗХ-ноос виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний тайланг танилцуулахаар хүргүүлсэн.

2.3.4. Виртуал хөрөнгийн салбарын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоо, орчныг бий болгох

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд СЗХ-ноос дараах журмын төсөл, тогтоол, журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулсан бөгөөд Монголбанкны зүгээс журмын төслүүдэд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон олон улсын туршлагад үндэслэн санал өгч ажиллав. Үүнд:

- “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд зайн болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”;
- “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”;
- “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”;
- “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох журам”;

- “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох, түр зогсоох, бүртгэлээс хасах журам”;
- “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоонд тавих шаардлагыг тогтоох журам”;
- “Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх журам”-д оруулах нэмэлт өөрчлөлт;
- “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д оруулах нэмэлт өөрчлөлт.

Түүнчлэн СЗХ-ноос төр, хувийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан 4 журмын төслийн хэлэлцүүлэгт Монголбанкнаас оролцож, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарах асуудлуудын талаар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд танилцуулав. Түүнчлэн 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн үндэсний эрсдэлийн үнэлгээ, холбогдох журам зааврыг таниулах” хэлэлцүүлэгт Монголбанк оролцож, “Виртуал хөрөнгийн салбарын эрсдэлийг бууруулах арга хэмжээ” болон “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ын талаар илтгэл, танилцуулга хийв.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг тусгаж, мэдээлэх үүрэгтэй этгээд болгосон. Мөн уг хуулийн 5 дугаар зүйлийн 5.14 дэх заалтын дагуу мэдээлэх үүрэгтэй этгээд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай тул нарийвчилсан зохицуулалтыг тусгах зорилгоор “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар болсон. Журмыг шинэчлэн найруулах, эрх бүхий байгууллагаар батлуулах ажлын хүрээнд Монголбанк, ХЗДХЯ, СЗХ-ны төлөөлүүдээс бүрдсэн ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-110 дугаар тушаалаар байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан ажлын хэсгийн хуралд журмын төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлтүүдэд саналаа өгсөн. Улмаар тус журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд олон нийтээс саналыг авч, нэгтгэн тусгаж, 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр холбогдох байгууллагуудаас санал авахаар хүргүүлэв.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн МУТСТ зохицуулалтын орчныг боловсронгуй болгож, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн шаардлагыг хангах холбогдох хууль тогтоомжийг батлах, хэрэгжүүлэх байдлаар виртуал хөрөнгийн салбарын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгох ач холбогдолтой юм. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасны дагуу СЗХ-ноос 2022 оны 6 дугаар сарын 25-ны өдрөөс виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэж эхэлсэн бөгөөд хяналт шалгалтын үйл ажиллагааг батлагдсан журмын дагуу хэрэгжүүлж байна. Ийнхүү виртуал хөрөнгийн салбарын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоо, орчныг бий болгов.

2.3.5. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх

Монголбанкнаас 2022 оны 2 дугаар улиралд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд оролцдог төр, хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөллийг олон улсын байгууллагаас зохион байгуулдаг сургалт, семинарт тогтмол хамруулан ажиллалаа. Тухайлбал, ФАТФ, АНДМУТБ, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагын цахим сургалтад төр, хувийн хэвшлийн 30 орчим албан тушаалтууд оролцов. Түүнчлэн Монголбанкнаас олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран мэргэжлийн холбоод, санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч, банкны комплаенсийн ажилтнууд зэрэг хувийн хэвшлийн нийт 400 гаруй төлөөлөлд 10 удаагийн сургалт зохион байгууллаа. Зохион байгуулсан сургалтын дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтээс харна уу.

№	Зохион байгуулсан байгууллага	Оролцогчид	Сургалтын тоо	Нийт оролцогчдын тоо
1	Монголбанк, СЗХ, Санхүүгийн боловсролын хаб, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг	Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид	5	245
2	Монголбанк	Банкны комплаенсийн газар, хэлтсийн удирдлага болон ажилтнууд	2	30
3	Монголбанк	Ашгийн бус байгууллагын төлөөллүүд	1	60
4	Монголбанк, СЗХ	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид	2	114
5	Монголбанк, Хууль сахиулах байгууллагууд	Хууль сахиулах байгууллагын ажилтнууд	3	107
6	Монголбанк	Гаалийн байгууллагын ажилтнууд	1	15

Монголбанкнаас МУТСТ чиглэлээр оюутнуудын дунд “Эрдэм шинжилгээний бага хурал”-ыг 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, оюутан залуусын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэн ажиллалаа.

Нэгдсэн үндэсний байгууллага (HYB)-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан goAML программын бүртгэл, хэрэглэгчийн эрхийн удирдлага, тайлан бөглөх заавар болох 3 төрлийн гарын авлагыг Монголбанкнаас боловсруулан goAML програмд оруулав.

Монголбанкнаас банкуудад сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор сэжигтэй гүйлгээнд хийсэн дүн шинжилгээний талаарх ерөнхий мэдээлэл, сэжигтэй гүйлгээний нийтлэг хэв шинж, арга хэлбэрийн талаар мэдээлэл өгдөг хагас жил тутмын уулзалтыг 6 дугаар сард зохион байгуулав. Үүнээс гадна 2022 оны 2 дугаар улиралд банкуудын комплаенсийн нэгжийн төлөөллүүдтэй 2 удаа уулзалт зохион байгуулж, тус уулзалтуудаар Корреспондент банкны харилцаа, Эцсийн өмчлөгчийн тухай гарын авлагын танилцуулга, Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүн, олон улсад үүсээд буй нөхцөл байдлын талаар хэлэлцлээ.

Түүнчлэн МУТСТ мэдээллийн нэгдсэн систем (www.amlcft.mn) болон Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудас (fiu.mongolbank.mn)-нд Монгол Улсын МУТСТ тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх сүүлийн үеийн мэдээ, мэдээллийг тогтмол байршуулж байгаа бөгөөд мэдээлэх үүрэгтэй этгээд, олон нийтэд зориулан гаргасан гарын авлага, заавар, зөвлөмжийг цахим хуудсанд нийтлэв.

Шинэчлэн боловсруулж байгаа “Мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны үйл ажиллагаанд Монголбанкнаас газар дээрх хяналт, шалгалт хийх журам”, “Мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны үйл ажиллагаанд Монголбанк зайнаас хяналт тавих журам”-ын төсөлд Монголбанкнаас тавигдах МУТСТ хяналт шалгалтын стандартыг таниулах, салбарын хэмжээнд шинээр үүсэж байгаа эрсдэлийн талаарх ойлголтыг сайжруулах, холбоотой ажиллах, сургах, соён гэгээрүүлэх, МУТСТ-тэй үр дүнтэй тэмцэх бодлогыг хэрэгжүүлэх эерэг хандлагыг төлөвшигүүлэн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах зохицуулалтыг тусгаад байна. Ингэснээр ФАТФ-ын Зөвлөмж 34 болон шууд хэрэгжилтийн 3.6-д хамаарах банктай холбоотой шалгуурт хамаарах ажлыг зохион байгуулна.

2.4. Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлж эхлэх бэлтгэл ажлын хүрээнд Монголбанк хөнгөлөлттэй хүйтэй ипотекийн

зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт 2023 онд багтаан бүрэн шилжүүлэх, энэ хугацаанд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.

Энэхүү хөтөлбөрийн нийгэм, эдийн засагт үзүүлж буй эерэг нөлөөг харгалзан үзэж цаашид урт хугацаанд, тогтвортой хэрэгжүүлэх нь ач холбогдолтой юм. Гэвч Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, олон улсын санхүүгийн байгууллагуудын зөвлөмжийн дагуу Монголбанкнаас хөтөлбөрийг цаашид санхүүжүүлж, хэрэгжүүлэх боломжгүй байна. Иймд 2024 оноос эхлэн хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газарт шилжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хүрээнд Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 285/A-334 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Монголбанкийг Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоо бүрдүүлэх хөтөлбөрөөс гаргах төлөвлөгөө”-нд нэмэлт, өөрчлөлтийг Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 163/A-136 дугаар хамтарсан тушаалаар оруулсан.

Орон сууцны ипотекийн хөтөлбөрийг урт хугацаанд тогтвортой үргэлжлүүлэх зорилгоор олон улсын сайн туршлагад үндэслэн төрөлжүүлж, зах зээлийн зарчимд сууриссан санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх судалгааг хийхтэй холбогдуулан Дэлхийн банкны төслийн хүрээнд дотоод зөвлөх үйлчилгээ авахтай холбоотой хийгдэх ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулах зэрэг бэлтгэл ажлыг хангасан. Дотоодын зөвлөх авсны дараа гадаадын зөвлөх үйлчилгээ авах ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангад байна.

Дээрх ажлууд хийгдэж байх хугацаанд КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль (цаашид “Цар тахлын тухай хууль” гэх), УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоол, Засгийн газраас хэрэгжүүлж буй Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө (цаашид “10 их наядын цогц төлөвлөгөө” гэх)-нд 2024 он хүртэл нийт 2 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн хөтөлбөрийн зээлийг олгохоор тусгагдсан. Үүнээс 2021 онд нийт 1.0 их наяд төгрөгийн зээлийг 13.4 мянган өрхөд олгосон бөгөөд 2022, 2023 онуудад нийт 1.0 их наяд төгрөгийн зээлийг олгох төлөвлөгөөтэй байгаагаас 2022 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар 293.81 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээлийг 3,689 өрхөд Монголбанк болон банкуудын эх үүсвэрээр олгосон байна. Ингэснээр хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш нийт 6.4 их наяд төгрөгийн хөтөлбөрийн зээлийг 107.5 мянган өрхөд олгоод байна.

Цар тахлын тухай хууль, УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолын дагуу цар тахлаас хамаарсан эдийн засгийн хүндрэлтэй үед өрхийн санхүүг дэмжих зорилгоор орон сууцны ипотекийн хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээлийн эргэн төлөлтийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлуулах арга хэмжээг нийт 5 удаа авч хэрэгжүүлсэн. Үр дүнд нь давхардсан тоогоор нийт 276.7 мянга гаруй өрхийн зээлийн төлбөрийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр ойролцоогоор нийт 31 сарын турш хойшлуулсан байна. Харин хамгийн сүүлийн удаа авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд 63.2 мянган өрхийн 3.4 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй зээлийн төлбөрийг 2022 оныг дуустал хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлуулаад байна.

2.5. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд гэрээний маргаан шийдвэрлэх үйл явцыг хялбаршуулах, зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх

Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах ажлын хүрээнд бизнес эрхлэгч хооронд (B2B)-ын болон бизнес эрхлэгч болон иргэн, санхүүгийн хэрэглэгч хооронд (B2C)-ын хэрэг, маргаан шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн бус журмаар өр төлбөр барагдуулахтай холбогдсон эрх зүйн орчин, тэдгээрийн хоорондын гэрээний болон үүргийн харилцааг зохицуулсан хууль зүйн орчныг

боловсронгуй болгох хөрөнгийн үнэлгээ, эх үүсвэрийн өртгийг хадгалах, хамгаалах, санхүүгийн хүргээмж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх агуулгаар Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж ХЗДХЯ-нд хүргүүлээд байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/84 дүгээр тушаалаар байгуулагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэгт Монголбанкнаас төлөөлөл оролцон ажиллаж, хуулийн төслийн үзэл баримтлалд тусгах саналыг Ажлын хэсэгт хүргүүлэв.

2.6. Уур амьсгалын өөрчлөлтийн эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөг судалж, бусийн болон олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, санаачилгатай уялдсан тогтвортой санхүүжилтийн бодлого, стратеги боловсруулж хэрэгжүүлэх

2.6.1. Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой санхүүжилтийн талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, шаардлагатай судалгаа, шинжилгээг хийхэд олон улсын байгууллага, бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах

Монголбанкнаас уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагууд болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал, Монголбанк нь Парисын хэлэлцээрийн зорилтуудыг биелүүлэхэд хэлэлцээрт нэгдэн орсон гишүүн орнуудын үүргээ биелүүлж ажиллахад хамтарч ажилладаг НҮБ-ын дэргэдэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр (YTXN) түншлэл байгууллагатай хамтран ажиллаж байна. YTXN түншлэлтэй “Төв банкийг ногооруулах” төсөл нь Монголбанканд 2 жилийн хугацаанд хийгдэх бөгөөд ногоон таксономын хэрэгжилт, уур амьсгалын өөрчлөлтийн толилуулгыг сайжруулах хүрээнд байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын аргачлалын журам, зааврыг боловсруулах, банкуудын уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үүсэж болзошгүй эрсдэлүүдийг тооцох аргачлалыг боловсруулах зэрэг ажлуудыг төслийн хүрээнд хийхээр тусгаад байна.

Түүнчлэн “Уур амьсгалын өөрчлөлтийн нийгэм, эдийн засагт үзүүлж болох нөлөө, учирч болох эрсдэл: Монгол Улсын жишээ” сэдэвт судалгааны ажлыг хийж гүйцэтгэв. Энэхүү судалгаагаар уур амьсгалын дэлхийн байгаль орчин, эдийн засагт үзүүлж буй нөлөөллөөс эхлээд манай улсын эдийн засагт хэрхэн нөлөөлж буй байдлыг шинжилж, цаашид гарах эрсдэлийг тодорхойлохыг зорьсон. Уур амьсгалын өөрчлөлт нь температур нэмэгдэх болон хур тунадас багасах байдлаар илрэх бөгөөд энэ нь байгаль, экологийн тэнцвэрийг алдагдуулж, цөлжилт үүсгэх, бэлчээрийг доройтуулах, ургац хураалтыг багасгах, нийт хөдөлмөрийн бүтээмжийг бууруулах байдлаар эдийн засагт сөргөөр нөлөөлдөг байна. Тоон шинжилгээний үр дүнгээс танилцуулбал, уур амьсгалыг төлөөлөгч үзүүлэлт болох температур 1 хэмээр нэмэгдэх нь манай улсын ДНБ-ийг 0.48 хувиар бууруулах бөгөөд нэг удаагийн шок 7-8 улирлын дараа сөрөг нөлөө нь илэрч, 3 жилийн дараагаас тогтвортых төлөвтэй байна. Харин үнэлгээний түүвэр хангалттай урт бус байдлаас шалтгаалан хур тунадас эдийн засгийн өсөлтөд ач холбогдолгүй гэсэн үр дүнг өгөв.

2.6.2. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулахад чиглэсэн зөвлөмж, санаачилгатай уялдсан тогтвортой санхүүжилтийн талаар баримтлах бодлого, стратеги болон тогтвортой хөгжлийн санхүүжилтийн таксономи боловсруулах, СТБЗ-д танилцуулах

Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ТоС холбоо) болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”-ийг боловсруулж, 2022 оны 3 дугаар сард СТБЗ-ийн хамтарсан тушаалаар батлуулав. Үүний дагуу холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон ТоС холбооны төлөөлүүдийг оролцуулан “Тогтвортой хөгжлийн зорилтуудын Санхүүжилтийн Таксономи”-г санхүүгийн салбарт тодорхой үе шаттайгаар нэвтрүүлэхээр уг баримт бичгийн төсөл боловсруулах хүрээнд хамтын ажиллагааг зохион байгуулж байна.

2.6.3. Ногоон таксономийн дэд ангилал болох “Тогтвортой нэхмэлийн боловсруулалт ба үйлдвэрлэл”-д ногоон зээл олгох шалгуурыг албажуулах шаардлага, ногоон таксономийг хэрэглэгч байгууллагуудад мөрдүүлэн ажиллах боломж бололцоог тус тус судлах, ногоон зээлийн статистик мэдээллийг баталгаажуулах гол эх сурвалж болгон ашиглах

Монголбанк банкуудын ногоон зээлийн тайланг улирал тутам нэгтгэн олон нийтэд танилцуулж байна. 2022 оны 2 дугаар улирлын байдлаар банкуудаас олгосон ногоон зээлийн үлдэгдэл 329.7 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын нийт зээлийн үлдэгдлийн 1.4 хувийг эзэлж байна.

2.6.4. Банкны салбарын статистик тайланг байгаль орчин, нийгэм, тогтвортой хөгжлийн зорилтыг хангахтай уялдуулан гаргах, хүйсээр ангилан нийтэд мэдээлэх

Бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд олгосон зээлийн хүйсээр ангилсан үзүүлэлтийг сар бүр, иргэдийн харилцах, хадгаламж, зээл болон банкуудын боловсон хүчний хүйсийн мэдээллийг 2021 оны байдлаар сум, дүүргээр нэгтгэн олон нийтэд түгээв.

2.7. Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний зориулалтыг хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр өргөтгөж, зээлдэгчид тавьж байгаа зарим нөхцөл, шаардлагыг сулруулан, ажлын байрыг дэмжих зээл, хөдөө аж ахуйг дэмжих зээл, малчдыг дэмжих зээл, ипотекийн зээл, репо санхүүжилтийн зээл болон бусад төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хяналтыг ургэлжлүүлэх

2.7.1. Банкуудаас ирүүлсэн зээлийн мэдээг нэгтгэн Сангийн яам болон бусад оролцогч байгууллагуудыг мэдээллээр хангах, тайлагнах

Монголбанкны зүгээс 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд олгогдож буй Ажлын байрыг дэмжих зээл, Репо санхүүжилт, Ипотекийн 6 хувийн зээл, Хөдөө аж ахуйг дэмжих зээлийн талаарх мэдээллийг банкуудаас авч, нэгтгэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж байна. Түүнчлэн зээл олголт болон холбогдох бусад мэдээллийг Сангийн яаманд тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. Хөдөө аж ахуйг дэмжих зээлийн хувьд 2022 оны 2 дугаар улиралд долоо хоногийн болон сарын тайлангуудыг нэгтгэж, ХХААХҮЯ-нд хүргүүлсэн бөгөөд Монголбанкнаас үзүүлэх хүүгийн хөнгөлөлтийг сар бүрээр гаргаж, хүүгийн төлбөрийг банкуудад шилжүүлж ажиллалаа.

2.7.2. Урт хугацаат репо санхүүжилт болон ипотекийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, санхүүжилтийн нөхцөлийг судлан шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулах

Урт хугацаат репо арилжаагаар олгосон эх үүсвэрээр зээл олгож эхэлснээс хойш банкууд 2022 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 1,494.1 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлтийг судалж үүнээс 3,622 зээлдэгчид 1,235.4 тэрбум төгрөгийн зээлийг олгожээ. Урт хугацаат репо арилжаагаар олгох санхүүжилтийн нөхцөлийг сайжруулах хүрээнд МБХ-ны 2022 оны 1 дүгээр тогтоолоор УУБ экспорт, боловсруулах аж үйлдвэрийн салбарт олгох урт хугацаат репо санхүүжилтийн хугацааг уян хатан болгох, тус салбарт банкны эх үүсвэрийг татан оролцуулах шийдвэрийг гаргасан. Үүнтэй уялдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-34 дүгээр тушаалаар эдгээр салбарт олгох санхүүжилтийн нөхцөлийг өөрчлөн баталсан.

Уг тушаалын дагуу 2022 оны 2 дугаар сарын 21-ний өдөр 81 тэрбум, 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 25.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус банкуудад олгосноос 61 тэрбум төгрөг нь 3 жилийн хугацаатай хамтын санхүүжилтийн эх үүсвэр байв. Үүнээс 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар банкууд 45.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг харилцагчид олгосон бөгөөд тус санхүүжилтийн 13.5 тэрбум төгрөг банкны өөрийн эх үүсвэрээс олгогдсон байна. Түүнчлэн урт хугацаат репо арилжааны эх үүсвэрээр 270.2 тэрбум төгрөг нь шатахууны нөөц бүрдүүлэх санхүүжилтийн хүрээнд банкаар дамжуулан 18 аж ахуйн нэгжид олгогдсон байна. Ингэснээр дээрх салбаруудад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн өрийн дарамт тодорхой хэмжээнд буурч байгаа бөгөөд тасалдаад байсан банкны зээл олголтыг нэмэгдүүлж байна.

Зураг 16. Урт хугацаат репо арилжаагаар олгосон зээл, салбараар



Зээл олголтын гүйцэтгэлийг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл бөөний болон жижиглэн худалдаа 47.3 хувийг, боловсруулах үйлдвэрлэл 16.5 хувийг, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 9.1 хувийг, зочид буудал, нийтийн үйлчилгээ 4.3 хувийг, эрүүл мэнд 4.2 хувийг, барилга 4.0 хувийг, өрхийн үйлдвэрлэл 3.4 хувийг, тээвэр агуулах 3.3 хувийг, хөдөө аж ахуй 2.0 хувийг, бусад салбар 6.0 хувийг тус тус эзэлж байна.

Эх сурвалж: Монголбанк

Монголбанкны эх үүсвэрийг бизнес эрхлэгчдэд шуурхай, үр дүнтэй хүргэх чиглэлээр банкуудтай тогтмол мэдээлэл солилцож, зээлийн явцын мэдээлэлд үндэслэн эх үүсвэрийг олгох, ашиглаагүй эх үүсвэрийг эргүүлэн төлүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн урт хугацаат репо санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс түүвэр судалгааны аргаар мэдээлэл авч, хөтөлбөрийн үр дүнг үнэлэх, улмаар нөхцөлийг сайжруулах судалгаанд шаардлагатай тоон мэдээллийг бүрдүүлэн ажиллаж байна.

2.7.3. “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлын байрыг дэмжих зээлийн хүүгийн дэмжлэгийн тооцооллыг түүвэрчлэн шалгах / орон нутгийн хянан шалгагчидтай хамтран ажиллах/

2.7.4. Ажлын байрыг дэмжих зээлийн хүүгийн тооцооллыг нэгтгэн, Сангийн яаманд хүргүүлж, банкуудад Засгийн газрын хүүгийн дэмжлэгийг дамжуулах /орон нутгийн хянан шалгагчидтай хамтран ажиллах/

2.7.5. “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлын байрыг дэмжих, репо санхүүжилт, ипотекийн зээлд хэсэгчилсэн шалгалт хийх /орон нутгийн хянан шалгагчидтай хамтран ажиллах/, Хөдөө аж ахуй болон малчдыг дэмжих зээлд зайнаас хяналт тавих

Ажлын байрыг дэмжих зээлийн хүрээнд тайлант улиралд банкуудаас ирүүлсэн долоо хоног болон сарын тайланг хянаж, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг банкуудад хүргүүллээ. Мөн Засгийн газраас төлөгдөх хүүгийн дэмжлэгийн тооцооллыг сар бүр үнэн, зөв тайлагнаж байгаа эсэхэд хяналт тавьж, холбогдох танилцуулгыг боловсруулан Монголбанкны удирдлагуудад танилцуулж, Сангийн яаманд сар бүр хүүгийн дэмжлэгийн тухай мэдээллийг хүргүүлж байна.

Ажлын байр дэмжих зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээний зээлийн зориулалт, зарцуулалт, нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхэд Монголбанкнаас хийсэн газар дээрх шалгалтын үр дун, банкуудын дотоод хяналтаар Засгийн газраас төлөгдөх хүүгийн дэмжлэгийг цуцалж, бизнесийн зээлд шилжүүлсэн зээлийн мэдээг 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар гарган, холбогдох зөрчил, дутагдлын талаарх мэдээллийг банкуудад хүргүүлэв. Шалгалтаар нийт 66 зээлдэгчийн 6.2 тэрбум төгрөгийн зээлийн 46 зээлдэгч 3.7 тэрбум төгрөгийн зээлийг зориулалт бусаар ашигласан, 10 зээлдэгчийн 2.1 тэрбум төгрөгийн зээл нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн, 10 зээлдэгчийн 332.8 сая төгрөгийн зээл шаардлага хангаагүй зээлдэгчдэд олгосон зөрчил, дутагдлыг илрүүлж, бизнесийн зээлд шилжүүлсэн болно.

4. Инфляцын зорилтыг хангах чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлэх арга хэмжээг макро здийн засгийн тогтвортой байдал, гадаад, дотоод тэнцвэрийг алдагдуулахгүйгээр дэмжин ажиллах

4.1. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн, стратегийн ач холбогдолтой бүтээгдэхүүний шаардлагатай нэмэлт нөөцийг бүрдүүлэхэд зориулан Төв банкны урт хугацаат репо арилжааны санхүүжилтийн нөхцөлийг өөрчлөх, хамрагдах салбарыг өөрчлөх эсэх саналыг боловсруулж МБХ-ны хуралд танилцуулж, шийдвэрлүүлэх. Тус шийдвэрийн хэрэгжилтийг хангах, Засгийн газартай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох санал боловсруулж, хэрэгжүүлэх

Монголбанкны МБХ-ны 2022 оны 1 дүгээр тогтоолд үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-34 дүгээр тушаалаар УУБ экспорт болон боловсруулах үйлдвэрлэлийн салбарт олгох урт хугацаат репо арилжааны санхүүжилтийн нөхцөлд дараах нэмэлт өөрчлөлтийг хийж шинэчлэн баталсан. Үүнд:

- Зээлийн хугацааг 18 сараас 3 хүртэл жил болгон сунгах;
- УУБ экспорт, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт Монголбанк болон банкууд хамтын санхүүжилт хэлбэрээр зээл олгох. Ингэхдээ:
 - Нэг зээлд Монголбанкны эх үүсвэрээс 15 тэрбум төгрөг хүртэл олгох;
 - Банкны эх үүсвэр нь зээл тус бүрийн хувьд зээлийн нийт дүнгийн 30 хувиас багагүй байх.
- Банкууд цаашид репо арилжаагаар авсан эх үүсвэрээр зээл олгоходоо тухайн авсан санхүүжилтийн 50 хувиас багагүй дүнгээр шинэ зээл олгох;
- Барьцаа хөрөнгийн төрөлд УУБ экспортлогч аж ахуйн нэгжийн хувьд агуулах дахь бараа материал, экспортын гэрээгээр баталгаажсан ирээдүйн борлуулалтын орлогыг барьцаалах.

2022 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар Монголбанкнаас урт хугацаат репо арилжаагаар банкуудад олгосон санхүүжилтийн үлдэгдэл 1,386.5 тэрбум төгрөг байгаа бөгөөд банкууд 3,622 зээлдэгчид 1,235.4 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна. Үүнтэй холбогдуулан репо хэлцэл хийх санхүүгийн актив болох төв банкны үнэт цаас болон хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаасны үнэлгээг хийх, эрсдэлийн хямдруулалтын хувь хэмжээг тогтоох зэрэг ажлуудыг тухай бүр гүйцэтгэв.

Мөн Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасны дагуу газрын тосны бүтээгдэхүүн импортлогчид эргэлтийн хөрөнгийн болон урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийг Монголбанкнаас олгож байна. Үүний хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-122 дугаар тушаалын дагуу Уулuurхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ), Монголбанк болон банкуудын хооронд 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан “Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдэд шатахууны нөөц бүрдүүлэх зорилгоор олгох санхүүжилтийн ерөнхий гэрээ”-нд нэмэлт, өөрчлөлт оруулан шинэчлэн батлав.

Тус гэрээний дагуу УУХҮЯ-наас 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр ирүүлсэн 01/1006 тоот албан бичигт үндэслэн УУХҮЯ-наас ОХУ-ын Роснефть компанитай хийсэн 120 мянган тонн АИ-92 шатахууны хөнгөлөлттэй нөхцөл бүхий хэлэлцээрийн урьдчилгаа төлбөрийн эх үүсвэрийг урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийн хүрээнд 14 аж ахуйн нэгжид банкаар дамжуулан олгохоор шийдвэрлэсэн. Ийнхүү 2022 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 287.0 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийн хүсэлт ирснээс Монголбанк 282.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, үүнээс 48.3 тэрбум төгрөг нь эргэн төлөгдсөн байна.

Түүнчлэн Цар тахлын тухай хууль болон холбогдох бусад хуульд үндэслэн 2021 оны 12 дугаар сараас газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэхэд шаардагдах эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн эх үүсвэрийг Монголбанкнаас банкаар дамжуулан аж ахуйн нэгжүүдэд олгож эхэлсэн. Банкуудаас 2022 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 510.3 тэрбум төгрөгийн шатахууны нөөц бүрдүүлэх эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн хүсэлт ирснээс Монголбанк 483.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон (үүнээс 270.2 тэрбум төгрөгийг урт хугацаат репо арилжааны эх үүсвэрээр олгосон) бөгөөд банкууд нийт 72.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг буцаан төлж, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн үлдэгдэл 410.4 тэрбум төгрөг байна.

Монголбанкнаас алт олборлогч аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг үзүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх, улмаар алт олборлолтыг нэмэгдүүлэх замаар Монгол Улсын гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор төв банкны үнэт цаасаар репо хэлцэл хийж, банкуудад урт хугацааны санхүүжилтийг 2020 оноос олгож эхэлсэн бөгөөд 2022 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар нийт олгосон санхүүжилтийн үлдэгдэл 484.0 тэрбум төгрөг байна. Үүнээс 30.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2022 оны 2 дугаар улиралд олгожээ.

Түүнчлэн Монголбанк олон улсад үүсээд буй нөхцөл байдлаас шалтгаалан нефть, нефтийн бүтээгдэхүүн болон цахилгаан эрчим хүч зэрэг стратегийн нэн чухал ач холбогдолтой бараа, бүтээгдэхүүн импортлогчдын гадаад төлбөр тооцоог саадгүй хийж гүйцэтгэх шаардлагын дагуу ээлжит бус валютын арилжааг 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрөөс зохион байгуулж эхлээд байна. Улмаар 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 415.3 сая ам.долларыг нефть, нефтийн бүтээгдэхүүн болон эрчим хүчний төлбөрт зориулан валютын заход нийлүүлсэн байна.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2022 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

(2022 оны 2 дугаар улирлын байдлаар)

1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:


1.1 Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2022-2024 онд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтвортжуулна. Инфляцыг тогтвортжуулахад чиглэсэн мөнгөний бодлогын шийдвэрийг гаргахдаа зах зээлийн зарчимд тулгуурлан нийлүүлэлтийн шалтгаантай үнийн осолтийн шууд бус нөлөөг нягтлан үзэж, эдийн засгийн сэргэлтийг удаашруулахгүй байх зарчмыг баримтална.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ээр хэмжигдэх инфляц 2022 оны 6 дугаар сард улсын хэмжээнд жилийн 16.1 хувь буюу зорилтот түвшин (6 хувь (+/-2))-ээс өндөр байв (Зураг 17). Цар тахлын дараа уул уурхайн бус эдийн засгийн үйл ажиллагаа тогтвортжиж буйгаас эрэлтийн шалтгаантай инфляц алгуур нэмэгдэх хандлагатай байгаа хэдий ч гадаад хүчин зүйлсээр өдөөгдсөн нийлүүлэлтийн хүчин зүйлсийн нөлөө давамгайлсан хэвээр байна.


Гадаад хүчин зүйлсээс 1) хилийн хязгаарлалт, худалдааны түнш орнуудын инфляц, төгрөгийн ханшийн өөрчлөлтийн нөлөөгөөр импортын барааны үнэ эрчтэй нэмэгдсэн, 2) хилийн хязгаарлалтаас үүдэлтэйгээр импортыг орлох дотоодын хүнсний үнэ хурдтай нэмэгдсэн, 3) шатахууны үнэ, импортын орцын үнийн өсөлттэй холбоотойгоор дотоодын бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зардал нэмэгдэж бараа, үйлчилгээний үнэ өссөн нь инфляциад том нөлөөтэй байв. Түүнчлэн бус нутагт үүссэн geopolitikiin асуудал нь гадаад инфляц, хүнс болон түүхий эдийн үнийн өсөлтийг эрчимжүүлсний зэрэгцээ олон улсын тээвэр, логистикт бий болсон түгжрэлийг даамжуулах эрсдэлтэй байна. Энэ нь дотоодын шатахуун, үйлдвэр, тээврийн зардал болон импортын бүтээгдэхүүний үнийг өсгөх нөлөөтэй юм.

2022 оны эхний улирлын байдлаар үйлдвэрлэлийн зардлын өсөлтөөр дамжин зардлын инфляц бий болох, инфляцын хүлээлт өсөх, төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэхийн зэрэгцээ гадаад суурь хүү хурдтай өссөн нь мөнгөний бодлогын төлөвийг илүү хурдтай чангариулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагыг бий болгосон юм. Иймд Монголбанкны МБХ-ны 2022 оны 1 дүгээр сарын ээлжит бус хурал, 3 дугаар сар, 6 дугаар сарын ээлжит хурлуудаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал гадаад, дотоод орчны төлөвийг хэлэлцэн бодлогын хүүг харгалзан 0.5, 2.5, 1.0 нэгж хувиар тус тус нэмэгдүүлж, 10.0 хувьд хүргэх шийдвэрийг гаргасан. Улмаар инфляц 2022 оны туршид зорилтот түвшин болох 6 хувь (+/-2)-иас дээгүүр байх, 2023 онд алгуур буурах хүлэлттэй байна.

Зураг 17. Улсын болон УБ хотын инфляц



Зураг 18. УБ хотын жилийн инфляц
(бүрэлдэхүүнээр)



Эх сурвалж: YCH

1.2 КОВИД-19 цар тахлын хүндрэлийг даван туулах, эдийн засгийн сэргэлт, дунд хугацааны макро тогтвортой байдлыг дэмжсэн зээлийн тогтвортой өсөлтийг хангаж, банкны системд эрсдэл хуримтлагдахаас сэргийлсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

Монголбанк нь санхүүгийн системд үүсэж болзошгүй эрсдэлийг хязгаарлах, макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж байна.

Банкны системийн нөхцөл байдлыг шинжилж, үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, макро зохистой бодлогын үр нөлөөг тооцох шинжилгээний аргачлал, индикаторуудыг олон улсын туршилагад нийцүүлэн хөгжүүлж, бодлогын шийдвэр гаргалтад нэвтрүүлэх зорилгоор олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, зорилтот төслүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, Азийн хөгжлийн банк (АХБ)-ны санхүүжилтээр хэрэгжиж буй төслийн хүрээнд системийн эрсдэлийн үнэлгээний загварын гол модуль болох Банкны ашиг, алдагдлын модулийг хөгжүүлж, загварын тавил, загварыг хэрхэн ажиллуулах талаар 6 удаагийн сургалтад хамрагдav. Монголбанкны зүгээс тус модулийг сайжруулах саналыг боловсруулж, АХБ-ны зөвлөхтэй хамтран ажиллаж байна. Цаашид дараагийн модулиудыг хөгжүүлэх, загварыг бүрэн боловсруулж дуусгахад шаардлагатай тоон мэдээллийг цуглуулах болон бусад холбогдох судалгааны ажлуудыг хийж байна.

Банкны системийн нэгтгэлийг боловсруулан системд үүсэж болзошгүй эрсдэлийг хянаж, сар болон улирал бүр нэгтгэж, удирдлагуудад танилцуулж байна. Монголбанкны МБХ-ны 2022 оны 6 дугаар сарын ээлжит хуралд “Банкны системийн өнөөгийн нөхцөл, үүсэж болзошгүй эрсдэл”-ийн талаар танилцууллаа. Түүнчлэн санхүүгийн системийн эрсдэлийн зураглал, мэдрэмжийн шинжилгээг системийн хэмжээнд болон банк тус бүрийн хувьд гүйцэтгэж байна. Мөн системийн тогтвортой байдал, төлбөрийн чадварын эрсдэлийн шинжилгээг гүйцэтгэх зорилгоор стресс тестийн загварчлалыг олон улсын байгууллагын санхүүжилттэй төслийн хүрээнд боловсруулан ажиллаж байна. Түүнчлэн санхүүгийн мөчлөгийн үнэлгээг боломжит тоон мэдээллийн хүрээнд шинэчилж, санхүүгийн системийн нөхцөл байдлыг шинжлэв.

1.3 Төв банкны олон нийттэй харилцах харилцааг хөгжүүлж, бодлогын ил тод байдлыг хадгалж ажиллана.

Монголбанкны олон нийттэй харилцах харилцааг хөгжүүлж, бодлогын шийдвэрийн ил тод байдлыг хангаж, түүний үндэслэлийг тайлбарлах хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Үүнд:

Зах зээлд оролцогчдыг мэдээллээр хангаж, мөнгөний бодлогын үр нөлөөг дээшилүүлэх ажлын хүрээнд:

- МБХ 2022 оны эхний хоёр улиралд ээлжит (2022.03.24, 2022.06.22) болон ээлжит бус (2022.01.28)-аар 3 удаа хуралдсан бөгөөд мөнгөний бодлогын мэдэгдэл болон хураангуй тэмдэглэлийг Монголбанкны цахим хуудас, олон нийтийн сүлжээний сувгуудад байршуулж, мөнгөний бодлогын шийдвэрийг олон нийтэд түгээв. Түүнчлэн МБХ-ны шийдвэрийг хэвлэлийн хурлаар болон Фэйсбүүкээр шууд дамжуулан олон нийтэд танилцуулав.
- Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн зөвлөмж, инфляцын тайлан, төв банкнаас нийтэлдэг бусад тайлан, статистик, график мэдээллийг оны эхний хагаст сар бүр хуваарийн дагуу веб хуудас болон сошиал хаягуудаар мэдээлэв.
- Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчидтэй чөлөөт уулзалтыг зохион байгуулж, төв банкны бодлого шийдвэр, сүүлийн үеийн эдийн засгийн нөхцөл байдлын талаар танилцуулав. Тухайлбал, 2022 оны 4 дүгээр сард төлбөрийн тэнцэл, 5 дугаар сард банкны IPO, 6 дугаар сард инфляц, мөнгөний бодлого сэдвүүдээр тус тус зохион байгуулав.
- Төв банкны цахим хаягууд болон олон нийтийн сошиал хуудсуудаар дамжуулан мөнгөний бодлогын шийдвэр, үндэслэл, төв банкны үндсэн зорилт, үйл ажиллагааны чиглэлийн талаарх видео контентууд, инфографик бэлтгэн энгийн товч байдлаар тайлбарлаж байна.

Олон нийттэй харилцах сувгийг хөгжүүлж, боловсронгуй болгох ажлын хүрээнд:

- Монголбанкны олон нийттэй харилцах цахим сувгуудыг хөгжүүлж Фэйсбүүк, Твиттер, Ютуб, Инстаграм сошиал хуудсуудаар дамжуулан цахим орчинд тогтмол мэдээлэл түгээж байна.
- Олон нийтэд хүртээмжтэй болон эдийн засгийн чиглэлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нэвтрүүлгээр дамжуулж төв банкны бодлого шийдвэрийг тогтмол түгээж байна. Тухайлбал, MYOHT-ийн “Эдийн засгийн тойм” булан, Блуүмберг телевизийн өдөр тутмын мэдээллийн хөтөлбөрүүд, Ийгл телевизийн “Тоон тойм” зэрэг дотоодын томоохон эдийн засгийн хөтөлбөрүүд болон өдөр тутмын сонин, вебсайтуудад тогтмол мэдээлэл нийлүүлж, удирдлагын түвшинд ярилцлага өгч, олон нийтийг мэдээ, мэдээллээр ханганд ажиллаж байна.
- Монголбанкны бодлого үйл ажиллагаа, гадаадад болон дотоодод өрнөж буй эдийн засгийн сүүлийн үеийн мэдээ, мэдээллийг багтаасан “Монголбанкны мэдээлэл” товхимлыг сар тутам эрхлэн гаргаж, шийдвэр гаргагчид, томоохон төрийн байгууллагуудад, эдийн засгийн чиглэлээр сургалт явуулдаг их, дээд сургуулиудад болон санхүүгийн салбарынханд түгээж байна.
- Монголбанкнаас олон нийт, иргэдийн дунд зохион байгуулдаг эрдэм шинжилгээний хурлын сэдвийг цаг үеийн сэдвээр сонгож, Монголбанкны бодлого, шийдвэр болон оюутан, судлаачдын бүтгэлийг олон нийтэд хүртээл болгох зорилгоор улирал бүр зохион байгуулж байна. Тухайлбал, 2022 оны 2 дугаар улиралд Монголбанкны нэрэмжит эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж, Монгол-Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын мэдээллийг олон нийтэд түгээх чиглэлээр ажиллав.

- Орон нутгийн иргэдийг төв банкны үйл ажиллагаа, эдийн засгийн мэдээллээр тогтмол хангах зорилгоор орон нутгийн салбар, нэгжийн удирдлагын захирлуудыг мэдээллээр хангах, сэтгүүлчдэд хийх сургалтад шаардлагатай мэдээллийг өгч байна.

2. БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД:

2.1 Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын стандартад нийцүүлэх арга хэмжээг үргэлжлүүлж, цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хүрээнд мөрдөгдөж буй зохицуулалтыг ердийн нөхцөлд шилжүүлэх төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.1.1. “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын хүрээнд цар тахлын үед мөрдүүлж буй зохицуулалтыг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан журмын ердийн нөхцөлд шилжүүлэх

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А-167 дугаар тушаалаар баталсан “Монголбанкнаас цар тахлын үед хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээг хэвийн горимд шилжүүлэх төлөвлөгөө”-ний дагуу 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр тус зохицуулалтын арга хэмжээнүүд бүрэн цуцлагдаж хэвийн горимд шилжүүлээд байна.

2.1.2. “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу бүрдүүлэх шаардлагатай, банкийг эрсдэлээс хамгаалах зориулалт бүхий нөөц интервалыг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан мөрдүүлэх

“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-138 дугаар тушаалаар баталж, 2019 оны А-338 дугаар тушаалаар өөрчлөлт оруулсны дагуу банкийг эрсдэлээс хамгаалах зориулалт бүхий нөөцийн интервалыг нэвтрүүлж, мөрдүүлэх хуваарыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-314 дүгээр тушаалын дагуу дахин өөрчлөлт оруулсан. Үүний дагуу банкны эрсдэл даах чадварыг хамгаалах нөөцийн интервалын суурь хэсгийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 1 нэгж хувиар, 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2 нэгж хувиар тогтоох, тусгай хэсгийн хувьсах бүрэлдэхүүнийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс тооцооор тус тус шийдвэрлэсэн.

2.1.3. Банкны үйл ажиллагаанд шинэчлэн тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг банкуудад нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлж, хэрэгжилтэд хяналт тавих

Банкны эрсдэл даах чадварыг хамгаалах зориулалт бүхий нөөц интервалыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-314 дүгээр тушаалаар баталсан хуваарийн дагуу бүрдүүлж байгаа эсэх, шинэчлэн тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг банкууд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-139 дүгээр тушаалаар баталсан хуваарийн дагуу нэвтрүүлж байгаа эсэхдэд Монголбанк тухай бүр хяналт тавьж ажиллаж байна.

2.1.4. Банкны тухай хуулийн дагуу Тогтвортжуулалтын санг бүрдүүлж эхлэх, тогтвортжуулалтын сангийн удирдлагын талаар олон улсын сайн туршлагыг судалж холбогдох зохицуулалтуудыг боловсронгуй болгох

Банкны тухай хуулийн дагуу Банкны тогтвортжуулалтын сангийн журмыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-155 дугаар тушаалаар баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэв. Дээрх журмын дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-359 дүгээр тушаалаар банкуудаас тус санд төвлөрүүлэх хураамжийн хэмжээг тогтоож, 2022 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр холбогдох банкуудад албан бичиг хүргүүлсэн. 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар Банкны тогтвортжуулалтын санд банкуудаас 6.8 тэрбум

төгрөгийг төвлөрүүлээд байна.

2.2 Банк хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулах хууль, эрх зүйн шаардлагын хүрээнд хяналт шалгалт, зохицуулалтыг боловсронгуй болгож мөрдүүлийн.

Хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулахаар хүсэлтээ гаргаж байгаа банкуудын IPO хийх төлөвлөгөө, банкны шинэчилсэн дүрэм болон бусад холбогдох баримт материалуудыг хяналж, СЗХ-нд албан бичгийн хувийг хүргүүлэн, хамтран хяналт тавих ажлыг гүйцэтгэж байна.

УИХ-аас 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуультай нийцүүлэн системийн нөлөө бүхий банканд мөрдөх “Банканд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах, хэрэгжүүлэх журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-56 дугаар тушаалаар батлав. Түүнчлэн “Банкийг албадан татан буулгах арга хэмжээг хэрэгжүүлэх, банкны эрх хүлээн авагч томилох, дуусгавар болгох журам”, “Банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөний журам”-ын төслийг боловсруулж, олон нийтээс санал авч, батлуулахаар эцэслээд байна.

2.3. Банкны салбарын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгаа, үр дүнд үндэслэн эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдлийг арилгаж нэгдмэл байдлыг хангах, зээлийн мэдээлэл, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, буцаан худалдан авах барьцаат санхүүжилтийн хэлцлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээ авна.

Монголбанкнаас банк, санхүүгийн салбарын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хяналт шалгалтын олон улсын сайн туршлага, зарчим, зохицуулалтыг Монгол улсын банкны системийн онцлогт нийцүүлэн, шат дараатайгаар нэвтрүүлэх, эрсдэл суурилсан хяналт шалгалтын арга барилд шилжих ажлууд үргэлжлэн хийгдэж байгаа бөгөөд энэхүү хүрээнд хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэн сайжруулж, банкны хяналт шалгалт, зохицуулалтын орчныг боловсронгуй болгоход чиглэсэн хууль, журам, зааврын төслийг боловсруулан ажиллаж байна.

Банкны салбарт мөрдөгдөж байгаа хуулийн эрх зүйн зохицуулалт, давхардал, зөрчил, хийдлийг арилгах үүднээс Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Иргэний хууль, Компанийн тухай хуулийг хамруулсан судалгааг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалаар баталсан “Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал”-д заасан шалгуурын дагуу дотоодын зөвлөхтэй хамтран хийж, судалгааны үр дүнг эцэслэн боловсруулахаар ажиллаж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А-1/255 тоот албан бичгээр УИХ-ын Тамгын газарт хуулиудын хувийн хэргийг авах хүсэлт хүргүүлж, 2022 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн ТГ-02/293 тоот албан бичгээр 7 хуулийн хувийн хэргийг хүлээн авч судалж байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль, тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулах ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-202 дугаар тушаалаар байгуулж, хуулийн төслийг урьдчилан тандан судлах ажлыг гүйцэтгэж байна.

“Санхүүгийн үүсмэл хэрэгслийг зохицуулах хууль”-ийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судалж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-137 дугаар тушаалаар байгуулж, санхүүгийн үүсмэл хэрэгсэл болон барьцаат санхүүжилттэй холбоотой зохицуулалтын хэрэгцээ шаардлагыг тандан судлах ажлыг гүйцэтгэж байна.

3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

3.1. Төв банкны цахим мөнгө гаргах талаар судалж, хөгжүүлнэ.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн А-228 дугаар тушаалаар Төв банкны цахим мөнгө (ТБЦМ) гаргах талаар судалж, хөгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, ТБЦМ-ний талаар гадаад улсын төв банкны туршлага, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зөвлөмж, Монголбанкнаас цахим мөнгө гаргах эрх зүйн орчин, хуулийн дүгнэлт, эрх зүйн хувьд анхаарах асуудал зэргийг судлан танилцуулга хийж, санал солилцож, мэдээллээ нэгтгэв. ТБЦМ-ний талаар судлах, турших ажлын хэсэгт зориулан Монголбанкны Төлбөрийн системийн шинэчлэл төслийн нэгжийн гадаад улсын зөвлөх “Бусад улсын ТБЦМ-ний талаар хэрэгжүүлж буй судалгаа, бодлого, төслүүд болон Монголбанк авч болох сайн туршлага” сэдвээр танилцуулга хийж, ажлын хэсгийн гишүүдтэй 2022 оны 5 дугаар сард хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн энэхүү ажлын хүрээнд ТБЦМ-ний талаарх олон улсын туршлага, сайн жишгийг судалж, холбогдох танилцуулгыг боловсруулаад байна.

3.2. Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулах замаар шинэ технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг дэмжиж, төлбөрийн систем дэх хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Монголбанк болон төрийн холбогдох байгууллагуудаас төлөөлөл оролцуулан Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-127 дугаар тушаалаар байгуулав. Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10 дугаар зүйлд тусгасан Монголбанкнаас олгодог зөвшөөрлийн төрөл давхардсан, мөн 15 дугаар зүйлд тусгасан шаардлагыг хангасан л бол зөвшөөрөл шууд олгох зэрэг зохицуулалт нь эрсдэл үүсгэж байгаа тул дахин найруулах, мөн уг хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т заасан цахим мөнгөтэй холбоотой заалт нь бутархай цахим мөнгө үүсэх нөхцөлийг хааж байгаа нь бодит байдалд нийцэхгүй байгаа талаар, 27 дугаар зүйлд заасан “Хязгаарлагдмал хүрээнд үйлчилгээ үзүүлэх” этгээдэд зөвшөөрөл олгох эсэхийг тодорхой болгох, зарим нэр томьёо нь бодит байдал дээр хэрэгжихэд хүндрэлтэй байгаа тул өөрчлөн найруулах, мөн 9 дүгээр бүлэгт төлбөрийн системийн оролцогч хоорондын гүйлгээ нь клирингийн төвөөр дамжих тухай заалт нэмж оруулахаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судалж, олон улсын стандарт, зөвлөмжийн дагуу хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.

Дэлхийн банкны зүгээс Монгол Улсын үндэсний төлбөрийн системийн үйл ажиллагааг хөгжүүлэх, олон улсын сайн жишигт нийцүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр 2015 оноос эхлэн техник туслалцаа үзүүлж, хамтран ажиллаж байна. Энэхүү техник туслалцааны хүрээнд Монгол Улсын төлбөрийн системийн хөгжлийн чиг баримжааг тодорхойлох, эрх зүйн орчныг бэхжүүлэх, төлбөрийн системийг цаашид хөгжингүй орны жишигт нийцүүлэх зорилгоор Монголбанкнаас “Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратеги 2022-2026” баримт бичгийн төслийг боловсруулж, холбогдох судалгааг хийж гүйцэтгэв.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль батлагдаж, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр төв банкнаас гадна зөвшөөрөл бүхий хуулийн этгээд клирингийн үйл ажиллагаа явуулах боломж бүрдсэн бөгөөд Монголбанк нь Худалдаа хөгжлийн банк (ХХБ)-нд өөрийн дэд гишүүн банкуудын хооронд төлбөрийн картын клирингийн систем ажиллуулах зөвшөөрлийг 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр олгосон. ХХБ нь зөвшөөрөл авснаас хойш “Банксүлжээ” системийн тестиийн

орчинд эрх нээлгэж, хоёр талаас тодорхой хугацаанд шаардлагатай бэлтгэл ажлуудыг хангаснаар 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн “Банксүлжээ” системд картын клирингийн үр дунгийн тооцооллын хаалтын гүйлгээг амжилттай дамжуулж эхлээд байна.

Монголбанк нь Үндэсний төлбөрийн системийг удирдан зохион байгуулах, хяналт тавих үндсэн чиг үүргийнхээ хүрээнд Үндэсний төлбөрийн системийн зөвлөл (YTCЗ)-ийн ээлжит хурлыг 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулж, уг хуралд YTCЗ-ийн гишүүн байгууллагын гүйцэтгэх болон удирдах түвшний нийт 66 гишүүн оролцов. Тус хурлаар Монголбанкнаас “Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг 2022-2026 онд хөгжүүлэх стратеги”, “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”, “Олон улсын төлбөр тооцооны нөхцөл байдал” сэдэвтэй илтгэлийг танилцуулан, оролцогчдын санал, хүсэлтийг хүлээн авч, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Үндэсний төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх үүднээс оролцогч болон операторын үйл ажиллагааны тайланд хяналт тавьж, илэрсэн зөрчилд арга хэмжээ авч ажиллав. Цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээний зөвшөөрөл авсан 7 байгууллагаас ирүүлж буй цахим мөнгөний тайланд хяналт тавьж, илэрсэн зөрчилд арга хэмжээ авч ажилласан. Түүнчлэн “Банксүлжээ” системийн үйл ажиллагаа, холбогдох гэрээ, журам, зааврын хэрэгжилт, үндсэн болон нөөц төвд иж бүрэн шалгалтыг хийж гүйцэтгэв. Хянан шалгагчид шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд мэдэгдэж, залруулах талаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд арга хэмжээ авав. ХААН банкны оролцогч хоорондын бага дүнтэй гүйлгээний болон картын төлбөрийн систем 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдөр тасарсантай холбоотойгоор газар дээрх гэнэтийн шалгалтыг хийж, хянан шалгагчид өөрийн бүрэн эрхийн хүрээнд арга хэмжээ авч ажиллалаа.

3.3. Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дэмжинэ.

Монголбанк нь СЗХ-той хамтран Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөлд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлж байгаа санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагыг тогтоож, зохицуулагч байгууллагаас зохистой хяналт шалгалтаас гадна санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, санхүүгийн хэрэглэгчээс гаргасан санхүүгийн үйлчилгээтэй холбоотой гомдол, маргааныг түргэн шуурхай хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий санхүүгийн омбудсманыг байгуулах агуулгаар эцслэн боловсруулж дуусав.

Тайлант улирлын байдлаар санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- “Бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ (БЖДҮҮ) эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар, Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих газартай хамтран хоёр удаагийн сургалтаар 21 аймаг, нийслэл хотын нийт 55 сургач багшийг бэлтгэв. Тус сургалтаар сургач багшийн заах арга зүй, банк санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээ, эдийн засгийн анхан шатны ойлголтууд, цахим худалдаа, хямралын үеийн эрсдэл болон санхүүгийн удирдлага зэрэг сэдвүүдээр мэдлэг, мэдээлэл олгов.
- Санхүүгийн мэдлэг олгох цахим хуудас (www.sankhuugiinbolovsrol.mn) болон Фейсбуу^ук хуудас (@sankhuugiinbolovsrol)-ыг шинэ мэдээ, мэдээлэл, подкастаар тогтмол баяжуулан ажиллаж байна. Тайлант улиралд мөнгөө хэрхэн зөв удирдаж, санхүүгийн бэрхшээлгүй амьдрах талаар цуврал подкастыг хийж эхэлсэн бөгөөд “Санхүүгийн боловсролтой хүн гэж ямар хүнийг хэлэх вэ?” сэдвээр дугаар бэлтгэж цахим хуудсуудад байршуулав.
- “Монголбанкны мэдээлэл” товхимол бэлтгэж түгээх ажлын хүрээнд тайлант улирлын

байдлаар нийт 3 дугаар (“Монголбанкны мэдээлэл” сэтгүүл – 60, 61 дүгээр дугаарууд, “Судалгааны ажил” товхимол 16, 2021 оны онцлох 20 ажил товхимол) эрхлэн гаргаж, 1200 хувийг хэвлүүлэн, дугаар бүрийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ, Засгийн газар, банкууд, Монголбанкны газар нэгжүүд, орон нутаг дахь хэлтэс салбар, аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, номын сан, сургуулиудад түгээж ажиллалаа.

- Монголбанк, Монголын Банкны Холбоо, ХБНГУ-ын Шпаркассэ банкны сан хамтран “Монгол Улсад банкны ажилтныг мэргшүүлэх-онол, практик хосолсон сургалт болон Дэлхийн хуримтлалын өдрийг нэвтрүүлэх төсөл”-ийг 2017 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн хүрээнд 2022 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 4 сургалтыг зохион байгуулж 66 оролцогчдыг хамруулав.
- Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд УИХ-ын Тамгын газар, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл, Батлан хамгаалах яам, ХХААХҮЯ, Онцгой байдлын ерөнхий газар, Рио Тинто ХХК, MYXAYT, Монголын бизнесийн зөвлөл, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Дэлхийн зөн олон улсын байгууллагуудын дэргэдэх ТББ зэрэг төр, хувийн хэвшлийн 32 байгууллагатай хамтран санхүү, эдийн засгийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг 1,490 хүнд оров.
- Монголбанкны нэрэмжит эрдэм шинжилгээний бага хурлын эцсийн шатны шалгаруулалтыг 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулав. Энэ удаагийн эрдэм шинжилгээний хуралд судлаачид болон оюутны ангилалд нийтдээ 22 бүтээл ирүүлсэн бөгөөд эхний шатанд ангилал тус бүрд шалгарсан 5 бүтээлийн хэлэлцүүлгийг зохион байгуулан байр эзлүүлэв.
- Олон нийтийн санхүү, эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгын хүрээнд Монголбанкнаас Төрийн банктай хамтран санхүүгийн мэдлэг олгох сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг хоёр дахь удаагаа зохион байгуулав. Тухайлбал, тайлант улиралд тус банкны 34 ажилтныг санхүүгийн суурь мэдлэгийн сэдвүүдээс гадна хичээлийн агуулга, заах арга барил, сургалт зохион байгуулах ур чадваруудын талаар хөтөлбөрт сургалт орж, сургагч багшаар бэлтгэв.

3.4. Макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн шинжилгээнд их өгөгдлийг ашиглах техникийн болон мэргэшлийн ур чадварыг үе шаттайгаар бүрдүүлж эхлийн.

3.4.1. Их өгөгдлийг ашиглан дүн шинжилгээ, боловсруулалт хийх чадавх бүхий дэд бүтцийг бий болгох ажлын хүрээнд хатуу дэд бүтцийг суурилуулж ашиглаж эхлэх

Монголбанканд тоо мэдээлэл ирүүлдэг байгууллагуудаас тоо мэдээллийг авч нэгтгэх, хадгалах, боловсруулахад шаардлагатай хатуу дэд бүтэц болон холбогдох систем, ажлын программуудыг суурилуулж, холбогдох туршилтуудыг гүйцэтгэсэн. Түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-128 дугаар тушаалаар Монголбанканд их өгөгдлийн сангийн удирдлагын системийг нэвтрүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг Монголын банкны холбоо болон банкуудаас төлөөлөл оролцуулан шинэчлэн байгуулан ажиллаж байна.

3.4.2. Их өгөгдлийн мэдээлэл нэгтгэх програмууд (IGS), их өгөгдөл боловсруулах Hadoop суурьтай програмууд, бизнес аналитикийн програмууд дээр ажиллах боловсон хүчнийг сургаж бэлтгэх

Их өгөгдлийн системийг нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэгч компанийтай хамтран хийж байгаа бөгөөд их өгөгдлийн системийн үйл ажиллагааг хэвийн явуулах үүрэг бүхий нэгж, түүний баг бүрэлдэхүүн, чиг үүрэг, ажлын уялдаа болон хариуцах ажил үүргийн хуваарь, ур чадварын шаардлага бүхий танилцуулгыг боловсруулж бэлтгэв. Үүний дагуу 2022 оны 2 дугаар хагаст 1) их өгөгдлийн системийн үйл ажиллагааг явуулах чиг үүрэг бүхий нэгж, түүний баг бүрэлдэхүүнд Talend болон Cloudera программуудын сургалтыг зохион байгуулах, 2) их өгөгдлийн системийн үйл ажиллагааг явуулах чиг үүрэг бүхий нэгжтэй ажил үүргээ уялдуулж ажиллах Монголбанкны бусад газар, нэгжүүдийн ажилтнууд (data steward)-д бизнес аналитикийн Tableau программын сургалтуудыг зохион байгуулна.

ТӨСЛИЙН ТООЦОО, СУДАЛГАА

I. ИНФЛЯЦ

Олон улсын геополитикт үүссээд буй хурцадмал байдал нь цар тахлаас шалтгаалан бий болсон дэлхийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэргүй байдлыг улам гүнзгийрүүлж, инфляцыг эрчимжүүлсээр байна. Манай улсын хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх жилийн инфляц 2021 оны 4 дүгээр сараас нэмэгдэж эхэлсэн нь гадаад орчны сөрөг нөлөөлөл, хилийн хязгаарлалт, зардлын өсөлтөөс шалтгаалж байна. Инфляц өмнөх оны 4 дүгээр улирлаас өсөлт нь хурдсаж 2022 оны 6 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 16.1 хувь, Улаанбаатар хотод 16.9 хувьд хүрлээ (Зураг 19). Гадаад орчинд үүссэн тодорхой бус байдал, түүнээс улбаатай нийлүүлэлтийн хязгаарлалт, үйлдвэрлэлийн нэмэлт зардлууд, худалдааны түнш орнуудын үнийн түвшний өндөр өсөлт, хүнс, газрын тосны өндөр үнэ зэрэг нийлүүлэлтийн шинж чанартай инфляц ирэх улирлуудад үргэлжлэх төлөвтэй байна. Үүний зэрэгцээ, уул уурхайн бус салбарын үйл ажиллагаа тогтворжиж буйтай уялдан эрэлтийн шалтгаантай инфляц алгуур нэмэгдэхээр байна.

2022 оны 6 дугаар сарын байдлаар инфляцад дараах хүчин зүйлс голлон нөлөөллөө.

Махнаас бусад дотоодын хүнсний бүтээгдэхүүний үнэ өмнөх оны 10 дугаар сараас эхлэн эрчимтэй нэмэгдэж, оны эцэст жилийн өсөлт 20 хувийг давсан бол энэ оны 6 дугаар сард жилийн өсөлт 34.0 хувьд хүрч инфляцад үзүүлэх нөлөө 3.9 нэгж хувь болж нэмэгдлээ (Зураг 20). Нэг талаас шатахуун болон импортын орцын үнэ өсөж буй нь үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлж дотоодын хүнсний үнэ өсөхөд нөлөөлж байна. Мөн улирлын шинжктэй үнэ өөрчлөгддөг хүнсний бүтээгдэхүүнүүдийн үнийн нөлөө өндөр байна. Тухайлбал, хүнсний ногооны үнэ сарын 28.9 хувиар буюу улирлын хандлагаасаа давж өсөж жилийн өсөлт нь 127.5 хувьд хүрээд байна. Өмнөх оны ургацын нөөц багасхтай зэрэгцэн 6, 7 дугаар саруудад хүнсний ногооны үнэ илүү ихээр өсдөг хэдий ч энэ жилийн хувьд II улиралд улирлын хандлагаасаа давж өсжээ.

Импортын нийт бараа, бүтээгдэхүүний инфляцад үзүүлэх шууд нөлөө нь 8.5 нэгж хувь буюу инфляцын 50 гаруй хувийг бүрдүүлж байна.

Гадаад орчны тодорхой бус байдал нэмэгдэж, хилийн хязгаарлалт үргэлжлэн, худалдааны түнш орнуудын инфляц өссөний зэрэгцээ төгрөгийн ханш суларсан нь импортын үнэ эрчтэй нэмэгдэх шалтгаан болж байна. Тодруулбал, **импортын бараа¹⁸-ны** үнэ 6 дугаар сарын байдлаар жилийн 12.7 хувь өсөж инфляцын 3.4 нэгж хувийг хувийг, **импортын хүнс** жилийн 33.2 хувиар нэмэгдсэн нэмэгдэж 2.2 нэгж хувийг бүрдүүлэв.

Дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ¹⁹ хурдтай нэмэгдэж, өндөр түвшинд тогтсон нь дотоодын шатахууны үнэ өсөх үндэслэл болж байна. **Шатахууны үнэ** 2022 он гарснаар дунджаар 361 төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1121 төгрөгөөр өсөж инфляцын 2.8 нэгж хувийг бүрдүүлжээ.


¹⁸ Хүнсний бус импортоос шатахууныг хассан бүлэг

¹⁹ Брент газрын тосны 2022 оны 6-р сарын эцсийн үнэ \$115/баррель байв.

Зураг 19. Улсын болон Улаанбаатар хотын инфляц



Зураг 20. Улаанбаатар хотын жилийн инфляцын задаргаа



Эх сурвалж: YCX

Хүснэгт 5. Жилийн инфляцад голлох нөлөө үзүүлсэн бараа, бүтээгдэхүүнүүд / 6 дугаар сарын байдлаар хувиар/

№	Нэр төрөл	Жин	Жилийн өсөлт	Жилийн инфляцид эзлэх хувь
1	Шатахуун	0.06	64.9%	2.8% (▲)
2	Импортын хүнс	0.06	33.2%	2.2% (▲)
3	Хувцас, бөс бараа, гутал	0.13	15.6%	1.9% (▲)
4	Хүнсний ногоо (дотоод)	0.01	127.5%	1.1% (▲)
5	Талх, гурилан бүтээгдэхүүн (дот)	0.04	28.8%	1.1% (▲)
6	Сүү, сүүн бүтээгдэхүүн (дотоод)	0.03	21.4%	0.8% (▲)
7	Нийтийн хоолны үйлчилгээ	0.04	15.3%	0.7% (▼)

ШИГТГЭ 1. Төв банкууд инфляцын зорилтоо нэмэгдүүлэх шаардлагатай юу?

Инфляц өсөж төв банкуудын зорилтот түвшнээс давж байгаатай зэрэгцэн төв банкууд инфляцын зорилтоо нэмэгдүүлэх шаардлагатай юу гэсэн асуулт гарах болсон. Инфляцын зорилтыг нэмэгдүүлэх талаар дэвшүүлж буй зарим үндэслэлийг авч үзье.

- 1) Зарим судлаачид инфляцын одоогийн өсөлт нь голлон нийлүүлэлтийн шалтгаантай буюу төв банкны шууд нөлөөлж чадахгүй хүнс болон эрчим хүчний үнийн өсөлттэй холбоотой учраас төв банк үүнд хариу үйлдэл үзүүлэн мөнгөний бодлогын төлөвөө хэт чанггуулахгүй байх ёстой. Иймд инфляцын зорилтоо нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэх хандлага гарч байна²⁰.
- 2) Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээрт улс орнууд дэлхийн дундаж температурын өсөлтийг аж үйлдвэржилтийн өмнөх үсийн температураас 1.5 хэмээс илүүгүй байхаар хязгаарлахын тулд «Хүлэмжийн хийг бууруулахад хүчин чармайлт гаргах» явдал гэж зорилтыг тодорхойлсон. Энэ хүрээнд улс орнууд ногоон бизнесийн орчныг дэмжихийн тулд карбоны үнэ/татварыг шат дараатай тогтоох, одоо байгаа зарим татварыг нэмэгдүүлэх шаардлага бий болж байна. Энэ нь эрчим хүчний үнийг өсгөж, улмаар бусад бараа, бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэх нөлөөтэй гэж зарим судлаачид үзэж байна. Энэ асуудалтай холбоотойгоор төв банкууд цаашид инфляц дунд хугацаанд зорилтот түвшнээс давах эрсдэлийг үнэлэх, инфляцын зорилтоо нэмэгдүүлэх шаардлагатай юу гэдгийг харгалzan үзэх шаардлагатай гэсэн тайлбар ч бий (ECB (2022))²¹.

²⁰ Greg Ip: How to Deal With Above-Target Inflation: Raise the Target.

²¹ “Climate and the Financial System” at the American Finance Association 2022

3) Зарим эдийн засагчид мөнгөний бодлогын орон зай хязгаарлагдмал буюу бодлогын хүү бага түвшинд байгаа үед инфляцын зорилтыг нэмэгдүүлэх нь ач холбогдолтой байж болохыг тэмдэглэжээ. Тухайлбал, 2007-09 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямралаас хойш ихэнх өндөр хөгжилтэй орнуудад бодит хүү буурч, нэрлэсэн хүү бага түвшинд байгаа нь төв банк эдийн засгийн уналтын үед бодлогын хүүгээ бууруулж эдийн засгийн идэвхжилийг дэмжих боломжийг хязгаарлаж байна. Үүний нэг шийдэл нь төв банкууд инфляцын зорилтыг нэмэгдүүлснээр богино хугацаанд нэрлэсэн хүүг өөрчлөхгүйгээр инфляцын хүлээлтээр дамжин бодит хүүг бууруулж, эдийн засгийн идэвхжилийг дэмжих боломж юм. Түүнчлэн энгийн үед харьцангуй өндөр инфляцын зорилтыг онилох тохиолдолд инфляцын хүлээлтээр дамжин зах зээл дээрх нэрлэсэн хүүгийн түвшин өсөх бөгөөд энэ нь мөнгөний бодлого боловсруулагчдад шаардлагатай үед (эдийн засгийн хямралын үед) бодлогын хүүг шат дараатай бууруулах бодлогын орон зайг үүсгэнэ гэж үзэх хандлага ч мөн гарч байна²². Өөрөөр хэлбэл, эдийн засгийн уналтын үед нэрлэсэн хүү 0-ээр хязгаарлагдаж байгаа нь төв банк инфляцын зорилтоо нэмэгдүүлэх үндэслэл байж болохыг онцолжээ.

Энд дурдсан үндэслэлүүд нь судалгааны болон хэлэлцүүлгийн түвшинд яригдаж байгаа бөгөөд үүсэж болох гол эрсдэлийн талаар нэмж судлах шаардлагатай юм. Сүүлийн 2 жилийн хугацаанд инфляцын зорилтоо нэмэгдүүлсэн төв банк одоогоор байхгүй байна²³. Төв банкуудын инфляцын зорилтыг тухайн улсын орлогын ангиллаар Зураг 21-д харууллаа.

Zuраг 21. Төв банкуудын инфляцын зорилт, орлогын ангиллаар (2022)



Эх сурвалж: Centralbanknews.info & Төв банкуудын цахим хуудас

Харин инфляцын зорилтыг нэмэгдүүлснээр үүсэж болох гол эрсдэлүүдийг авч үзье (Mishkin (2018)):

- Зорилтот түвшнийг нэмэгдүүлснээр инфляцын хэлбэлзэл өсөж инфляц, түүний хүлээлтийг тогтвортжуулахад илүү хүнд сорилттой тулгарна.
- Сүүлийн 30 жилд инфляцын зорилт тогтоож, инфляцыг бууруулан зорилтын орчимд тогтвортжуулсан нь төв банкуудын хувьд томоохон амжилт юм. Харин инфляцын зорилтыг нэмэгдүүлэх нь энэхүү сүүлийн 30 жилийн хугацаанд бий болгосон олон нийтийн төв банканд итгэх итгэлийг алдагдуулж, төв банкыг нэр хүндийн эрсдэлд оруулна.
- Цаашид инфляц өсөх үед төв банкнаас инфляцын зорилтыг дахин нэмэгдүүлнэ гэсэн хүлээлт үүсэх, олон нийтийн үнийн өсөлтийн талаарх нэрлэсэн аргамжаа (nominal anchor) алдагдах эрсдэлтэй.

²² (Blanchard et al. (2010), Krugman (2014), Mishkin (2018), Ball (2013), Summers (2018))

²³ Centralbanknews.info болон төв банкуудын цахим хуудас

- Богино хугацааны тодорхой бус байдлаас үүдэн дунд, урт хугацааны инфляцын зорилтоо нэмэгдүүлэх нь нөхцөл байдал хэвийн болох тохиолдолд мөнгөний хэт зөвлөн бодлого хэрэгжүүлж, үүнээс үүдэлтэй эдийн засгийн дотоод тэнцвэр алдагдах эрсдэлтэй.

Холбооны Нөөцийн Банк (ХНБ) болон Европын Төв банк (ЕТБ) инфляцын зорилтыг нэмэгдүүлэхгүйгээр стратегидаа зарим томьёоллын өөрчлөлт оруулан мөнгөний бодлогыг харьцангуй уян хатан болгож, бодлогын орон зайлж нэмэгдүүлж байна.

Тодруулбал, Холбооны Нөөцийн Банк 2020 оны 8 сард мөнгөний бодлогын стратегидаа “**инфляцын зорилт 2 хувь**” хэт хатуу байсныг “**инфляцын зорилтыг дунджаар 2 хувь**” болгож өөрчлөн баталлаа. Ингэснээр инфляц зорилтолт түвшнээс доогуур байсан үеүйдийн дараа хэсэг хугацаанд инфляц зорилтоос өндөр байх боломжтой буюу инфляцыг дунджаар 2 хувьд байхад анхаарч байна. Энэ нь эдийн засаг хямраалаас сэргэж байх үед бодлогын хүүг бага түвшинд харьцангуй удаан хадгалах, эдийн засгийн идэвхжилийг дэмжих бодлогын орон зайлж бий болгоно гэж тооцжээ (ХНБ (2020)). Харин Европын Төв Банкны хувьд мөнгөний бодлогын стратегидаа “**инфляцын зорилт 2 хувиас бага боловч түүний орчимд**” гэж тусгасан байсныг 2021 оны 7 сард “**инфляцын зорилтыг 2 хувь**” болгон өөрчиллөө. Улмаар инфляцын зорилт нь тэгш хэмтэй (symmetric) болж байгаа нь ЕТБ-ны зүгээс инфляц зорилтолт түвшнээс бага эсвэл өндөр байх нь адилхан эдийн засгийн зардалтай гэж үзэн аль ч тохиолдолд инфляцыг 2 хувийн түвшинд хүргэх бодлогын арга хэмжээ авах юм. Энэ нь сүүлийн 10 гаруй жилийн турш бага түвшинд байсан инфляц болон нэрлэсэн хүүгийн түвшнийг нэмэгдүүлэхэд түлхэц болно гэж үзжээ. Түүнчлэн өмнө нь инфляцын зорилтын дээд хязгаар 2 хувь байсан бол шинэ зорилтын хүрээнд инфляц түр хугацаанд 2 хувиас дээгүүр байх боломжтой юм (ЕТБ (2021)).

Монгол Улсын хувьд дунд хугацааны инфляцын зорилт 6 ± 2 хувь байгаа нь бусад орнууд, тэр дундаа орлогын түвшин ойролцоо ангилалд байгаа орнуудтай харьцуулахад бага зэрэг өндөр байна (Зураг 21). Ийнхүү харьцангуй өндөр байгаа зорилтыг одоо байгаа түвшнээс нэмэгдүүлэх нь төв банкны инфляцыг нам дор түвшинд тогтвортжуулж мацро эдийн засгийн тодорхой бус байдлыг бууруулах, эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэрийг хангах, цаашлаад ядуурал болон тэгш бус байдлыг бууруулах зэрэг дунд болон урт хугацааны эдийн засгийн үндсэн зорилтуудад нийцгүй юм.

Инфляцын зорилтыг өсгөж мөнгөний бодлогын орон зайлж нэмэгдүүлэх үндэслэл нь инфляцын зорилт харьцангуй бага, нэрлэсэн хүү нь эдийн засгийн хямралын үед тэгээр хязгаарлагдаж буй орнуудад илүүтэй хамаарна. Манай улсын хувьд инфляцын зорилт болон нэрлэсэн хүү харьцангуй өндөр байгаа нь инфляцын зорилтыг нэмэгдүүлэх үндэслэл болохгүй юм.


II. БОДИТ СЕКТОР

2.1. Нийт нийлүүлэлт

Цар тахал, түүнтэй холбоотой хязгаарлалт, тээвэр логистикийн хүндрэлийн нөлөөгөөр идэвхжил нь буураад байсан манай эдийн засаг 2022 он гарсаар алгуур сэргэх хандлага ажиглагдаж байна. ААН-үүд цар тахлын нөхцөл байдалтай илүү дасан зохицож, хорио цээрийн дэглэм супарснаар худалдаа, үйлчилгээний салбаруудын борлуулалт нэмэгдэн, бараа бүтээгдэхүүнд ногдуулах татварын орлого тэлсэн, цаг уурын таатай нөхцөл мал аж ахуйн салбарт эергээр нөлөөлсөн зэрэг хүчин зүйлс эдийн засгийг голлон тэтгэж байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар эдийн засаг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9 хувиар өсөв.

Хэдийгээр эдийн засаг алгуур сэргэж байгаа ч цар тахлын өмнөх үеийн түвшинд хүрээгүй хэвээр байна. Өөрөөр хэлбэл, 2019 оны эхний хагас жилийн үйлдвэрлэлтэй харьцуулахад манай эдийн засаг 1.4 хувиар бага байв.

Зураг 22. ДНБ-ий жилийн өсөлт, нийлүүлэлтийн бүрэлдэхүүнээр




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбаруудаар авч үзвэл хилийн боомтууд дээр үүссэн хязгаарлалттай холбогдуулан 2022 оны эхний хагас жилд уул уурхайн салбар өмнөх оны мөн үеэс 28.8 хувиар, тээврийн салбар 22.5 хувиар агшлаа. Уул уурхайн салбарыг гол нэр төрлийн бүтээгдэхүүнээр нь дэлгэрүүлбэл газрын тосны олборлолт зогсож, нүүрсний үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 43.9 хувиар, төмрийн хүдэр, баяжмал 9.8 хувиар, алт 3.9 хувиар тус тус уналттай байв. Зэсийн баяжмалын хувьд олборлолт 16.3 хувиар буурснаас гадна хүдрийн онцлогоос шалтгаалан металлын агууламж нь багасжээ.

Харин цар тахлын хязгаарлалтууд суларч, улмаар худалдаа үйлчилгээний салбаруудын идэвхжил нэмэгдэн, 2022 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар өсжээ. Бараа, бүтээгдэхүүний борлуулалт ийнхүү нэмэгдэж байгаатай уялдан улсын төсөвт төвлөрөх татварын орлого өмнөх оны мөн үеэс бодит дүнгээр 11.8 хувиар нэмэгдсэн байна. Түүнчлэн цаг агаарын таатай байдал том малын зүй бус хорогдол олон жилийн дунджаас бага, мал төллөлт харьцангуй өндөр байх нөхцөлийг бүрдүүлж, хөдөө аж ахуйн салбар өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар тэлсэн нь эдийн засгийн өсөлтөд том нөлөөтэй байв.

Зураг 23. Аж үйлдвэрийн салбаруудын өсөлт



Зураг 24. Үйлчилгээний салбаруудын өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ШИГТГЭЭ 2. Тээвэр, логистикийн өнөөгийн байдал

Монгол Улсын нийт барааны импортын 70 орчим хувийг гүйцэтгэдэг чингэлэг тээврийн салбарт сайжруулах ажлууд, шийдвэрлэх асуудлууд олон байна. Тухайлбал, тээврийн салбарын нийлүүлэлтийн сүлжээ сайн хөгжөөгүй тул тээвэрлэх хугацаа урт, цагийн хуваарь баталгаагүй, цаашлаад манай улсын импортоор авч буй бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт цөөн хэдэн далайн тээврийн компаниудаас хамаарал өндөртэй байна. Өнөөгийн үүсээд байгаа хүндрэлүүдээс үзвэл логистикийн нэгдсэн төв байгуулах, салбарын дотоод үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг ажил нэн чухал гэж тус салбарын бизнес эрхлэгчид үзэж байна.

Логистикийн нэгдсэн төв (ЛНТ)-ийн тухай

Гаднаас авч буй ихэнх ачааг Улаанбаатар хот хүртэл тээвэрлэдэг бөгөөд одоогоор 11 гаалийн хяналтын терминалын чингэлэг хүлээн авч байна. “Улаанбаатар төмөр зам ХНН” (УБТЗ) хүлээн авсан чингэлгийн галт тэргийг олон салбар замууд руу хуваарилах ажиллагаанд зардал болон хугацаа их зарцуулах, улмаар вагоны эргэлтийн хугацаа уртсах зэрэг асуудлууд тулгарч байна. Ийнхүү хугацаа уртсаж байгаа асуудал нь чингэлгийн түрээсийн зардал, зам дээр зогсоон төлбөрийг нэмэгдүүлэх байдлаар тээврийн зардлыг өсгөх, чингэлгийн эргэлтийг удаашруулдаг байна. Цаашилбал, далайн тээврийн компаниуд манай улс руу чингэлгээ оруулах сонирхлыг бууруулдаг. Түүнчлэн, чингэлгийн түрээсгүй эргэх хугацаа маш бага байдгаас шалтгаалж тээвэрлэлтийн зардал дээр чингэлэг түрээсийн өртөг нэмэгдэж логистикийн зардлыг өсгөж байна. Энэ нь тусгай зориулалтын чингэлгүүдээр тээвэрлэгддэг ачаанд ихээхэн хамааралтай юм (хөлдөөгчтэй чингэлэг REF, тавцант чингэлэг FR, open-top чингэлэг).

Эдгээр хүндрэлүүдийг шийдвэрлэх нэг боломжит шийдэл нь Улаанбаатар хотод Логистикийн нэгдсэн төв (ЛНТ) байгуулах юм. Цаашилбал логистикийн нэгдсэн төвийн стандартыг боомтын стандарттай уялдуулснаар далайн тээврийн баримт, бичиг эцсийн хүрэх Улаанбаатар хотын хуурай боомт гэсэн статус бий болох боломжтой болж, улмаар далайн тээврийн томоохон компаниудын чингэлгүүд Монголд орж ирэх сонирхол нэмэгдэн, манай улсын гадаад худалдааны тээвэр логистикийн зардал буурах боломж бүрдэнэ. Тодруулбал, ЛНТ байгуулснаар чингэлгийг ачиж буулагах давтамж цөөрөхөөс гадна нийт үйл ажиллагааны бүтээмж сайжирч, сүл зогсолтыг бууруулах тул тээвэр, логистикийн дэд бүтцийн хүчин чадлын ашиглалт нэмэгдэнэ. Ачаа тээврийн урсгалыг нэг цэгт төвлөрүүлэх нь чингэлгийн ашиглалтыг сайжруулж, цутгуулбар ачааг цөөлөх ач холбогдолтой. ЛНТ онцлог, ач холбогдолтой. Үүнд:

- Тээвэр зуучлагч, терминалын оператор, гуравдагч талын логистикийн үйлчилгээ үзүүлэгч зэрэг олон оролцогчид бие даан эсвэл хамтран ажиллах боломж олгодог.
- Төмөр замын шугам, гүүрэн кран, чингэлэг зөөвөрлөх машин, чингэлэг болон бусад тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний байгууламж зэрэг дэд бүтцийг дундаа ашиглах боломжтой.
- Гаалийн байгууллагаас бүх тээвэр зуучлагчдын үйл ажиллагааг нэгдсэн байдлаар хянах боломжтой тул дэд бүтэц, хүний нөөцийн хувьд хэмнэлттэй.
- Амин чухал дундын дэд бүтцээр хангахын зэрэгцээ ачаа тээврийн урсгалыг нэг цэгт төвлөрүүлэх тул хотын замын ачааллыг бууруулна.
- Хоосон чингэлгүүдийг цутгуулж, хадгалах төв болох бөгөөд чингэлгийг экспортын тээвэрт ашиглах боломжтой.
- Нэгдсэн терминал ашиглалтад орсноор үйл ажиллагааны бүтээмжийг сайжруулж, ачаа тээврийн эргэлтийг эрчимжүүлнэ. Ийм нэгдсэн төв байгуулагдсанаар УБТЗ-ын төмөр замын терминал дээр чингэлэг цуваа ангилах, илгээхэд цаг зарцуулах шаардлагагүй болно.
- Нэгдсэн төв байгуулагдсанаар чингэлэг ангилан ялгах, тээвэр зуучлагчдын терминал руу ангилсан ачааг тээвэрлэх зардал угүй болно.
- Нэгдсэн терминал дээрхээс гадна банкны үйлчилгээ, ачааны машины нэгдсэн зогсоол, чингэлэг болон ачааны машины засвар үйлчилгээний цех, 24 цагийн нэгдсэн хамгаалалт зэрэг бусад давуу талуудтай.

Тээвэр логистикийн салбарын дотоодын үр өгөөжийн нэмэгдүүлэх

ОХУ болон төмөр замын өргөн царигтай орнуудын вагон эзэмшигчид, оператор компаниуд өөрийн вагонуудаар тээвэр хийж, үндсэн тээврийн тарифаас гадна вагон ашиглуулсны зардлыг өөрсдийн зах зээлийн үнээр нэмдэг тул энэ нь тээвэр логистикийн зардлын ихээхэн хэсэг гадагшаа урсах шалтгаан болж байна. Иймд үндэсний оператор, мөн вагон эзэмшигч нарын хөрөнгө оруулалтыг дэмжих, тэдгээр хүмүүст дотоодын тээврийг гүйцэтгэх боломжоор хангах, гадны оператор компаниудтай ижил түвшинд өрсөлдөх боломжийг олгох нь дотоодод илүү нэмүү өртгийг бий болгох, валютын гадагшлах урсгалыг бууруулах, цаашилбал Орос – Монгол – Хятадын эдийн засгийн коридорын үр ашгийг сайжруулах ач холбогдолтой.

Эх сурвалж: Монголын тээвэр зуучлагчид


2.2. Нийт эрэлт

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон бодит дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) буюу нийт эрэлт 2022 оны эхний хагас жилд 1.9 хувиар өслөө. Эцсийн хэрэглээ болон хөрөнгийн нийт хуримтлал 18.0 хувиар тэлж, нийт эрэлтэд 21.8 нэгж хувийн зерэг нөлөөтэй бол цэвэр экспорт 19.9 нэгж хувийн бууруулах нөлөөг үзүүлжээ.

Хэрэглээ, хөрөнгө оруулалтын импорт оны эхнээс хурдтай өсөж, тэдгээр бүлгүүд нийт эрэлтийг дэмжих гол шалтгаан болж байна. Тухайлбал, оны эхний хагаст хөрөнгийн нийт хуриимлал дахь машин тоног, төхөөрөмж, орон сууцны барилга оны үнээр 70 гаран хувь, эргэлтийн хөрөнгө 84 хувиар өссөн ба өрхийн хэрэглээний хувьд загас, далайн бүтээгдэхүүн, тээврийн хэрэгсэл, согтууруулах ундаа бүлгийн хэрэглээ өндөр өсөлттэй байв. Мөн цар тахлын сөрөг нөлөөнд хүчтэй өртсөн үйлчилгээний салбарын хэрэглээ 30 гаран хувиар тэлжээ.

Харин уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт удааширсантай холбоотойгоор экспорт биет хэмжээгээр 16.0 хувиар буурч, хэрэглээ, нефтийн бүтээгдэхүүн болон хөрөнгө оруулалтын импорт огцом тэлж цэвэр экспорт нийт эрэлтэд 19.9 нэгж хувийн сөрөг нөлөөтэй байв (Зураг 25).

Зураг 25. ДНБ-ий жилийн өсөлт, эрэлтийн бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

III. УЛСЫН ТӨСӨВ

Энэ оны эхний хагас жилд Монгол Улсын нэгдсэн төсөвт 2 удаа тодотгол хийгдэв. Эхний тодотгол /2022.01 сар/-оор төсвийн зардлын булг хооронд дахин хуваарилах замаар өндөр настны тэтгэврийн зардлын хэмжээг 600 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн бол хоёр дахь тодотгол /2022.04 сар/-оор төсвийн орлого, зардлын төлөвлөгөөг 200 орчим тэрбум төгрөгөөр тус тус бууруулсан юм. Улмаар 2022 онд төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оноос 2.8 их наяд төгрөг, төсвийн нийт зардал 2.3 их наяд төгрөгөөр нэмэгдэж нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ хуульд заасан дээд хэмжээнд 5.1 хувьтай буюу 2.4 их наяд төгрөгт хүрэхээр байна (Зураг 26).

Зураг 26. Нэгдсэн төсвийн орлого, зардал, тэмцэл



Хүснэгт 6. Монгол улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Их наяд төгрөг	2021 Урьд. Гүй.	2022 Тод. Гүй.	2022.07 Гүй. хувь
Нийт орлого	14.3	16.3	9.4 98.1
Сангийн орлого	1.6	0.8	0.7 191
Тэнцвэржүүлсэн орлого	12.7	15.5	8.7 94.3
Татварын орлого	11.3	13.6	8.2 97.9
Татварын бус орлого	1.4	1.9	0.5 59.1
Нийт зардал	15.6	17.9	9.5 82.4
Анхдагч зардал	14.8	17.0	9.0 82.4
Хүүгийн зардал	0.8	0.9	0.5 81.9
Нийт тэнцэл	-1.3	-1.6	-0.1
ДНБ-д эзлэх хувь	-3.0%	-3.5%	-0.1%
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-2.9	-2.4	-0.8
ДНБ-д эзлэх хувь	-6.6%	-5.1%	-1.7%
Анхдагч тэнцэл	-2.1	-1.5	-0.3
ДНБ-д эзлэх хувь	-4.7%	-3.2%	-0.7%

Эх сурвалж: Сангийн яам

Оны эхний 7 сарын байдлаар төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 13.7 хувиар нэмэгдэж 8.7 их наяд төгрөгт, төсвийн зардал 11.9 хувиар өсөж 9.5 их наяд төгрөгт хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 788 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа (Хүснэгт 6).

ШИГТГЭЭ 3. Үнэ-цалин харилцан нэгнээ өсгөх үзэгдэл

Инфляц өндөр, үнэ цаашид ч өснө гэсэн хүлээлт нь ажил олгогчдод цалин өсгөх дарамт үүсгэнэ. Төрөөр хэлбэл, ажилчид худалдаж авах чадвараа хадгалахын тулд ядаж инфляцын түвшинтэй дүйх хэмжээгээр нэргэсэн цалингаа нэмэгдүүлэхийг ажил олгогчоос шаардаж, эцэстээ цалин өсгөх үр дүнд хүргэдэг. Цалин нэмэгдмэгц аж ахуйн нэгжийн зардал өсөж, ашгийн хэмжээ буурах учраас ашгийн түвшнээ хадгалах зорилгоор аж ахуй нэгж бараа, үйлчилгээний үнийг өсгөнө. Нөгөө талд өссөн цалин нь хэрэглээг буюу бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлэх замаар өсөж буй инфляцыг улам даамжуулна. Бараа, үйлчилгээний үнэ нэмэгдэх нь эргээд цалинг өсгөх шаардлагыг үүсгэдэг (Зураг 27).

Энд дурдсан үнийн өсөлт нь цалингийн өсөлтийг бий болгож, энэ нь эргээд инфляц нэмэгдэх үзэгдлийг “Үнийн хоёр дахь үеийн нөлөө” буюу “Үнэ-Цалин эзлжлэн өсөх үзэгдэл” гэж нэрлэдэг.

Зураг 27. Үнэ - Цалин эзлжлэн өсөх үзэгдэл




Сүүлийн улирлуудад цар тахал, геополитикийн зөрчлийн улмаас дэлхий даяар үнийн өсөлт эрчимжсэн. Энэ өсөлт олон улсын худалдааны интеграцийг дагаад олон оронд худалдааны нөхцөл муудаж, хүнс, шатахууны үнэ огцом нэмэгдсэнээс инфляцын дарамт үүсэж байна. Зардлын өсөлт олон бүтээгдэхүүнийг хамарч, инфляцыг богино хугацаанд эрчимжүүлдэг учраас хэрэглэгчдийн бодит орлогыг багасгаж, нийгмийн бухимдал үүсгэдэг. Цар тахлын үед зарим төрийн салбарын цалин нэмэгдсэн, хalamжийн тэлэх бодлого нь хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлж аж ахуйн нэгжүүд ажиллах хүчээ хадгалах зорилгоор цалинг нэмэх хандлага өнгөрсөн улирлуудад ажиглагдсан. Гэхдээ, инфляц эрчимжиж байгаа нь ажилчид цалингаа цаашид нэмүүлэх шаардлага тавихад хүргэхээр байна. Тухайлбал, Frederic etc. (2022)-д дурдсанaan 2021 оноос АНУ-д худалдаа, үйлчилгээний салбаруудын цалингийн түвшин хурдтай нэмэгдэж байгаа бол Евро бусэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, төрийн салбарын цалин өндөр өссөн байна. Хэдий хөгжингүй оруулад нийтлэг ажиглагдаж буй цалингийн өсөлт нь үнэ-цалин ээлжлэн өсөх үзэгдэл өртсөн талаар дүгнэлт хийх эрт байгаа ч эрсдэлийг анхааралдаа авах нь чухал гэдгийг мөн тэмдэглэжээ.

Түүнчлэн “Үнэ-цалин ээлжлэн өсөх үзэгдэл”-д өртөхгүй байх, өндөр инфляц удаан хугацаанд үргэлжлэхээс сэргийлэхийн тулд нэгж хөдөлмөрийн зардлыг нэмэгдүүлэхгүй байх нь чухал юм. Хэрэв ажил олгогч ажиллах хүчинийхээ тоо хэмжээг хадгалахын зэрэгцээ цалинг нэмэгдүүлбэл нэгж хөдөлмөрийн зардлыг өсгөх замаар аж ахуй нэгжийн нийт зардал өснө. Энэ үед аж ахуй нэгжийн бүтэээмж хэвэндээ байх нь ашгийн түвшнийг бууруулах учраас бараа бүтээгдэхүүний үнийг улам нэмэгдүүлэх шаардлага бий болно. Иймд бүтээмжийн өсөлт нь хөдөлмөрийн зардлын өсөлтөөс их эсвэл адил хэмжээнд байх нь “Үнэ-цалин ээлжлэн өсөх үзэгдэл”-д өртөхгүйгээр цалинг өсгөх боломжийг бүрдүүлэх чухал хүчин зүйл болно. Тухайлбал,

- Ажил олгогч цалин нэмэгдүүлсэн ч нэгж хөдөлмөрийн зардлаа тогтвортой хадгалахын тулд харьцангуй цөөн бөгөөд чадвартай ажиллах хүчин бүрдүүлж болно. Гэхдээ энэ нь хөдөлмөр эрхлэлтийг бууруулах буюу хөдөлмөрийн зах зээлд сөрөг нөлөө үзүүлнэ.
- Бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд нэгж хөдөлмөрөөр үйлдвэрлэж буй гарцын хэмжээг өсгөх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлийн технологийг сайжруулах замаар бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өргөжүүлэх боломжтой.

Судалгаанаас²⁴ үзэхэд Монгол Улсын хувьд цалингийн өсөлт нь 1 улирлын дараагаас инфляцын шалтгаан boldog бол, инфляц нь 2 улирлын дараагаас цалингийн өсөлтийг бий болгодог бөгөөд харилцан бие бисийнхээ шалтгаан boldog байна. Өөрөөр хэлбэл, инфляцаас өрхийн орлогын өсөлт рүү, харин богино хугацаанд өрхийн орлогын өсөлтөөс инфляц руу гэсэн чиглэл тод ажиглагдаж байна (Зураг 28). Цаашилд цалингийн 1 удаагийн өндөр өсөлтөөс улбаатай инфляц нь энэ хугацаанд бодит цалингийн өсөлтийг бууруулах нөлөөтэй байж болохыг тэмдэглэж, нэг дор өндөр хувиар өсгөх бус шат дараалалтай алгуур нэмэгдүүлэх нь төсвийн дарамтыг бууруулах нөлөөтэй.

Зураг 28. Монгол Улсын инфляц, нэрлэсэн цалингийн өсөлт



Эх сурвалж: YCH, Монголбанк

²⁴ Д.Ган-Очир. 2009. “Цалин болон орлого, инфляц хоорондын уялдаа.” Монголбанкны товхимол

“Үнэ-цалин ээлжлэх өсөх үзэгдэл” нь эдийн засгийн төлөв, өрхийн амьжиргаанд муугаар нөлөөлж буйг манай орны хувьд ч судлаачид онцолдог. Иймд инфляц өндөр байгаа одоогийн төлөв байдалд цалин, орлогыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэхдээ үнийн хоёр дахь үеийн нөлөөнд өртөхгүй байх оновчтой цалингийн өсөлтийг тодорхойлж, бүтээмжийн өсөлттэй уялдуулах нь чухал сорилт бөгөөд бодлогын шийдвэр гаргахаасаа өмнө зайлшгүй анхаарч авч үзэх хүчин зүйл юм.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, нэмэгдсэн өртгийн албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын орлого өндөр өсөлттэй байлаа. Харин ААНОАТ болон татварын бус орлого өнгөрсөн оны мөн үеэс нийлбэр дүнгээр 900 орчим тэрбум төгрөгөөр буурав. Энэ нь 2021 оны 4 дүгээр сард “Оюу Толгой” компанийн 1.0 их наяд төгрөгийн татварын орлогыг төсвийн орлогод тооцож бүртгэсэнтэй холбоотой юм.

“Хуримтлалтай хүүхэд”, КОВИД-19 тусlamж үйлчилгээ, тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээний үр дүнд төсвийн татаас, шилжүүлгийн зардал КОВИД-19 цар тахлын өмнөх буюу 2019 оны мөн үетэй харьцуулахад 3 дахин нэмэгдэж, төсвийн зардлын 62 хувийг дангаар бүрдүүлж байна.

Оны эхнээс төсвийн тэнцэл 788 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсны 233 тэрбум төгрөгийг гадаад зээлээр, 174 тэрбум төгрөгийг дотоод үнэт цаасаар, үлдсэн 380 тэрбум төгрөгийг төрийн сангийн харилцах дансны үлдэгдлээс санхүүжүүлэв (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Санхүүжилтийн шаардлага ба эх үүсвэр бүрдүүлсэн байдал

тэрбум төгрөг		2022 он	
		Жилийн төлөвлөгөө	Эхний 7 сард
1	Шаардлагатай санхүүжилтийн хэмжээ	3933	1237
1.1	Үнэт цаас эргэн төлөхөд	709	126
	Дотоод	292	126
	Гадаад	417	0
1.2	Зээл эргэн төлөхөд	837	323
	Дотоод	0	0
	Гадаад	837	323
1.3	Төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд	2387	788
2	Эх үүсвэрийн бүрдэл	3933	1237
2.1	Шинээр гаргасан үнэт цаас	2064	300
	Дотоод	2064	300
	Гадаад	0	0
2.2	Шинээр авсан зээл	1617	557
	Дотоод	0	0
	Гадаад	1617	557
	Төслийн зээл	1324	557
	Хөтөлбөрийн зээл	293	0
2.3	Тогтвортжуулалтын сан	752	0
2.4	Монголбанканд байрших дансны цэвэр өөрчлөлт	-500	380


Эх сурвалж: Сангийн яам

IV. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

4.1. Эдийн засгийн өсөлтийн төлөв

Эдийн засаг 2022 онд 3 хувиар өсөх хүлээлттэй байна. Уул уурхайн бус салбар сэргэн эдийн засгийн өсөлт энэ оны эхний хагаст хүлээлтээс өндөр гарлаа. Тодруулбал, хөл хорионы дэглэм суларч, дотоод эрэлт сэргэж эхэлснээр худалдаа, үйлчилгээний зарим салбаруудын идэвхжил нэмэгдэж, үүнээс улбаалан татварын орлого бүрдүүлэлт өссөн бол цаг агаарын таатай нөхцөл байдалтай уялдан малын зүй бус хорогдол бага, мал төллөлтийн явц сайн байсан нь хөдөө аж ахуйн салбар идэвхжихэд нөлөөлснөөр уул уурхайн бус салбарын өсөлтийг тэтгэлээ. Харин хилийн хязгаарлалт, геополитикийн хурцадмал нөхцөл байдал, БНХАУ-ын хэрэгжүүлж буй “Тэг-КОВИД” бодлого зэргийн улмаас гадаад эрэлт саарч, нүүрс, газрын тос, зэсийн баяжмал зэрэг гол металлуудын олборлолт төсөөллөөс бага гарснаар уул уурхайн салбарын үйлдвэрлэл хүлээлтэд хүрсэнгүй. Энэ оны сүүлийн хагасаас хилийн боомтууд дээр хязгаарлалт суларч, нүүрсний тээвэрлэлт сэргэж байгаатай холбоотойгоор уул уурхайн салбарын үйлдвэрлэл алгуур нэмэгдэхээр байна. Уул уурхайн бус салбарын хувьд хөдөө аж ахуй, худалдаа, бүтээгдэхүүний цэвэр татвар зэрэг эдийн засгийн өсөлтийг голлон тэтгэж буй салбаруудын хандлага оны сүүлийн хагаст хадгалагдах бол санхүү, даатгалын үйлчилгээ бууран үйлчилгээний салбарын өсөлт удаашрах төлөвтэй болов. Барилга, тээврийн салбарын үйлдвэрлэл энэ онд агшихаар байна.

Зураг 29. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл (эрэлт болон нийлүүлэлт талаас)



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Нийт эрэлтийг энэ оны сүүлийн хагаст хөрөнгө оруулалт, өрхийн хэрэглээ тэтгэх бол Засгийн газрын хэрэглээ, цэвэр экспорт бууруулах нөлөө үзүүлэхээр байна. Хөл хорио суларч, өнгөрсөн 2 жилийн хугацаанд агшсан үйлчилгээ болон зарим төрлийн импортын хэрэглээ сэргээнээр өрхийн хэрэглээ сүүлийн 3 улирал дараалан өсөж, нийт эрэлтийг нэмэгдүүллээ. Хөрөнгийн нийт хуримтлал энэ оны эхний хагаст 43.3 хувиар өсөж, дотоод эрэлтийг голлон тэтгэв. Өрхийн хэрэглээ оны сүүлийн хагаст үргэлжлэн тэлж, нийт эрэлтийг дэмжих бол төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын зардал буурсан, банкны зээл олголт буурч байгаа тул хөрөнгийн нийт хуримтлал цаашид удааширч, эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө саарахаар байна.

Харин 2023, 2024 онуудын эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 30 хувийн итгэх интервалд авч үзвэл харгалзан 2.0 – 6.8 хувь, 3.4 – 8.9 хувь байхаар байна. Оюу толгойн үйлдвэрлэл нэмэгдэх, нүүрсний экспорт хэвийн түвшинд хүрэх, газрын тосны олборлолт энэ оноос сайжрах нөлөөгөөр уул уурхайн салбарын өсөлт ирэх онд нэмэгдэх бол гадаад эрэлт саарах, худалдааны нөхцөлийн төлөв муудах, гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оноос төдийлөн нэмэгдэхээргүй байгаа нь уул уурхайн бус салбарын өсөлтийг сааруулахаар байна. 2024 оны хувьд уул уурхайн салбарын өсөлт суурь үеийн нөлөөгөөр алгуур буурах ч, Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт

жигдэрч эхлэн, үйлдвэрлэл тогтвортажсоонор уул уурхайн салбарын өсөлтийн төлөвт эргээр нөлөөлнө. Уул уурхайн бус салбаруудын хувьд урт хугацааны уналтаас гарч, үйлдвэрлэл хэвийн түвшинд хүрснээр эдийн засгийн өсөлтийг дэмжинэ гэж үзлээ.


4.2. Төсвийн бодлогын төлөв

КОВИД-19 цар тахлын үед төсвийн орлого бүрдүүлэлт огцом саарч, төсвийн зардал нэмэгдсэн нөлөөгөөр төсвийн төлөв 2020 онд 8.8 нэгж хувиар суларсан байна. Харин 2021 оноос цар тахлын үед тогтоосон хөл хориог шат дараатай сулруулах, эдийн засгийн идэвхжил сэргэж эхэлснээс гадна Оюу толгойн (ОТ) татварын маргаантай холбоотой 1 орчим их наяд төгрөгийг төсвийн орлогод бүртгэж, төсвийн орлого бүрдүүлэлт сэргэж эхлэв. Энэ онд төсвийн нийт зардал 17.9 их наяд төгрөг (ДНБ-ий 36.4 хувь) байна. Үүнээс, төсвийн ургал зардал 13.8 их наяд төгрөг (ДНБ-ий 28.1 хувь), хөрөнгийн зардал 4.4 их наяд төгрөг (ДНБ-ий 9 хувь)-т хүрэх хүлээлттэй байна. Түүнчлэн, 2021 оноос төсвийн зардлын өсөлт тогтвортаж төсвийн алдагдал 2.9 их наяд төгрөг болж буурсан байна. Үүнээс ОТ-н татвар болох 1 их наядыг хасаж тооцвол төсвийн алдагдал 3.9 их наяд төгрөг байх юм. Харин энэ оны хувьд төсвийн тодотголоор төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувьд -5.1 хувьд, эдийн засгийн мөчлөгөөр засварласан төсвийн төлөв ДНБ-ий -3.4 хувьд хурч, өмнөх оноос 1.9 нэгж хувиар буурах хүлээлттэй байна.

Ирэх онуудын хувьд “2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн дагуу 2023, 2024 онуудад төсвийн алдагдал үргэлжлэн буурах тооцоололтой байна. Тухайлбал, төсвийн нийт зардал 2023 онд 19.2 их наяд төгрөг (ДНБ-ий 33.8 хувь)-т хүрч, энэ оноос 1.3 их наяд төгрөгөөр буюу 7.3 хувиар өсөхөөр суурь төсөөлөлд тусгав. Тухайлбал, төсвийн урсгал зардал 14.9 их наяд төгрөг (ДНБ-ий 26.1 хувь), хөрөнгийн зардал 4.6 их наяд төгрөг (ДНБ-ий 8 хувь) байхаар тооцоололд орууллаа. 2023 онд төсвийн алдагдал 1.9 их наяд төгрөг буюу ДНБ-ий -3.6 хувь, 2024 онд 1.6 их наяд төгрөг буюу ДНБ-ий -2.8 хувьд хүрэх хүлээлттэй байна.

Энэ оны төсвийн тодотголд Засгийн газрын нийт өрийн өнөөгийн үнэ цэнээр (ΘҮЦ) илэрхийлэгдэх дүн 28.3 орчим их наяд төгрөг буюу ДНБ-ий 60.7 хувьд хүрэхээр тусгав. Энэ нь “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуульд тусгасан төсвийн тусгай шаардлагын дагуу тогтоосон өрийн дээд хязгаараас доогуур байна. Харин ирэх жилийн хувьд Засгийн газрын нийт өрийн (ΘҮЦ) ДНБ-д эзлэх хувь 65 хувьд хүрэхээр байгаа нь төсвийн тусгай шаардлагын дагуу тогтоосон дээд хязгаартай тэнцүү буюу Засгийн газрын өрийн таазанд тулах төлөвлөгөөтэй байна. Үүнтэй холбоотойгоор ирэх онд төсвийн орлого бүрдүүлэлт төлөвлөгөөнөөс дутах тохиолдолд үүнийг өрөөр санхүүжүүлэх боломж хязгаарлагдаж, орлогын бууралттай уялдуулан зарим зардлыг танах, ирэх жилүүдийн төсвийн хөрөнгө оруулалт төсвийн орлогоор хязгаарлагдана.

Зураг 30. Төсвийн импульс



*Ирээдүйн өв сан (2022-2024) болон Оюу-толгойн татварын маргаантай холбоотой орлогыг (2021) хасаж тооцүү.
Эх сурвалж: Санчийн яам, Монголбанк

Хүснэгт 8 . Засгийн газрын өрийн үзүүлэлт

	2018	2019	2020	2021	2022*	2023*	
тэрбум төгрөг	Гүй.	Гүй.	Гүй.	Гүй.	Бат.	Тод.	ТХМ.
Засгийн газрын нийт өр (ΘҮЦ)	18956	20526	23024	21837	31439	28262	34428
ДНБ-д эзлэх хувь (ΘҮЦ-ээр тооцсон)	58.9	55.6	62.3	50.7	67.2	60.7	65.0
Өрийн хязгаар (ДНБ-д эзлэх хувь)	80.0	75.0	70.0	70.0	70.0	70.0	65.0
Зээлийн үйлчилгээний төлбөр	1046	861	959	828	959	909	
Төсвийн орлогод эзлэх хувь	11.3	8.0	10.1	6.9	6.1	5.9	
Төсвийн тэнцэл	12	-628	-4539	-2909	-2387	-2387	-1907
ДНБ-д эзлэх хувь	0.0	-1.7	-12.2	-6.8	-5.1	-5.1	-3.6

Эх сурвалж: Сангийн яам

ШИГТГЭ 4. ХҮҮХДИЙН МӨНГӨ-НИЙ ТАЛААРХ ЭХ СУРВАЛЖ, СТАТИСТИК

Цар тахал, олон улсын геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалж, улс орны эдийн засгийн байдал хүнд байна. 2021 оны байдлаар улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2.9 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан. Гаадаад өрийн дарамт 2023-2024 онд маш өндөр байхаар байгаа. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас боловсруулж, Улсын Их Хурлаар баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-д “Халамжаас хөдөлмөрт шилжих” зорилтыг дэвшүүлсэн.

Монгол Улс үндсэндээ Халамжийн улс болсныг хaa сайгүй ярьдаг бөгөөд олон улсын байгууллагууд ч энэ талаар дурдаж, халамжийн бодлогоо эргэж харах, халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх зөвлөмж, анхааруулга огдөг. Халамж иргэдийн хөдөлмөр эрхлэх сонирхлыг бууруулах, хөгжих, бүтээх эрмэлзлийг чедөрлөх, залхуурах, бэлэнчлэх сэтгэлгээг өөгшүүлдэг зэрэг олон сөрөг нөлөөтэй.

2021 онд нийгмийн халамжийн үйлчилгээнд манай улсын нийт иргэдийн **76.5 хувь буюу 2.6 сая иргэн** хамрагдсан байна. Ингэхдээ иргэд төрөл бурийн халамжид давхар хамрагдах нь цөөнгүй байна. Тухайлбал, хүүхдийн мөнгийг оруулахгүйгээр бусад төрлийн халамжид хэрхэн хамрагдаж буйг авч үзэхэд 100 хүн тутмын **43** нь 1 халамжид, **23** нь 2 төрлийн халамжид, үлдсэн **34** нь 3 болон түүнээс дээш төрлийн халамж авч байна²⁵. Эдгээр 3 болон түүнээс дээш халамж авч буй хүмүүс хөдөлмөр эрхлэх шаардлага үндсэндээ байдаггүй гэдгийг судалгаа, иргэдийн яриа харуулдаг.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 2018 онд 870.9 мяняган хүүхэд хамрагдаж байсан бол **2021 онд 1.2 сая хүүхэд** хамрагдсан. Засгийн газраас олгосон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж 2021 онд нийт дунгэрээ **2.0 их наяд** төгрөг бөгөөд үүний **1.4 их наядыг** Хүүхдийн мөнгөн тэтгэмжэд олгожээ. Энэ нь нэгдсэн төсвийн орлогын **11 хувийг зөвхөн Хүүхдийн мөнгөнд** зарцуулж байна гэсэн үг юм.

КОВИД-19 цар тахлаас иргэдийн амьжиргааг хамгаалж, дэмжихийн тулд 2020 оны 5-р сард Хүүхдийн мөнгийг 20.000 төгрөгөөс 100.000 төгрөг болгож нэмэгдүүлсэн. Хүүхэдтэй өрхүүдийн **66 хувь** нь цар тахлын нөлөөгөөр орлого нь буурсан гэсэн судалгаа гарсан. Тиймээс энэ орлого нь буурсан айл өрхүүдэд Хүүхдийн мөнгө томоохон дэмжлэг болсон. Гэвч хүүхдийн тэтгэмжийн мөнгөөр архи уудаг, зайлшгүй шаардлагатай бус зүйлд зарцуулдаг, бүр зээлийн барьцаа болгодог гэх мэт асуудлууд хөндөгддөг. Иймд энэ хэвээрээ удаан үргэлжилж болохгүй юм.

Хүүхдийн мөнгийг цаашид яаж олгох вэ гэдэг дээр хэд хэдэн хувилбар дэвшүүлсэн байdag. Тухайлбал, (i) Зөвхөн зорилтот бүлэгт олгох, (ii) КОВИД-ийн үед 100.000 төгрөг болгосон хэмжээгээ багасгаж 50.000 төгрөг болгох, (iii) Хүүхдийн нэр дээр тусгай данс нээж, хуримтлал хэлбэрээр өгөх зэрэг юм.

ЮНИСЕФ-ээс 2021.06-р сард хийсэн судалгаагаар²⁶ 4 өрх тутмын нэг нь хүүхдийн мөнгийг шууд хадгаламжийн данс руу татуулдаг байна. Хүүхдийн мөнгийг нийт өрхийн **58 орчим хувь** нь хүнсэнд, **25-28 хувь** нь хүнсний бус өргөн хэрэглээний бараанд зарцуулдаг байна. Цаашид хүүхдийн мөнгөн тэтгэмжийг зогсооход өрхийн амжиргаанд хэр нөлөө үзүүлэх талаар асуултанд:

²⁵ Үндэсний статистикийн хорооноос Хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн санд үндэслэн гаргасан үзүүлэлт

²⁶ <https://www.unicef.org/mongolia/mn/media/3541/file>


- о **21.7 хувь** нь ямар нэгэн нөлөө гарахгүй (*Хүүхдийн мөнгө шаардлагагүй хэсэг*).
- о **40.5 хувь** нь хүүхдийн мөнгө авахгүй бол хэцүү, гэхдээ боломжтой. (*Хүүхдийн мөнгө заавал шаардлагатай биш хэсэг*)
- о **37.9 хувь** нь хүүхдийн мөнгөгүй бол маш хэцүү болно, зогсоож огт болохгүй гэж үзсэн байна. (*Хүүхдийн мөнгө зайлшигүй шаардлагатай хэсэг*)

Энэ мэт судалгаа, бодит нөхцөл байдлыг сайтар тооцож үзээд Хүүхдийн мөнгийг зорилтот хэсэгтээ олгох нь ард иргэдийн ч, улс орны ч эрх ашигт нийцнэ гэж дүгнэжээ.

4.3. Мөнгө, зээлийн үзүүлэлтийн төлов

Төлбөрийн тэнцлийн алдагдалтай холбоотойгоор банкны системийн гадаад цэвэр актив (ГЦА) буурч, мөнгөний нийлүүлэлт өмнөх жилээс хумигдаж эхэллээ. Сүүлийн 3 улирлын турш төлбөрийн тэнцэл алдагдалтай байгаагаас гадаад валютын улсын нөөц сүүлийн жилд 1.7 орчим тэрбум ам.доллароор буурсан нь мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт саарахад голлон нөлөөлөв. Харин сүүлийн 1 жилийн хугацаанд банкны системийн зээл олголт нэмэгдэн, зээлийн өсөлт өндөр түвшинд хадгалагдсан нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг нэмэгдүүлэх чиглэлд нөлөөллөө. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлт 2022 оны 7 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар буурахад зээлийн өсөлт 14.6 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн бол гадаад цэвэр актив (ГЦА) -20.8 нэгж хувийн бууруулах нөлөөтэй байв (Зураг 31). Цаашид төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэх болон зээлийн өсөлт алгуур буурснаар мөнгөний нийлүүлэлтийн өсөлт үргэлжлэн саарч, нам түвшинд хадгалагдах хүлээлттэй байна.

Зураг 31. M2 мөнгөний жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр²⁷



Зураг 32. Банкны системийн долларжилт



Эх сурвалж: Монголбанк

Эх сурвалж: Монголбанк


Банкны системийн эх үүсвэр талаас мөнгөний нийлүүлэлт хумигдахад төгрөгийн хадгаламж буурсан нь голлон нөлөөллөө. Тодруулбал, мөнгөний нийлүүлэлт 1.4 хувиар буурахад төгрөгийн хадгаламжийн өсөлт -7.6 нэгж хувь, төгрөгийн харилцахын өсөлт 1.5 нэгж хувь, гадаад валютын харилцахын өсөлт 3.7 нэгж хувь, гадаад валютын хадгаламжийн өсөлт 1.3 нэгж хувийг бүрдүүлэв. Харилцах болон хадгаламжаар нь нэгтгэн авч үзвэл төгрөгийн эх үүсвэр 6.1 нэгж хувиар бууруулах, харин гадаад валютын эх үүсвэр 5.0 нэгж хувиар өсгөх нөлөөг үзүүллээ. Улмаар банкны системийн эх үүсвэрийн долларжилт нэмэгдэх хандлага үргэлжлэн 2022 оны 7 дугаар сард 29.3 хувьд хүрсэн нь оны эхнээс 6 нэгж хувиар өссөн, ханшийн нөлөөг хасаж тооцвол 26 хувьд хүрч, оны эхнээс 3.8 нэгж хувиар нэмэгджээ. Үүнд, валютын ханш супларч байгаа нь голлон нөлөөлж байна. Ийнхүү төгрөгийн бодит хүү болон төгрөгийн харьцангуй өгөөж цаашид сөрөг

²⁷ Банк бусаас авах авлага (ББАА) – Ихэнх хэсгийг зээл эзэлдэг болно.


түвшинд удаан хадгалагдах нь эх үүсвэрийн долларжилт үргэлжлэн нэмэгдэх эрсдэлтэй.

Банкны системийн зээлийн өсөлт “10 их наядын цогц төлөвлөгөө”-ний нөлөөгөөр сүүлийн 5 улирлын турш эрчимжсэн хэдий ч 2022 оны 4 дүгээр сараас саарч эхэллээ. Тухайлбал, банкны системийн зээлийн үлдэгдэл²⁸ 2022 оны 7 дугаар сард 23.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.8 их наяд төгрөгөөр, жилийн 20.0 хувиар өссөн байна. Энэ нь 2022 оны 4 дүгээр сараас 9 нэгж хувиар буурсан дүн юм. Зээлийн зориулалтаар нь харвал бизнесийн зээлийн өсөлт 15 хувьд хүрсэн нь нийт зээлийн 9.2 нэгж хувь, хэрэглээ болон хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт 27.4 хувьд хүрсэн нь нийт зээлийн 6.7 нэгж хувь, ипотекийн зээлийн өсөлт 33.5 хувьд хүрсэн нь нийт зээлийн 4.1 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна. Валютын төрлөөр нь авч үзвэл төгрөгийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 24.1 хувиар нэмэгдэж, гадаад валютын зээлийн үлдэгдэл 21.1 хувиар буурав.

Зураг 33. Банкны системийн зээлийн өсөлт



Зураг 34. Банкны системээс олгосон зээл болон зээлийн эргэн төлөлт



Эх сурвалж: Монголбанк

Энэ онд төлбөрийн тэнцлийн алдагдалтай холбоотойгоор мөнгөний нийлүүлэлт хумигдах хүлээлттэй байна. Хэдийгээр зээлийн өсөлт саарч, цаашид алгуур буурах төлөвтэй байна. Түүнчлэн энэ оны хувьд төсвийн алдагдлыг дотоод бондын эх үүсвэрээр санхүүжүүлэх тохиолдолд мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд нөлөөлнө.

Ирэх онуудад төлбөрийн тэнцэл алдагдалтай байх нь банкны системийн эх үүсвэрт сөргөөр нөлөөлж, зээлийн өсөлт болон мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг хязгаарлах хүлээлттэй байна. Түүнчлэн ирэх онуудаас төсвийн төлөв чангарахаар байгаа нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг бууруулах чиглэлд нөлөөлнө. Улмаар ирэх онуудын хувьд төлбөрийн тэнцэл үргэлжлэн алдагдалтай байх нөхцөлд зээлийн өсөлт саарах, мөн төсвийн төлөв чангарч мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нам түвшинд хадгалагдах төсөөлөлтэй байна. Цаашид гадаад орчны эрсдэл, тодорхой бус байдал болон Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ, арилжааны банкуудын зээлийн нөхцөл, шалгуур хэрхэн өөрчлөгдхөөс зээлийн өсөлт болон мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн цаашдын төлөв хамаарахаар байна.

²⁸ Үнэт цаасжуулсан ипотекийн зээлийн нөлөөг хассан.

ШИГТГЭЭ 5. Жендерийн мэдрэмжтэй санхүүгийн салбарын хэрэгцээ, шаардлага

Сүүлийн жилүүдэд Монголын санхүүгийн салбар байгаль орчны асуудлуудад ихээхэн анхаарал хандуулж ирлээ. Тухайлбал, ногоон санхүүгийн ургалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн Үндэсний ногоон таксономи боловсруулж, санхүүгийн байгууллагууд ногоон санхүүгийн бүтээгдэхүүн олноор хөгжүүлж, иргэд, бизнесүүд түүний ашиг шимийг хүртэж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулж байна. Гэвч нийгмийн асуудлууд, тэр дундаа жендерийн асуудлыг санхүүгийн үйл ажиллагаанд төдийлөн авч үзэлгүй ирсэн. Энэ нь нийгмийн үр нөлөөг хэмжих, бүртгэх, тайлагнах тогтолцоо бүрдээгүйтэй ч зарим талаар холбогдож байна.

Эдийн засгийн өсөлт хүртээмжтэй бус байгаагаас нийгмийн зарим бүлгүүд хөгжлийн гадна үлддэг. Тэр дундаа тодорхой эрхэлсэн ажилгүй, өрх толгойлсон болон хувиараа хөдөлмөр эрхлэгч (албан бус бизнес эрхлэгч) эмэгтэйчүүд эдийн засгийн хувьд эмзэг хэсэгт хамаарч байна. Монгол Улс жендерийн ялгаатай байдлын индексээр 2021 онд дэлхийн 156 орноос 69-р байрт орж, эдийн засгийн оролцоо, боломжийн ялгааны дэд индексээр дэлхийд 23-р байранд жагссан²⁹ үзүүлэлттэй байна.

Манай улс жендерийн эрх тэгш байдлыг хамгаалах эрх зүйн тогтолцоо бүрдүүлж, олон улсын өмнө тодорхой үүрэг амлалтуудыг авсан нь салбар бүрд жендерийн эрх тэгш байдлыг хөгжүүлэх суурь болдог. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 2011 онд баглагдаж, улмаар уг хуулийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий институц болох Жендерийн үндэсний хороо байгуулагдсанаар хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендерийн тэгш байдлыг хамгаалах эрх зүйн үндэс тавигдсан.

Манай эмэгтэйчүүдийн боловсролын хамрагдалтын түвшин дэлхийн бусад орнуудтай харьцуулахад өндөр хэдий ч энэхүү давуу талаа ашиглан хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцож чадахгүй байна. Тухайлбал, Үндэсний статистикийн хорооны 2020 оны мэдээллээр эмэгтэйчүүдийн ажиллах хүчиний оролцооны түвшин эрэгтэйчүүдийнхээс 10.5 нэгж хувиар бага байна.

Харин аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын дундаж цалинг авч үзэхэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 16.3 хувиар бага цалин хөлс авч байна (YCX, 2020). Түүнчлэн ижил төрлийн ажлын байранд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс бага цалин авдаг бөгөөд цалингийн хувьд жендерийн зоруутгай байдал хэвээр байна (Бат-Эрдэнэ, 2019). Тухайлбал, магистр ба түүнээс дээш түвшний боловсрол эзэмшсэн эмэгтэйчүүд яг ижилхэн түвшний боловсролтой эрэгтэйчүүдээс дунджаар 22 хувиар бага цалин авдаг нь судалгаагаар тогтоогджээ. Эмэгтэйчүүд худалдаа, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг уламжлалт сэтгэлгээгээр “эмэгтэйчүүдийн” хэмээн танигдсан салбаруудад тулхүү ажилласаар байгаагаас гадна улс төрийн болон эдийн засгийн шийдвэр гаргах түвшинд тэдний төлөөлөл хангалтгүй байна (А.Гантуяа, 2020).

Нийгэмд тогтсон жендерийн хэвшмэл ойлголт болон соёл, хандлагаас шалтгаалан гэр бүлийн хөдөлмөрийн хуваарь ёсоор гэр ахуйн ажил үүргийн ихэнх нь эмэгтэйчүүдэд ногддог. Тухайлбал, асаргаа шаардлагатай гэр бүлийн гишүүдийг асрах цалин хөлсгүй хөдөлмөрт Монгол эмэгтэйчүүдийн зарцуулдаг цаг эрэгтэйчүүдийнхээс даруй 2.1 дахин их байдаг (ЭЗХАХБ, 2019). Мөн эрэгтэйчүүд гэр орны цалин хөлсгүй ажилд өдөрт 117 минут зарцуулдаг бол эмэгтэйчүүд дунджаар 281 минут зарцуулж байна (YCX, 2020). Монголын нийт хүн амын 6 хувь нь гэр бүлийнхээ эмэгтэй хүнийг гэрээс гадуур, цалин хөлстэй ажил эрхлэхийг хүлээн зөвшөөрдөгтүй гэсэн судалгаа үр дүн ч гарчээ (ЭЗХАХБ, 2019).

Нөгөө талаас, эмэгтэйчүүдийн нөхөн үргижүйн үүргийн талаарх жендерийн хэвшмэл ойлголт нийгэмд хүчтэй байсаар байгаа нь хүн амаа өсгөх бодлогын үр дагавар байж болох юм гэж судлаачид үздэг (МУЗГ, 2015). Өөрөөр хэлбэл, төрөөс төрөлтийг дэмжих бодлого баримталж байгаа ч олон хүүхдтэй эмэгтэйчүүдийн хувьд хүүхд асрах үйлчилгээ болон цэцэрлэгийн хүртээмж, хүрэлцээ муугаас болж гэртээ хүүхдүүдээ харахаас өөр эдийн засгийн үр ашигтай сонголт байхгүй байна.


Дээр дурдсан асуудлууд нь эмэгтэйчүүдийг хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцох, орлогоо өсгөх, бизнесийн тогтмол үйл ажиллагаа явуулахад саад тогтор болдог бөгөөд энэ нь тухайн хүний сонголтоос бус байгалийн өгөгдөл гэдгийг бүх түвшинд ойлгож, илүү жендерийн мэдрэмжтэй байх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай болж байна. Нийгэмд тогтсон жендерийн хэвшмэл ойлголтоор үл хөдлөх хөрөнгийн эзэмшил ихэвчлэн гэр бүлийн эрэгтэй гишүүдийн нэр дээр байх нь түгээмэл бөгөөд энэ нь эмэгтэйчүүд зээл, санхүүжилт авахад томоохон бэрхшээл болдог. Түүнчлэн эмэгтэйчүүд гэрлэлтийн байдлаас болж хэрэгцээтэй санхүүжилтээ авч чадахгүй байх тохиолдол байсаар байна.

²⁹ Global Gender Gap Report 2021, World Economic Forum


Тухайлбал, ихэнх санхүүгийн байгууллагууд хамтран зээлдэгчийн шаардлага тавьдаг жишээг дурдаж болно. Мөн эмэгтэйчүүдийн нөхөн үржихүй, хүүхэд асрахуйн тухай нийгмийн хэвшмэл ойлголт нь эмэгтэйчүүдийг эрсдэлтэй зээлдэгч гэж үзэхэд нөлөөлдөг. Дээр дурдсанчлан, цэцэрлэг, сургуулийн хүртээмжгүй байдал, гэрийн ажил, хүүхэд, ахмад, өвчтөнүүдийг асрах цалин хөлсгүй хөдөлмөрт эрэгтэйчүүдээс илүү их цаг зарцуулдаг зэрэгтэй холбоотойгоор санхүүгийн үйлчилгээ авахад орон зай, цаг хугацааны хязгаарлагдмал байдалд ордог. Түүнчлэн бичил, жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүд ихэвчлэн оёмол, хатгамал бүтээгдэхүүн, гоёлын эд зүйлс гэх мэт өрхийн шинжтэй, бизнесийн хэмжээгээр эрэгтэйчүүдтэй харьцуулахад харьцангуй жижиг байх хандлагатай байдаг. Гэвч санхүүгийн байгууллагын ажилтнууд дээрх эмэгтэйчүүдийн бизнесийн онцлогийг ойлгохгүй байх, үл хүндэтгэх, жендерийн мэдрэмжгүй хандлага гаргах зэрэг нь эмэгтэйчүүд зохих санхүүгийн үйлчилгээ авч чадахгүй байгаа шалтгаануудын нэг юм.

Санхүүгийн салбар дахь жендерийн эрх тэгш байдлыг авч үзвэл, “Монгол Улсын Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагийн жендерийн стратегийн дунд хугацааны бичиг баримт” нь санхүүгийн салбарт хамааралтай цорын ганц жендерийн бодлогын баримт бичиг юм. Гэвч уг баримт бичигт хувийн хэвшилийн санхүүгийн байгууллагуудад хамаарах асуудлыг оруулаагүй байна.

Дотоодын зарим санхүүгийн байгууллага жендерийн асуудал хариуцсан тусгай нэгж буюу Жендерийн хороотой байгаа боловч байгууллага доторх жендерийн эрх тэгш байдлыг хариуцдаг ажилтантай банкууд нийт банкны 25 хувийг эзэлж байна (Санхүүгийн салбарын жендерийн эрх тэгш байдлын суурь судалгаа, ТоС Холбоо, 2021). Банкны нийт ажилтнуудын 63 хувийг, дунд түвшний удирдлагуудын 43 хувийг, салбарын захирлуудын 45 хувийг, харин гүйцэтгэх түвшний удирдлагын 28 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна. Эндээс албан тушаал ахих тусам эмэгтэйчүүдийн төлөөлөл буурч байгааг харж болно (ТоС-ийн хэрэгжилтийн үнэлгээ, 2021).




Санхүүгийн салбарын жендерийн эрх тэгш байдлын суурь судалгаанд оролцсон томоохон банк, ББСБ-уудын 31 хувь нь жендерийн бодлого, стратегитай байгаа бол 54 хувь нь жендерийн асуудлыг тусгасан бодлого, стратегийг боловсруулж байна. Жендерийн бодлоготой санхүүгийн байгууллагуудын жендерийн бодлогод тусгасан асуудлуудыг авч үзвэл, банкуудын 77 хувь нь хөдөлмөрийн хуульд тусгасан шаардлагаас илүү их амралт, чөлөөний боломжийг ажилтнууддаа өгөх тухай, ижил тэгш ажил эрхлэх боломжийг олгох тухай, 69 хувь нь уян хатан ажлын хуваариар ажиллах тухай, 62 хувь нь ижил тэгш цалин, урамшуулал олгох тухай, 54 хувь нь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай асуудлуудыг тус тус бодлого, журамдаа тусгасан байна.




ТоС Холбоо нь 2015 оноос эхлэн гишүүн санхүүгийн байгууллагуудаа тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтийн үнэлгээг жил тутам хийж ирсэн. 2021 оноос эхлэн жендертэй холбогдох асуудлыг үнэлгээний асуулгад нэмж оруулсан. Гэхдээ салбарын хэмжээнд жендерийн бодлоготой болох, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ жендерийн мэдрэмжтэй болгох чиглэлд илүү их ажиллах шаардлагатай харагдаж байна.

Эмэгтэйчүүд харилцах, хадгаламж, зээлийн дансны тоогоор эрэгтэйчүүдээс илүү байгаа хэдий ч авч буй санхүүжилтийн дундаж хэмжээ нь эрчүүдээс даруй 25 хувиар бага, харин нэг эмэгтэй зээлдэгчид ногдох дундаж зээлийн хэмжээ нь эрэгтэйчүүдээс 31 хувиар бага хэвээр байна. Харин нийт чанаргүй зээлд эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс дунджаар 18 хувиар бага байдаг буюу сайн зээлдэгчид гэдгийг батлах статистик мэдээллүүд бий.


Зураг 35. Нийт данс эзэмшигчид



Зураг 36. Авч буй зээлийн хэмжээ



Зураг 37. Чанаргүй зээлд эзлэх хувь



Дотоодын санхүүгийн байгууллагуудын санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээг авч үзвэл, нийт 2 банкны 4 нь, ТОП-10 ББСБ-ын 1 нь эмэгтэйчүүдэд зориулсан тусгай санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээтай байна. Гэвч “эмэгтэй жижиг дунд бизнес эрхлэгч” гэсэн хуулийн тодорхойлолт байхгүйгээс шалтгаалан санхүүгийн байгууллагуудын эмэгтэй бизнес эрхлэгчид тавих шаардлага ялгаатай байна. Тухайлбал, зарим банкны хувьд Төлөөлөн удирдах зөвлөлийн 51-ээс дээш хувь эмэгтэй бол эмэгтэй бизнес эрхлэгч гэж үзэх бол зарим банкны хувьд энэ хувь нь 66.7 хувь байх жишээтэй.

Эмэгтэйчүүдэд зориулсан тусгай санхүүгийн бүтээгдэхүүний зээл олгох дээд хэмжээ нь 1 тэрбум төгрөг хүртэл дүнтэй, зээлийн хугацаа 36 сар хүртэл, хүү нь жилийн 12-15.6 хувь, зээлийн эргэн төлөлтөөс чөлөөлөх хугацаа 6-12 сарын хугацаатай байна (Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний жендерийн мэдрэмжтэй байдлын үнэлгээ, ТоC Холбоо, 2021).

Жендерийн мэдрэмжтэй санхүүжилтийн үйл ажиллагаа явуулах нь нийгэмд эерэг өөрчлөлт авчрахаас гадна тухайн байгууллагад ч давуу талуудыг бий болгодог. Ихэнх томоохон гадны хөрөнгө оруулагчдын санхүүжилт олгох нэг шаардлагад жендерийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой шаардлага ороод удаж байна. Тухайлбал, Уур амьсгалын ногоон сан, олон талт хөгжлийн байгууллагууд санхүүжилт олгоходо жендерийн бодлого, түүнийг хэрэгжүүлэгч жендерийн хороотой болох, нийт ашиг хүртэгчдийн тоонд квот заах, жендерийн үнэлгээ хийх, нээлттэй тайлагнахыг шаардах замаар жендерийн эрх тэгш байдлыг ханггуулахаар ажиллаж байна. Иймд нийгмийн өөрчлөлт, хөрөнгө оруулагчдын шаардлага, тэгш байдлын төлөөх өсөн нэмэгдэж буй дуу хоолойг анзаарч, үйл ажиллагаагаа түүнтэй уялдуулах, харилцагчид болон зах зээлээ хамгаалах зорилгоор санхүүгийн байгууллагууд одооноос дорвitoй алхам хийж эхлэх цаг болжээ. Зөвхөн шаардлага гэж харахаас илүүтэйгээр жендерийн эрх тэгш байдлыг хангаж, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлснээр нэр хүндтэй байх, хүний нөөцөө тогтоон барих, эрүүл, тэнцвэртэй, олон талыг бодолцсон шийдвэр гаргах зэрэг эерэг давуу талууд ч дагаад бий болно.

4.4. Төлбөрийн тэнцэл, гадаад секторын төлөв

Төлбөрийн тэнцлийн алдагдал огцом нэмэгдээж, төгрөгийн хани сулрах дарамт улам ихсэхээр байна. Урсгал дансыг авч үзвэл экспортын барааны орлого өмнөх оноос 855 сая ам.доллароор агшиж, импортын барааны зардал 1361 сая ам.доллароор, үйлчилгээний дансны алдагдал 248 сая ам.доллароор тус тус өмнөх оноос тэлэх хүлээлттэй байна. Өнгөрсөн оны сүүлийн хагасаас хойш хилийн боомтууд дээр цар тахалтай холбогдуулан үүссэн хязгаарлалтаас үүдэж нүүрс, газрын тос, төмрийн хүдэр зэрэг голлох уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт удаширсан нь экспортын орлогод сөргөөр нөлөөлж байна. Харин сүүлийн саруудад томоохон хилийн боомтуудын үйл ажиллагаа идэвхжиж, боомтоор нэвтрэн өнгөрөх тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэж байгаа нь цаашид нүүрсний экспортын биет хэмжээ сэргэнэ гэж үзэх гол үндэслэл болж байна. Гэвч уул уурхайн компаниудын экспортолсон бүтээгдэхүүнээс орж ирэх бодит орлого уг биет хэмжээний өсөлттэй нийцтэйгээр төдийлон нэмэгдэхгүй байх эрсдэл бий. Нөгөө талаас, хатуу хөл хорионы хязгаарлалтууд дуусаж, эдийн засагт хэрэглээ хөрөнгө оруулалт сэргэн дотоод эрэлт өмнөх оноос тэлсэн, төмөр зам, авто зам, Оюу толгой гэх мэт том төслүүдийн нөлөөгөөр хөрөнгө оруулалтын импорт нэмэгдсэн, гадаад үнийн өсөлттэй холбоотойгоор импортын үнэ өссөн зэрэг нь импортын зардлыг нэмэгдүүлэх нөлөө үзүүлж байна. Тухайлбал, нийт импортын үнийн жилийн өсөлт 17-25 орчим хувийн хооронд хэлбэлзэлтэй байна. Үүн дотроос олон улсын зах зээл дээрх газрын тос, түлшний үнийн өсөлтөөс шалтгаалж нефтийн бүтээгдэхүүний импортын зардал өмнөх оны эхний 7 сараас 63.3 хувиар өссөн байна. Ийнхүү экспортын биет хэмжээ болон үнийн нөлөөгөөр, импортын нөлөөгөөр урсгал дансны алдагдал энэ онд ДНБ-ий 20 хувийг давахаар байна.

Энэхүү урсгал дансны алдагдлыг санхүүжүүлэх гол эх үүсвэр болох санхүүгийн дансны ашиг өмнөх оноос 100 гаруй сая ам.доллароор нэмэгдэх төлөвтэй байгаа нь энэ онд гадаад валютын нөөцөд ирэх дарамтыг улам ихэсгэж байна. Тодруулбал, энэ онд донор болон олон улсын байгууллагуудаас нийтдээ 400 гаруй сая ам.долларын санхүүжилт, Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын хүрээнд нийтдээ 1.2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэхээр хүлээгдэж байна. Харин нөгөө талаас, Өүлэн бондын хийгдээд буй үндсэн, хүүгийн төлбөрүүд болон Чингис бондын хүлээгдэж буй үлдэгдэл төлбөрүүд нийтдээ 220 гаруй сая ам.доллароор хэмжигдэж байна. *Ингэснээр 2022 онд суурь төсөөллөөр нийт төлбөрийн тэнцэл 2.1 тэрбум ам.долларын алдагдалтай байж, төдий хэмжээгээр гадаад валютын улсын нөөцийг бууруулахаар байна.* Гадаад эдийн засгийн төлөв байдал тасралтгүй муудаж, тодорхой бус байдал сөрөг чиглэлд давамгайлж буй өнөө үед манай экспортын орлого болон хөрөнгийн орох урсгал хүлээлтээс саарч, улмаар төлбөрийн тэнцлийн алдагдал одоогийн суурь төсөөллөөс улам томрох эрсдэл бий.

Төлбөрийн тэнцэл ирэх онуудад алдагдалтай хэвээр байх төловтэй байна. Цаашид хилийн хязгаарлалтууд суларснаар уул уурхайн бүтээгдэхүүний экспорт хэвийн түвшиндээ хүрч, Оюу толгойн ил уурхайн үйлдвэрлэлийн агууламж сэргэн, далд уурхайн үйлдвэрлэл 2023 оны сүүлчээс жигдэрч эхлэхээр тооцвол экспортын орлогыг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцэлд эергээр нөлөөлөх хүлээлттэй байна. Гэвч нөгөө талаас, эдийн засгийн идэвхжилтэй уялдан хөрөнгө оруулалтын импорт, ачаа тээвэр болон аяллын үйлчилгээтэй холбоотой зардлууд өндөр байгаа нь урсгал тэнцлийн алдагдлыг өндөр байлгаж байна.

Ирэх онуудад санхүүгийн дансны ашиг энэхүү урсгал дансны алдагдлыг нөхөхөөргүй түвшинд байна. Үүнд, санхүүгийн дансны голлох орох урсгалыг бүрдүүлж буй Оюу толгойн далд уурхайн төслийн ажлууд жигдэрч байгаатай холбогдуулан хөрөнгө оруулалт төлөвлөгөөний дагуу алгуур буурна. Харин гарах урсгалын хувьд Гэрэгэ бондын үлдэгдэл 540 орчим сая ам.доллар, МУХБ-ны Евро бондын 500 сая ам.доллар, МУХБ-ны Самурай бондын 235 сая ам.доллар, Хуралдай бондын 600 сая ам.доллар, ХАБ-ны своп хэлцэл зэрэг томоохон хэмжээний эргэн төлөлтүүд хүлээгдэж байна. Суурь төсөөлөлд Самурай бондоос бусад өр, төлбөрүүдийг гадаад бонд, зээлээр дахин санхүүжүүлнэ гэж үзсэн. Хэрвээ эдгээр гадаад өр, төлбөрүүдийг дахин санхүүжүүлэх боломжгүй, эргэн төлөх шаардлага үүссэн тохиолдолд гадаад санхүүжилтийн хэрэгцээ улам нэмэгдэх эрсдэлтэй юм.

Төлбөрийн тэнцлийн алдагдал суурь төсөөллөөс томрох эрсдэл өндөр байна. Үүнд экспорт цаашид хүлээлтэд хүрч сэргэхгүй байх, гадаад санхүүжилтээр хийгдэж буй томоохон төслүүдийн хөрөнгө оруулалт удааширч хөрөнгийн орох урсгал саарах, ирэх онуудад төлөгдөх том дунтэй гадаад өр төлбөрүүдийг дахин санхүүжүүлэхэд хүндрэл үүсэх, geopolitic, гадаад орчны гэнэтийн өөрчлөлтөөс орлуулах боломжгүй импортын гол нэрийн бүтээгдэхүүн (шатахуун г.м)-ий үнэ огцом өсөх, төсвийн хэт тэлсэн бодлого үргэлжлэх зэргийг дурдаж болохоор байна. Хэрэв эдгээр эрсдлүүд биелвэл төлбөрийн тэнцлийн алдагдал огцом тэлж, гадаад валютын улсын нөөц тэр хэмжээгээр хорогдож болзошгүй юм.

Гадаад валютын нөөцийн хүрэлийн цаашид эмзэг байдлын дээд түвшинд хүрч болзошгүй байна. Төлбөрийн тэнцлийн их хэмжээний алдагдалтай уялдан гадаад валютын улсын нөөц энэ оны эцэст 2.3 тэрбум ам.доллар байна гэж тооцвол валютын төлбөртэй импортын барааны 3.3 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрч огцом буурахаар байна.

4.5. Инфляцын гол эрсдлүүдэд суурисан хувилбар төсөөлөл

Инфляц суурь төсөөллөөс өөрчлөгдөж болзошгүй олон тооны эрсдэл байгаа тул инфляцыг өсгөх болон бууруулах гадаад, дотоод хүчин зүйлсийн тохиолдох магадлалыг харгалzan хувилбар төсөөллийг боловсрууллаа. Инфляцыг нэмэгдүүлэх хүчин зүйлсийн хувьд: 1) гадаад инфляц өсөж, бусад Төв банкуудын инфляц зорилтын орчимд тогтвортых хугацаа 2 улирлаар хойшлох, 2) тээврийн үнэ өсөх, 3) газрын тосны үнэ өсөх, 4) дээрх гадаад эрсдлүүд эдийн засагт бодитой тохиолдвол банкны эх үүсвэр буурч, ирэх онд зээлийн хэмжээ өсөхгүй байх, 5) нэрлэсэн цалин өсөх, 6) төсвийн зардал тэлэх гэсэн таамаглалд үндэслэв. Харин инфляцыг бууруулах хүчин зүйлсийн хувьд дээрх эрсдлүүд суурь төсөөлөлд авч үзсэнээс буурах тохиолдлын илрэх магадлалыг харгалzan ялгаатай авч үзлээ. Хувилбар төсөөллийг боловсруулахдаа дээрх таамаглалт нөхцөлүүдийг дэс дараалан нэмэх байдлаар тооцов. Таамаглалд авч үзсэн нөхцөлүүдийн дэлгэрэнгүйг доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 9. Инфляцыг өсгөх болон бууруулах гадаад, дотоод хүчин зүйлсийн таамаглал

Инфляцыг өсгөх гадаад, дотоод хүчин зүйлс		
1	Гадаад үнэ өсөх	Гадаад инфляц Төв банкны зорилтод тогтвортыхи хугацаа 2 улирлаар хойшилж, импортын бараа, бүтээгдэхүүний үнэ өсөх
2	Тээврийн үнэ өсөх	Тээврийн үнэ инфляцын 18 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд тээврийн үнэ энэ оны сүүлээс өссөнөөр нийт инфляцын 24 хувийг эзэлж, инфляцын дарамт нэмэгдэх
3	Газрын тосны үнэ өсөх	АИ-92 шатахууны үнийг хямдралтай үнээр худалдан авах гэрээ дуусгавар болохын зэрэгцээ газрын тосны зах зээл дэх эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэргүй байдал үргэлжилж, газрын тосны үнэ ирэх онд 30 хувиар өсөх
4	Зээлийн хэмжээ өсөхгүй байх	Дээрх гадаад эрсдэлүүд эдийн засагт бодитой тохиолдвол банкны эх үүсвэр буурч, ирэх онд зээлийн хэмжээ өсөхгүй байх
5	Нэрлэсэн цалин өсөх	Инфляц өсөж, бодит орлого буурсантай холбоотойгоор цалин өсөх дарамт нэмэгдэн, ирэх оны эхнээс цалин 30 хувиар өсөх
6	Төсвийн зардал тэлэх	Төсвийн зардал тодотголоор тэлж, 2023 онд төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь 38 хувь, 2024 онд 34 хувьд хүрэх
Инфляцыг бууруулах гадаад, дотоод хүчин зүйлс		
1	Гадаад үнэ буурах	Гадаад инфляц Төв банкны зорилтод тогтвортыхи хугацаа 1 улирлаар наашилж, импортын бараа, бүтээгдэхүүний үнэ буурах
2	Тээврийн үнэ буурах	Тээврийн үнэ өсөхтэй адил хэмжээгээр тээврийн үнэ буурч, инфляцын дарамт багасах
3	Шатахууны үнэ хэвээр хадгалагдах	АИ-92 шатахууныг он дуустал хөнгөлөлттэй үнээр худалдан авах гэрээ амжилттай сунгагдаж, ирэх оны 1 дүгээр улирал хүртэл шатахууны үнэ хэвээр хадгалагдах
4	Төсвийн зардал буурах	Төсвийн зардал тодотголоор буурч, 2023-2024 онд төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь харгалзан 30 хувьд хүрэх

Эх сурвалж: ОУВС (2022 оны 7 сар), Дэлхийн банк (2022 оны 6 сар)-ын тайллан


Инфляц нэмэгдэх хувилбар төсөөлөл: Гадаад инфляц өсвөл нэг талаас импортын бараа, бүтээгдэхүүний үнэ, нөгөө талаас гадаад суурь хүү өсөж, төгрөгийн ханш суларч инфляц нэмэгдэнэ. Үүнтэй зэрэгцээд тээврийн зардал өсөх нь импортын бараа, бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх, тээвэр, үйлдвэрлэлийн зардлаар дамжин дотоодын бараа, бүтээгдэхүүний үнэ өсөх нөлөөг үзүүлнэ. Гадаад үнэ, тээврийн зардал нэмэгдэхтэй зэрэгцэн ирэх оноос АИ-92 шатахууныг хөнгөлөлттэй үнээр авах хэлэлцэр дуусгавар болвол газрын тосны үнэ 30 хувиар өсөх тохиолдолд шатахууны инфляц огцом нэмэгдэх бөгөөд үүний дам нөлөө бусад бараа, бүтээгдэхүүний үнэд хүчтэй ажиглагдана. Ялангуяа, тээвэр, үйлдвэрлэлийн зардал өсөж, зардлын инфляцаар дамжин дотоодын бараа, бүтээгдэхүүний үнэ өсөх нөлөө үзүүлнэ. Түүнчлэн, газрын тосны үнэ өссөнтэй холбоотойгоор импортын төлбөрүүд нэмэгдэж, ханш сулрах дарамт нэмэгдэх тул импортын барааны үнээр дамжин инфляц хурдтай нэмэгдэнэ. Ийнхүү дээрх гадаад эрсдэлүүд зэрэг тохиолдох нөхцөлд төлбөрийн тэнцлийн алдагдал тэлж, улмаар банкны эх үүсвэр буурч, зээлийн хэмжээ ирэх онд нэмэгдэхгүй байх хувилбарыг авч үзэв. Энэ үед эдийн засгийн өсөлт хурдтай саарч, эрэлтийн шалтгаантай инфляц хумигдах юм. Нөгөө талаас, эдийн засагт төгрөгийн нийлүүлэлт багасах тул ханш бага зэрэг чангарт, инфляцын дарамтыг бууруулна.

Үүнтэй зэрэгцээд нэрлэсэн цалинг өсгөх нь орлогын өсөлтийн нөлөөгөөр эрэлтийн инфляцыг өдөөж, инфляц илүү хурдтай нэмэгдэх эрсдэл үүсэж болзошгүй. Хэдийгээр нэрлэсэн цалин өссөнөөр хэрэглээ нэмэгдэх ч, үүнийг дагаад инфляц өсөж бодит дүнгээр хэрэглээг төдийлон өсгөх нөлөө үзүүлэхгүй байх эрсдэл өндөр тул эдийн засгийн өсөлтийг дэмжих нөлөө бага юм. Дунд хугацаандаа цалин өсөж, үйлдвэрлэлийн зардал (хөдөлмөрийн бүтэээмж нэмэгдэхгүй гэж үзвэл) нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлтийг сааруулна. Цалин өсөх, хөрөнгө оруулалтын зардал нэмэгдэн төсвийн нийт зардал төсвийн хүрээний мэдэгдлээс нэмэгдэж батлагдах эрсдэл өндөр тул үүнийг инфляцыг өсгөх нэг эрсдэлт хүчин зүйлсээр авч үзлээ. Энэ тохиолдолд хөрөнгө оруулалтууд нэмэгдэж, эдийн засгийн өсөлтийг тэтгэх хэдий ч импорт өсөж, ханш сулрах

дарамтыг нэмэгдүүлнэ. Энэ үед инфляц эрэлт болон ханшийн аль алинаар нь өдөөгдөж, хурдтай нэмэгдэнэ. Энэ нь бодлогын хүүг илүү ихээр, хурдтай өсгөх шаардлагыг үүсгэнэ.

Инфляцыг өсгөх эрсдэлт хүчин зүйлсээс гадаад үнэ өсөх, тээврийн зардал нэмэгдэх нь богино хугацаанд илрэн эргээд инфляц жил орчмын дараагаас буурч, суурь төсөөллийн орчимд тогтвржиж байгаа бол шатахууны үнэ өсөх, цалин нэмэгдэх, төсвийн зардал тэлэх нөлөө илүү удаан хугацаанд инфляцыг нэмэгдүүлж, Төв банкны зорилтод тогтвржих хугацааг жил орчмоор хойшлуулж байна. Ялангуяа, шатахууны үнэ нь зардлын инфляц, ханшийн нөлөөгөөр дамжин үнэд нөлөөлдөг тул инфляцыг өсгөх нөлөө хүчтэй юм. Түүнчлэн, төсвийн зардлын шок нь эрэлтийн инфляцыг өдөөх, ханшаар дамжин импортын үнийг нэмэгдүүлэх зэргээр инфляцыг өсгөх нөлөө нь хамгийн урт хугацаанд үргэлжилж байна. Ийнхүү дээрх эрсдэлт хүчин зүйлс зэрэг тохиолдох нөхцөлд инфляц ирэх онд 19 орчим хувьд хүрч, 2024 оноос алгутур бууран 2025 оны эхний улирлаас зорилтын дээд интервалд тогтвржиж байна. Төгрөгийн ханш сулрах дарамт хурдтай нэмэгдэж, 2023-2024 онуудад суурь төсөөллөөс 250-450 орчим төгрөгөөр сүл тогтох төсөөлөлтэй ба энэ үед бодлогын хүү 17 хувьд хүрч өсөх шаардлага үүснэ. Гадаад үнэ өсөх, тээврийн зардал нэмэгдэхэд эдийн засгийн өсөлт бага зэрэг саарч, шатахууны үнэ нэмэгдсэнээр нэг талаас худалдааны нөхцөл муудах, нөгөө талаас үйлдвэрлэлийн зардал өсөж, эдийн засгийн өсөлт 2023 онд 3.8 хувьд хүрч буурна. Ингээд зээлийн тасалдалтай холбоотойгоор эдийн засгийн өсөлт хурдтай саарч, 1.7 хувьд хүрэх тооцоолол гарч байна. Үүний дараа нэрлэсэн цалин өсөх нь хэрэглээг дэмжих ч, энэ нь эргээд инфляцыг өсгөн бодит орлогыг төдийлөн нэмэгдүүлэхгүй тул эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө бага юм. Харин төсвийн зардал тэлснээр эдийн засгийн өсөлт 3.4 хувьд хүрч богино хугацаандаа үйлдвэрлэлийг дэмжих хэдий ч, энэхүү нөлөө нь дунд хугацаандаа өндөр инфляц, төгрөгийн ханшийн сулралыг бий болгож, үйлдвэрлэлийн зөрүү хаагдах хугацааг улам бүр хойшлуулах юм.

Зураг 38. Инфляцын төсөөлөл




Эх сурвалж: Монголбанк

Инфляц буурах хувилбар төсөөлөл: Инфляцыг бууруулах хүчин зүйлсээр 1) гадаад үнэ буурах, 2) тээврийн зардал буурах, 3) шатахууны үнийн хөнгөлөлт үргэлжлэх, 4) төсвийн зардал буурах гэсэн таамаглалт нөхцөлүүдийг ашиглалаа. Бусад төв банкууд мөнгөний бодлогын төлөвөө хүлээлтээс илүү хурдтай хатууруулах бодлого хэрэгжүүлж эхэлсэн, тээврийн saat алгуур арилж, олон улсын тээврийн үнийн индекс буурч байгаа болон газрын тосны үнэ гадаад ихэнх төсөөллөөс бага байгаа, цаашид буурах төсөөллийг зарим гадаад эх сурвалжууд хийж байгаа зэрэг нь гадаад инфляц буурах, тээврийн үнэ буурах болон шатахууны үнийг бууруулах хувилбар төсөөллийг боловсруулах үндэслэл болж байна. Харин төсвийн зардал буурах нөлөөг хэмжих,

харьцуулах зорилгоор төсвийн зардал буурах хувилбарыг авч үзлээ. Гадаад үнэ, тээврийн үнэ буурах нөлөөгөөр инфляц бодино хугацаанд буурч эргээд тогтвортыхи нөлөөг үзүүлж байгаа бол төсвийн зардал буурах нь инфляциад хамгийн хүчтэй нөлөөг үзүүлж байна. Учир нь төсвийн зардал буурснаар дунд хугацаандаа инфляциад нөлөөлөх эрэлтийн болон зардлын нөлөө буурахын зэрэгцээ төгрөгийн ханш сулрах дарамт багасах юм. Ийнхүү төсвийн зардал буурч, нийлүүлэлтийн шинжтэй аливаа дарамтууд арилан, гадаад эрсдэлүүд саарах нөхцөлд инфляц буурч, төгрөгийн ханшид ирэх дарамт багасах бөгөөд энэ үед мөнгөний бодлогын орон зай нэмэгдэн бодлогын хүүг бууруулах боломж бурдэх юм.

Эдийн засгийн өсөлтийн төсөөллийн хувьд гадаад үнэ, тээврийн үнэ өсөх зэрэг нь бага хэмжээний бууруулах нөлөөтэй бол банкуудын зээл олголт хумигдах нь хамгийн том сөрөг нөлөөг үзүүлж байна. Ирэх онд банкуудын зээлийн хэмжээ өсөхгүй гэж үзвэл эдийн засгийн өсөлтийг 2.1 нэгж хувиар бууруулж, уул уурхайн бус салбаруудын үйл ажиллагаа эрчтэй хумигдах нөлөөг үзүүлэхээр байна. Үүнээс гадна, төсвийн зардал нэмэгдэх нь дотоод эрэлтийг тэтгэж байгаа ч инфляцыг өдөөж, ханш сулрах дарамтыг нэмэгдүүлэх давхар хор уршигтай байна.

*Зураг 39. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл**



*4 улирлын нийлбэр бодит ДНБ-ий жилийн өсөлт
Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 10. Инфляцын эрсдэлд сууринсан хувилбар төсөөллийд

Хувилбарууд		Авч үзсэн нөхцөлүүд	Эдийн засгийн өсөлт				Инфляц**			
			2021	2022*	2023*	2024*	2021	2022*	2023*	2024*
Суурь		Суурь төсөөлөл	1.6	3.0	4.4	6.1	11.4	13.6	7.8	6.3
Инфляц өсөх хувилбар	X2.1	(1) Гадаад үнэ өсөх	1.6	3.0	4.2	6.3	11.4	13.9	8.6	6.5
	X2.2	2. (1) + Тээврийн үнэ өсөх	1.6	3.0	3.9	6.4	11.4	14.7	10.2	6.3
	X2.3	3. (2) + Газрын тосны үнэ өсөх	1.6	3.0	3.8	5.8	11.4	14.7	14.2	6.5
	X2.4	4. (3) + Зээл зогсох	1.6	3.0	1.7	7.4	11.4	14.7	12.9	5.9
	X2.5	5. (4) + Цалин өсөх	1.6	3.0	1.7	6.2	11.4	14.8	15.5	6.9
	X2.6	6. (5) + Төсвийн зардал тэлэх	1.6	3.0	3.4	5.7	11.4	14.9	17.9	8.8

Инфляция хувийн хаалтадар	X3.1	(1) Гадаад үнэ буурах	1.6	3.0	4.5	6.1	11.4	13.5	7.5	6.3
	X3.2	2. (1) + Тээврийн үнэ буурах	1.6	3.0	4.6	6.4	11.4	12.5	5.9	6.2
	X3.3	3. (2) + Шатахууны хөнгөлөлт үргэлжлэх	1.6	3.0	4.6	6.6	11.4	12.5	5.1	6.2
	X3.4	4. (3) + Төсвийн зардал буурах	1.6	3.0	2.8	7.1	11.4	12.5	3.1	4.7
	** Он тус бүрийн 4 дүгээр үлирлын дундаж инфляц									

Эх сурвалж: Монголбанк

ЭДИЙН ЗАСАГ БОЛОН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД										
Гүйцэтгэл							2022	2023	2024	
	2017	2018	2019	2020	2021	2022.07	Төс.			
Бодит сектор (6 сар)										
Бодит ДНБ	5.6	7.7	5.6	-4.6	1.6	1.9	3.0^	4.4^^	6.1^^^	
Уул уурхайн ДНБ	-3.9	5.4	-1.6	-9.9	0.8	-28.8	-11.7	10.6	5.7	
Уул уурхайн бус ДНБ	7.7	8.2	6.9	-3.7	1.8	6.4	5.3	3.6	6.1	
Хэргэлзэний үнүүн индекс	6.4	8.1	5.2	2.3	13.4	15.7	13.6	7.8	6.3	
ДНБ-ний дефлятор	10.6	8.0	8.3	5.9	13.3	19.3	9.6	10.2	5.0	
Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд										
Нийт орлого	7,922	10,063	11,937	10,402	14,255	9,440	16,169	17,843	19,765	
Ирээдүйн өв сан	358	621	1,040	914	938	0	0	0	0	
Тогтвортжуулалтын сан	326	207	95	66	628	732	1,124	512	559	
Тэнцвэржүүлсэн орлого	7,239	9,235	10,802	9,422	12,689	8,709	15,046	17,331	19,206	
Татварын орлого	6,303	8,207	9,749	8,502	11,263	8,206	14,020	15,876	17,628	
Татварын бус орлого	936	1,028	1,053	920	1,427	503	1,027	1,455	1,579	
Нийт зардал ба цөвэр зээл	8,981	9,223	11,429	13,961	15,598	9,497	17,913	19,219	20,978	
Ургал зардал	6,842	7,348	8,208	10,872	12,754	8,004	13,820	14,855	15,854	
Хөрөнгийн зардал ба зээл	1,975	1,875	3,222	3,089	2,844	1,493	4,093	4,364	5,124	
Хөрөнгийн зардал	1,646	1,608	2,818	3,052	3,047	1,437	4,432	4,554	5,325	
Эргэж төлөгдөх цөвэр зээл	329	267	403	38	-203	56	-340	-189	-201	
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-1,742	12	-628	-4,539	-2,909	-788	-2,867	-1,888	-1,772	
Анхдагч тэнцэл (Тэнцвэржүүлсэн тэнцээс тооцсон)	-586	1,059	233	-3,580	-2,081	-333	-2,020	-955	-1,112	
Шаардлагатай санхүүжилт	7,290	2,703	1,231	7,378	7,021	1,237	4,374	6,254	5,572	
Дотоод эх үүсвэр	1,589	1,263	-272	2,307	2,893	680	2,851	1,103	-486	
Гадаад эх үүсвэр	5,701	1,440	1,503	5,071	4,128	557	1,523	5,151	6,058	
Монгол ба зээлийн үзүүлэлтүүд										
M2 мөнгө	30.5	22.8	7.0	16.3	13.8	-1.4	-4.4	-4.1	0.2	
Зээл+ИЗББ	11.0	24.3	4.5	-4.0	17.8	17.4	13.0	9.8	11.4	
Зээл	9.6	26.5	5.0	-4.0	21.3	20.0	15.5	11.0	12.6	
Нийт харицах, хадгаламж, тэрбум ₮	15,249	18,804	20,219	23,467	27,016	26,273	25,888	24,837	24,894	
Төгрөгийн харицах, хадгаламж, тэрбум ₮	10,836	13,517	14,409	16,843	20,699	18,463	18,192	17,453	17,493	
Гадаад валютын харицах, хадгаламж, тэрбум ₮	4,413	5,287	5,810	6,624	6,318	7,810	7,696	7,383	7,400	
Төлбөрийн тэнцэл										
Ургал тэнцэл	-1138	-2210	-2140	-675	-2012	-2201				
Худалдааны тэнцрл	1470	676	1047	1756	1308	-379				
Экспорт Ф.О.Б.	5840	6557	7156	6991	8143	4377				
Импорт Ф.О.Б.	-4370	-5871	-6109	-5235	-6835	-4756				
Хөрөнгийн ба санхүүгийн тэнцрл	2706	2181	2766	1607	2505	674				
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	1414	2137	2197	1693	2036	957				
Санхүүгийн хөрөнгө оруулалт	452	73	370	-563	-58	-93				
Бусад	763	-121	199	-146	527	-191				
Нийт тэнцрл	1460	-147	453	787	-222	-1317				
сая ам.доллароор										

^ - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь [(1.4) - (4.6)]

^^ - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь [(2.0) - (6.8)]

^^^ - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь [(3.4) - (8.9)]

ЭДИЙН ЗАСАГ БОЛОН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД									
	Гүйцэтгэл						2022	2023	2024
	2017	2018	2019	2020	2021	2022.07	Төс.		
Бодит сектор (6 сар)									
Нэрлэсэн ДНБ, тэрбум төгрөгөөр	28011	32583	37839	37453	43019		49168	56824	63205
Бодит ДНБ (жилийн өсөлт)	5.6	7.7	5.6	-4.6	1.6	1.9	3.0^	4.4^^	6.1^^^
Хэрэглээний үнийн индекс	6.4	8.1	5.2	2.3	13.4	15.7	13.6	7.8	6.3
ДНБ-ний дефлятор (жилийн өсөлт)	10.6	8.0	8.3	5.9	13.3	19.3	9.6	10.2	5.0
Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд									
Нийт орлого	28.3	30.9	31.5	27.8	33.1	19.2	32.9	31.4	31.3
Ирээдүйн өв сан	1.3	1.9	2.7	2.4	2.2	0.0	0.0	0.0	0.0
Тогтвортжуулалтын сан	1.2	0.6	0.2	0.2	1.5	1.5	2.3	0.9	0.9
Тэнцвэржүүлсэн орлого	25.8	28.3	28.5	25.2	29.5	17.7	30.6	30.5	30.4
Татварын орлого	22.5	25.2	25.8	22.7	26.2	16.7	28.5	27.9	27.9
Татварын бус орлого	3.3	3.2	2.8	2.5	3.3	1.0	2.1	2.6	2.5
Нийт зардал ба цэвэр зээл	32.1	28.3	30.2	37.3	36.3	19.3	36.4	33.8	33.2
Ургал зардал	24.4	22.6	21.7	29.0	29.6	16.3	28.1	26.1	25.1
Хөрөнгийн зардал ба зээл	7.1	5.8	8.5	8.2	6.6	3.0	8.3	7.7	8.1
Хөрөнгийн зардал	5.9	4.9	7.4	8.1	7.1	2.9	9.0	8.0	8.4
Эргэж төлөгдөх цэвэр зээл	1.2	0.8	1.1	0.1	-0.5	0.1	-0.7	-0.3	-0.3
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-6.2	0.0	-1.7	-12.1	-6.8	-1.6	-5.8	-3.3	-2.8
Анхдагч тэнцэл (Тэнцвэржүүлсэн тэнцэлээс тооцсон)	-2.1	3.2	0.6	-9.6	-4.8	-0.7	-4.1	-1.7	-1.8
Шаардлагатай санхүүжилт	26.0	8.3	3.3	19.7	16.3	2.5	8.9	11.0	8.8
Дотоод эх үүсвэр	5.7	3.9	-0.7	6.2	6.7	1.4	5.8	1.9	-0.8
Гадаад эх үүсвэр	20.4	4.4	4.0	13.5	9.6	1.1	3.1	9.1	9.6
Мөнгө ба зээлийн үзүүлэлтүүд									
M2 мөнгө (жилийн өсөлт)	30.5	22.8	7.0	16.3	13.8	-1.4	-4.4	-4.1	0.2
Зээл+ИЗББ (жилийн өсөлт)	11.0	24.3	4.5	-4.0	17.8	17.4	13.0	9.8	11.4
Зээл (жилийн өсөлт)	9.6	26.5	5.0	-4.0	21.3	20.0	15.5	11.0	12.6
Нийт харилцах, хадгаламж, тэрбум ₮	54.4	57.7	53.4	62.7	62.8	53.4	52.7	43.7	39.4
Төгрөгийн харилцах, хадгаламж, тэрбум ₮	38.7	41.5	38.1	45.0	48.1	37.6	37.0	30.7	27.7
Гадаад валютын харилцах, хадгаламж, тэрбум ₮	15.8	16.2	15.4	17.7	14.7	15.9	15.7	13.0	11.7
Нэрлэсэн ДНБ, тэрбум төгрөгөөр	28011	32583	37839	37453	43019		49168	56824	63205
Нэрлэсэн ДНБ, жилийн өсөлт	17.0	16.3	16.1	-1.0	14.9		14.3	15.6	11.2
Төлбөрийн тэнцэл									
Ургал тэнцэл	-9.9	-17.9	-15.5	-5.1	-13.3	-15.1			
Худалдааны тэнцэл	12.7	5.5	7.6	13.4	8.7	-2.6			
Экспорт Ф.О.Б.	50.6	53.2	51.7	53.2	53.9	30.1			
Импорт Ф.О.Б.	-37.9	-47.6	-44.1	-39.8	-45.3	-32.7			
Хөрөнгийн ба санхүүгийн тэнцэл	23.4	17.7	20.0	12.2	16.6	4.6			
Гадаадын шудд хөрөнгө оруулалт	12.3	17.3	15.9	12.9	13.5	6.6			
Санхүүгийн хөрөнгө оруулалт	3.9	0.6	2.7	-4.3	-0.4	-0.6			
Бусад	6.6	-1.0	1.4	-1.1	3.5	-1.3			
Нийт тэнцэл	12.7	-1.2	3.3	6.0	-1.5	-9.1			


^ - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь $(1.4) - (4.6)$ ^^ - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь $(2.0) - (6.8)$ ^^^ - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь $(3.4) - (8.9)$

V. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


5.1. Мөнгөний нийлүүлэлт, зээл

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2021 оны 2 дугаар хагасаас үргэлжлэн саарч, харин банкны системийн зээлийн өсөлт 2021 оны эхнээс нэмэгдэн сүүлийн улирлуудад өндөр түвшинд хадгалагдав. Энэ оны 2 дугаар улирлын байдлаар мөнгөний нийлүүлэлт өмнөх жилийн мөн үеэс 1.3 хувиар буурлаа. Үүнд, төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдсэнээс банкны системийн гадаад цэвэр актив (ГЦА) буурч байгаа нь голлон нөлөөлж байна. Харин 2021 оны 1 дүгээр улирлаас хэрэгжиж эхэлсэн “Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-тэй холбоотойгоор банкны системийн бизнесийн зээлийн өсөлт сэргэсэн, түүнчлэн иргэдийн хэрэглээ болон хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт 2021 оны сүүлийн улирлаас эрчимжсэн нь мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлд нөлөөллөө. Энэ онд зээлийн өсөлт болон төсвийн алдагдалтай холбоотой дотоод санхүүжилтийн шаардлага нэмэгдэж байгаа нь мөнгөний нийлүүлэлтийг өсгөх чиглэлд нөлөөлөх хэдий ч төлбөрийн тэнцлийн алдагдал тэлж байгаа нөлөөгөөр энэ онд мөнгөний нийлүүлэлт алгуур буурах хүлээлттэй байна.

Зураг 40. M2 мөнгөний жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр /актив/




Зураг 41. M2 мөнгөний жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр /пассив/




Эх сурвалж: Монголбанк

Эх үүсвэр талаас авч үзвэл банкны системийн төгрөгийн хадгаламж буурсан нөлөөгөөр мөнгөний нийлүүлэлтийн өсөлт сүүлийн улирлуудад үргэлжлэн саарв. Нөгөө талаас гадаад валютын харилцах өмнөх жилийн мөн үеэс нэмэгдсэн нь мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлд нөлөөлсөн байна. Тодруулбал, 2022 оны 2 дугаар улирлын байдлаар мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт -1.3 хувьд хүрэхд гадаад валютын харилцах 2.6 нэгж хувийн эерэг нөлөө, төгрөгийн хадгаламж -4.8 нэгж хувийн бууруулах нөлөөг тус тус үзүүлсэн байна. Ийнхүү 2022 оны эхнээс төгрөгийн эх үүсвэр буурч, гадаад валютын эх үүсвэр өсөж байгаа нөлөөгөөр банкны системийн эх үүсвэрийн долларжилтын түвшин сүүлийн 2 улиралд үргэлжлэн нэмэгдэж, 2022 оны 2 дугаар улирлын эцэст 28.6 хувьд хүрсэн байна. Энэ нь 2021 оны 2 дугаар улирлаас 3.2 нэгж хувиар, оны эхнээс 5.3 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм. Харин зээлийн долларжилт сүүлийн улирлуудын турш алгуур саарч 6 хувьд хүрлээ.

Зураг 42. Банкны системийн долларжилт



Зураг 43. Зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк

Сүүлийн улирлуудад “10 их наядын цогц төлөвлөгөө”-ний нөлөөгөөр хурдацтай нэмэгдсэн банкны системийн зээлийн өсөлт 2022 оны 2 дугаар улиралд тогтвортож байна. Банкны системийн зээлийн үлдэгдэл 2022 оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар нэмэгдэв. Эдийн засгийн салбараар нь харвал хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээл, худалдаа болон үл хөдлөх салбарын зээл голлон бүрдүүлжээ. Зээлийн зориулалтаар нь авч үзвэл ипотекийн зээл жилийн 36 хувиар (нийт зээлийн өсөлтийн 4.3 нэгж хувь), хэрэглээ болон хадгаламж барьцаалсан зээл жилийн 30.4 хувиар (7.5 нэгж хувь), бизнесийн зориулалттай зээл 17 хувиар (10.8 нэгж хувь) тус тус ессөн байна.

Банкны системийн анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл 2022 оны 2 дугаар улиралд 1.1 орчим их наяд төгрөгт хүрч, жилийн -7.2 хувиар буурав. Харин чанаргүй зээлийн үлдэгдэл 2.1 орчим их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх жилийн мөн үеэс 7.5 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. Үлмаар банкны системийн анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн нийлбэр дүн нийт зээлийн багцын 13.7 хувийг бүрдүүлж байгаа нь өмнөх жилийн мөн үеэс 2.8 нэгж хувиар буурав. Үүнд, банкны системийн зээлийн чанар төдийлөн өөрчлөгдөөгүй, харин зээл олголт сүүлийн улирлуудад огцом нэмэгдсэн нь анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь буурахад голлон нөлөөлж байна.

Мөнгөний тойм	(өөрөөр заагаагүй бол тэрбум төгрөг)										2023	2024
	2017	2018	2019	2020	2021	2022						
	Q4	Q4	Q4	Q4	Q4	Q1	Q2	M07	Q3	Q4	Q4	Q4
	Гүйцэтгэл											
M2 монго	15861	19475	20834	24220	27863	26508	27614	27032	27000	26636	25554	25613
M1 монго	2826	4031	3904	4197	6507	5748	6067	5920	5913	5833	5596	5609
Банкнаас гадуурх монго	612	670	614	753	847	727	757	759	758	748	718	719
Харилцах ₮	2214	3360	3290	3444	5660	5021	5310	5161	5154	5085	4878	4890
Бараг монго	13035	15444	16930	20023	21356	20760	21547	21112	21087	20803	19958	20004
Хадгаламж ₮	8622	10156	11120	13398	15039	13702	13788	13302	13286	13107	12575	12604
Хадгаламж \$	2532	3020	3484	4642	3973	4281	4526	4517	4512	4451	4270	4280
Харилцах \$	1881	2268	2326	1983	2345	2777	3232	3294	3290	3245	3114	3121
Гадаад цэвэр актив	-1252	249	1847	5356	3806	1219	588	-33	-745	-3372	-8841	-11356
Төв банкны	2283	3892	5182	6273	4892	1908	1541	880	-6	-1260	-5922	-8155
Арилжааны банкны	-3536	-3643	-3335	-916	-1085	-688	-953	-913	-739	-2111	-2919	-3201
Дотоод цэвэр актив	17114	19226	18987	18864	24057	25288	27026	27065	27745	30008	34395	36969
Дотоодын цэвэр зээл	17203	20194	18825	19333	24203	25344	26679	26167	27211	29513	32048	34896
ЗГ-ын цэвэр зээл	-77	-771	-2488	-1524	-471	-803	-743	-1103	-638	1196	688	-229
Төв банк	-1111	-177	-1229	-1114	-738	-1127	-908	-1359	-1516	-865	244	-246
Арилжааны банкууд	1034	-594	-1258	-411	267	325	166	256	878	2061	444	16
ЗГ-ас авах авлага	2649	1519	1480	1690	1734	1761	1673	1705	2385	3569	1951	1524
ЗГ-ын хадгаламж	-1615	-2112	2738	2100	1467	1436	1508	1449	-1508	-1508	-1508	-1508
Банк бусас авах авлага	17280	20965	21313	20857	24674	26146	27421	27270	27849	28317	31360	35125
Зээл+ИЗБ	16133	20060	20979	19975	23530	25029	26356	26212	26520	26988	29631	32996
Үүнээс зээл	13615	17226	18096	17207	20876	22090	23471	23341	23649	24118	26761	30126
Хэрэглээний зээл	3597	5572	5143	4196	5214	5776	6098	5996	6375	6375	7650	8644
Бизнесийн зээл	10018	11653	12953	13011	2796	2798	2799	2800	3204	3364	3787	4165
Бусад санхүүний байгууллагаас авах авлага	3665	3739	3381	3650	12867	13516	14575	14546	14070	14379	15324	17316
Төв банк												
Ноөц монго	3943	4908	5172	4516	4808	5211	5703	5557	5438	5128	4063	3745
Гүйлгээнд гаргасан бэлэн монго	906	969	897	991	1106	994	1035	1032	1031	1017	975	978
Арилжааны банкуудын харилцах, хадгаламж	3036	3939	4275	3525	3702	4217	4668	4525	4408	4111	3087	2767
Гадаад цэвэр актив	2283	3892	5182	6273	4892	1908	1541	880	-6	-1260	-5922	-8155
Дотоод цэвэр актив	1659	1016	-10	-1757	-84	3303	4162	4677	5444	6388	9985	11900
Меморандум үзүүлэлтүүд:												
M2 монголийн жилийн өөрчлөлт (%)	30.5	22.8	7.0	16.3	13.8	4.2	-1.3	-1.4	-0.9	-4.4	-4.1	0.2
Ноөц монголийн жилийн өөрчлөлт (%)	28.6	24.5	5.4	-12.7	6.5	45.2	34.6	33.6	35.5	6.7	-20.8	-7.8
M2 монголийн үргэлжлэгч (нэгжээр)	4.02	3.97	4.03	5.36	5.80	5.09	4.84	4.86	4.96	5.19	6.29	6.84
Зээл+ИЗБ жилийн өөрчлөлт (%)	10.9	24.3	4.5	-4.0	17.8	21.3	19.5	17.4	15.2	13.0	9.8	11.4
Зээлийн жилийн өөрчлөлт (%)	9.6	26.5	5.0	-4.0	21.3	25.2	22.5	20.0	17.0	15.5	11.0	12.6
Хэрэглээний зээлийн жилийн өөрчлөлт (%)	51.5	54.9	-7.7	-18.4	13.9	21.9	30.4	27.4	29.0	22.3	20.0	13.0
Бизнесийн зээлийн жилийн өөрчлөлт (%)	-0.5	16.1	11.1	1.7	18.9	23.7	16.9	14.6	11.4	11.7	6.6	13.0
Зээл+ДНБ	0.58	0.62	0.57	0.55	0.56	0.58	0.56	0.58	0.54	0.55	0.52	0.52
Монголийн эргэлтийн хурд	1.76	1.66	1.77	1.48	1.54	1.64	1.69	1.69	1.80	1.85	2.22	2.47
Банкуудын ТБ дахь ноөц/Нэрлэсэн ДНБ	10.9	12.2	11.6	9.6	8.6	9.7	10.0	9.1	8.4	5.4	4.4	
Нэрлэсэн ДНБ /тэрбум төгрөг/	28011	32583	37839	37453	43019	43387	46718	46869	49168	56824	63205	
Нэрлэсэн ДНБ-ийн жилийн осолт (%)	17.0	16.3	16.1	-1.0	14.9	10.7	15.8		19.4	12.9	15.6	11.2
Жилд шилжүүлсэн бодит ДНБ-ийн осолт (%)	5.6	7.7	5.6	-4.6	1.6	-1.7	-0.3	0.8	3.0	4.4	6.1	

5.2. Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр

Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2022 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар Монголбанк, Засгийн газар, банкуудын эх үүсвэрээр нийт 6.5 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүйтэй зээлийг 107.5 мянган зээлдэгчид олгоод байна.

КОВИД-19 цар тахлын эдийн засагт үзүүлсэн нөлөөнөөс шалтгаалан ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх хугацааг “Коронавируст халдвэр /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”, УИХ-ын 2020 оны 32 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Коронавируст халдвэр /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээ”, Монгол Улсын Засгийн Газрын 183 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээ”-ний дагуу ипотекийн хөтөлбөрийг Монголбанк цар тахлын үед үргэлжлүүлэн санхүүжүүлж, хөтөлбөрийн нийгэм, эдийн засагт үзүүлж буй эерэг нөлөөг эрчимжүүлж байв.

Гэвч цар тахлын эдийн засагт үзүүлсэн нөлөө төдийлөн саармагжаагүй тул 2021 онд Засгийн газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлж, ипотекийн хөтөлбөрийг Монголбанкнаас хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд багтааж буюу 2023 онд багтаан Засгийн газарт шат дараатай хөтөлбөрийг шилжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Уг ажлын хүрээнд орон сууцны ипотекийн хөтөлбөрийн санхүүжилтийн схемийг олон улсын сайн туршлагад суурилсан, урт хугацаанд хэрэгжих боломжтой хэлбэрт шилжүүлэх ажлыг хийх шаардлагатай бөгөөд уг шаардлагын дагуу Дэлхийн банкнаас техникийн туслалцаа буюу зөвлөх авахаар тогтсон.

“Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд Монголбанк болон банкуудын эх үүсвэрээр жилд нийт 700 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээл олгохоор ажиллаж байгаа бөгөөд 2021 онд 1.0 их наяд төгрөгийн хөтөлбөрийн зээлийг 13.5 мянган өрхөд олгосон. Харин энэ оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 293.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийг 3.7 мянган өрхөд олгоод байна.

ШИГТГЭЭ 6. Эдийн засгийн сектор хоорондын хөрөнгийн урсгал

ОУВС-аас боловсруулсан хөрөнгийн урсгалын матриц шинжилгээг ашиглан Монгол Улсын сектор хоорондын хөрөнгийн урсгалын шинжилгээг 2021 оны байдлаар гүйцэтгэв.


A. Санхүүгийн бус тэнцлийг тооцоходоо эдийн засгийн үндсэн адилтгал буюу хуримтлал, хөрөнгө оруулалтын зөрүүгээр³⁰ тодорхойлдог. Тэгшигтгэлийн гол агуулга нь дотоод эдийн засгийн секторуудын хуримтлал нийт хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй нөхцөлд гадаад секторын хөрөнгөөр зөрүү хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх бөгөөд урсгал тэнцлийн алдагдал тус дүнгээр нэмэгдэхийг харуулна. Эдийн засгийн харьятууд 2021 онд нийт 38.5 их наяд төгрөгийн цэвэр орлоготой ажилласнаас 33.9 их наяд төгрөгийг хувийн сектор, 4.6 их наяд төгрөгийг Засгийн газар татварын цэвэр орлого³¹ хэлбэрээр бүрдүүлжээ. Тайлант хугацаанд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 12.7 их наяд төгрөг, нийт зардал 15.6 орчим их наяд төгрөгт хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2.9 их наяд төгрөгийн алдагдалтай гарав. Харин хувийн сектор 22.5 их наяд төгрөгийг хэрэглээнд, 14.3 их наяд төгрөгийг хөрөнгө оруулалтад зарцуулснаар 2.9 их наяд орчим төгрөгийн алдагдалтай байв. Ийнхүү дотоод эдийн засаг дахь салбаруудын хуримтлал, хөрөнгө оруулалтын зөрүү 2021 онд цэвэр дүнгээр -5.8 их наяд төгрөгт хүрч, тус хэмжээний хөрөнгийг гадаад сектороос санхүүжүүлсэн байна. Санхүүгийн бус тэнцэлд төсвийн нэгдсэн үзүүлэлтүүд болон төлбөрийн тэнцлийн уялдаа холбоог эдийн засгийн нийт хадгаламж (S) болон хөрөнгө оруулалт (I)-ын үзүүлэлтүүдийг хувийн сектор болон Засгийн газар гэж бүрэлдэхүүн хэсгүүдэд задлах байдлаар хялбархан харж болно.

³⁰ $[GNDI = C + I + (X - M) + Y_f + Y_r] \Rightarrow [GNDI - C - I = CAB] \Rightarrow [S - I = CAB] \Rightarrow [(S_g - I_g) + (S_p - I_p) = CAB]$.

Энд – Үндэсний цэвэр орлого, – Нийт экспорт, – Нийт импорт, – Төлбөрийн тэнцлийн анхдагч орлого, – Төлбөрийн тэнцлийн хоёрдогч орлого, – Үндэсний нийт цэвэр орлого, – Эцсийн хэрэглээ, – Нийт хөрөнгө оруулалт, – Урсгал тэнцэл, – Дотоодын нийт хуримтлал, – Засгийн газрын хуримтлал, – Засгийн газрын хөрөнгө оруулалт, – Хувийн секторын хуримтлал, – Хувийн секторын хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ.

³¹ Төсвийн цэвэр орлого нь нийт тэнцвэржүүлсэн орлогоос зээлийн үйлчилгээний төлбөр, татаас болон бусад урсгал шилжүүлгийг хасаж тооцдог.

Зураг 44. Ургал тэнцлийн алдагдал (Хадгаламж, хөрөнгө оруулалтын зөрүү)



Хүснэгт 11. Эдийн засгийн секторууд хоорондын хөрөнгийн урсгалын шинжилгээний матриц, тэрбум төгрөгөөр

Гүйлгээ/Салбарууд	Дотоод эдийн засаг	Дотоод эдийн засгийн салбарууд						Гадаад сектор	ХОНДЛОН ШАЛГАЛТ
		Засгийн газар	Хувийн сектор	Санхүүгийн сектор	Үүнэс				
					Төв банк	Банк	Бусад санхүүгийн байгууллага		
ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО	38487	4595	33892						0.0
Эцсийн хэрэглээ	28762	-6272	-22490						0.0
Нийт хөрөнгө оруулалт	15542	-1232	-14310						0.0
Экспорт	25689							-25689	
Импорт	-26370							26370	0.0
Хүчин зүйлсийн орлого	-6358							6358	0.0
Шилжүүлэг (пэвэр)	1223							-1223	0.0
A. САНХҮҮГИЙН БУС ТЭНЦЭЛ	-5817	-2909	-2908					5817	0.0
1. ГАДААД САНХҮҮЖИЛТ	4806	232	4686	-112			-112	-4806	0.0
Хөрөнгө оруулалт	6003	-361	6305	59			59	-6003	0.0
ГШХО	5869		5869					-5869	0.0
Санхүүгийн ХО	-191	-361	111	59			59	191	0.0
Хөрөнгийн данс	325		325					-325	0.0
Гадаад цэвэр зээл	-1197	593	-1619	-171			-171	1197	0.0
Бэлэн валют, харилцах	-236		-236					236	0.0
2. ДОТООД САНХҮҮЖИЛТ	2664	-1026	-1637	-1640	-282	285			0.0
Дотоод зээл	992	4444	-5436	-754	-4238	-444			0.0
Засгийн газрын цэвэр зээл	992	0	-992	-376	-677	61			0.0
Зээл, үнэт цаас		4444	-4444	-378	-3561	-505			0.0
Нийт монго		-3137	3137	-136	3273				0.0
Санхүүгийн байгууллага хоорондын хөрөнгийн урсгал				-467	0	468			0.0
Төв банк				-1253	875	379			0.0
Банк				383	-875	492			0.0
БСБ				403	0	-403			0.0
Бусад цэвэр зүйлс	1671	-2333	662	-283	684	261			0.0
3. ГЦАКТИВЫН ӨӨРЧЛӨЛТ (-)	-1749			-1749	-1580	-169		1749	0.0
Гадаад актив (+)	-784			-784	-482	-302		784	0.0
Гадаад пассив (ОУВС-гийн зээл орсон) (-)	965		965	1098	-133			-965	0.0
Б. САНХҮҮГИЙН ТЭНЦЭЛ	6555	2896	3660	-1	-60	-113	173	-6555	
В. АЛДАА БА ЗАЛРУУЛГА БОСОО ШАЛГАЛТ	-739 0.0	13 0.0	-752 0.0	0 0.0	60 0.0	113 0.0	-173 0.0	739 0.0	0 0.0

Санхүүгийн тэнцлийг тооцоходоо эдийн засгийн харьятууд болох Засгийн газар, хувийн секторын хувьд гадаад санхүүжилт болон дотоод санхүүжилтийн нийлбэрээр, харин санхүүгийн секторын хувьд гадаад санхүүжилт, гадаад цэвэр активын өөрчлөлт болон дотоод санхүүжилтийн нийлбэрээр тооцдог. Энэ нь эдийн засгийн харьятууд гадаад зах зээлээс хэр хэмжээний эх үүсвэр татсан, дотоод эдийн засагт салбарууд хооронд эх үүсвэр хэрхэн шилжсэнийг харуулдаг.

Гадаад санхүүжилт нь дотоод эдийн засагт үүссэн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэх гол эх үүсвэр юм. Дотоод эдийн засгийн салбарууд гадаад сектороос нийт 4.8 орчим их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын хөрөнгийн урсгалыг хүлээн авснаас дийлэнхийг буюу 4.7 орчим их наяд төгрөгийг хувийн сектор бүрдүүлэв. Нийт гадаад санхүүжилтийн дун дотоодын санхүүгийн бус тэнцлээс бага (их) байгаа нь төлбөрийн тэнцлийн алдагдалтай (ашигтай) холбоотой бөгөөд энэ нь гадаад цэвэр активыг бууруулна (нэмэгдүүлнэ). Харин төлбөрийн тэнцэл, нэгдсэн төсөв болон мөнгөний тоймын статистик хоорондын зөрүү, алдаа, орхигдуулга, валютын ханшийн зөрүү нь цэвэр алдаа ба залруулгыг тайлбарлаж байна.

Хувийн сектор гадаад зах зээлээс цэвэр дүнгээр нийт 4.7 орчим их наяд төгрөгийн эх үүсвэрийг татсаны дийлэнх нь ГШХО хэлбэртэй байна. Тухайлбал, хувийн сектор 5.9 их наяд төгрөгийн ГШХО татсан бөгөөд үүний 65.3 хувь нь Оюутолгой төслийн бүтээн байгуулалттай холбоотой хөрөнгө оруулалт байв. Түүнчлэн хувийн сектор цэвэр дүнгээр 1.6 их наяд төгрөгийн гадаад зээлийг эргэн төллөө.

Засгийн газар төсвийн алдагдлыг санхүүжүүлэхээр цэвэр дүнгээр 232 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг гадаад зах зээлээс татсан байна. Үүнд, Засгийн газар цэвэр дүнгээр 593 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг гадаад зээлээр бүрдүүлсэн бол 361 тэрбум төгрөгийн бондыг эргэн төлөв.

Дотоод санхүүжилтийн хэсэгт сектор хоорондын санхүүгийн хөрөнгийн урсгалыг харуулдаг. Дотоод эдийн засагт **хувийн сектор болон санхүүгийн системээс** цэвэр дүнгээр хөрөнгө шилжсэн бол Засгийн газар хөрөнгө хүлээн авсан байна. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -2.9 их наяд төгрөг (ДНБ-ийн -6.7 хувь)-ийн алдагдалтай гарсан бөгөөд энэхүү алдагдлыг голчлон дотоод эх үүсвэрээс санхүүжүүлэв. Тухайлбал, төсвийн алдагдлын 292 тэрбум төгрөгийг гадаад зах зээлээс, дотоодын банкны системд хуримтлуулсан эх үүсвэрээс цэвэр дүнгээр 992 тэрбум төгрөг, ирээдүй өв сан болон тогтвортжуулалтын сантай холбоотой 1.7 их наяд төгрөгийг дотоод эх үүсвэрээс санхүүжүүллэв.

Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор хэрэгжүүлсэн “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний нөлөөгөөр 2021 онд банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оноос 21.3 хувиар буюу 3.6 их наяд төгрөгөөр өссөн байна.

Санхүүгийн секторын гадаад цэвэр активын өөрчлөлт -1.7 их наяд төгрөг байгаа нь Төв банк болон арилжааны банкуудын гадаад цэвэр актив тус дүнгээр буурсныг илэрхийлнэ. Тухайлбал, арилжааны банкны хувьд гадаад цэвэр актив (гадаад актив – гадаад пассив) 169 тэрбум төгрөгөөр бууран, энэ дүнгээр арилжааны банкуудын гадаадад байршуулсан хөрөнгө цэвэр дүнгээр буурсныг харуулж байна. Харин Төв банкны гадаад цэвэр актив 1.6 их наяд төгрөгөөр буурсан байна. Үүнд, гадаад актив 482 тэрбум төгрөгөөр буурч, гадаад пассив 1 их наяд орчим төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Тус хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх хүртэл хугацаанд санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд дараах нөхцөл байдал үүсээд байгааг анхаарах шаардлагатай. Үүнд:


Ипотекийн зээлийн эрэлт өндөр байна. Ипотекийн хөтөлбөрийн зээлийн эрэлт өндөр байгаа бөгөөд 2022 оны эхнээс 6 дугаар сарын байдлаар банкуудад нийт 1.1 их наяд төгрөг (14.5 мянган иргэн)-ийн ипотекийн зээлийн хүсэлт ирээд байгаагаас 293.8 тэрбум төгрөг (3.7 мянган иргэн)-ийн зээл олгогдож, 352.0 тэрбум төгрөг (3.9 мянган иргэн)-ийн зээлийн хүсэлтэд журам, гэрээний шаардлага хангаагүй болон өөрийн хүсэлтээр гэсэн шалтгаанаар татгалзсан байна. Улмаар нийт 466.6 тэрбум төгрөг (7.3 мянган иргэн)-ийн ипотекийн зээлийн хүсэлт банкууд дээр хуримтлагдаж, сар тутам ойролцоогоор 185.1 тэрбум төгрөг (2.4 мянган иргэн)-ийн хүсэлт нэмэгдэж байна. Иймд зах зээлийн нөхцөл байдлаас хамааран ипотекийн зээлийн эрэлт өндөр үед хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг тогтвортой түвшинд байлгах нөхцөл үүссэн.

Монголбанкнаас олгох санхүүжилтийн эх үүсвэр буурсан. Коронавируст цар тахлын хүндрэлтэй холбоотойгоор банкууд орон сууцны ипотекийн зээлийн төлбөрийг хойшлуулах хүсэлтийг иргэдээс хүлээн авч 5 дахь удаагаа шийдвэрлэсэн бөгөөд 3.4 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 63.2 мянган иргэний зээлийн эргэн төлөлтийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлуулав (Зураг 45). Эдгээр хойшлуулсан ипотекийн зээлийн хэмжээ нь нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 80 орчим хувийг эзэлж байна.

Зураг 45. Зээлийн төлбөр хойшилуулсан зээлийн мэдээлэл (тэрбум төгрөг)



Зураг 46. Монголбанкны эзэмшилийн ИЗББ-ын орлогын төсөөлөл




Ипотекийн зээлийн төлбөрийг хойшилуулснаар Ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)-ын үндсэн болон купоны төлбөр тасалдаж, улмаар орон сууцны ипотекийн зээлийг санхүүжүүлэх эх үүсвэр буурах эрсдэл үүссэн. Иймд ИЗББ-ны ирээдүйн мөнгөн урсгалаас санхүүжүүлэх замаар эх үүсвэрийг шийдвэрлэж, хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийн тасралтгүй байдлыг хангах шаардлага бий болсон. Уг шаардлагын дагуу Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 285/A-334 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоо бүрдүүлэх хөтөлбөрөөс гаргах төлөвлөгөө”-нд Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 163/A-136 дугаар хамтарсан тушаалаар холбогдох өөрчлөлтийг оруулсан. Ийнхүү Монголбанкны эзэмшилийн ИЗББ-ын ирээдүйн орлогоос хөтөлбөрийг санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч ИЗББ-ын орлогын хэмжээ нь 2022 оны 7 дугаар сараас 2023 оны 12 дугаар сар дуустал 1) үндсэн төлбөр 319.9 тэрбум төгрөг, 2) купоны төлбөр 269.0 тэрбум төгрөг байх төсөөлөлтэй байна (Зураг 46). Үнээс дүгнэхэд Монголбанкны эзэмшилийн ИЗББ-ын орлого нь жил бүр 700.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй зээл олгоход хүрэлцээгүй байгаа бөгөөд Засгийн газраас нэмэлт эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлага үүсэхээр байна.

5.3. Мөнгөний зах, хүүгийн түвшин


Банкуудын зээл олгох эсвэл хадгаламж татах шийдвэр нь банк хоорондын зах дээрх санхүүгийн хэрэгслүүдийн хүүгээс хамаарч байдаг. Иймд Монголбанкнаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүгийн нэгдсэн бодлого болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийн тусламжтай банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүг бодлогын хүүтэй ойролцоо түвшинд хадгалахыг зорьдог билээ.

Зураг 47. Банк хоорондын захын арилжааны хүү
(Хувиар, 2021.II-2022.II)



Эх сурвалж: Монголбанк


Зураг 48. Банк хоорондын захын хүүгийн бодлогын хүүнээс хазайх хэлбэлзлийн хистограмм (Хувиар, 2021.II-2022.II)



Эх сурвалж: Монголбанк


Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2022 онд бодлогын хүүг шат дараалалтай нийт 4.0 нэгж хувиар нэмэгдүүлэн 10.0 хувийн түвшинд хүргээд байна. Ингэснээр банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү өмнөх оны 2 дугаар улирлаас хойш 2.9 хувиар өсөж, 2022 оны 2 дугаар улиралд дунджаар 9.1 хувийн түвшинд хадгалагдлаа (Зураг 47). Мөн 2021 оны 2 дугаар улирлаас хойш банк хоорондын захын хүүгийн бодлогын хүүгээс хазайх абсолют хазайлт дунджаар 0.09 нэгж хувь байгаа бөгөөд нийт хугацааны 90.2 хувьд хүүгийн хэлбэлзэл нь [0.0;0.25] интервалд харьялагдаж байгаа нь банк хоорондын захын хүү бодлогын хүүтэй ойролцоо түвшинд хадгалагдсаныг харуулж байна (Зураг 48).

Зураг 49. Банк хоорондын захын төгрөгийн арилжааны хэмжээ
(Тэрбум ₮, 2021.II-2022.II)



Эх сурвалж: Монголбанк

Зураг 50. Банк хоорондын захын төгрөгийн арилжааны дундаж хугацаа (Хоногоор, 2021.II-2022.II)



Эх сурвалж: Монголбанк

2022 оны 2 дугаар улиралд банк хоорондын төгрөгийн заход нийт 2,870.8 тэрбум төгрөгийн дүн бүхий 230 хэлцлийг 9.1 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр, 12.3 хоногийн дундаж хугацаатайгаар байгуулжээ (Зураг 49, Зураг 50). Банк хоорондын төгрөгийн заход хийгдсэн нийт хэлцлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 66.1 нэгж хувиар өссөн бол нэг хэлцлийн дундаж хэмжээ 13.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.1 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт байна. Энэ нь нэг талаас эдийн засгийн идэвхжил тайлант хугацаанд нэмэгдсэн, нөгөө талаас банкны системийн бүтцийн илүүдэл нөөц буурч байгаагаар тайлбарлагдаж байна.

Хүснэгт 12. Хоёрдогч зах зээлийн арилжаанд эзлэх хувь, хэлцлийн төрлөөр (Хувиар)

Үзүүлэлт	2021				2022	
	I	II	III	IV	I	II
Репо (ТБҮЦ)	39.9%	30.7%	50.2%	52.0%	45.1%	20.3%
Шууд (ТБҮЦ)	27.3%	58.0%	40.7%	29.6%	43.2%	25.2%
Овернайт	15.5%	3.8%	0.5%	1.6%	0.2%	16.0%
Банк хоорондын хадгаламж	17.3%	7.4%	8.6%	9.9%	11.5%	38.6%


Эх сурвалж: Монголбанк

Мөн банк хоорондын захын арилжааны бүтцийг авч үзвэл нийт банк хоорондын арилжаанд ТБҮЦ-ыг барьцаалан хийж байгаа репо хэлцэл 20.3%, ТБҮЦ-ны шууд хэлцэл 25.2%, овернайт хэлцэл 16.0%, банк хоорондын хадгаламж 38.6%-ийг тус тус бүрдүүлж байна. Банк хоорондын ТБҮЦ-ны шууд болон репо хэлцэл нь харилцагчийн эрсдэл багатай тул нийт арилжаанд давамгайлж байгаа бөгөөд 2022 оны 2 дугаар улиралд банк хоорондын хадгаламж идэвхжэсэн байна (Хүснэгт 12).

5.4. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

Энэ оны I улиралд төгрөгийн ам.доллартой харьцах ханш өмнөх улирлаас 3.48 хувиар, II улиралд өмнөх улирлаас 6.30 хувиар тус тус супарч, оны эхнээс нийт 9.99%-аар супран, 3134.10 төгрөгт хүрээд байна. Ингэхдээ, 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар төгрөгийн ам.доллартой харьцах ханш нэг өдөрт хамгийн ихдээ 0.14 хувиар чангарч, 0.82 хувиар супарч, өдрийн дундаж хэлбэлзэл 0.09% байсан нь 2021 оны мөн үетэй харьцуулахад 0.08 нэгжээр өссөн байна.

Зураг 51. Төгрөгийн ам.доллартой харьцах ханишийн өдрийн хэлбэлзлийн давтамж




Зураг 52. Төгрөгийн ам.доллартой харьцах албан ханишийн өөрчлөлт




Эх сурвалж: Монголбанк

КОВИД-19 цар тахлын эсрэг вакцинуулалт хурдацтай хийгдэж, улс орнууд цар тахлын нөхцөлд дасан зохицох болсноор томоохон эдийн засгууд сэргэж Монгол Улсын экспорттын голлох түүхий эдийн үнэ өндөр түвшинд хадгалагдсан хэвээр байна. Тухайлбал, 2021 оны төгсгөлд 1 тонн зэсийн үнэ 9740.6 ам.доллар байсан бол 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 8,258.0 ам.долларт болж буурсан хэдий ч оны эхнээс хойш өдрийн дундаж үнэ 9,748.3 ам.доллар буюу зэсийн үнэ өндөр түвшинд хадгалагдсаар байна. Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ 2021 оны төгсгөлд тонн тутамд 172.2 ам.доллар байсан бол 2022 оны 6 дугаар сарын байдлаар 273.6 ам.доллар болж 58.8 хувиар өсөөд байна. Харин манай нүүрс экспортлогч компаниудын үнэ дэлхийн зах зээл дээрх гэрээний үнээс 2 орчим дахин доогуур байна.

Зураг 53. Зэсийн үнэ, \$/тонн



Зураг 54. Нүүрсний үнэ, \$/тонн



Харин БНХАУ-д “Тэг-КОВИД” бодлого болон “Бээжингийн олимп 2022”-той холбоотойгоор хилийн хоригтой байснаар экспорттын бүтээгдэхүүний тоо хэмжээний бууралтаас шалтгаалан экспорттын орлого энэ оны 6 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 1.7 тэрбум ам.доллароор буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь олон улсын зах зээл дээрх түүхий эдийн үнэ өндөр үеийг хангалттай түвшинд ашиглаж чадахгүй байгааг харуулж байна.

Түүнчлэн, Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2022 оны 6 дугаар сарын байдлаар төлбөрийн тэнцэл 1,058.0 сая ам.долларын алдагдалтай гарсан. Үүнд БНХАУ-ын “Тэг-КОВИД” бодлогын хүрээнд манай голлох экспорттын түүхий эд болох нүүрсний экспорттын биет хэмжээ буурсан, тээвэрлэлтийн saat, хяналт шалгалтаас үүдэн импортын тээврийн зардал нэмэгдсэн, ковидын дараах эдийн засгийн сэргэлтээс үүдэн импорт 2022 оны эхний 6 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 21%-иар өссөн зэрэг нь урсгал тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлж байна. Улмаар Гадаад валютын албан нөөц оны эхнээс 1.3 тэрбум ам.доллароор буурч, импортын 4.6 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрээд байна.

Монголбанкны гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл нь дотоодын зах зээлээс худалдаж авдаг алт байдаг. Гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх нь олон нийтийн төгрөгт итгэлийг бэхжүүлэх, Монгол Улсын зээлжих зэрэглэлд эергээр нөлөөлөх болон эдийн засгийн дархлааг нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдолтой. Монголбанк 2021 онд 20.8 тонн үнэт металл худалдан авсан бол 2022 оны 6 дугаар сарын байдлаар нийт 7.9 тонн үнэт металл худалдан аваад байна.

Монголбанкнаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлд нийцтэй, уян хатан тогтох зарчмыг баримталж ажилладаг бөгөөд богино хугацааны төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын заход шаардлагатай үед тухай бүр оролцон ажилладаг. Тус зорилгынхоо хүрээнд Монголбанк 2022 оны 6 дугаар сарын байдлаар нийт 1,593.2 сая ам.долларыг худалдан авч, гадаад валютын дуудлага худалдаа болон цахим талбараар нийт 3,387.2 сая ам.долларыг дотоодын валютын заход нийлүүлсэн. Ингэснээр Монголбанк цэвэр дүнгээр 1,794.0 сая ам.долларыг валютын заход нийлүүлээд байна.

VI. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ЗЭЭЛ

6.1. Төлбөрийн тэнцэл

2022 оны эхний 6 сарын урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 106 хувиар өсөж 2,144.7 сая ам.долларт, санхүүгийн дансны ашиг 50 хувиар нэмэгдэж 1,038.6 сая ам.долларт тус тус хүрснээр, нийт тэнцлийн алдагдал өмнөх оноос 1,003.7 сая ам.доллароор өсөж 1,058.0 сая ам.долларт хүрсэн.


Хүснэгт 13. Төлбөрийн тэнцлийн 2022 оны эхний 6 сарын урьдчилсан гүйцэтгэл, сая ам.доллар

	Эхний 6 сар		Өөрчлөлт	
	2021	2022	Дүн	Хувь
I. Урсгал данс	-1,088	-2,231	-1,143	105%
1.1 Бараа ба үйлчилгээний худалдаа	-418	-1,287	-870	208%
А. Бараа	295	-425	-720	-244%
Б. Үйлчилгээ	-712	-862	-149	21%
1.2 Анхдагч орлого	-880	-1,194	-313	36%
1.3 Хоёрдогч орлого	210	250	40	19%
II. Хөрөнгийн данс	49	87	38	77%
<i>Урсгал ба Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээлтэг -)</i>	<i>-1,039</i>	<i>-2,145</i>	<i>-1,106</i>	<i>106%</i>
III. Санхүүгийн данс	-691	-1,039	-348	50%
<i>Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээлтэг -)</i>	<i>-691</i>	<i>-1,039</i>	<i>-348</i>	<i>50%</i>
А. Гадаадын шууд хөрөнгө оруулалт	-920	-1,177	-257	28%
а.1. Актив	87	46	-41	x
а.2. Пассив	1,007	1,223	216	21%
Б. Багцын хөрөнгө оруулалт	61	95	34	55%
б.1. Актив	28	27	0	-2%
б.2. Пассив	-34	-68	-34	102%
В. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	-2	-37	-35	1967%
в.1. Актив	-2	-37	-35	2038%
в.2. Пассив	0	0	0	x
Г. Бусад хөрөнгө оруулалт	170	80	-89	-53%
г.1. Актив	170	107	-63	6x
г.2. Пассив	0	27	26	5393%
IV. Алдаа ба орхигдуулга	294	48	-246	-84%
<i>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</i>	<i>-54</i>	<i>-1,058</i>	<i>-1,004</i>	<i>1851%</i>
IV. Албан нөөцийн өөрчлөлт	-54	-1,058	-1,004	1851%

Зураг 55. Төлбөрийн тэнцэл



Зураг 56. Ургал ба хөрөнгийн тэнцэл



Эх сурвалж: Монголбанк

Ургал ба хөрөнгийн данс

Ургал ба хөрөнгийн дансны алдагдал 2022 оны эхний 6 сард өнгөрсөн оны мөн үеэс 1,105.9 сая ам.доллароор өссөн. Үүнд барааны дансны алдагдал 720.1 сая ам.доллароор нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлэв.

Дотоодын эдийн засгийн сэргэлт, уул уурхайн бүтээн байгуулалтууд болон импортын өсөлтөөс шалтгаалж ургал дансны алдагдал 2012 онд ДНБ-ий 44 хувьд хүрч байсан. Тэгвэл 2014 оноос барааны гадаад худалдаа ашигтай гарч эхэлснээр алдагдал буурч 2015 онд ДНБ-ий 8 хувь, 2016 онд 6 хувьд хүрсэн. Тэгвэл 2018 онд импортын өсөлттэй холбоотой барааны дансны ашиг буурснаар уг алдагдал 34 хувьд хүрч өссөн бол 2022 оны 2 дугаар улирлын байдлаар 49 хувьтай байна.

Зураг 57. Ургал тэнцэл/Нэрлэсэн ДНБ



Эх сурвалж: Монголбанк

ШИГТГЭЭ 7. Гадаад төлбөр тооцоонд үүсж буй хүндрэл, эрсдэлийг бууруулахад Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээ

Олон улсад үүссэн геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалж Монгол Улсаас ОХУ руу иргэд, аж ахуй нэгжийн гадаад шилжүүлэг хийх, бараа бүтээгдэхүүний төлбөр тооцоог гүйцэтгэхэд 2022 оны гуравдугаар сараас эхлэн хүндрэл үүсээд байна. Монголбанкны зүгээс импортын нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүн төдийгүй иргэдийн гадаад төлбөр тооцоог рублиэр саадгүй гүйцэтгэхийн тулд банкуудаас нөхцөл байдлын талаар тухай бүр судалгаа авах, дүн шинжилгээ хийх, оролцогч талуудыг хэрэгцээт мэдээлэл болон зохицуулалтаар хангах, эрх бүхий олон улсын байгууллагуудад үүсж буй хүндрэл, эрсдэлийн талаар уламжилж, боломжит арга хэмжээ авах, гадаад төлбөр тооцоог дамжуулах нэмэлт суваг бүхий олон улсын төлбөр тооцооны бусад сүлжээнд холбогдох гарцыг судлах зэрэг ажлыг тогтмол хийж байна.

Гадаад төлбөр тооцооны нөхцөл байдал

Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээний хүрээнд СВИФТ сүлжээнээс ОХУ-ын банк, санхүүгийн 7 байгууллагыг 2022 оны 3 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн хассан бөгөөд улмаар олон улсын бусад корреспондент банкууд тус улс руу гүйлгээ дамжуулахаас татгалзаж, манай улсын дийлэнх банкуудын ОХУ руу хийх төлбөр тооцоо буюу иргэд, аж ахуй нэгжийн гүйлгээг зогсооход хүргэсэн. Холбогдох зарим банкууд ОХУ-ын Транскапитал банкаар дамжуулан зөвхөн нэн шаардлагатай төлбөр тооцоог гүйцэтгэж байсан боловч Америкийн Нэгдсэн Улсын Сангийн яамны дэргэдэх Гадаад хөрөнгийн хяналтын газар (OFAC)-аас 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн санхүүгийн нэмэлт хориг арга хэмжээ авах шийдвэрийн дагуу Транскапитал банкаар төлбөр тооцоог дамжуулах боломжгүй болсон. Европын холбооны 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн шийдвэрийн дагуу СВИФТ сүлжээнээс Москва Кредит банкийг 2022 оны 6 дугаар сарын 14-ний өдөр хассанаар Монгол Улсаас ОХУ руу хийх иргэдийн төлбөр тооцоо бүрэн зогссон.

Зураг 58. ОХУ-тай холбоотой хориг арга хэмжээ авсан улсууд



Хэрэгжүүлсэн арга хэмжээ, хамтын ажиллагаа:

Монголбанк нь оролцогч талуудаас олон удаагийн давтамжтайгаар мэдээлэл цуглуулж, тэдгээрт дүн шинжилгээ хийн олон улсын эрх бүхий байгууллагуудад холбогдох асуудлаар албан бичиг, захидал хүргүүлж, уулзалт зохион байгуулах замаар онцгой анхаарал хандуулан хамтран ажиллаж ирсэн.

Үүний үр дүнд Монголбанк нь Америкийн Нэгдсэн Улсын Сангийн яамны дэргэдэх Гадаад хөрөнгийн хяналтын газар (OFAC), Английн Сангийн яамны Санхүүгийн хориг арга хэмжээний хэрэгжилтийн газар (OFSI) зэрэг байгууллагаас 2022 оны 5 дугаар сарын 16, 2022 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсаас шилжүүлэг хийхэд төлбөр тооцоог хориг арга хэмжээнд ороогүй байгууллагаар дамжуулан гүйцэтгэх зориулалт бүхий “Монгол Улсын эрчим хүч, энергийн бүтээгдэхүүний төлбөр” ерөнхий лицензийг (General licenses) авсан. Мөн энэ дагуу банкуудад ерөнхий лицензийн талаарх мэдээллийг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.

Манай улсын нефть, шатахууны төлбөр тооцоог гүйцэтгэхэд ОХУ-ын Оросын Бүс Нутгийн Хөгжлийн Банк (Всероссийский банк развития регионов), Росбанк, Газпромбанктай манай банкууд корреспондент харилцаа тогтоож, ностро дансыг тус банкууд дээр нээх албан хүсэлт хүргүүлсэн. Эдгээрээс Росбанк, Газпромбанк тус хүсэлтийг хүлээн авч, дотоодын зарим банкуудын ностро данс нээх үйл ажиллагаа хяналтын шатандaa явагдаж байна.

Монгол Улсаас гадаад гүйлгээг саадгүй дамжуулах, СВИФТ сүлжээнээс гадна нөөц системтэй байх, олон улсад үүссэн геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалж ОХУ руу гүйцэтгэх нэн шаардлагатай бараа, бүтээгдэхүүн тэр дундаа шатахуун, нефтийн бүтээгдэхүүний төлбөр тооцоо саатаж хомдол үүсэх, цаашлаад Үндэсний аюулгүй байдалд сергеөр нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор олон улсын төлбөр тооцооны БНХАУ-ын CIPS систем, Сбер Финлайн систем, ОХУ-ын СПФС системийг судлах ажлыг хийж гүйцэтгэсэн. Эдгээрээс СПФС системийг нэвтрүүлж, суурилуулснаар ОХУ руу хийх төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэх боломжтой талаар тус байгууллагатай холбогдож, техникийн шаардлагыг хүлээн авсан. ОХУ-ын Төв банкнаас нэвтрүүлсэн “Санхүүгийн мессеж дамжуулах систем (Financial messaging system- СПФС)-д 400 гаруй банк, санхүүгийн байгууллага гишүүнээр элссэн ба үүний 23 нь олон улсын банк, санхүүгийн байгууллага байна.

Манай улсын банкуудаас СПФС системд холбогдон төлбөр тооцоогоо гүйцэтгэдэг банк одоогоор бүртгэгдээгүй бөгөөд ОХУ-ын Төв банктай хэрхэн хамтран ажиллах, СПФС системд холбогдоход гарч болох эрсдэл, сүл болон давуу байдал, бусад улсаас манай улсад үзүүлэх нөлөөллийн талаар судлан холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Цаашидын чиг хандлага

ОХУ-тай холбоотой үүссэн геополитикийн нөхцөл байдал нь урт хугацаанд үргэлжлэх төлөвтэй байгаа тул гадаад төлбөр тооцоог саадгүй дамжуулах тогтвортой үргэлжлэх урт хугацааны шийдлийг олж, энэ дагуу Монгол Улсын гадаад харилцааны бодлоготой уялдуулан авч хэрэгжүүлэхэд Монголбанкнаас гадна төрийн бусад байгууллагын оролцоо, шаардлагатай байна. Ингээнээр төрийн болон хувийн хэвшлийн зүгээс нэгдсэн чиглэлийн дагуу хугацаа алдалгүй, үр дүнтэй хариу арга хэмжээг авах боломжтой юм.

Гадаад худалдаа тэлж байна. Энэ оны эхний 6 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 26%-иар буюу 1,884.0 сая ам.доллароор өсөж 9,256.4 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 29%-иар буюу 1,197.0 сая ам.доллароор, импорт 21%-иар буюу 687.0 сая ам.доллароор тус тус өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 510.0 сая ам.доллароор өсөж 1,360.2 сая ам.долларын ашигтай байна.


Энэ оны эхний 6 сард чулуун нүүрс, төмрийн хүдэр, газрын тосны экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс буурч харин зэсийн баяжмал, мөнгөжөөгүй алтны экспортын биет хэмжээ өссөн үзүүлэлттэй байна. Дэлхийн зах зээл дээрх алт, зэс, нүүрс болон газрын тосны үнэ өссөнөөр манай улсын экспортын орлого өмнөх оны мөн үеэс өссөн. Тодруулбал, алт болон нүүрсний дэлхийн зах зээл дээрх үнэ сэргэснээр хилийн дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 1%-иар, 163%-иар тус тус өссөн нөлөөгөөр алтны экспортын орлого 296.0 сая ам.доллароор, чулуун нүүрсний экспортын орлого 1,332.9 сая ам.доллароор тус тус нэмэгдсэн.

Импорт өмнөх оны мөн үеэс 687.0 сая ам.доллар буюу 21%-иар өсөхөд нефтийн бүтээгдэхүүний импорт хамгийн их буюу 306.5 сая ам.доллароор, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 306.1 сая ам.доллароор, аж үйлдвэрлэлийн орц 59.0 сая ам.доллароор, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 10.6 сая ам.доллароор тус тус өссөн нь нөлөөлсөн. Нефтийн бүтээгдэхүүний хувьд хамгийн өндөр өсөлтгэй нь АИ-92, АИ-95 бензиний импорт 155%-иар буюу 158.2 сая ам.доллароор өссөн байна.


Үйлчилгээний дансны алдагдал өсөв. Үйлчилгээний дансны алдагдал 2022 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 149.5 сая ам.доллароор өсөж 861.8 сая ам.долларт хүрсэн.

Ийнхүү алдагдал өсөхөд тээврийн үйлчилгээний зардал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 106.5 сая ам.доллароор өссөн нь голлох нөлөөг үзүүлжээ.

Зураг 59. Барааны гадаад худалдаа



Зураг 60. Үйлчилгээний гадаад худалдаа




Эх сурвалж: Монголбанк

Анхдагч орлогын дансны алдагдал өссөн. Анхдагч орлогын дансны алдагдлын хэмжээ өмнөх оны мөн үеэс 36 хувиар буюу 313.4 сая ам.доллароор өсөж, 1,193.8 сая ам.долларт хүрэхэд хөрөнгө оруулалтын зарлагын өсөлт голлон нөлөөлжээ.

Санхүүгийн данс. Санхүүгийн дансны ашиг 2022 оны эхний 6 сарын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 50% хувиар өсөж, 1,038.6 сая ам.долларт хүрчээ. Үүнд шууд хөрөнгө оруулалтын дансны ашиг 256.9 сая ам.доллароор өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Зураг 61. Санхүүгийн данс



Зураг 62. Гадаад валютын албан нөөц



Эх сурвалж: Монголбанк


Гадаад валютын албан нөөц. 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт төлбөрийн тэнцэл 1,058.0 сая ам.долларын алдагдалтай гарч, гадаад валютын албан нөөц 6 дугаар сарын эцэст 3,097.3 сая ам.доллар болж буурсан. Энэ нь импортын барааны 4.2 сарын хэрэгцээг хангах түвшин юм.

ШИГТГЭЭ 8. Суудлын автомашины импорт


Манай улсын хувьд суудлын автомашины импорт нийт импортын 7 орчим хувийг, хэрэглээний импортын 20 гаруй хувийг эзэлж, жилд дунджаар 400 гаруй сая ам.доллар буюу 1 их наяд гаруй төгрөгийг автомашин худалдан авахад зарцуулж байна.³² Үүнээс сүүлийн 10 жилийн хугацаанд нийтдээ 3.7 тэрбум ам.долларыг зөвхөн суудлын автомашин худалдан авахад зарцуулжээ. Суудлын автомашины импорт 2015 оноос хойш тасралтгүй нэмэгдэж, 2019 онд түүхэн дээд хэмжээнд буюу 70 орчим мянган автомашин импортолж, 420 орчим сая ам.долларыг зарцуулсан байна (Зураг 63). Хилийн хязгаарлалт, хорио цээрийн дэглэмээс шалтгаалан 2020 онд автомашины импорт буурсан ч 2021 оноос эргээд нэмэгдэж, энэ оны эхний 8 сарын байдлаар 396 сая ам.долларын суудлын автомашины импорт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 58 хувиар өссөн үзүүлэлт болж байна. Сүүлийн саруудад хилийн боомтууд дээрх ачаа бараа татан авалтууд нэмэгдэн, чингэлгийн бөөгнөрлүүд багассанаар импорт ийнхүү нэмэгдлээ.

Энэ оны эхний 8 сарын байдлаар суудлын автомашин, түүний сэлбэг хэрэгслүүд хэрэглээний импортын 26 хувь, нийт импортын 8.4 хувийг эзэлж байгаа нь өмнөх 2 жилээс нэмэгдэж, цар тахлын өмнөх үе рүү дөхсөн үзүүлэлт болж байна (Зураг 64).

Зураг 63. Суудлын автомашины импорт
сая ам.доллароор



тоо ширхэээр /мянга/




Эх сурвалж: ГЕГ


Суудлын автомашины импортыг үнийн дүнгээр задлан харвал, 2021 оны байдлаар 100 сая төгрөг хүртэлх үнэтэй автомашин нийт автомашины 95 гаруй хувийг эзэлж байгаа ч үнийн дүнгийн 65 хувийг, харин 100 саяас дээш төгрөгийн үнэтэй автомашин нийт автомашины дөнгөж 4 хувийг бүрдүүлсэн ч үнийн дүнгийн 35 хувийг эзэлж байгаа нь өндөр дүнтэй автомашин худалдан авах сонирхол нь валютын гарах урсгалд ихээхэн дарамт болдгийг харуулж байна (Зураг 65). Түүнчлэн, өмнөх онд 250 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 322 ширхэг автомашин импортоор орж ирсэн ба энэ нь нийт үнийн дүнгийн 8.3 хувийг эзэлж байгаа юм.

³² Сүүлийн 5 жилийн дунджаар

Зураг 64. Нийт импортын задаргаа



Зураг 65. Суудлын автомашины импорт, унийн дүнгээр, 2021 он



Эх сурвалж: ГЕГ

6.2. Хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2022 оны 1 дүгээр улирлын эцэст -41,101.2 сая ам.доллар байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гадаадаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадагш хийсэн хөрөнгө оруулалтаас 41,101 сая ам.доллароор өндөр байна. Гадаад хөрөнгө оруулалтын актив, пассивийн үлдэгдэл болон позицийг Хүснэгт 14-д дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт 14. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц, 2022 оны 1-р улирал, сая ам.доллар

A. ГАДААД АКТИВ	7,272	B. ГАДААД ПАССИВ	48,374
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	848	6. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)	26,934
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт	717	6.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт	14,368
1.2 Бусад хөрөнгө	131	6.2 Бусад хөрөнгө	12,566
2. Багцын хөрөнгө оруулалт	424	7. Багцын хөрөнгө оруулалт	4,331
2.1 Хөрөнгийн хувьцаа	386	7.1 Хөрөнгийн хувьцаа	112
2.2 Өрийн бичиг	38	7.2 Өрийн бичиг	4,219
3. Санхүүгийн дериватив	5	8. Санхүүгийн дериватив	0
4. Бусад хөрөнгө оруулалт	2,676	9. Бусад хөрөнгө оруулалт	17,109
4.1 Худалдааны зээл	601	9.1 Худалдааны зээл	1,048
4.2 Зээл	245	9.2 Зээл	13,865
4.2.1 Төв банк	0	9.2.1 Төв банк	460
4.2.2 Засгийн газар	0	9.2.2 Засгийн газар	5,769
4.2.3 Банк санхүүгийн байгууллага	195	9.2.3 Банк санхүүгийн байгууллага	1,178
4.2.4 Аж ахуйн нэгж	50	9.2.4 Аж ахуйн нэгж	6,458
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	1,830	9.3 Бэлэн мөнгө ба харилцах	2,032
4.4 Бусад актив	0	9.4 Бусад пассив	163

5. Нөөц актив	3,319	В. ПОЗИЦ	-41,101
5.1 Мөнгөжсөн алт	472	10. Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	-26,085
5.2 Зээлжих тусгай эрх	132	11. Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	-3,907
5.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө (цэвэр)	7	12. Санхүүгийн дериватив (цэвэр)	5
5.4 Бэлэн валют ба харилцах	1,596	13. Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	-14,432
5.5 Үнэт цаас	1,111	14. Нөөц актив	3,319
5.6 Санхүүгийн дериватив (цэвэр)	0		
5.7 Бусад нөөц актив	0		

Эх сурвалж: Монголбанк

Гадаад актив. Монгол Улсаас эдийн засгийн харьятат бус этгээдэд оруулсан хөрөнгө оруулалтын дун (актив) 7,272.4 сая ам.доллар байна. Үүний 46%-ийг гадаад валютын албан нөөц, 37%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 12%-ийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 6%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Гадаад пассив. Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дун (пассив) 48,373.6 сая ам.долларт хүрэв. Үүний 56%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 9%-ийг багцын хөрөнгө оруулалт, үлдсэн 35%-ийг бусад хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 53%-ийг буюу 14,367.9 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 47% буюу 12,565.7 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

ШИГТГЭЭ 9. Монгол Улсын корреспондент банкны харилцаа

Дэлхийн банк (World bank), Төлбөрийн болон зах зээлийн дэд бүтцийн хороо (CPMI), Олон Улсын төлбөр тооцооны банк (BIS) зэрэг байгууллагуудаас олон улсын корреспондент банкны харилцаанд гарсан өөрчлөлт, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг судлахад корреспондент банкны харилцаа нь дэлхий дахинаа буурсаар ирсэн байна. Монгол улсын корреспондент банкны³³ харилцаа 2012-2021 оны хооронд нийт 56 гадаад улсын банк харилцаагаа цуцалсан бол 73 банктай шинээр корреспондент харилцааг эхлүүлжээ. Авч үлдсэн болон шинээр эхлүүлсэн корреспондент банкны харилцааг газар зүйн байршилаар авч үзвэл Ази, Евроазийн бүсийн орнуудын банкууд зонхицж байна. Харин АНУ-ын болон Европын холбоонд төвтэй банкууд 2010-2017 онд Монгол улстай ностро дансаа хааж эхэлсэн бөгөөд АНУ-ын банкуудтай шууд корреспондент харилцаагүй болсон байна.

Монгол улсын корреспондент банкны харилцаанд нөлөөлсөн гадаад хүчин зүйлс

Гадаад улсын банкуудын корреспондент банкны харилцаагаа таслах гол шалтгаануудыг судлахад корреспондент банкны дотоод бодлогын дагуу, Монголын зах зээлтэй шууд харилцаа холбоо байхгүй гэж үзсэн, тухайн банкны дотоод эрсдэлийн бодлогын дагуу бүх гадны банк санхүүгийн байгууллагуудын дансыг хаахаар шийдсэн, комплаенсийн хяналт чангач, зардал нэмэгдэж байгаа тул гүйлгээний хэмжээ бага дансуудаа хаасан, эрсдэлийн удирдлагын шийдвэр зэрэг байв.

АНУ дахь банкуудын хувьд мөн дээр дурдсантай адил манай улсын арилжааны банкуудтай харилцаатай байх нь ашиггүй гэж үзсэн, комплаенсийн зардал ёссөн, бизнес стратегийн дагуу, Монголын зах зээлтэй шууд харилцаа холбоо байхгүй учир үйл ажиллагаагаа зогсоо шийдвэр гаргасан, хууль эрх зүй болон хяналт шалгалтын орчин чангарсан зэргээс шалтгаалж корреспондент банкны харилцаагаа цуцалсан байна.

³³ Корреспондент банкны харилцаа гэдэг нь аливаа банкнаас (“корреспондент банк”) өөр банканд (“харилцагч банк”) банкны үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ гэж Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) тодорхойлсон байдаг. Корреспондент банкууд нь “харилцагч банк”-ны хэрэглэгчдийн гүйлгээг боловсруулж, дамжуулдаг бөгөөд корреспондент банк нь эдгээр хэрэглэгчтэй бизнесийн шууд харилцаа холбоо байдаггүй учир корреспондент банкны хувьд үндсэн хэрэглэгч нь “харилцагч банк” болдог.

АНУ дахь санхүүгийн зохицуулагч байгууллагуудын тавьж буй стандарт, шаардлага хатуу бөгөөд түүнд тавих хяналт шалгалт, дагаж мөрдөөгүй нөхцөлд хүлээлгэх хариуцлага, торгууль өндөр байдаг. Үүнээс шалтгаалж АНУ-ын банк санхүүгийн байгууллагууд корреспондент банкны харилцаа тогтоохдоо ФАТФ-ын 40 зөвлөмжтэй харьцуулахад харьцангуй өндөр шаардлага тавих, эрсдэлтэй харилцаанаас зайлсхийх бодлого баримталж байна.

Корреспондент банкны харилцаанд өөр банкны харилцагчийг таньж мэдэх, гүйлгээний эдийн засаг, хууль эрх зүйн үндэслэл, мөнгөний гарал үүслийн талаар хангалттай мэдээлэл олж авах боломж хязгаарлагдмал байдаг тул гүйлгээг эхлүүлж байгаа улс орны МУТС-тэй тэмцэх тогтолцоо, тухайн улсад ихээхэн үйлдэгддэг гэмт хэргийн төрөл, хоригийн хэрэгжилт зэрэг мэдээллийг ашиглан эрсдэлийн үнэлгээ хийж, гүйлгээнд тавих хяналтын цар хүрээг тогтоодог. Иймд олон корреспондент харилцаатай байх нь гүйлгээний хяналтын чанарт нөлөөлж, эрсдэл дагуулах магадлалтай учир дэлхийн өнцөг булан бүрд байгаа банкуудтай корреспондент харилцаа тогтоохын оронд бүсчилсэн хэлбэрт шилжих чиг хандлагыг бий болгож байна. Тухайлбал АНУ-ын банкууд гэхэд Монгол Улсын банктай шууд харилцаа тогтоохын оронд Сингапур, Япон, БНСУ зэрэг хяналтын тогтолцоо өндөр бусад улсын банкуудаар дамжуулан харьцах байдлаар давхар хяналтын тогтолцоонд шилжиж, комплаенсийн зардаа бууруулах, эрсдэлээс зайлсхийх чиг хандлагатай байна.

Монгол Улсын корреспондент банкны харилцаанд нөлөөлсөн дотоод хучин зүйлс

Монгол Улсын хөрөнгийн болон санхүүгийн зах зээл харьцангуй жижиг тул арилжааны банкуудын гадаад гүйлгээний тоо, хэмжээ, цар хүрээ хөгжингүй улсуудтай харьцуулахад маш бага юм. Үүнээс шалтгаалж гадаад улсын банкууд корреспондент банкны харилцаанаас олох ашиг, гарах зардлыг харьцуулахад ашиггүй байна гэж үзэн корреспондент харилцаагаа цуцлах, шинээр тогтоохоос зайлсхийх шийдвэр гаргаж байна. Манай улсын иргэд, аж ахуйн нэгжийн хийж байгаа гадаад төлбөр тооцооны хэмжээ, давтамж харьцангуй бага, АНУ болон Европын Холбооны орнуудын хөрөнгө оруулалттай бизнесийн үйл ажиллагаа бага, мөн гадаадын аж ахуйн нэгжүүд орлогын данс болон үндсэн данснуудаа гадны банкуудад байршуулж байгаа нь Монголын банкуудтай корреспондент банкны харилцаа тогтоох хүсэл, сонирхолыг төрүүлэх түлхцийг бий болгохгүй байна.

Үүнээс гадна гадаад улсын банкууд Монгол улстай бизнес харилцаа тогтоох зорилгоор тэнцвэртэй мэдээлэл олж авахад хүндрэл учирдаг. Харилцан үнэлгээний тайлан, Явцын тайлан гэх мэт эх сурвалжид өмнө тусгагдаж байсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (МУТС)-тэй тэмцэх тогтолцооны сул тал, эрсдэлтэй хучин зүйлсээс хамаарч корреспондент банкны харилцааг таслах, буурах нехцөл шалтгаан болж байсан. ФАТФ-ын саарал жагсаалтаас гарсан, Явцын тайлангаар Монгол Улс техник хэрэгжилтийн 40 зөвлөмжтэй 39-ийг ханган билүүлээд байгаа зэрэг МУТСТ тогтолцоонд гарсан ахиц дэвшүүд нь нэгэнт тасарсан харилцааг буцаан сэргээх хөшүүрэг болж чадахгүй байна. Мөн төрийн болон хувийн байгууллагын мэдээллийн ил тод байдал хангалтгүй, англи хэл дээрх мэдээлэл дутмаг зэргээс шалтгаалан Монгол улсын эрсдэлийг үнэн, зөв үнэлэх, хамтын ажиллагаа эхлүүлэхэд хүндрэл учирдаг байна.

Корреспондент банкны харилцаа муудсанаас гарч буй үр дагавар

Корреспондент банкны харилцаа буурснаар гүйлгээ дамжих банкны тоо нэмэгдэж, иргэдийн хувьд гадаад төлбөр тооцооны хугацаа удаашрах, төлбөр тооцоо хийх зардал нэмэгдэх, санхүүгийн хүртээмж буурах зэрэг олон сөрөг үр дагаврыг дагуулж байна. Банкуудын хувьд корреспондент банкны харилцааг хадгалж авч үлдэх, харилцаа цуцалсан тохиолдолд тус харилцааг нехөх өөр шинэ харилцаа тогтоох зэрэг өндөр хучин чармайлт шаардахуйц саад бэрхшээл, хүндрэлүүд тогтмол тулгардаг.

Түүнчлэн корреспондент банкны харилцаа муудах нь гадаадын хөрөнгө оруулалт татах, гадаад улсын хуулийн этгээд Монгол улсад үйл ажиллагаа явуулах зэрэгт шууд нөлөөлдөг бөгөөд энэ нь цаашлаад гадаад худалдааны тэнцэл, валютын ханш зэрэгт сергөөр нөлөөлөх эрсдэлтэй юм.

Корреспондент банкны харилцааг сэргээхтэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Корреспондент банкны харилцааг сэргээхэд дан Монголбанк эсвэл арилжааны банк ажиллаад үр дүнд хүрэх боломжгүй юм. Харин нийт банкууд, Монголын Банкны Холбоо, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газар болон төрийн бусад байгууллагын уялдаа холбоо, хамтын ажиллагааны үр дүнд урт хугацааны төлөвлөгөөний үндсэн дээр корреспондент банкны харилцааг сэргээх боломжтой. Түүнчлэн дараах асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай болж байна:

- Улс төрийн өндөр түвшний уулзалт, айлчлалын үеэр (голчлон АНУ-тай) болон гадаад улсаас Монгол Улсад суугаа элчин сайд, гадаад улс дахь Монгол Улсын элчин сайдын яамдуудтай хамтран Монгол Улсын санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал, хамтын ажиллагаа, корреспондент банкны харилцааг бэхжүүлэх чиглэлээр яриа, хэлэлцээр хийх, шат дараалалтай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Корреспондент банкны харилцаа тогтоох эсэх нь эрсдэлийн үнэлгээн дээр тулгуурлан гардаг шийдвэр тул мэдээллийн тэнцвэртэй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн байгууллагууд авч хэрэгжүүлэх, эцсийн өмчлөгчийг тогтоохтой холбоотойгоор мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдалд анхаарал хандуулах;
- Төрийн болон хувийн хэвшил хамтран Монгол Улсын санхүүгийн тогтолцооны хяналт шалгалт, стандартыг дээшлүүлэх, зах зээлийг тэлэх, комплайнсын стандартыг бүхий л санхүүгийн байгууллагуудын түвшинд өндөр стандартад бий болгох, МУТСТ тогтолцооны тогтвортой ажиллах зарчмыг үргэлжлүүлэх.

6.3. Монгол Улсын гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өр 2022 оны 1 дүгээр улирлын эцэст 33,893.4 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 5%-иар буюу 1,503.3 сая ам.доллароор нэмэгдсэн. Энэхүү өсөлтөд компани хоорондын зээллэг буюу гадаадын хөрөнгө оруулалттай ААН-үүдийн толгой компаниасаа авсан хөрөнгө оруулагчийн зээл болон худалдааны зээлийн өсөлт голчлон нөлөөлж байна.

Засгийн газрын гадаад өр 97.8 сая ам.доллароор *Xүснэгт 15. Гадаад өрийн үлдэгдэл, сая ам.доллар* буурч 8,374.5 сая ам.долларт, Төв банкны гадаад өр 412.9 сая ам.доллароор өсөж 2,605.2 сая ам.долларт хүрчээ.

Засгийн газрын гадаад өрийн бууралт нь олон улсын зах зээлд арилжаалсан бондыг харьяат арилжааны банкууд эзэмших болсонтой холбоотой бол Төв банкны гадаад өрийн өсөлт нь зээлийн өсөлтөөс шалтгаалжээ.

Үзүүлэлт	3/31/2021	3/31/2022	YoY, %	%*
Нийт гадаад өр	32,390	33,893	5%	100%
Засгийн газар	8,472	8,374	-1%	25%
Төв банк	2,192	2,605	19%	8%
Банк	1,591	1,426	-10%	4%
Богино хугацаат	547	227	-58%	
Үрт хугацаат	1,044	1,199	15%	
Бусад сектор	8,364	8,922	7%	26%
Богино хугацаат	496	1,071	116%	
Үрт хугацаат	7,868	7,851	0%	
Хөрөнгө оруулагч зээл	11,771	12,566	7%	37%

*Нийтэд зээл %

Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээл өнгөрсөн оны мөн үеэс 1,188.1 сая ам.доллароор нэмэгдэж 22,913.7 сая ам.доллар болсон байна.

Банкны салбарын гадаад өр. Банкны салбарын гадаад өрийн үлдэгдэл 2022 оны 1 дүгээр улиралд 1,425.8 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 10%-иар буюу 164.7 сая ам.доллароор буурчээ. Тус гадаад өрийн 76 хувийг урт хугацаат зээл, 10 хувийг оршин суугч бусын харилцах,

хадгаламжийн дансны өглөг, 8 хувийг бонд өрийн бичиг, үлдсэн 6 хувийг богино хугацаат зээл тус тус бүрдүүлж байна.

Бусад (банкны бус) салбарын гадаад өр. Аж ахуйн нэгж, иргэдийн гадаад өр 2022 оны 1 дүгээр улирлын эцэст өнгөрсөн оны мөн үеийн үлдэгдлээс 1,352.8 сая ам.доллароор нэмэгдэж 21,487.9 сая ам.долларт хүрэв. Үүний 58 хувь буюу 12,565.7 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээл байна. Энэ төрлийн зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор урт хугацаатай, ихэнх тохиолдолд хүүгүй олгогддог, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдаг.

VII. САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

7.1. Санхүүгийн салбар

Манай улсын санхүүгийн салбар банк давамгайлсан буюу санхүүгийн системийн нийт активын 90 гаруй хувийг банкны салбар дангаараа бүрдүүлж байна. Банкаас бусад санхүүгийн салбарын үйл ажиллагааны цар хүрээ жилээс жилд нэмэгдэж байгаа боловч банктай харьцуулахад санхүүгийн нийт системд эзлэх хувь харьцангуй бага хэвээр байна (Хүснэгт 16).

Хүснэгт 16. Санхүүгийн салбарын голлох үзүүлэлтүүд /2022 оны 2 дугаар улирлын байдлаар/


Үзүүлэлтүүд	Банк	БСБ	ХЗХ	Даатгал
Актив	40,057.7	2,972.8	291.3	418.5
Өр төлбөр	36,343.3	1,108.5	225.6	215.1
Эзэмшигчдийн өмч	3,714.4	1,864.3	65.7	203.4
Зээлийн өрийн үлдэгдэл	21,872.4	2,293.6	219.3	-
Чанаргүй зээл	2,117.1	149.0	7.0	-
Тайлант үеийн ашиг	201.9	78.6	3.2	3.4
Даатгалын хураамжийн орлого	-	-	-	51.3
Даатгалын нохон төлбөр	-	-	-	26.3

Эх сурвалж: Монголбанк, СЗХ

КОВИД-19 цар тахлын эхэн үед манай улсын эдийн засаг хурдтай агшиж, аж ахуйн нэгж, өрхүүдийн секторт орлого тасалдах, зээлийн эргэн төлөлт доголдож төлбөрийн чадварын хүндрэлд орох нөхцөл байдал үүссэн. Санхүүгийн системийн эрсдэлийн нэгдсэн индексээс харахад 2020 оны эхнээс системийн эрсдэл эрчимтэй нэмэгдсэн бөгөөд үүний 50 гаруй хувийг макро болон гадаад секторын эрсдэл дангаараа бүрдүүлж байв. Иймд санхүүгийн зохицуулагч байгууллагуудын зүгээс иргэд, аж ахуйн нэгжүүдийн өрийн дарамтыг бууруулж, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх зорилгоор шат дараатай арга хэмжээг өргөн хүрээнд авч хэрэгжүүлсний үр дүнд иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадвар тогтвожиж, банк, санхүүгийн системийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэв (Зураг 66).

Харин 2022 оны эхнээс геополитикийн хурцад мал байдлаас шалтгаалан тодорхойгүй байдал нэмэгдэн, дэлхийн эдийн засгийн сэргэлт удааширч эхэлсэн нь Монгол Улсын гадаад сектор, макро эдийн засгийн эрсдэлийг нэмэгдүүлж, санхүүгийн системийн эрсдэлийн нэгдсэн индекс эрчимтэй өслөө. Түүнчлэн БНХАУ-ын “Тэг КОВИД” бодлогоос шалтгаалсан хилийн боомтуудын үйл ажиллагааны доголдол нь мөн экспортыг удаашруулж, төлбөрийн тэнцэл, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөв.

Зураг 66. Санхүүгийн системийн эрсдэлийн нэгдсэн индекс



Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн зохицуулагч байгууллагуудын зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, эдийн засгийг дэмжих бодлогын нөлөөгөөр санхүүгийн зуучлал хэвийн үргэлжиж, банк, санхүүгийн системийн тогтвортой байдал хангагдаж байгаа боловч зохицуулалтын арга хэмжээ хэвийн горимд шилжиж, дэлхийн геополитикийн хурцадмал байдлаас шалтгаалсан сорилтууд үүсж буй өнөөгийн нөхцөлд банк, санхүүгийн системд дараах сорилтууд тулгарч болзошгүй байна. Үүнд:

- Зохицуулалтын арга хэмжээнүүд хэвийн горимд шилжиж байгаатай холбоотойгоор чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх эрсдэлтэй байна. Ялангуяа цар тахлын вирусийн шинэ вариантууд гарч, геополитикийн зөрчил хурцдаж буй нь эдийн засгийн сэргэлтийг удаашруулж, аж ахуйн нэгжүүдийн орлогыг бууруулах, улмаар зээлийн эргэн төлөлтөд хүндрэл учирч, зээлийн чанар муудах, санхүүгийн салбарыг эрсдэл үүсж магадлалтай юм. Тухайлбал активын ангиллын түр хугацааны хөнгөлөлттэй зохицуулалт 2022 оны 4 дүгээр сараас эхлэн хэвийн горимд шилжсэн бол орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн төлбөрийг хойшлуулах хугацаа 2022 оны эцсээр дуусгавар болно. Уул уурхай, боловсруулах, барилгын салбарын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2022 оны 6 дугаар сарын байдлаар хамгийн өндөр буюу харгалзан 34.0 хувь, 22.0 хувь, 15.2 хувьтай байна.
- Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн бүтээгдэхүүний үнийн богино хугацааны савлагаа, цар тахал болон геополитикийн хурцадмал байдлаас шалтгаалсан экспорт импортын тасалдал, хүлээлт, глобал инфляц, шатахууны үнийн өсөлтийн нөлөө зэрэг нь дотоод эдийн засагт сэргөөр нөлөөлж, санхүүгийн салбарт томоохон эрсдэл, эмзэг байдлыг бий болгож байна. Тухайлбал төлбөрийн тэнцэл, зах зээлийн хүлээлт муудах нь ханшийн дарамт, эрсдэлийг нэмэгдүүлж, санхүүгийн долларжилтыг өсгөх нөлөөтэй бол глобал инфляц, шатахууны үнийн өсөлтөөс шалтгаалан дотоодын инфляц нэмэгдэж, санхүүгийн нөхцөл чангараах, санхүүгийн зуучлал хумигдах зэрэг сөрөг үр дагавартай.

ШИГТГЭЭ 10. Хувьцаат компани хэлбэртэй банкны зохицой засаглалын зарчмуудын тухай

Компанийн засаглалын асуудал анх “Левант компани”, “Зүүн энэтхэг компани”, “Хадсоны булан компани” хэмээх хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага бүхий бүтэцтэй компаниуд 16, 17 дугаар зуунд үүсгэн байгуулагдахад бий болсон гэж судлаачид үздэг хэдий ч 1970-1980 онд Америкийн нэгдсэн улс (цаашид АНУ гэх)-ын компаниуд хурдтайгаар өсөн тэлж, гүйцэтгэх удирдлагын нь нөлөө хэт давамгайлсны улмаас тухайн улсын санхүүгийн зохицуулах эрх бүхий этгээд болох “Үнэт цаасны арилжааны хороо”-ноос гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлагыг зохицуулж эхлэх хүртэлх хугацаанд компанийн засаглалыг хууль, журмаар тодорхойлж, зохицой засаглалын хүрээнд дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоож байгаагүй билээ.

АНУ-д 1970 онд компанийн засаглалын асуудал төлөөлөн удирдах зөвлөлийн гүйцэтгэх удирдлагад тавих хяналтын дутмаг байдлаас үүдэн компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөх байдлаар илэрч байсан бөгөөд улмаар “Үнэт цаасны арилжааны хороо”-ноос хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудад төлөөлөн удирдах зөвлөлийнхөө хараат бус гишүүдийн тайланг боловсруулж нийтэлдэг байх, аудитын, нэр дэвшүүлэх болон цалин, урамшууллын хороодыг байгуулах шаардлагыг тус тус тавьж эхэлжээ.


Монгол Улсын хувьд Компанийн тухай хуулийг анх 1999 оны 7 дугаар сарын 2-ны өдөр баталсан боловч уг хуулиар компанийн засаглалтай холбоотой аливаа зохицуулалт хийгээгүй бөгөөд компанийн засаглалын талаар 2000 оноос түлхүү ярилцаж эхэлсэн байdag.

Энэ мөрөөр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас 1999 онд баталж, 2004 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан “Компанийн засаглалын зарчмууд”, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмж, зөвлөгөө, дэлхийн бусад улс орны туршлага, Монгол Улсын онцлог, бодит нөхцөл байдал зэргийг харгалзан Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтооюор “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг баталсан.


Дээрх кодексд компанийн үйл ажиллагааны хэтийн төлөв, төлөвлөгөөг тодорхойлох чиг үүрэг бүхий бодлогын хороо, компанийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий аудитын хороо, компанийн боловсон хүчин, урамшууллын үйл ажиллагааг тодорхойлох чиг үүрэг бүхий боловсон хүчин, хүний нөөцийн хороо, компани дахь аливаа зөрчлийг зохицуулах чиг үүрэг бүхий маргаан шийдвэрлэх хороог төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд байгуулах зэрэг компанийн зохицой засаглалын зарчмуудыг тодорхойлж өгсөн нь Компанийн тухай хуулийн 2011 оны шинэчилсэн найруулга, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 2013 оны шинэчилсэн найруулга батлагдсанаар л зарчмуудыг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл бүрдсэн болно.

Монгол Улсын зохицой засаглалтай холбоотой эрх зүйн түүхэн замналыг Зураг 67, одоогийн хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд баримталбал зохих засаглалын бүтцийг Зураг 68-т тус тус доор харууллаа. Үүнд:

Зураг 67. Монгол Улсын зохицой засаглалтай холбоотой эрх зүйн түүхэн замнал



Зураг 68. Компанийн тухай хуулийн 2011 оны шинэчилсэн найруулгын зохицуулалтаарх хувьцаат компани хэлбэртэй компанийн засаглалын бутэц



Компанийн засаглал гэж тухайн компанийн хэтийн зорилтыг биелүүлэх, мөн гүйцэтгэлд хяналт тавих чиглэл, зорилго бүхий компанийн гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөл болон хувьцаа эзэмшигчид хоорондын харилцааг хэлнэ. Одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын Компанийн тухай хууль болон олон улсын сайн туршилагын дагуу хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилсон зөвлөл төлөөлж, энэхүү төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн нэрийн өмнөөс компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий гүйцэтгэх удирдлагад хяналт тавьж ажиллана.

Аливаа улс орны эдийн засаг ба түүний хөгжил, дэвшилд чухал үүрэг гүйцэтгэдэг банкууд, тэр дундаа системд нөлөө бүхий банкуудын засаглалын зүй зохистой байдал буюу зохистой засаглалын зарчмуудыг тухайн банк болон зохицуулагч этгээдээс сайтар тодорхойлж, хэрэгжүүлэх нь тухайн улсын санхүүгийн салбарын тогтвортой байдалд нэн чухал юм.

Банк нь бусад чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг этгээдтэй харьцуулахад хэт өндөр хөшүүргийн харьцаанд тулгуурлан санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг тул эрсдэлд харьцангуй мэдрэмтгий байдгаас гадна банкны салбарын гүйцэтгэл эдийн засгийн бусад салбар, өсөлтөд материаллаг нөлөө үзүүлдэг. Өөрөөр хэлбэл, иргэд, аж ахуйн нэгжийн хадгалуулсан мөнгөн хөрөнгийг бусдад зээлдүүлэх бизнес загвар бүхий банкны үйл ажиллагаа доголдох тохиолдолд тухайн улсын эдийн засгийн тогтвортой байдалд шууд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй билээ. Иймээс банкны үйл ажиллагааг хянан зохицуулах эрх бүхий этгээдээс зохицуулж, хяналт тавьж ажилладаг.

Базелын банкны хяналт шалгалтын хорооноос банкны зохистой засаглалын дараах 13 зарчмыг тодорхойлж өгсөн. Үүнд:

Зарчим 1. Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТУЗ гэх)-ийн үүрэг, хариуцлага: ТУЗ банкны бизнес стратеги болон зорилт, банкны соёл, засаглал буюу ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлагын хэм хэмжээг тодорхойлох, хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ, эрсдэл, хөрвөх чадварын талаар баримтлах бодлогыг боловсруулж батлах, тэдгээрт тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх зэрэг банкны эрх ашгийг хамгаалж, бизнесийн зорилтын биелэлтийг хангах үүргийг хүлээнэ.

Зарчим 2. ТУЗ бөгөөд түүний гишүүнд тавигдах шаардлага: ТУЗ болон түүний гишүүн үүрэг хариуцлагаа биелүүлэх чадвар бүхий этгээд байх шаардлагатай. Гишүүн тус бүр нь хөрөнгийн зах зээл, эрсдэлийн удирдлага, санхүүгийн шинжилгээ зэрэгт мэргэшсэн байх шаардлагагүй ч хамтдаа тухайн банкийг удирдах, үүрэг хариуцлагаа биелүүлэх чадвар бүхий байх нь зүйтэй.

Зарчим 3. ТУЗ-ийн бүтэц, үйл ажиллагааны зарчим: ТУЗ үйл ажиллагаандаа мөрдлөг болгох зүй зохистой засаглалын бүтэц, зарчим, мөн ашиг сонирхлын зөрчил үүсэх тохиолдолд баримтлах бодлогыг тодорхойлж, түүний биелэлт, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах шаардлагатай. Энэ зорилгоор ТУЗ-ийн дэргэд аудитын, эрсдэлийн, цалин урамшууллын болон бусад шаардлагатай хороодыг байгуулбал зүйтэй.

Зарчим 4. Гүйцэтгэх удирдлага: Гүйцэтгэх удирдлага ТУЗ-ийн удирдлага, хяналт дор ТУЗ-өөс тодорхойлж, баталсан бизнес стратеги, зорилт, мөн эрсдэлийн, цалин урамшууллын талаарх болон бусад холбогдох бодлогод нийцүүлэн банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ТУЗ-д тухай бүр тайлагнан ажиллана.

Зарчим 5. Нэгдлийн засаглал: Банкны нэгдлийн толгой компанийн ТУЗ тухайн нэгдэл болон оролцогч нь болж буй компанийн зохистой засаглалын зарчмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Банкны ТУЗ болон гүйцэтгэх удирдлага аливаа нэгдлийн оролцогч болсноор хүлээх эрсдэлийн талаар мэдлэг мэдээлэлтэй байх нь зүйтэй.

Зарчим 6. Эрсдэлийн удирдлага: Банк хараат бус, үр дүнтэй эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байх нь зүйтэй.

Зарчим 7. Эрсдэлийг үнэлж, хянах: Банкны хүлээсэн эсвэл хүлээж болзошгүй эрсдэлийг нэгдсэн байдлаар болон үйл ажиллагааны нэгж тус бүрээр тогтмол илрүүлэн үнэлж, хянах шаардлагатай.

Зарчим 8. Эрсдэлийн тайлагнай: Банк ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад холбогдох этгээдүүдэд эрсдэлийн талаар тухай бүр тайлагнах тогтолцоотой байх нь зүйтэй.

Зарчим 9. Комплаянс: Банкийг хууль, журмаар тогтоосон шаардлагуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байгаа эсэх, хууль, журамтай холбоотойгоор үүсэж болзошгүй эрсдэлийг үнэлж, тайлагнах үүрэг бүхий ТУЗ-ийн дэргэдэх нэгжтэй байх нь зүйтэй.

Зарчим 10. Дотоод аудит: Банкны дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, засаглалын тогтолцоо, үйл явцын талаар дүгнэлт гаргаж, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад тайлагнах үүрэг бүхий хараат бус нэгжийг байгуулбал зүйтэй.

Зарчим 11. Цалин, урамшуулал: Банкны цалин, урамшууллын бодлого зохистой засаглалын бөгөөд эрсдэлийн удирдлагын зарчимтай нийцтэй байна.

Зарчим 12. Тайлагнай ба ил тод байдал: Банкны зохистой засаглал болон ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа хадгаламж эзэмшигчид, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогчдод ил тод байх нь зүйтэй.

Зарчим 13. Зохицуулагч байгууллагын үүрэг, хариуцлага: Банкыг хянан шалгаж, зохицуулах эрх бүхий этгээд тухайн банканд зохистой засаглалын талаар зөвлөмж гарган хянаж ажиллах нь зүйтэй.

Базэлын банкны хяналт шалгалтын хорооноос гаргасан дээрх зарчмууд нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас баталсан “Компанийн засаглалын зарчмууд”-тай харьцуулахад илүү нарийвчилсан бөгөөд өргөн цар хүрээг хамарсан юм.

Тус хорооноос гаргасан зөвлөмжид дурдсан банкны засаглалын бүтцийг загварчлан хялбаршуулж, Зураг 69-т харууллаа. Үүнд:

Зураг 69. Базелын зөвлөмжсийд дурдсан банкны засаглалын бүтцийг хялбаршуулж, дурсэлсэн байдал (бусад чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг компаниас онцлог хэсгүүдийг цэнхэр өнгөөр тодруулав)




Банкны тухай хуулийн 2021 оны нэмэлт, өөрчлөлтөөр системд нөлөө бүхий банкуудыг нээлттэй хувьцаат компани, бусад банкыг хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах шаардлага, нэг этгээдийн банкны гаргасан хувьцаанаас эзэмшиж болох дээд хязгаар зэргийг тогтоож, банкны ил тод байдал, хяналт хариуцлагын тогтолцоог олон улсын сайн туршлагатай нийцүүлэх чиглэлээр бодлогын томоохон арга хэмжээг авсан. Ийнхүү банкны тогтолцоонд томоохон шинэчлэлүүдийг хэрэгжүүлж байгаа энэ чухал үед банкны салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдыг үнэн зөв, хангалттай мэдээллээр хангаж ажиллахад банкны засаглал болон удирдлагын тогтолцоог сайжруулж, олон улсын стандартад нийцүүлэх бодит хэрэгцээ тулгарч байна. Энэ хүрээнд Монголбанк шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэхийг зорин ажиллаж байна.

Банкны байгууллагын оршин тогтонон үндэс бол түүнд итгэл итгэл билээ. Хөрөнгө оруулагч, харилцагч, хадгаламж эзэмшигчид нэр хүндтэй, ёс зүйн өндөр хэм хэмжээг баримталдаг байгууллагад хөрөнгө, мөнгөө даатган өгөхийг эрмэлздэг тул банкуудын засаглалын шинэчлэлийн асуудал салбарын ирээдүйн хөгжлийг тодорхойлох боломжтой юм.


7.2. Банк бус санхүүгийн салбар

Банк бус санхүүгийн салбарын дунд, урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хөрөнгийн зах зээлийг дэмжих, зах зээлд оролцогч иргэд, аж ахуйн нэгжүүдийг эрсдэлээс хамгаалах зорилгоор авч хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалтын арга хэмжээний үр дүнд шинэ бүтээгдэхүүний тоо нэмэгдэж, хөрөнгийн захын идэвхжил эрчимжиж, гол илтгэгч үзүүлэлтүүд 2022 оны эхний улиралд өндөр түвшинд хүрлээ. Монголын хөрөнгийн бирж дээр хийгдсэн үнэт цаасны арилжааны дүн эрчимтэй тэлж, 2022 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 66.8 хувиар нэмэгдэж, 119.83 тэрбум төгрөгт хүрэв. 2020 оноос эхлэн хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, 2021 оноос эхлэн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг арилжиж эхэлснээр үнэт цаасны арилжаа илүү төрөлжиж байна. Хөрөнгийн захын үнэлгээ мөн эрчимтэй өсөж, 2022 оны эхний улирлын байдлаар 5.38 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 45.56 хувиар өссөн буюу ДНБ-ийн 12.5 хувьд хүрсэн үзүүлэлт болов (Зураг 70).

Зураг 70. Зах зээлийн үнэлгээ



Зураг 71. Даатгалын салбарын нийт хөрөнгө / тэрбум төгрөг/




Эх сурвалж: СЗХ

Даатгалын салбарын нийт хөрөнгө 2022 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өсөж, 418.5 тэрбум төгрөгт хүрсэн нь сүүлийн 5 жилийн мөн үеийн дундаж өсөлт 13.2 хувиас харьцангуй бага байна. (Зураг 71). Даатгалын компаниудын нийт хөрөнгийн 83.5 хувийг ердийн даатгал, 14.3 хувийг давхар даатгал, 2.3 хувийг урт хугацааны даатгал бүрдүүлж байна. Тус улиралд даатгалын нийт хураамж 29.5 хувиар өссөн нь сүүлийн 5 жилийн мөн үеийн дундаж өсөлт 8.5 хувиас ихээхэн өндөр түвшинд хүрээд байна. Үүнд гэнэтийн осол, эмчилгээний даатгал 59.4 хувиар, хөрөнгийн даатгал 32.7 хувиар, авто тээврийн хэрэгслийн даатгал 39.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.


Харин 2022 оны эхний улиралд хохирлын харьцаа (нөхөн төлбөрийн зардал, орлогод тооцсон хураамжийн харьцаа) ердийн даатгалын компаниудын хувьд 66.9 хувь, урт хугацааны даатгалын компанийн хувьд 53.7 хувь байгаа бол хосолсон харьцаа 124.3 болон 107.2 хувьтай байна. Энэ нь даатгалын компаниудын удирдлага, үйл ажиллагааны зардал харьцангуй өндөр байгааг харуулж байна.

Манай улсад банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 529 банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 93.1 хувь буюу 492 нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй. 2022 оны эхний улиралд ББСБ-уудын нийт хөрөнгө 3.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 42.3 хувиар, нийт зээлийн хэмжээ 2.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 61.3 хувиар тус тус өссөн байна. Салбарын нийт харилцагчдын тоо давхардсан тоогоор 4.6 саяд хүрч өмнөх оны мөн үеэс 33.4 хувиар, зээлдэгчдийн тоо 1.5 саяд хүрч өмнөх оны мөн үеэс 2.4 дахин нэмэгдэв. (Зураг 72, Зураг 73)

Зураг 72. ББСБ-ын тоо ба харилцагчид



Зураг 73. ББСБ-ын нийт хөрөнгө ба зээл / тэрбум төгрөг/




Эх сурвалж: СЗХ

Цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, санхүүгийн салбарын нөхцөл байдалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооноос 2019 онд баталсан “ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх шинэчилсэн хуваарь”-ийг 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаагаар түр хойшшуулж, дэмжлэг үзүүлэв. Түүнчлэн “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д нийт 4 удаа өөрчлөлт оруулж, 2021 оныг дуустал сунгасан нь зээлдэгч нарын төлбөрийн дарамтыг бууруулж, ББСБ-ын салбарын зээлийн чанар алдагдахаас сэргийллээ (Зураг 74).

Зураг 74. Зээлийн ЖДХ ба чанар



Зураг 75. ББСБ-ын нийт хөрөнгө /ДНБ, зээл / ДНБ-ий харьцаа




Эх сурвалж: СЗХ

Цахим шилжилтийн эрин үед үйлчилгээний түгээлтийн суваг, хэрэглэгчийн чиг хандлага өөрчлөгддэж, хамгийн хялбараар, түргэн шуурхай санхүүгийн үйлчилгээг нэг дороос авах боломжтой болсон ба санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд бий болж, ББСБ-ын салбар хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийн үйл ажиллагаатай уялдан олон тулгуурт санхүүгийн үйлчилгээ хөгжиж байна. Тухайлбал, 2021 оны эцсийн байдлаар ББСБ-ын нийт харилцагчдын 92.1 хувь нь финтекийн харилцагчид, нийт зээлдэгчдийн 80.2 хувь нь финтекийн зээлдэгчид болоод байна.


Иймд санхүүгийн салбарын кибер аюулгүй байдлыг сайжруулах, одоогийн зохицуулалт, хяналт, шалгалтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, салбарын онцлог, бүтээгдэхүүн, үйлчилгээнд нийцсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгох ажлыг эрчимжүүлэх шаардлага үүсж байна.

Манай улсад 2022 оны эхний улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй 205 хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ) үйл ажиллагаа эрхэлж байна. Нийт гишүүдийн тоо 74,966 хүрсэн бөгөөд салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 4.4 хувь буюу 12.4 тэрбум төгрөгөөр өсөж 291.3 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын 0.73 хувтай тэнцэж байна. Салбарын хэмжээнд нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 14.2 хувиар өсөж 219.3 тэрбум төгрөгт хүрсэн бол хадгаламж өмнөх оны мөн үеэс 0.35 хувиар өсөж, 202.1 тэрбум төгрөгт хүрээд байна. (Зураг 76, Зураг 77).

Зураг 76. ХЗХ-дын тоо ба гишүүд



Зураг 77. ХЗХ-дын салбарын нийт хөрөнгө, хадгаламж /тэрбум төгрөг/



Эх сурвалж: СЗХ

Зураг 78. Зээлийн чанар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: СЗХ

Цаашидын төлөв

Монгол Улсын банкны бус санхүүгийн салбар нь банкны салбартай харьцуулахад бага хувийг эзэлж байгаа боловч үйл ажиллагааны цар хүрээ, санхүүгийн зуучлал жилээс жилд эрчимтэй өсөх хандлагатай байна. Тухайлбал КОВИД-19 цар тахлын нөлөөллөөс үл хамааран ББСБ-ын үйл ажиллагаа эрс идэвхжиж, 2022 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар нийт зээл ба ДНБ-ийн харьцаа өмнөх жилийн мөн үеэс 1.47 нэгж хувиар өсөж 5.27 хувь, нийт актив ба ДНБ-ийн харьцаа өмнөх жилийн мөн үеэс 1.25 нэгж хувиар өсөж 6.83 хувьд хүрээд байна (Зураг 75).

Манай улсын санхүүгийн зах зээл олон улс болон бус нутгийн интеграцад нэгдэн ороогүй, дотоодын хөрөнгийн зах зээлийн хэмжээ бусад Азийн улсуудтай харьцуулахад бага хэвээр, мөн түүний эдийн засагт гүйцэтгэх үүрэг өндөр түвшинд хүрээгүй байгаатай холбоотойгоор олон улсын санхүүгийн зах зээлд гарч буй сөрөг нөлөө, томоохон өөрчлөлт, шок зэрэг нь хөрөнгийн зах зээлд шууд хариу үзүүлдэггүй тул эдгээр нөлөөллөөс шалтгаалах эрсдэлийн түвшин харьцангуй бага байна.

Сүүлийн үед дотоодын зах зээлд хурдацтай шинээр бий болж буй виртуал хөрөнгөтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын орчныг тодорхой болгох шаардлага үүсэж, 2021 оны 12 дугаар сард “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль” батлагдсан. Ингэснээр хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, тэдгээрт учрах санхүүгийн эрсдэлийг бууруулах боломж бүрдсэн ба цаашид үйл ажиллагаанд нь хяналт тавих журам, заавар, эрх зүйн зохицуулалтуудыг илүү нарийвчлан боловсруулж, хяналт шалгалтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай юм.


7.3. Банкны салбарын өнөөгийн байдал, цаашдын төлөв

Банкны салбарт 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 12 банк 1,385 салбар нэгжээр дамжуулан банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг 3.0 сая хадгаламж эзэмшигч, 1.5 сая зээлдэгчид хүргэж байна.


Активын бүтэц, өөрчлөлт

Банкны салбарын нийт активын хэмжээ 2022 оны 2 дугаар улирлын эцэст 42.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны 2 дугаар улирлаас эхлэн “Эдийн засгийг идэвхжүүлэх цогц хөтөлбөр”-ийн нөлөөгөөр банкны системийн зээл олголт нэмэгдэж, Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалт буурах хандлагатай байсан. Ингэснээр тайлант жилийн хугацаанд зээлийн үлдэгдэл 22.4 хувиар буюу 4.3 их наяд төгрөгөөр өссөн бол Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалт 45.5 хувиар буюу 4.5 их наяд төгрөгөөр буурчээ. Харин 2022 оны 2 дугаар улирлын хувьд Төв банкны үнэт цаасан дахь хөрөнгө оруулалт өмнөх улиралтай харьцуулахад нэмэгдсэн байна.

Зураг 79. Активын бүтэц, өөрчлөлт (их наяд төгрөг)



Зураг 80. Жилийн өөрчлөлт (их наяд төгрөг)



Эх сурвалж: Монголбанк


Нийт активыг бүтцээр нь авч үзвэл зээлийн өрийн үлдэгдэл 52.0 хувь, Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалт 12.7 хувь, мөнгөн хөрөнгө 20.2 хувь, Засгийн газрын үнэт цаас дахь хөрөнгө оруулалт 3.8 хувь, бусад хөрөнгө 11.3 хувийг тус тус эзэлж байна.

КОВИД-19 цар тахлын нөлөөлөл банкны системд илрэч эхэлсэн 2020 оны 1 дүгээр улиралтай харьцуулахад зээлийн нийт активт эзлэх хувь 2022 оны 2 дугаар улирлын эцэст 6.7 нэгж хувиар өссөн бол Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалт 0.8 нэгж хувиар буурсан буюу активын бүтэц дэх зээлийн эрсдэл цар тахлын өмнөх үеэс нэмэгдсэнийг харуулж байна.

Зээл, түүний өөрчлөлт

Банкны салбарын зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны 2 дугаар улирлын байдлаар 23.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 22.4 хувиар буюу 4.3 их наяд төгрөгөөр, оны эхнээс 12.4 хувиар буюу 2.6 их наяд төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтийг зээлдэгчийн төрлөөр задлан үзвэл, 14.4 нэгж хувь буюу 2.7 их наяд төгрөгийн өсөлтийг иргэдийн зээл, 8.0 нэгж хувь буюу 1.6 их наяд төгрөгийн өсөлтийг байгууллагын зээл тус тус бүрдүүлсэн байна.


Зураг 81. Зээлийн үлдэгдэл, түүний өөрчлөлт (их наяд төгрөг, %)



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн өрийн үлдэгдлийг эдийн засгийн салбарын ангиллаар өмнөх оны мөн үтэй харьцуулахад худалдааны салбарын зээл хамгийн өндөр буюу 33.8 хувийн өсөлт үзүүлсэн бол зээлийн өсөлтийн дүнгээр хэрэглээ, өрхийн аж ахуйн зээл хамгийн өндөр буюу 1.9 их наяд төгрөгийн өсөлт үзүүлсэн байна.

Зураг 82. Эдийн засгийн голлох салбаруудын зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөг), нийт зээлд эзлэх хувь, зээлийн жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн чанар


Энэ оны хагас жилийн байдлаар нийт зээлийн 85.7 хувь буюу 20.1 их наяд төгрөгийн зээл хэвийн ангилалд, 6.1 хувь буюу 1.4 их наяд төгрөгийн зээл анхаарал хандуулах ангилалд, 8.2 хувь буюу 1.9 их наяд төгрөгийн зээл чанаргүй ангилалд тус тус ангилагдаж, төлбөрийн зөрчилтэй нийт зээлийн дун 3.3 их наяд төгрөгт хүрсэн байна.

Банкны системийн хэмжээнд чанаргүй зээлийн харьцаа тайлант улиралд 8.2 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар буурсан, КОВИД-19 цар тахлын банкны системд үзүүлэх нөлөөлөл эхлэхээс өмнөх үе буюу 2020 оны 1 дүгээр улирлаас 0.5 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чанаргүй зээлийн харьцаа буурч, цар тахлын өмнөх үеийн хэмжээнд хүрсэн нь Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээ болон “Эдийн засгийг идэвхжүүлэх цогц хөтөлбөр”-ийн нөлөөлөл бөгөөд чанаргүй зээлийн харьцаа буурсан нь банкны системийн зээлийн эрсдэл буурснаас илүүтэйгээр нийт зээлийн өсөлтөөр голчлон тайлбарлагдаж байна.

ШИГТГЭЭ 11. Банкны харилцагчдын сэтгэл ханамжийн судалгаа

Дэлхийн ихэнх хөгжиж буй орнуудад банкны салбарын харилцагчийн сэтгэл ханамжийн судалгааг хийж банкны салбарын хөгжил дэвшил тухайн цаг үетэйгээ хэрхэн нийлж буй эсэхийг үнэлж дүгнэн цаашид хөгжүүлэх шаардлагатай зүйлсийг тодорхойлж ажилладаг. Арилжааны банкуудын иргэдэд санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд харилцагчийн хүлээлтэд хэр нийцж байгааг тодорхойлох зорилгоор тус судалгааг³⁴ хийж гүйцэтгэлээ.

Зураг 83. Сэтгэл ханамжийн түвшин




Эх сурвалж: Statista, bank customer satisfaction worldwide, 2021

Сэтгэл ханамжийн түвшин гэдэг нь харилцагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээг авах үед хүлээлтэд хэр хүрч байгааг тодорхойлдог. Судалгааны үр дүнд Монгол Улсын арилжааны банкуудаар үйлчлүүлдэг иргэдийн банкны үйл ажиллагаанд өгч буй сэтгэл ханамжийн түвшин 76.1% гарсан нь дэлхийн дундаж үзүүлэлттээс 2.7%-иар бага байна. Япон, Франц зэрэг өндөр хөгжилтэй орнуудын иргэд банкаар үйлчлүүлэхдээ өндөр шаардлага тавьдаг тул сэтгэл ханамжийн түвшин нь доогуур байхад Энэтхэг улсын иргэд хүлээлт багатайгаар банкаар үйлчлүүлдэг учраас сэтгэл ханамж нь өндөр гарахад нөлөөлжээ. Харилцагчид банкны зээл, хадгаламжийн бүтээгдэхүүний нөхцөлүүдийн уян хатан биш байдал, салбар тооцооны төвөөр биелэн очиж үйлчлүүлэхэд болон банкны мэдээлэл хүргэлтэд харьцангуй сэтгэл дундуур³⁵ байлаа.

³⁴ Судалгааг Банк санхүүгийн академи, Германы Шпаркассэ банкны Монгол дахь сан, Монголын банкны холбоо хамтран гүйцэтгэв. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлоходо олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга зүй болох ServQual загварыг ашиглан тоон судалгааны нэгдсэн арга зүйд тулгуурлалаа. Судалгааны түүвэрт банк санхүүгийн салбарт ажилладаггүй, сүүлийн гурван сар банкаар очиж үйлчлүүлсэн, 20-70 насны харилцагч байх гэсэн шалгуур хангасан нийт 750 харилцагчыг хамруулсан.

³⁵ Судалгааны асуултгыг 2022 оны 3-р сарын 1-ээс 4-р сарын 10-ны хооронд авсан.

Зураг 84. Бүлэг тус бүр дээрх сэтгэл ханамжийн түвшин



Судалгааны үр дүнгүүдээс дурдахад судалгаанд оролцогчдын турван хүн тутмын нэг нь сүүлийн нэг жилийн хугацаанд банкнаас зээл авчээ. Эдгээр харилцагчдын хувьд банкнаас зээл авах явцад банкны ажилтнууд тухайн зээлтэй холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөхөд нь дуртай байдаг гэжээ. Гэвч зээлийн үйлчилгээний нөхцөлд сэтгэл дундуур байгаа нь ийм үр дүнд хүргэжээ. Иймд зээлийн үйлчилгээний хүү, нөхцөлийг эргэн харах, зээлийн ажилтны харилцаа, зөвлөгөө өгөх чадварыг сайжруулах шаардлагатай гэдэг нь судалгааны явцад ажиглагдлаа.

Хадгаламжийн үйлчилгээнд сэтгэл дундуур байхад инфляцын өсөлт болон хадгаламжийн хүү бага байгаа нь голчлон нөлөөллөө. Гэвч иргэдийн хувьд хадгаламжийн үйлчилгээг зайнаас, онлайнаар авахыг хамгийн их чухалчилсан үр дүнг харууллаа.


Сүүлийн жилүүдэд банкны бүтээгдэхүүн үйлчилгээнд дижитал шилжилтүүд хийгдэж байгаа ч иргэд банкны салбараар үйлчлүүлсэн хэвээр байна. Судалгаанд оролцсон харилцагчдын 60% нь сүүлийн 6 сард банкны салбар тооцооны төвөөр үйлчлүүлжээ. Банкны салбар, тооцооны төвийн нэг ажилтанд оногдож буй харилцагчийн тоо их, үйлчилгээний дараалал их, үйлчилгээний харилцааны ур чадвар зэрэг нь хүлээлтээс доогуур байгаа нь иргэдийн сэтгэл ханамжийг бууруулахад нөлөөлжээ.

Банкны мэдээлэл хүргэлт гэсэн үзүүлэлт бусад үзүүлэлтээс хамгийн бага гарлаа. Судалгаанд оролцогчдын 50% нь банкны мэдээлэл хүргэлттэй холбоотой асуултад мэдэхгүй гэж хариулжээ. Энэ нь нэг талаас иргэдийн санхүүгийн боловсрол сүл банкнаас өгч буй мэдээ мэдээллийг бүрэн гүйцэт ойлгодоггүй, нөгөө талдаа банкууд иргэдэд тохирсон энгийн үг хэллэг бүхий мэдээллийг хүргэдэггүй байх талтай.

Иймд банкууд харилцагч нартаа санхүүгийн суурь мэдлэгийг олгох, харилцагч бүрийн хэрэгцээнд тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох мэргэжлийн зөвлөх үйлчилгээг нэвтрүүлэх шаардлагатай байна. Ингэснээр олон нийтийн санхүүгийн боловсрол дээшилж, улмаар харилцагчдын сэтгэл ханамжийн түвшин сайжрах боломжтой юм.

Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээ 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон бөгөөд банкууд тайлант улирлаас эхлэн зээлийн ангиллыг хэвийн горимын дагуу хийж байна.


Зураг 85. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөг), тэдгээрийн нийт зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарын анхаарал хандуулах зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар буюу 194.3 тэрбум төгрөгөөр буурсан бол чанарагүй зээлийн үлдэгдэл 5.9 хувиар буюу 107.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. Эргэн төлөлтийн зөрчилтэй зээлийг эдийн засгийн салбараар авч үзвэл, өмнөх оны мөн үе болон оны эхэн үетэй харьцуулахад уул, уурхайн болон боловсруулах үйлдвэрийн салбарын зээлийн чанар муудсан байна.

Зураг 86. Тухайн салбар дахь чанарагүй болон анхаарал хандуулах зээлийн хувь



Эх сурвалж: Монголбанк


Эх үүсвэрийн бүтэц, өөрчлөлт

Банкны салбарын нийт эх үүсвэр 2022 оны 2 дугаар улиралд 37.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар буюу 1.3 их наяд төгрөгөөр өссөн. Харилцах дансны үлдэгдэл 1.4 их наяд төгрөг буюу 18.0 хувиар, банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 1.9 их наяд төгрөгөөр буюу 38.6 хувиар өссөн нь эх үүсвэрийн өсөлтийг голчлон тайлбарлаж байна. Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлтийн дийлэнх буюу 63.1 хувийг Монголбанкаас татсан эх үүсвэр бүрдүүлж байна.


Хадгаламжийн дансны үлдэгдэл 2.0 их наяд төгрөг буюу 9.9 хувиар буурсан бөгөөд төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.2 хувиар, валютын хадгаламж 2.3 хувиар тус тус буурсан байна. Ийнхүү хадгаламжийн дансны үлдэгдэл буурсан шалтгаан нь хугацаагүй хадгаламж 34.1 хувиар буурч 3.6 их наяд төгрөгт хүрсэн буюу “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуульд заасны дагуу хугацаагүй хадгаламжид хүү тооцохгүй болсонтой холбоотойгоор хугацаагүй хадгаламж болон харилцах дансны хоорондох шилжилт хөдөлгөөн нэмэгдсэнээр тайлбарлагдаж болохоор байна.

Харин харилцах дансны үлдэгдлийн өсөлтийн 42.5 хувийг иргэд, хувийн хэвшлийн харилцах бүрдүүлж байгаа бол 57.4 хувийг төсвийн байгууллагын харилцах бүрдүүлж байна.

Зураг 87. Эх үүсвэрийн бүтэц, өсөлт (их наяд төгрөг)



Зураг 88. Жилийн өөрчлөлт (их наяд төгрөг)



Эх сурвалж: Монголбанк

Нийт эх үүсвэрийг бүтцээр нь авч үзвэл, банкны салбарын нийт эх үүсвэрийн 48.7 хувийг хадгаламж, 25.0 хувийг харилцах, 17.8 хувийг банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, үлдэх 5.6 хувийг банкнаас дотоод, гадаадын зах зээл дээр гаргасан үнэт цаас, төслийн санхүүжилт зэрэг бусад төрлийн эх үүсвэрүүд бүрдүүлж байна.

7.4. Банкны салбарын эрсдэл даах чадвар

Банкны системийн хэмжээнд нэгдүгээр зэрэглэлийн болон нийт өөрийн хөрөнгийн харьцаа тус бүр 15.5 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохицой харьцааны шаардлагаас харгалзан 6.5 болон 3.5 нэгж хувиар өндөр байна. Мөн хөрвөх чадвар сайтай активыг нийт өр төлбөрт харьцуулдаг төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт 35.5 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон доод хязгаараас 10.5 нэгж хувиар өндөр байна.

Банкны салбар 2022 оны 2 дугаар улирлын байдлаар 358.8 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад банкны системийн нийт орлого 22.1 хувиар, нийт зардал 3.6 хувиар тус тус өссөн байна.

Гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүсэж болох алдагдлыг банкны эрсдэл даах чадвартай уялдуулах зорилгоор тэдгээрийн гадаад валютын авлага, өглөгийн зөрүү нь өөрийн хөрөнгө буюу эрсдэл даах эх үүсвэрийн +/-30 хувиас хэтрэхгүй байх зохицой харьцааг Монголбанкнаас мөрдүүлдэг бөгөөд 2022 оны 06 дугаар сарын байдлаар энэ үзүүлэлт нь -7.5 хувь байна.

ШИГТГЭЭ 12. Банкны зээлийн шимтгэлийн талаарх судалгаа

Энэхүү судалгаагаар зээлийн шимтгэл хураамжийг яагаад авдаг талаар, манай улстай ижил төстэй орнуудад зээлийн үйлчилгээний шимтгэлийг хэрхэн ямар хэмжээнд авч байгаа, зээлийн шимтгэл хураамжийг авахгүй байх нь зээлийн хүүд хэрхэн нөлөөлдөг талаар харьцуулан судлахыг зорилоо.

Банкууд нь зээлдэгчээс зээлийн хүсэлт авах, зээл хүсэгчийн мэдээллийг шалгах, судлах, тухайн харилцагчийн зээлийн үнэлгээ хийх, баталгаажуулах зэрэг биет болон биет бус зардууд зээл олгох явцад гардаг ба энэхүү зардуудыг нөхөн шаардлагатай тулгардаг. Иймд банкууд өөрсдийн болон зээлдэгчдийн онцлог, зээлийн хэмжээнээс шалтгаалан шимтгэлээ өөр өөр тогтоодог ба ихэнх тохиолдолд 1% байгаа нь харагдаж байна. Зээлийн шимтгэлийг нарийвчлан тооцох олон төрлийн аргачлал байдгаас хамгийн түгээмэл ашигладаг нь тухайн зээлдэгчийн кредит скоринг оноо юм. Харилцагчийн кредит скоринг сайн байх тутам илүү бага шимтгэл төлдөг бол муу байх тутам илүү их шимтгэл төлдөг.

Хүснэгт 17. Зээлийн шимтгэл, хүү, инфляцын хэмжээ, сонгосон улсуудаар

Улс	Зээлийн шимтгэл (%)	Зээлийн хүү (%)	Сүүлийн 3 жилийн дундаж инфляц (%)
АНУ	0.65	15	3
Канад	1	18	2
Австрали	0.3	12	1.8
Филиппин	0.5	27	4
Вьетнам	0.95	8	4
Монгол	0.75	17	7
Камбож	1	18	5
Киргизстан	0.75	26	15
Тажикстан	0	22	15
Узбекистан	0	30	9
Энэтхэг	1	13	6
Мьянмар	1.2	15	8
Индонез	1	10	4

АНУ-д зээл олголтын шимтгэл 2009 оны эдийн засгийн хямралын үеэс өмнө зээлийн хэмжээнээс хамааран 4-5 хувийн шимтгэл төлдөг байжээ. Хямралын дараагаар АНУ-ын засгийн газар банк харилцагч (орон сууцны зээлдэгч)-аас нийт зээлийн дүнгийн 1 хувиас дээш хэмжээгээр авахыг хориглосон.

Сонгон судалсан улсууд³⁶ нь зээл олгоходо кредит скоринг оноог ашиглан харилцагчийн зээлийн хэмжээг тооцоолдог бөгөөд зээлийн кредит скорингоос хамааран шимтгэлийн хэмжээ нь 0.1-1 хүртэл хувь байна. Филиппин, Мьянмар улсуудын хувьд зээлийн шимтгэл нь 0.5 хувь хэдий ч зээлийн шийдвэр гарсан тохиолдол харилцагчаас тэмдэгтийн хураамж хэмээн зээлийн дүнгээс үл хамааран 4\$ тутамд 0.02\$-ийг суутган авдаг. Тажикстан, Узбекистан улсуудын хувьд зээлийн шимтгэл авдагтүй боловч зээлийн хүү бусад улсуудтай харьцуулах харьцангуй өндөр байна.

Харин дээрх улсуудын банк, санхүүгийн зах зээлийг зохицуулсан хууль тогтоомжид зээлийн шимтгэлийг нарийн зохицуулсан дүрэм, журам байхгүй байлаа. Тухайлбал сонгосон улсуудад зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй арилжааны банкууд нь өөрсдийн дотоод, журмын хүрээнд зээлийн шимтгэлийг тооцоолон харилцагчдад санал болгодог. Мөн ил тод байдлын тухай эрх зүйн зохицуулалт байх бөгөөд үүнд тусгаснаар бол банкууд үйлчилгээний шимтгэл, хураамжийг ил тод байршуулдаг. Харин кредит скоринг ашиглан тооцож буй бол зээлийн шимтгэлийн талаарх мэдээллийг харилцагчдад мэдэгдэн харилцан тохиролцсоны хүрээнд тооцдог байна.

³⁶ 1 хүнд ногдох ДНБ-ний хэмжээгээр Монгол Улстай адил орнуудыг сонгосон харууллаа. Түүнчлэн өндөр хөгжилтэй зарим орнуудыг орууллаа.

Манай улсын банкууд зээлийн төрлөөс хамааран 1 хүртэл хувийн шимтгэл авдаг нь ижил төрлийн эдийн засгийн хөгжилтэй улсуудтай харьцуулахад ижил түвшинд байгаа нь харагдлаа. **Мөн зээлийн хүсэлт өгсөн харилцагч бүрээс зээлийн шимтгэл авдаггүй зөвхөн зээлийн шийдвэр гарсан тохиолдолд зээлийн хэмжээнээс хамааран харилцагчаас зээлийн шимтгэл авч байна.** Түүнчлэн тэмдэгтийн хураамж, зээл урьдчилан төлсний шимтгэл, зээлийн шийдвэр гаргасны төлбөр зэрэг олон төрлийн шимтгэл хураамж авдаггүй.

Банк, санхүүгийн зах зээл өндөр хөгжсөн АНУ, Канад, Австрали зэрэг улсуудад зээлийн шимтгэл харьцангуй өндөр байна. Санхүүгийн зах зээл хөгжихийн хэрээр банкны үйл ажиллагаа, үйлчилгээ улам нарийн болж үүнийг дагаад олон нэр төрлийн шимтгэлийг харилцагчаас авдаг. Зээлийн шимтгэлээс гадна харилцагчаас тэмдэгтийн хураамж, зээл цуцалсны төлбөр, зээлийн данснаас заасан хугацаанд зээлээ аваагүйн шимтгэл зэрэг маш олон төрлийн шимтгэл хураамжийг авч байна. Мөн зарим улсуудын хувьд зээлийн шимтгэл 0 гэсэн боловч зээлийн хүү нь жилийн 30 орчим хувьтай байгаа нь ихээхэн сонирхол татлаа. Манай улсын хувьд зээлийн хүсэлт ирүүлсэн харилцагч бүрээс зээлийн шимтгэл авдаггүй бөгөөд зээлийн шийдвэр гарсан харилцагчаас л зээлийн шимтгэлийг авдаг байна. Бусад улсуудын хувьд зээлийн хүсэлт өгөхөөс эхлээд шимтгэл, хураамжийг төлдөг.

Сонгосон улсуудын хувьд зээлийн шимтгэлийн хэмжээг зохицуулсан эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Харин Төв банкны зүгээс зээлийн хүү болон шимтгэлийг харилцагчдад ил тод байлгахыг шаарддаг. Зээлийн шимтгэлийн талаарх онолын судалгаануудаас харахад зээлийн хүү болон шимтгэл нь хоорондоо урвуу хамааралтай болох нь харагдаж байна³⁷. Өөрөөр хэлбэл зээлийн шимтгэлийг тодорхой хэмжээнд барих эсхүл зээлийн хүүд банкны зээл олгохтой холбоотой үйл ажиллагааны зардлыг шингээх гэсэн 2 төрлийн сонголтоос нэгийг нь хийдэг байна. Тиймээс онолын хувьд банкны бүхий л төрлийн үйл ажиллагаанд шимтгэл, хураамжийг оруулан хүүгийн бус орлогыг нэмэгдүүлэх замаар хүүгийн зардлыг бууруулах боломжтой байдаг. Нөгөө талаас зээлийн хүүг нэмэгдүүлэх замаар зээлийн шимтгэлийг бууруулах цаашлаад байхгүй болгох боломжтой боловч харилцагчийн хувьд энэ нь илүү санхүүгийн хувьд хохиролтой юм. Учир нь зээлийн хүүгийн төлбөр нь урт хугацаанд хуримтлагдан харилцагчаас зээлийн эхэнд төлөх байсан нэг удаагийн шимтгэлээс их төлбөр авах боломж бүрддэг.

Банкны салбарт тулгамдаж буй эрсдэл

Зээл олголт саарч байна

Банкны системийн хэмжээнд зээлийн өрийн үлдэгдэл өмнөх улирлаас 6.1 хувиар өссөн бол тайлант улирлын 6 дугаар сард банкууд зээл олголтыг хязгаарлаж, зээлийн өсөлтийн хурд саарснаар өмнөх сараас ердөө 0.6 хувь буюу 143.8 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь тайлант улирлын эхний хоёр сарын өсөлтийн дунджаас 2.2 нэгж хувиар бага үзүүлэлт. Банкууд Монголбанкнаас мөрдүүлдэг зохистой харьцааны шаардлага үзүүлэлтүүдийг банкууд хангаж, зээл олгох боломжит эх үүсвэртэй хэдий ч бодит эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөр банкны зээлийн эрсдэл нэмэгдэж байгаа нь банкны зээл олголт саарах хүчин зүйл болж байж болзошгүй юм.

КОВИД-19 цар тахал банкны салбарын зээлийн чанарт сөргөөр нөлөөлсөн хэвээр байна

Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь цар тахлын өмнөх үеийн хэмжээнд хүрсэн ч цар тахлаас үүдэн БНХАУ-аас тогтоосон хилийн хоригийн үр дагавар Монгол улсын уул уурхайн салбарт сөргөөр нөлөөлсөн хэвээр байна. Ихэнх салбаруудын чанаргүй зээлийн хувь 2022 оны 2 дугаар улирлын байдлаар буурсан ч уул уурхайн салбарын чанаргүй зээлийн жилийн өөрчлөлт нь 47.1 хувиар нэмэгдсэн буюу өмнөх оны мөн үеийн өсөлттэй харьцуулахад 13.2 нэгж хувиар өсжээ.

Банкны салбарын хөрвөх чадвар сайтай активын хэмжээ өндөр хэвээр байна.

³⁷ Laetitia Lepetit et al, *The expansion of services in European banking: Implications for loan pricing and interest margins*, Aurora Ferrari et al, 2018. *Interest rate caps-theory and the practice*. Caner Gerek, 2017. *The effects of fees and commissions on loan pricing and profitability: Theoretical evidences*,

Цар тахлын нөлөөгөөр банкууд эрсдэлээ бууруулж, эрсдэл багатай үнэт цаасан дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж байсан ч “Эдийн засгийг идэвхжүүлэх хөтөлбөр”-ийн үр дүнд Төв банкны үнэт цаасан дахь хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс эхлэн тасралтгүй буурсан. Гэвч тайлант улиралд банкууд зээл олголтыг хязгаарласнаар Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалтад өсөлт ажиглагдаж эхэллээ.

Банкны систем дэх түргэн борлогдох активын хэмжээ 2022 оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 3.4 их наяд төгрөг буюу 22%-иар буурсан үзүүлэлттэй гарлаа. Ингэснээр банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.3 нэгж хувиар буурч 35.5 хувьд болсон хэдий ч зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээс даруй 10 нэгж хувиар өндөр хэвээр хадгалагдаж байна.

VIII. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН МӨНГӨНИЙ БОЛОН МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭНҮҮД


8.1. КОВИД-19 цар тахлын эдийн засагт нөлөөлсөн сувгууд

КОВИД-19 цар тахал нь Монгол Улсын эдийн засаг, банк, санхүүгийн салбарт эхэндээ 1) төлбөрийн тэнцлийн, 2) орлогын болон 3) зээлийн сувгуудаар дамжин нөлөөлөв (Зураг 89).

1. Төлбөрийн тэнцлийн суваг

Цар тахлаас шалтгаалан 2020 оны эхний хагаст Монгол Улсын экспортын голлох түүхий эдүүд, металлын үнэ унаж, БНХАУ-тай хиллэдэг хилийн боомтууд хаагдсанаар нүүрс, газрын тосны экспорт тасалдаж, гадаад худалдаа, төлбөрийн тэнцлийн алдагдал өсөв. Тухайлбал, металлуудын үнэ 17 орчим хувиар, түүхий нефтийн үнэ 40 орчим хувиар унаж, худалдааны нөхцөл муудав. Үүнээс шалтгаалан экспортын орлого унахын зэрэгцээ хөрөнгийн гадагшлах урсгал бий болж, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш унаж эхлэх хандлага ажиглагдсан. Харин 2020 оны сүүлийн хагасаас дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлд таатай өөрчлөлтүүд гарч, эрдэс түүхий эдүүдийн үнэ эргээд сэргэж эхэлснээс гадна БНХАУ-ын эдийн засгийн өсөлт өндөр түвшинд хадгалагдаж, гадаад эрэлт нэмэгдсэнээр манай улсын гадаад худалдааны тэнцэл ашигтай гарахад эргээр нөлөөлөв. Урсгал дансны алдагдал буурч, хөрөнгө оруулалтууд өссөн нь төлбөрийн тэнцэл 2020 онд 786.7 сая ам.долларын ашигтай гарахад нөлөөлөв. Гэвч экспортын голлох эрдэс бүтээгдэхүүнүүдийн үнэ өссөн боловч БНХАУ-ын “Тэг КОВИД” бодлогоос шалтгаалан хилийн боомтууд хэсэгчлэн болон бүрэн хаагдсанаар экспорт удааширч, урсгал тэнцлийн алдагдал тэлснээр төлбөрийн тэнцэл 2021 онд 221.6 сая ам.доллар, 2022 оны эхний хагаст 1058.0 сая ам.долларын алдагдалтай гарав.

Зураг 89. КОВИД-19 цар тахлын эдийн засаг, санхүүгийн салбарт нөлөөлөх сувгууд




Эх сурвалж: Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлан-2020

Зураг 90. Худалдааны нөхцөлийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: YСХ, ГЕГ

Зураг 91. Гадаад худалдааны тэнцэл (гэрээний үнээр, сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк, ГЕГ

2. Орлогын суваг

2020 оны эхнээс Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого буурч, төсвийн алдагдлыг нэмэгдүүлэв. КОВИД-19 цар тахал, түүнээс сэргийлэх хорио цээрийн арга хэмжээний нөлөөгөөр эдийн засгийн идэвхжил саарч, нүүрс, газрын тосны экспорт буурч, барааны импортоос орох татварын орлого буурсан зэрэг нь төсвийн орлого буурахад нөлөөлөв.

Цар тахлын улмаас үйл ажиллагаа эрхлээгүй, түр болон бүрэн зогсоосон ААН, байгууллагын тоо 2020 онд өмнөх оны мөн үеэс 12 мянгаар, 2021 онд 27 мянгаар нэмэгдсэн нь сүүлийн 10 жилийн


хамгийн өндөр үзүүлэлт болов (Зураг 92). Үүнээс худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах салбарт үйл ажиллагааны доголдол их байсан буюу бусад салбаруудтай харьцуулахад эдгээр салбарт хамгийн олон тооны аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа түр эсвэл бүрэн байдлаар зогсоод байв (Зураг 93).

Зураг 92. Бизнес, регистрийн санд бүртгэлтэй ААН, байгууллагын жилийн өөрчлөлт (мянга)



Эх сурвалж: YCX

Зураг 93. Үйл ажиллагаа эрхлээгүй, түр, бүрэн зогсоосон ААН, байгууллагын тоо (мянга)



Эх сурвалж: YCX


Түүнчлэн цар тахлаас үүдэн өрхүүдийн орлого буурсантай холбоотойгоор банкуудын зээлийн нөхцөлийг сулруулах, хугацааг хойшлуулах хүсэлт, шаардлага нэмэгдсэн. ААН-үүдийн орлого буурч, аялал жуулчлал, боловсрол, зочид буудал, нийтийн хоол болон тээвэр, агуулахын үйлчилгээний салбар дахь ААН-үүд цар тахлын нөлөөнд хамгийн их өргтсөн байна. Тухайлбал аж үйлдвэрийн салбарын ААН-үүдийн борлуулалт 2020 оны эхний хагаст 7.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 30.3 хувиар буурсан. Үүний дотор уул уурхай, олборлох салбарын борлуулалт 39.0 хувиар, боловсруулах салбарын борлуулалт 15.6 хувиар тус тус буурав. Харин 2021 оны тус хугацаанд аж үйлдвэрийн салбарын ААН-үүдийн борлуулалт 63.7 хувиар нэмэгдэж, эрчимтэй сэргэсэн болно. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулалт 79.6 хувиар, боловсруулах салбарын борлуулалт 40.6 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Зураг 94. Ажиллах хүчиний оролцоо, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: YCX

Зураг 95. Нэрлэсэн, бодит цалингийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: YCX


КОВИД-19 цар тахал нь хөдөлмөрийн зах зээлд хүчтэй сөрөг нөлөөг үзүүлсэн. Цар тахал эхэлснээс хойш ажиллах хүчиний оролцоо буурсаар 2021 оны 1 дүгээр улиралд 54.9 хувьд хүрсэн нь сүүлийн 15 жилийн хамгийн бага үзүүлэлт болов. Ажилгүйдлийн түвшин цар тахлын эхэн үеэс нэмэгдсээр 2021 оны 1 дүгээр улиралд 8.8 хувьд хүрсэн (Зураг 94).

Улсын дундаж цалин 2021 оны 4 дүгээр улиралд 8.3 хувиар нэмэгдсэн боловч бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ илүү хурдан өссөнөөр бодит цалин 2.8 хувиар буурсан дүнтэй гарсан. Ийнхүү сүүлийн улирлуудад өрхүүдийн худалдан авах чадвар буурах чиглэлд өөрчлөгдөж, өрхийн санхүүд нэмэлт дарамт үүсэж эхэлсэн (Зураг 95).

3. Зээлийн суваг

Банкнаас шинээр олгосон зээлийн хэмжээ 2020 оны эхний хагаст 9.4 их наяд төгрөгтэй тэнцэж, 2020 оны дүнтэй харьцуулахад 7.7 хувиар буурч байв. Зээлийн төлөвийн судалгааны үр дүнгээр банкуудын зээл олголт буурахад КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор бизнесийн үйл ажиллагаа хумигдсан, эдийн засгийн идэвхжил буурсан зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлж байв.

Зураг 96. Хувийн байгууллагын зээлийн жилийн өсөлт, салбаруудаар *Зураг 97. Банкуудын иргэдийн зээлийн жилийн өсөлт*



Эх сурвалж: Монголбанк




Эх сурвалж: Монголбанк

2020 онд эдийн засгийн голлох салбаруудад олгосон зээлийн хэмжээ огцом буурсан (Зураг 96). Харин, иргэдэл олгож буй цалин, тэтгэвэр, хэрэглээний зээлийн өсөлт 2019 онд 10 орчим хувьтай байсан бол 2020 онд эсрэгээр 10 орчим хувиар буурчээ (Зураг 97). Түүнчлэн банкуудын зээлийн чанар муудаж эхэлсэн. Банкны системд хийсэн стресс тестийн үр дүнгээр банкуудын ашигт ажиллагаа буурч, алдагдалтай ажиллах, зээл олголт буурч, санхүүгийн салбар болон бодит сектор хоорондын харилцан уялдаагаар дамжин эдийн засгийн үйл ажиллагаанд сергөөр нөлөөлөх үр дүн гарч байлаа.

8.2. КОВИД-19 цар тахлын эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдалд үүсэж буй эрсдэлүүд

Дэлхий даяар тархаад буй КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас манай улсын эдийн засаг 2020 онд агшиж, аж ахуйн нэгж, өрхүүдийн секторт орлого тасалдах, төлбөрийн чадварын хүндрэлд орох, улмаар зээлийн эргэн телелт доголдох нөхцөл байдал үүсж байв. Санхүүгийн системийн эрсдэлийн нэгдсэн индексээс харахад 2020 оны эхнээс системийн эрсдэл эрчимтэй нэмэгдсэн бөгөөд үүний 50 гаруй хувийг макро болон гадаад секторын эрсдэл дангаараа бүрдүүлж байв. Банкны сектор, хөрөнгийн зах, хөрвөх чадвар, санхүүжилтийн эрсдэлүүд мөн нэмэгдэж, нийт системийн эрсдэл үргэлжлэн нэмэгдэх хандлагатай болсон байлаа (Зураг 98).


Зураг 98. Санхүүгийн системийн эрсдэлийн нэгдсэн индекс



Эх сурвалж: Монголбанк

КОВИД-19 цар тахлаас шалтгаалан 2020 онд гадаад эрэлт муудах, эрдэс бүтээгдэхүүний үнэ буурах, гадаад худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалтууд удаашрах хандлагууд бий болж байв. Энэ нь орлогын сувгаар дамжин төсвийн орлого буурах, аж ахуйн нэгжүүдийн орлого тасалдах, цаашлаад өрхүүдийн цалин, хөлсний орлого буурах зэргээр илэрч, эдийн засаг 2020 онд 4.6 хувиар агшихад хүргэсэн. Үүнийг даган бодит ДНБ-ий төсөөлөл ч муудав (Зураг 99).

Зураг 99. Бодит ДНБ-ий төсөөллийн өөрчлөлт




Эх сурвалж: Монголбанк

Зээлийн тасалдал

Эдийн засгийн уналтыг дагаад санхүүгийн зах зээлийн тодорхой бус байдал нэмэгдэж, банк, санхүүгийн байгууллагуудын үйл хөдлөл зээлийн нөхцөлөө чангараулах, зээл олголтоо хумих чиглэлд шилжсэн бөгөөд зээлийн сувгаар дамжин бодит эдийн засаг улам хүндрэх нөхцөл байдал үүссэн. Тухайлбал, банкуудын зээлийн үлдэгдэл 2020 онд 5 хувиар, шинээр зээл олголт 6 хувиар тус тус буурсан (Зураг 100).

Зураг 100. Банкуудын зээлийн жилийн өсөлт, голлох салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк

ААН болон өрхийн өрийн эргэн төлөлт, төлбөрийн чадвар

ААН-үүдийн үйл ажиллагаа доголдсоноос тэдгээрийн болон иргэдийн мөнгөн орлого тасалдах, төлбөрийн чадвар муудах, банкнаас олгосон зээлийг гэрээний дагуу эргэн төлөхөд хүндрэл үүсжжээ. Тухайлбал, 2020 оны 5 дугаар сарын байдлаар давхардсан тоогоор 43.6 мянган зээлдэгчийн 3.01 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй зээлийн эргэн төлөлтөд доголдол үүсээд байсан. Үүнээс 74.4% нь буюу 2.3 их наяд төгрөг нь аж ахуйн нэгжид, 25.6% нь буюу 791.6 тэрбум төгрөг нь иргэнд тус тус хамаарч байв. Мөн хуваарийн дагуу хийгдэх ёстой нийт өрийн үйлчилгээнээс 227 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 67 тэрбум төгрөгийн хүү төлөгдөөгүй байв.

Хэрэв энэхүү нөхцөл байдал цаашид үргэлжлэх тохиолдолд зээлдэгчид зээлийн өрийн үйлчилгээг хийж чадахгүйд хүрэх, банкны алдагдал огцом өсөж, эрсдэл даах чадвар алдагдах, өөрийн хөрөнгийн зохистой харьцаанд сөргөөр нөлөөлөх, нэмэлт зээлийг санхүүжүүлэх эх үүсвэрийн дутагдалд орох, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар доройтох зэрэг эрсдэл үүсэхээр байв.

Банкуудаас ирүүлсэн мэдээллээр банкны хяналт, шалгалтын хүрээнд хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэгүй тохиолдолд банкны системийн чанаргүй зээл 1.5 их наяд төгрөгөөр нэмэгдэх бөгөөд улмаар чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 16.1 хувьд хүрэхээр байв.

Банкны ашигт ажиллагаа, ТТГЧ, толбөрийн чадвар

КОВИД-19 цар тахлын хязгаарлалттай холбоотойгоор банкны орлого буурах, зээлийн чанар муудсанаас банкуудын ашигт ажиллагаа огцом муудах, өөрийн хөрөнгийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдах, улмаар банкны салбарт ноцтой хүндрэл үүсжжээ болзошгүй байв. Тухайлбал, цар тахлын нөлөөгөөр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсноос банкнаас санхүүгийн үйлчилгээ авах нь багасах, банкны шимтгэл, хураамжийн орлого буурах, тахлын тархалтаас сэргийлж, банкны салбар, нэгжүүдэд харилцагчдыг олноор төвлөрүүлэхгүй байх үүднээс цахим банк ашиглах, цахим гүйлгээний шимтгэл хураамжийг бууруулах арга хэмжээ авсан нь банкны тогтвортой үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөр байв.

Банкны эх үүсвэрийн долларжилт

Банкны салбарын зээлийн долларжилт буурсан ч эх үүсвэрийн долларжилт нэмэгдэх хандлагатай байгаа нь банкуудын баланс дахь валютын тэнцвэрт бус байдлыг нэмэгдүүлж, банк, санхүүгийн салбарт эрсдэл хуриатлагдах нөхцөлийг бүрдүүлж байв.

8.3. Цар тахлын үед авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүд, үр дүн

Олон улсын санхүүгийн байгууллагуудын зөвлөмж, бусад төв банкуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг судлан үзээд өөрийн орны онцлогт тохирсон бодлогын цогц арга хэмжээг Монголбанкнаас авч хэрэгжүүлэв. Эдгээр арга хэмжээ нь олон улсын сайн туршлагатай нийцтэй бөгөөд санхүүгийн зуучлал хэвийн үргэлжлэх боломжийг бүрдүүлээд зогсохгүй КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засагт учрах сөрөг нөлөөг бууруулахаад нөлөөлсөн.

Зээлдэгчдэд чиглэсэн зохицуулалтын арга хэмжээнүүд

Эргэн төлөлтөд хүндрэл учирсан зээлийн бүтцийг өөрчилж, хугацааг сунгах, зээлийн ангилиыг тодорхой хугацаанд бууруулахгүй хэвээр хадгалах зэрэг зээлдэгчдэд чиглэсэн хөнгөлөлтийн арга хэмжээнүүдийг цар тахлын үед дэлхийн улс орнуудад түгээмэл ашиглаж байв. Иймд Монголбанкнаас цар тахалтай холбоотойгоор зээлдэгчдэд үүсж буй дарамтыг бууруулах зорилгоор дараах бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэв. Үүнд:

- Ипотек, цалин, тэтгэвэр болон бусад хэрэглээний зориулалтаар иргэнд олгосон зээлийн ангиалал бууруулах хугацааг уртасгах, зээлийн ангилиыг тодорхой хугацаанд бууруулахгүй байх;
- Бүх төрлийн зээлд бүтцийн өөрчлөлт хийхэд хязгаарлалтгүй болгох;
- Эргэн төлөлтийн хүндрэлд орсон иргэдийн хэрэглээний зээлийн хугацааг сунгах боломжийг олгох;
- Төрөөс хэрэгжүүлж буй ипотекийн зээлийн хүү болон үндсэн төлбөрийг түр хугацаагаар хойшшуулах.

Банкуудад мөрдүүлж буй “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, “Банкны үйл ажиллагааны зохицстой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих журам”-ын зарим зохицуулалтад түр хугацаанд өөрчлөлт оруулсан. Тухайлбал, зээлдэгчдийн зээлийн эргэн төлөх нөхцөлийг дахин өөрчлөх, эргэн төлөлтийн доголдолтой зээлийн ангиалал, зээлийн түүхийг түр хугацаанд бууруулахгүй, дордуулахгүй байх асуудлыг бие даан шийдвэрлэх боломжийг банкуудад олгов.

Мөнгөний бодлогын хороо (МБХ)-ны 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хурлаар эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах шийдвэр гаргав. Уг шийдвэрийн хүчинтэй хугацааг МБХ-ны 2020 оны 8-р сарын 7-ны өдрийн хурлаар 12-р сарын 31 хүртэл сунгахаар болов.

Санхүүгийн нохцөлийг зөөлрүүлж, зээлийн тасалдаас сэргийлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүд

Бодлогын хүүг түүхэн доод түвшинд хүргэв. Монголбанкнаас бодлогын хүүг 2020 онд 5 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэсэн бөгөөд 2021 оны туршид хэвээр хадгалав. Тус шийдвэр нь КОВИД-19 цар тахлын үед нийгэм, эдийн засагт тулгарч буй санхүүгийн хүндрэл, дарамтыг зөөлрүүлэх, эдийн засгийн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн. Үүний үр дүнд шинээр олгосон зээлийн хүү 2019 оны 12 сард 16.9 хувь байсан бол 2020 оны төгсгөлд 14.8 хувьд хүрч түүхэн доод түвшинд хүрч, түүнээс хойш 14-15 хувийн орчимд тогтвортой байна. Нөгөө талд, шинээр татсан хадгаламжийн дундаж хүү 2019 оны 12 сард 10.5 хувь байсан бол 2020, 2021 оны эцэст харгалзан 8.4, 5.8 хувьд хүрч буурсан (Зураг 101).

Зураг 101. Хүүгийн тувшин



Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээг бууруулав. Мөнгөний бодлогын хүрээнд төгрөгийн заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээг 2020 онд 4.5 нэгж хувиар бууруулж б хувьд хүргэх, хүүгийн коридорыг бодлогын хүүнээс +/-1 нэгж хувиар тогтоох, жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх, санхүүжилтийн хэмжээг тогтоох зэрэг багц шийдвэрийг гаргасан. ЗБН-ийн хувийг ийнхүү бууруулснаар 700 гаруй тэрбум төгрөгийн эх үүсвэр банкуудад чөлөөлөгдсөн. Энэхүү шийдвэр нь цар тахлын үед банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хадгалах, банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, банкны зээлд гаргах боломжтой эх үүсвэрийг нэмэгдүүлэх, зээлийн хүүг бууруулах, улмаар эдийн засаг дахь санхүүгийн зуучлалыг дэмжих зорилготой байв.

Аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадварыг дэмжих зорилгоор 2021 оны 2 сард Засгийн газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгaa сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г баталсан. Тус төлөвлөгөөний хүрээнд 2021 онд нийт 5.5 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй зээл олгохоор төлөвлөсөн бөгөөд аж ахуйн нэгж, иргэд, малчдад санхүүгийн дэмжлэг болж, бизнесийн хэвийн үйл ажиллагааг хангаж, эдийн засаг дахь төлбөрийн чадварын хүндрэлээс сэргийлнэ гэж үзсэн. Ажлын байрыг дэмжих,repo санхүүжилт, ипотек, хөдөө аж ахуйн зээлийн хүрээнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 61,719 зээлдэгчид 4.24 их наяд төгрөгийн санхүүжилт олгов (Хүснэгт 18). Тус төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хувьд авч үзвэл 56 арга хэмжээний 25 арга хэмжээг 2021 онд, 3 арга хэмжээг 2021-2022 онд, 17 арга хэмжээг 2021-2024 онд, 11 арга хэмжээг халдвартархалтын шаталсан түвшин, нөхцөл байдлаас хамаарч тухай бурд нь хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2021 оны төлөвлөгөөний биелэлт 89 хувьтай гарсан байна.


Ажлын байрыг дэмжих болон урт хугацааны repo санхүүжилтийн хүрээнд олгосон нийт санхүүжилтийн 43 хувийг нь бөөний болон жижиглэнгийн салбарт, 18 хувийг үйлчилгээний бусад салбарт олгожээ. Харин дэмжлэг үзүүлсэн нийт 146 мянган ажлын байрны 35 хувь буюу 50,708 ажлын байрыг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 19 хувь буюу 27,131 ажлын байрыг үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт, 13 хувь буюу 19,289 ажлын байрыг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 7 хувийг барилгын салбарт, бусад эдийн засгийн салбарт 19 хувь буюу 27,598 ажлын байрыг дэмжиж зээл олгосон байна.

Хүснэгт 18. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, 2021 он

Зээл, санхүүжилтийн хөтөлбөр	Зээлийн дүн		Зээлдэгчийн тоо	Хадгалсан ажлын байр
	Төлөвлөгөө тэрбум ₮	Биелэлт тэрбум ₮		
Ажлын байрыг дэмжих зээл	2,000.0	1,965.6	25,514	109,763
Үрт хугацаат репо санхүүжилттэй зээл	2,000.0	834.9	3,395	36,622
Орон сууцны ипотекийн зээл	1,000.0	955.7	12,223	
Хөдөө аж ахуйн зээл	500.0	494.3	20,607	
Нийт	5,500.0	4,241.4	61,719	146,385

Эх сурвалж: Монголбанк, Сангийн яам

Зураг 102. Зээлийн өсөлт




Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд зээлийн өсөлт сэргэж, бодит секторыг шаардлагатай санхүүжилтийн нэмэлт эх үүсвэрээр хангаж, эдийн засгийн сэргэлтэд зөргээр нөлөөлов.

2021 он гарснаас хойш дэлхий дахинд эдийн засаг, санхүүгийн зах зээл сэргэж, эрдэс бүтээгдэхүүний үнэ өсөж, гадаад орчинд эерэг өөрчлөлтүүд гарч, хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүдийн олголт нэмэгдсэнээр манай улсын санхүүгийн мөчлөг тэнцвэрт түвшнээс илүү сэргэж эхэлсэн (Зураг 103). Банкуудын нийт зээлийн үлдэгдэл 2022 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 25 хувиар өссөн дүнтэй байна (Зураг 104).

Сүүлийн 2 жилд зээл олголт нэмэгдсэн нь иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадварт дэмжлэг үзүүлсэн бөгөөд цаашид зээлийн өсөлтийг дотоод эдийн засгийн нөхцөл байдал, макро орчинтой уялдуулах шаардлага бий.


Түүнчлэн, зээлдэгчдэд чиглэсэн зохицуулалтын арга хэмжээнүүд авснаар иргэд, аж ахуйн нэгжид учраад байсан өрийн үйлчилгээний дарамтыг түр хугацаанд хөнгөлж, бодит секторыг шаардлагатай санхүүжилтийн нэмэлт эх үүсвэрээр хангав.

Зураг 103. Санхүүгийн мөчлөг (улирлаар)



Эх сурвалж: Монголбанк

Зураг 104. Зээлийн жилийн өсөлт (улирлаар)



Эх сурвалж: Монголбанк

Банкны ашигт ажиллагаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүд


Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 25 хувь байсныг 20 хувь болгож бууруулах, өөрийн хөрөнгийг хамгаалах нөөц зөрчигдөхөд авч хэрэгжүүлэх арга хэмжээг түр хугацаанд түдгэлзүүлэх шийдвэрийг гаргаснаар банкуудын санхүүгийн чадавхад эерэг нөлөө үзүүлэв. Түүнчлэн цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор 2020 онд Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын зарим зохицуулалтыг сулруулсан ба 2021 оноос эхлэн хэвийн горим руу шилжүүллээ.

Бодлогын арга хэмжээний үр дүнд банкны ашигт ажиллагаа, ТТГЧ, төлбөрийн чадвар сайжирсан. Тухайлбал чанаргүй зээл, анхаарал хандуулах зээлийн хувь хэмжээ 2021 онд эрчимтэй буурав (Зураг 105). Аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадварыг дэмжих зорилгоор 10 их наядын хөнгөлөлттэй зээлийн арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд эдийн засаг дахь төлбөрийн чадварын хүндрэлээс сэргийлэв.

Санхүүгийн салбарын долларжилтыг бууруулах арга хэмжээнүүдийг шат дараалан хэрэгжүүлснээр хадгаламжийн долларжилт 2020 оны 4 дүгээр улирлаас эхлэн 2022 оны эхний улирал хүртэл эрчимтэй буурав (Зураг 106). Цар тахлын үеийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн төлөв, эрсдэлийг харгалзан банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор дараах арга хэмжээг авав. Үүнд:

- Гадаад валютын татан төвлөрүүлсэн хөрөнгөнд тооцох заавал байлгах нөөцийн хувийг нэмэгдүүлэх;
- Гадаад валютын хадгаламжийг албан даатгалд хамруулахгүй байх;
- Иргэн хуулийн этгээд хоорондын мөнгөн төлбөрийн үүрэг, гүйлгээг гадаад валютаар гүйцэтгэхийг хязгаарлах;
- Өндөр хүйтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын дүнгээс хамааруулан ЗБН-ийн урамшууллыг бууруулах.

Зураг 105. Чанаргүй, анхаарал хандуулах зээлийн нийт зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк

Зураг 106. Зээл, хадгаламжийн долларжилт



Эх сурвалж: Монголбанк

8.4. Монголбанкны урт хугацаат репо санхүүжилт

Монголбанкнаас дэлхийн бусад улс, орнуудын төв банкуудын Ковид-19-ын цар тахлын үед хэрэгжүүлж буй сайн туршлагыг судалж, зээлийг багцлан үнэт цаасжуулан репо нөхцөлөөр санхүүжилт олгох механизмыг 2020 оны 4 дүгээр улиралд нэвтрүүлсэн. Уг арга хэмжээний хүрээнд Монголбанкнаас 2 жил хүртэл хугацаатайгаар банкуудад репо нөхцөлөөр санхүүжилт олгож, банкууд эцсийн зээлдэгчид 3 нэгж хувь нэмж шинээр зээл олгох, олгосон зээлийг дахин санхүүжүүлэх арга хэмжээ авсан.

Хүснэгт 19. Зээл олголт тэрбум ₮, 2022 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар

Зээлийн дүн ³⁸	Зээлдэгч	Үүнээс:								Зээлдэгчийн ажлын байр	
		ААН		Иргэн		Улаанбаатар		Орон нутаг			
		Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	УБ хот	Орон нутаг
1,240.2	3,633	1,038.5	1,963	201.7	1,670	1,078.0	2,300	162.2	1,333	59,532	6,899

Эх сурвалж: Монголбанк

2022 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар нийт 4,384 зээлдэгчийн 1,498.9 тэрбум төгрөгийн хүсэлт ирүүлснээс **1,240.2 тэрбум төгрөгийг 3,633** (1,963 аж ахуйн нэгж, 1,670 иргэн) зээлдэгчид олгоод байна. Ингэснээр улсын хэмжээнд нийт 66.4 мянган ажлын байрыг хадгалахад дэмжлэг узүүлжээ. Нэг иргэний зээлийн дундаж хэмжээ 120.8 сая төгрөг, аж ахуйн нэгжийн авсан дундаж зээлийн хэмжээ 529.0 сая төгрөг байна. Урт хугацаат репо арилжааны нэмэлт нөхцөлд³⁸ санхүүжилтийн 50 хувиас багагүй дүнгээр шинэ зээл олгохоор (зээлдэгчийн өрийн дарамтыг бууруулах зорилгоор) тусгасан бөгөөд нийт зээлийн 53 хувь нь шинээр олгосон зээлд, 47 хувь нь өмнө нь олгосон зээлийн дахин санхүүжилтэд зарцуулагджээ (Зураг 107).

Монголбанкны урт хугацаат репо санхүүжилт нь хүртээмжтэй өсөлтийг бий болгох, эдийн засгийг төрөлжүүлэх ач холбогдол бүхий жижиг дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортын салбарын өрийн дарамтыг бууруулах зорилгын хүрээнд эх үүсвэрийг анх уг салбарын аж ахуй нэгж, иргэнд олгож эхэлсэн. Үүний дараа цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг богино хугацаанд арилгах, ажлын байрыг хадгалах зорилгоор үйлчилгээ, боловсруулах, бөөний ба жижиглэн худалдааны салбаруудаар хамрах хүрээг өргөтгөсөн юм. Улмаар, зээл олголтын задаргааг салбараар нь авч үзвэл ажлын байрыг дэмжих зээлийн адил репо санхүүжилтийн хүрээнд бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарыг (46


³⁸ Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 3-р сарын 26-ны А-89, 2021 оны 7-р сарын 6-ны А-185, 2021 оны 9-р сарын 22-ны А-247, 2022 оны 2-р сарын 11-ний А-34 дүгээр тушаалууд

хувь) голлон дэмжсэн байна. Мөн олгосон зээлийн 17 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 9 хувийг үйлчилгээний бусад салбар, 4 хувийг барилга (49 тэрбум төгрөг), эрүүл мэнд болон нийгмийн үйлчилгээ (55 тэрбум төгрөг), зочид буудал байр орон сууцны нийтийн хоолны үйлчилгээний салбар (52 тэрбум төгрөг)-т тус тус олгожээ. Үлдсэн бусад эдийн засгийн 14 салбарт 15 хувийг олгосон байна (Зураг 108).

Зураг 107. ААН, иргэдэд олгосон зээлийн мэдээлэл




Зураг 108. Рено санхүүжилт, салбараар, эзлэх хувь



Зураг 109. Хадгалсан ажлын байрны тоо, зээлдэгчээр

■ Аж ахуй нэгж


■ Иргэд



Зураг 110. Олгосон зээлийн тоо, зээлчдэгчээр

■ Аж ахуй нэгж

■ Иргэд



Эх сурвалж: Монголбанк

Хөдөө аж ахуйн зээл

Цогц төлөвлөгөөнд “Хөдөө аж ахуйг дэмжих” 500 тэрбум төгрөгийн зээлийн хөтөлбөр багтсан. Уг хөтөлбөр нь хаврын тариалалтад 100 тэрбум төгрөг, ноос, ноолуур бэлтгэлд 200 тэрбум төгрөг, малчдыг дэмжих зориулалтаар 200 тэрбум төгрөгийн зээл гэсэн үндсэн 3 хэсгээс бүрдэнэ. Хөтөлбөрийн хүрээнд зээлийн санхүүжилтийг арилжааны банкуудын эх үүсвэрт тулгуурлан жилийн 3 хувийн хүйтэй 494.3 тэрбум төгрөгийг 2021 онд олгосон байна.

Харин Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэлд зааснаар “Хөдөө аж ахуйг дэмжих зээл”-ийн хүрээнд 2022 онд 380 тэрбум төгрөгийг олгохоор шийдвэрлэсэнээс 2022 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар 63 хувийн гүйцэтгэлтэйгээр 238.6 тэрбум төгрөгийг олгожээ. Энэ удаагийн санхүүжилт нь ноолуур бэлтгэл (97.4 тэрбум), газар тариалан (70.4 тэрбум), гурил, тэжээл (38.5 тэрбум), төмс, хүнсний ногоо

(27.4 тэрбум)-ны үйлдвэрлэл рүү голлон чиглэж, нийтдээ 233.6 тэрбум төгрөгийг олгон, 1,459 зээлдэгчид дунджаар 160.1 сая төгрөгийн зээл олгосон байна.


Хүснэгт 20. Зээл олголт сая ₮, зориулалтаар

Зээлийн төрөл	2021		2022.8 сар	
	Дүн	Тоо	Дүн	Тоо
Малчдыг дэмжих зээл	199,643	19,870	199,643	19,870
Махны нөөц бүрдүүлэх зээл	97,597	46	97,597	46
Хаврын тариалалтын зээл	43,301	629	43,301	629
Улаан буудай, тосны ургамал худалдан авах	42,415	11	42,415	11
Ноолуур бэлтгэлийн зээл	94,921	38	192,277	68
Газар тариалангийн үйлдвэрлэл			70,422	449
Гурил, тэжээл, ургамлын тосны үйлдвэрлэл			38,474	11
Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл			27,394	969
Арьс шир бэлтгэлийн зээл	13,202	9	15,702	13
Ноос бэлтгэлийн зээл	3,215	4	5,725	9
Нийт	494,294	20,607	732,950	22,075

Эх сурвалж: Монголбанк

Энэхүү хөнгөлөлттэй зээлийн 11 хувь иргэд, 89 хувь нь хуулийн этгээдэд олгогдсон бөгөөд иргээдэд олгосон зээлийн 73 хувь нь төмс хүнсний ногооны үйлдвэрлэлд зориулж олгогджээ. Харин хуулийн этгээдийн хувьд ноолуур бэлтгэх, газар тариалан, гурил, тэжээлийн ургамлын тосны үйлдвэрлэлийн зээлүүд голлох хэсгийг бүрдүүлж байна.

Зураг III. Зээл олголт хуулийн этгээдийн хэлбэрээр, тэрбум ₮



Эх сурвалж: Монголбанк


Ипотекийн зээл

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний нэг хэсэг нь агаар, орчны бохирдлыг бууруулах үндсэн зорилгын хүрээнд бага, дунд орлоготой иргэдийг орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамруулах, тэдгээрийг орон сууцжуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 2021-2023 онуудад нийт 2 их наяд төгрөгийн эх үүсвэрээр орон сууцны хөтөлбөрийг санхүүжүүлэх юм.

Хөтөлбөрийн хүрээнд зээл олголтын нөхцөлийг хөнгөвчилж, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанк 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүг жилийн 6 хувь болгон бууруулсан (Монголбанк, 2021). Уг зээлийг Монголбанк 60 хувь, банкуудын 40 хувийн эх үүсвэртэйгээр хэрэгжүүлж байна.

Зээл олголтыг харвал 2022 оны 8 дугаар сарын байдлаар Монголбанк болон банкуудын эх үүсвэрээр нийтдээ 741.9 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар буурсан байна (Зураг 112). Мөн орон сууцны ипотекийн санхүүжилтэд 2021 онд сард дунджаар 129.5 тэрбум төгрөг олгож байсан бол 2022 онд 92.7 тэрбум төгрөг болж сард дунджаар 36.8 тэрбум төгрөгөөр буурчээ.

Зураг 112. Тухайн жилд олгосон зээл болон дахин санхүүжилтийн нийлбэр дүн



Эх сурвалж: Монголбанк

Цогц төлөвлөгөөний хүрээнд 2021 оны 3 дугаар сараас 2022 оны 8 дугаар сарын хооронд Монголбанкнаас нийт 2,231.7 тэрбум төгрөгийн 27,195 зээлийн хүсэлт ирүүлснээс **1,310.1 тэрбум төгрөгийг 15,938 зээлдэгчид олгожээ** (Хүснэгт 21). Иргэдийн авсан зээлийн дундаж хэмжээ 82.2 сая төгрөг, үүнээс Улаанбаатар хотод олгосон зээлийн дундаж 89.0 сая төгрөг, орон нутагт 60.2 сая төгрөг байна.

Хүснэгт 21. Зээл олголт 2021.03-2022.08 сар, тэрбум ₮

Зээлийн дүн	Зээлдэгч*	Үүнээс:					
		Улаанбаатар		Орон нутаг		Шинэ зээл	Дахин санхүүжилт
		Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Дүн
1,310	15,938	1,084	12,183	226	3,755	1,255	55

*Дахин санхүүжилт авсан зээлдэгчдийн тоог оруулаагүй
Эх сурвалж: Монголбанк

СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД

I. ИНФЛЯЦЫН ЗОРИЛТ		Жилийн инфляц (Үлс)	Жилийн инфляц (ҮБ)	Үүнээс:		(хувь)
				Хүнсний инфляц	Хүнсний бус инфляц	Сарын инфляц (ҮБ)
2000			8.1	14.7	3.4	2.1
2001			9.2	16.1	(5.0)	1.7
2002		8.0	2.0	(1.8)	4.3	1.5
2003		5.0	4.2	8.7	1.7	0.9
2004		5.0	10.5	15.9	7.3	0.7
2005		5.0	8.7	16.2	2.2	1.1
2006		7.0	4.8	2.2	6.3	0.4
2007		5.0	14.1	24.6	8.2	0.5
2008		6.0	23.2	24.5	22.4	(0.5)
2009		10.0	4.3	1.9	(0.5)	0.2
2010		8.0	14.3	20.6	10.3	2.4
2011		10.0	9.4	7.6	10.2	0.7
2012		10.0	14.2	19.9	11.8	0.7
	I	8.0	9.1	9.5	9.3	0.8
2013	II	8.0	8.3	7.3	6.8	(0.4)
	III	8.0	9.1	7.7	7.8	1.2
	IV	8.0	11.9	12.0	11.5	1.8
	I	8.0	12.4	11.9	12.8	0.5
2014	II	8.0	14.6	15.1	15.9	0.5
	III	8.0	13.0	13.6	14.7	1.0
	IV	8.0	11.0	10.7	12.4	0.6
	I	7.0	9.3	8.1	11.4	0.4
2015	II	7.0	7.3	5.9	9.6	(0.0)
	III	7.0	4.9	3.6	6.0	(0.7)
	IV	7.0	1.9	0.6	4.1	(0.1)
	I	7.0	0.8	(3.0)	2.7	0.4
2016	II	7.0	1.2	1.2	2.6	(0.3)
	III	7.0	(0.0)	(0.2)	0.3	(0.7)
	IV	7.0	1.3	0.8	0.2	0.7
	I	8.0	3.1	3.0	1.9	1.6
2017	II	8.0	3.4	3.5	4.5	(0.6)
	III	8.0	5.8	6.6	5.8	0.5
	IV	8.0	6.4	7.2	7.0	0.3
	I	8.0	6.6	7.7	8.3	1.2
2018	II	8.0	7.2	8.0	6.7	0.7
	III	8.0	5.7	5.9	6.8	(0.0)
	IV	8.0	8.1	9.7	9.5	0.7
	I	8.0	6.7	7.5	7.4	0.8
2019	II	8.0	8.3	9.8	9.1	1.5
	III	8.0	9.0	10.5	7.8	(0.0)
	IV	8.0	5.2	5.0	4.0	0.6
	I	8.0	6.4	6.8	5.1	0.7
2020	II	8.0	2.8	2.4	1.7	0.4
	III	8.0	1.7	1.4	1.6	(0.3)
	IV	8.0	2.3	1.9	(0.7)	(1.7)
	I	6.0	2.5	2.0	(0.7)	0.7
2021	II	6.0	6.6	7.1	4.7	0.9
	III	6.0	9.6	9.9	7.9	0.4
	IV	6.0	13.4	14.8	11.9	2.6
	I	6.0	14.4	15.8	14.6	0.9
2022	II	6.0	16.1	16.9	15.0	1.5

Үргэлжлэл: Жилийн инфляцын бүрэлдэхүүн				(өсөлтөд үзүүлэх нөлөө, хувь)			
	Max	Хүнсний ногоо	Шатахуун	Хатуу түлш	Импортын хүнс	Бусад импорт	Бусад
2000	0.9	(0.2)	(0.0)				
2001	0.9	0.2	0.1				
2002	(0.0)	0.6	0.1				
2003	1.5	(1.3)	0.2				
2004	1.8	0.8	0.3				
2005	3.6	0.7	0.3				
2006	(0.1)	(0.0)	0.2				
2007	2.6	0.6	0.4	0.4	0.6	1.3	
2008	1.5	1.8	0.2	1.1	2.8	4.0	
2009	(0.9)	(0.0)	0.1	(0.4)	1.5	2.2	
2010	3.1	0.6	(0.1)	(0.2)	1.0	2.5	
2011	1.5	0.1	0.8	0.4	0.2	2.3	
2012	4.0	0.3	0.4	0.4	0.6	3.0	
	I	1.5	0.3	0.1	0.4	0.6	1.8
	II	1.5	0.1	0.1	(0.1)	0.4	1.7
2013	III	1.2	(0.0)	0.1	(0.5)	0.4	1.7
	IV	1.2	0.2	-	(0.0)	1.1	2.9
	I	0.3	0.1	(0.0)	0.3	0.8	3.1
2014	II	0.8	0.2	0.1	0.9	1.0	3.8
	III	0.0	0.3	0.1	1.3	1.0	3.8
	IV	0.0	0.1	0.1	1.2	0.5	2.4
	I	(0.6)	0.2	(0.0)	1.1	0.4	2.4
2015	II	(0.8)	0.1	-	1.4	0.3	1.5
	III	(1.1)	0.3	-	1.1	0.3	0.3
	IV	(2.1)	0.2	-	0.1	0.2	0.5
	I	(0.9)	0.1	(0.3)	(0.2)	0.2	0.3
2016	II	(0.7)	0.2	(0.4)	(0.5)	0.3	0.4
	III	(0.7)	(0.3)	(0.4)	(0.6)	0.2	0.9
	IV	0.2	(0.3)	(0.4)	0.1	0.1	0.1
	I	0.3	(0.2)	0.1	0.3	0.4	0.5
2017	II	(0.5)	(0.5)	0.3	0.3	0.4	1.6
	III	0.5	0.7	0.3	0.7	0.5	1.8
	IV	0.2	0.4	0.2	0.7	0.4	2.6
	I	0.1	0.3	0.4	1.9	0.3	2.1
2018	II	0.8	1.0	0.5	1.7	0.5	0.7
	III	0.4	(0.4)	0.9	1.3	0.2	0.6
	IV	1.7	(0.2)	1.3	2.4	0.4	1.0
2019	I	1.5	(0.1)	0.5	0.9	0.5	1.7
	II	3.0	(0.3)	0.7	0.9	0.6	2.1
	III	3.4	0.4	0.2	0.8	0.7	2.2
	IV	1.2	0.1	(0.1)	(0.4)	0.4	1.5
2020	I	2.1	0.3	0.2	(0.0)	0.4	1.6
	II	0.5	0.2	(1.3)	0.1	0.3	1.2
	III	(0.3)	(0.3)	(1.1)	0.3	0.1	1.3
	IV	1.1	0.1	(1.0)	(1.6)	0.5	1.4
	I	0.9	0.0	(0.9)	(1.3)	0.5	0.9
2021	II	2.1	(0.1)	0.4	0.6	0.7	1.4
	III	1.8	0.2	1.7	0.8	1.0	1.4
	IV	2.2	0.4	2.2	1.7	1.8	1.9
2022	I	1.7	0.4	2.6	1.3	1.8	3.0
	II	0.3	1.1	2.8	0.4	2.2	3.4
							6.6

II. БОДИТ СЕКТОР		(өсөлтөд үзүүлэх нөлөө, хувь)					
	Эдийн засгийн өсөлт (нийт эрэлт)	Өрхийн хэрэглээ	ЗГ-ын хэрэглээ	Үндсэн хөрөнгийн хуримтлал	Материаллаг хөрөнгийн өөрчлөлт	Экспорт	Импорт
2006	12.5	7.8	1.1	12.9	(9.0)	3.3	(3.6)
2007	7.0	8.3	1.3	2.9	3.8	2.0	(11.3)
2008	8.6	10.7	0.1	1.8	4.4	2.1	(10.4)
2009	(1.3)	1.2	0.1	(8.5)	(3.6)	8.7	0.9
2010	6.5	5.1	1.0	6.2	4.2	1.7	(11.7)
2011	17.5	6.1	1.5	17.4	6.1	4.3	(17.9)
2012	12.5	5.1	2.1	4.3	4.8	1.8	(5.6)
	I	8.1	8.4	3.5	(0.7)	(7.6)	6.0
	II	9.4	13.4	1.9	(7.9)	(0.5)	5.9
	III	13.2	6.5	3.7	3.1	(1.1)	6.7
	IV	14.7	3.6	(1.0)	(4.8)	24.2	(3.2)
	I	9.2	4.8	1.9	(0.9)	(1.8)	14.3
	II	5.6	8.2	4.1	(11.7)	(4.4)	10.4
	III	9.1	11.3	1.0	(12.7)	(1.5)	16.5
	IV	8.8	8.4	5.5	6.3	(26.5)	30.3
	I	4.0	20.1	4.1	(7.8)	(29.0)	22.9
	II	1.0	3.7	0.0	(4.0)	(0.9)	2.6
	III	8.6	7.2	(0.1)	(7.0)	0.0	(1.4)
	IV	(2.7)	3.7	(2.9)	(9.7)	5.6	(7.8)
	I	2.8	7.0	2.9	3.0	(4.3)	(2.8)
	II	0.5	(4.4)	1.2	2.5	3.1	2.9
	III	(5.8)	(1.3)	3.4	(4.0)	3.8	(10.0)
	IV	9.2	4.8	0.6	4.9	(10.8)	22.3
	I	5.8	(0.1)	(0.8)	1.8	12.7	8.7
	II	5.6	1.4	0.7	5.9	(7.4)	4.2
	III	7.8	5.7	(2.6)	3.7	(4.3)	8.9
	IV	3.3	3.0	0.9	9.2	9.1	(7.7)
	I	6.5	16.3	0.9	10.7	4.5	5.1
	II	7.5	5.1	(0.3)	6.7	6.7	(21.8)
	III	6.2	1.2	(0.4)	11.9	8.6	(0.5)
	IV	9.7	8.5	0.6	1.9	10.7	(2.7)
	I	8.6	3.8	1.4	7.6	(6.1)	2.1
	II	7.1	2.8	2.1	3.9	(1.7)	4.2
	III	6.0	5.2	1.8	4.4	(7.5)	12.6
	IV	1.4	3.2	1.8	1.5	(1.4)	3.6
	I	(7.3)	5.3	2.0	(4.5)	1.4	(23.3)
	II	(7.7)	3.5	1.3	(7.5)	(5.4)	(8.2)
	III	(3.2)	3.3	2.3	(1.7)	(13.5)	(4.6)
	IV	(0.2)	(5.5)	3.2	(11.9)	(17.6)	18.9
	I	15.1	(10.6)	(2.2)	3.3	5.2	27.7
	II	(0.5)	(4.5)	(1.0)	3.2	12.3	(10.2)
	III	(1.2)	(4.5)	(1.3)	(3.3)	38.2	(21.6)
	IV	(2.7)	1.3	9.4	13.8	3.6	(15.3)
	I	(3.8)	6.2	0.4	(1.9)	6.9	(13.7)
	II	6.9	3.2	1.0	21.1	5.3	(21.8)

Үргэлжлэл:		(жилийн өсөлт, хувь)					
		Үүнээс:					
	Эдийн засгийн өсөлт (нийт эрэлт)	Өрхийн хэрэгслий	ЗГ-ын хэрэгслий	Үндсэн хөрөнгийн хуримтлал	Материаллаг хөрөнгийн өөрчлөлт	Экспорт	Импорт
2006	12.5	21.9	7.5	50.7	(56.0)	16.8	32.3
2007	7.0	21.3	9.4	8.6	60.6	9.9	85.6
2008	8.6	24.2	0.7	5.2	46.2	10	45.4
2009	(1.3)	2.3	0.5	(25.4)	(28.0)	40.9	(2.8)
2010	6.5	9.7	7.6	24.6	45.1	5.4	38.6
2011	17.5	11.4	11.6	58.9	48.1	14.2	45.5
2012	12.5	9.9	16.8	10.8	30.1	6.2	11.5
I	8.1	17.1	33.6	(2.8)	(20.8)	32.6	4.0
II	9.4	26.5	16.4	(17.3)	(3.1)	19.5	6.3
III	13.2	12.7	33.3	6.2	(10.2)	20.0	10.0
IV	14.7	7.5	(5.7)	(14.3)	161.6	(12.5)	9.7
I	9.2	9.0	14.3	(3.8)	(6.8)	63.3	23.7
II	5.6	14.0	34.3	(34.0)	(30.7)	31.7	1.9
III	9.1	22.2	7.4	(27.4)	(17.5)	46.2	10.0
IV	8.8	18.7	37.0	24.9	(77.8)	153.4	38.8
I	4.0	37.7	30.1	(38.6)	(127.5)	67.9	14.7
II	1.0	6.0	0.3	(18.8)	(9.2)	6.4	0.9
III	8.6	12.6	(1.0)	(22.7)	0.6	(2.8)	(17.9)
IV	(2.7)	7.6	(15.7)	(33.2)	80.2	(17.0)	(16.8)
I	2.8	9.8	17.1	25.3	72.1	(5.1)	6.2
II	0.5	(6.7)	8.0	14.2	36.6	6.8	9.5
III	(5.8)	(2.2)	28.6	(18.4)	63.1	5.4	23.9
IV	9.2	8.8	3.6	24.7	(83.8)	56.7	29.3
